

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ

*Монгол Улсад хууль зүй, дотоод хэргийн салбар үүсэж хөгжсөний
110 жил, цагдаагийн байгууллагын 100 жилийн ойд зориулав.*



ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2021 №2 (76)
19 дэх жилдээ

СЭТГҮҮЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Пүрэвдорж БАТБААТАР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Батбуян БАТ-ЭРДЭНЭ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бөхчулуун БАТ-ЭРДЭНЭ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жигжидсүрэн БОЛДБААТАР
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Баатар БОЛДБААТАР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Галбат ГАНТӨМӨР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Очирхуяг ЗОРИГТ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Авирмэд ЛХАГВА
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Чойжил НЯМСҮРЭН
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Тамжид ОЮУНЧИМЭГ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Заяатхүү ТӨРМАНДАХ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХВАН И ГАБ
ДОКТОР, ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батсүх АЛТАНСҮХ
ДОКТОР (Ph.D)

Шаравдорж АРИУНБИЛЭГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Лувсан БАТ-ОЧИР
ДОКТОР (Ph.D)

Рагчаасүрэн БАЯРМАГНАЙ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Жаргалсайхан МӨНХБОЛД
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Намжилдорж МӨНХЗУЛ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Думбурай МЯГМАРЦЭРЭН
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бадарч НАРМАНДАХ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жутъяа НЯМДУЛАМ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батхишиг ЛХАГВАСҮРЭН
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Буриад ЛХАГВАРАГЧАА
ДОКТОР (Ph.D)

Шархүү ЧУЛУУНБАТ
ДОКТОР (Ph.D)

Батзэвэг ЭНХБОЛД
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Магмадорж ЭРДЭНЭБАЯР
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН:

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:

Бэгзсүрэн ЖАМСРАН

ГАРЧИГ

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Монгол Улсад 2019 онд бүртгэсэн гэмт хэргийн Төлөв байдал, түвшин, хөдөлгөөн, бүтэц	<i>Б.Мөнхдорж Э.Дашгаадан</i>	5
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үнэлгээ, түүний эрх зүйн зохицуулалт	<i>Д.Булган Б.Хулан</i>	26
Цагдаагийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд таамаглал ашиглаж буй байдалд хийсэн дүн шинжилгээ	<i>М.Хүрэлбаатар</i>	30
Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийн эрүүгийн нөхцөл байдал	<i>П.Очбадрах</i>	35

ХАРЬЦУУЛСАН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Тайланд Улсын эрүүгийн хууль, тогтолцоо, онцлог	<i>Г.Гантөмөр</i>	38
Цар тахлын үеийн хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, зүйлчлэлийн асуудал	<i>Л.Бат-Очир</i>	47
Криптовалютын талаарх гадаадын зарим улс, олон улсын хууль, эрх зүйн зохицуулалт	<i>Ж.Болд</i>	51

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Эрүү ба эрүүгийн процессын эрх зүйн нэр томъёоны зарим асуудал	<i>Н.Манлайбаатар</i>	58
Гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагаа ба гэмт хэргийн талаарх гүйцэтгэх ажлын мэдээ, баримт сэлт	<i>М.Цогтоо Б.Оргилдорж</i>	62

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулах зарим арга зам	<i>Б.Баянмөнх</i>	75
Тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэх эрх зүйн зохицуулалт, анхаарах зарим асуудал	<i>Ш.Чулуун</i>	83
Мэргэжлийн ёс зүй, хандлагыг тодорхойлох шалгуур, тэдгээрийн онцлог	<i>Л.Нямдаваа</i>	89

ХУУЛЬ ЗҮЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Хуульчийн үргэлжилсэн сургалтын зарим хөтөлбөрт хийсэн шинжилгээ	<i>Н.Мөнхзул</i>	99
--	------------------	----

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

МОНГОЛ УЛСАД 2019 ОНД БҮРТГЭСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ТҮВШИН, ХӨДӨЛГӨӨН, БҮТЭЦ

Б.Мөнхдорж
ДХИС-ийн ЭШНХ-ийн Хууль сахиулахуйн боловсролын судлалын төвийн
эрхлэгч, доктор, цагдаагийн дэд хурандаа
Э.Дашгаадан
Докторант, цагдаагийн ахлах дэслэгч

Товч агуулга. Монгол Улсад гэмт хэргийн тоо бүртгэл хөтөлж, статистик мэдээлэлд боловсруулалт, дүн шинжилгээ хийх ажил 1967 оноос цагдаагийн байгууллагад төвлөрөн явагдаж, хөгжиж ирсэн түүхтэй. Өнөөдрийн байдлаар манай улсад бүртгэж байгаа гэмт хэргийн талаарх хамгийн бодитой бөгөөд өргөн хүрээтэй мэдээллийн сан цагдаагийн байгууллагад байна.

Тиймээс өгүүллийг бэлтгэхдээ ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Статистикийн хэлтсийн гэмт хэрэг, зөрчлийн сангийн мэдээллийг голчилон ашигласан болно. Бид энэхүү өгүүлэлд гэмт хэргийн тоон болон чанарын үзүүлэлтийг харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, шалтгаан, хүчин зүйлийн нөлөөлөл, харилцан хамаарлыг тодорхойлох зэрэг арга ашиглан, 2019 онд болон сүүлийн 10 жилд улсын хэмжээнд бүртгэсэн гэмт хэргийн ерөнхий төлөв байдалд дүн шинжилгээ хийхийг зорилоо.

Түлхүүр үг. Гэмт хэрэг, гэмт хэргийн бүтэц, хөдөлгөөн, түвшин.

Хүлээн авсан дуудлага, гомдол, мэдээлэл

Цагдаагийн байгууллага 2019 онд иргэн, хуулийн этгээдээс 620172 дуудлага, мэдээлэл хүлээн авч хуульд заасан үндэслэл, журмын дагуу шалгаж шийдвэрлэсний 41.8% (259179) нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байжээ.


Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 259179 гомдол, мэдээллийн 28.6% (74159)-ийг гэмт хэргийн шинжтэй, 71.4% (185020)-ийг зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл тус тус эзэлж байгааг 2018 оны статистиктай харьцуулбал, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 5.7%-иар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 44.6%-иар тус тус өссөн байна.

Хүснэгт 1. Цагдаагийн байгууллага бүртгэсэн гомдол, мэдээлэл (2018-2019 он)

Он	Нийт гомдол, мэдээлэл	Гэмт хэргийн шинжтэй	Зөрчлийн шинжтэй
2018	198130	70167	127963
2019	259179	74159	185020

Цагдаагийн байгууллага хүлээн авсан гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт гомдол, мэдээллийн 99.2%-ийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд шалгаж шийдвэрлэсэн бөгөөд гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 53.5%-д хэрэг бүртгэлтийн, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 43.5%-д зөрчлийн хэрэг тус тус нээж шалгасан байна.

График 1. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



Цагдаагийн байгууллага 2019 онд хүлээн авч шалгасан гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо өмнөх оноос өссөн нь Эрүүгийн хууль шинэчлэгдэн, Зөрчлийн тухай хууль шинээр батлагдан мөрдөж эхэлсэн, иргэд цагдаагийн байгууллагад хандах, мэдэгдэх тохиолдол нэмэгдсэнтэй холбоотой.

Түүнчлэн, 2019 онд цагдаагийн байгууллага "хоногийн мэдээ"-ний програм хангамжаа боловсронгуй болгон шинэчилж, үйл ажиллагаандаа ашиглаж эхэлснээр гомдол, мэдээллийн бүртгэл, шийдвэрлэлтийн байдалд тавих шат шатны хяналт сайжирсан нь тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэж болохоор байна.

Бүртгэсэн гэмт хэрэг

2019 онд улсын хэмжээнд нийт 31524 гэмт хэрэг бүртгэсэн бөгөөд нийт гэмт хэргийн 20261 (64.3%) нь нийслэл Улаанбаатар хотод, 11204 (35.5%) нь орон нутагт, 59 (0.2%) нь бусад газарт үйлдсэн гэмт хэрэг байна.

График 2. Монгол Улсад бүртгэсэн гэмт хэрэг, аймгуудаар, (2019 он)





График 3. Нийслэлд бүртгэсэн гэмт хэрэг, дүүргээр, (2019 он)



2019 онд гэмт хэрэг 12 аймагт 0.5-43.4%-иар өсөж, 9 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт 1.5-41.7%-иар буурсан байна.

Улсын хэмжээнд бүртгэсэн нийт гэмт хэргийн 47.4%-ийг нууц, далд аргаар үйлдсэн гэмт хэрэг, 13.9%-ийг согтуугаар үйлдсэн гэмт хэрэг, 9.9%-ийг эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэрэг, 3.4%-ийг насанд хүрээгүй хүн үйлдсэн гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Словен улсад төвтэй дэлхийн улс орнуудын гэмт хэргийн рейтинг тогтоодог Numdeo байгууллагын алба ёсны сайтад байршуулсан мэдээлэлд дурдсанаар Монгол Улс 2019 онд тус сайтын рейтингд хамрагдсан 123 орноос гэмт хэргийн индекс 57.76, аюулгүй байдлын индекс 42.24 гэсэн үзүүлэлттэйгээр гэмт хэрэг, аюулгүй байдлын индексийн хувьд "таагүй" орнуудын эхний 25-д бичигджээ.

Энэхүү сайт нь дэлхийн улс орнуудын иргэд, оршин суугчид болон жуулчдын өгч буй мэдээлэлд боловсруулалт хийх замаар улс орон, хотуудын гэмт хэргийн болон аюулгүй байдлын индексийг тогтоодог тул зарим тохиолдолд албан ёсны статистик мэдээллээс зөрүүтэй байдгийг дурдах нь зүйтэй. Тус сайтын 2018 онд тогтоосон индексийг үзвэл манай улс гэмт хэргийн индекс 61.70 аюулгүй байдлын индекс 38.30 гэсэн үзүүлэлттэйгээр 18 дугаарт бичигдсэн байна. Үүнээс үзвэл, манай улсын гэмт хэрэг, аюулгүй байдлын индекс 2019 онд 2018 оноос "дээрдсэн" гэж дүгнэж болох ба энэ нь Монгол Улсад 2019 онд бүртгэсэн гэмт хэргийн тоо 2018 оноос бараг 4700-гаар цөөн болж буурсан статистик мэдээтэй ерөнхийдөө дүйж байна.

Numdeo байгууллагын албан ёсны сайтын мэдээллээр гэмт хэрэг, аюулгүй байдлын "хамгийн сайн" индекстэй орнуудын жагсаалтыг Катар, Япон, Сингапур, Тайвань, Арабын нэгдсэн эмират, Гонконг, Швейцарь зэрэг нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдхүүний хэмжээ өндөртэй улсууд тэргүүлж байгаа бол хамгийн "таагүй" индекстэй орнуудыг Венесуэл, Папуа-Шинэ гвиней, Гондурас, ӨАБНУ, Тринидад Тобаго, Бразил зэрэг орнууд тогтвортой тэргүүлдэг байна.

Гэмт хэргийн түвшин

Гэмт хэргийн тоон үзүүлэлтийн нэг болох гэмт хэргийн түвшинг нь тодорхой нутаг дэвсгэрт тодорхой хугацаанд бүртгэсэн гэмт хэргийг тухайн нутаг дэвсгэрт оршин сууж буй 16-аас дээш насны 10 000, 100 000 хүн амд харьцуулсан тоогоор илэрхийлнэ.

2019 онд манай улсын 16-гаас дээш насны 10 000 хүн ам тутамд улсын хэмжээнд 147, нийслэлд 208, орон нутагт 95 гэмт хэрэг ногдож байна¹.

График 4. Аймгуудад бүртгэгсэн 16-аас дээш насны 10 000 хүн амд ногдох гэмт хэрэг. (2019 он)





График 5. Нийслэлийн дүүргүүдэд бүртгэгсэн 16-аас дээш насны 10 000 хүн амд ногдох гэмт хэрэг. (2019 он)




Дээрх графикаас үзвэл, гэмт хэргийн түвшин нийслэлийн төвийн 6 дүүрэг болон Хэнтий аймагт улсын дундаж (147)-аас, нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт нийслэлийн дундаж (208)-аас тус тус өндөр байна. Аймгуудын хувьд авч үзвэл, Хэнтий аймгаас бусад 20 аймгийн гэмт хэргийн түвшин улсын болон нийслэлийн дунджаас бага байгаа бөгөөд нийт 12 аймгийн гэмт хэргийн түвшин орон нутгийн дундаж (95)-аас дээгүүр байжээ.

2019 оны гэмт хэргийн түвшинг 2018 онтой харьцуулахад улсын дундаж 22 нэгжээр, нийслэлийн дундаж 55 нэгжээр тус тус буурч, орон нутгийн дундаж 5 нэгжээр өссөн байна.

¹ www.1212.mn цахим хуудаснаас хүн амын тоог татаж авсан болно.


График 6. Улсын хэмжээнд бүртгэсэн 16 ба түүнээс дээш насны 10000 хүн амд ногдох гэмт хэрэг. (2018-2019 он)



Гэмт хэргийн хөдөлгөөн /өсөлт, бууралт/

2019 онд улсын хэмжээнд бүртгэсэн гэмт хэргийн тоог өмнөх 2018 онтой харьцуулбал 4696-аар буюу 13%-иар, нийслэлд 5391-ээр буюу 21%-иар тус тус буурсан бол орон нутагт бүртгэсэн гэмт хэрэг 700-аар буюу 6.7%-иар өсчээ.

График 7. Бүртгэсэн гэмт хэргийн өсөлт, бууралт. (2018-2019 он)



Нийслэл Улаанбаатар хотод бүртгэсэн гэмт хэрэг улсын хэмжээнд бүртгэсэн гэмт хэргийн 64.3%-ийг эзэлж байгаа нь цөөн хүн амтай, өргөн уудам нутагтай манай орны хувьд хүн амын төвлөрөл буюу хүн ам зүйн хүчин зүйл гэмт хэргийн түвшинд шууд нөлөөлдгийг харуулж байна.

2019 онд гэмт хэрэг 12 аймагт 0.5%-иас 43.4%-иар өсч, 9 аймаг, нийслэлийн хэмжээнд 9 дүүрэгт 1.5%-иас 41.7%-иар буурсан байна. 2018, 2019 онд бүртгэсэн гэмт хэргийн өсөлт, бууралтыг аймаг, дүүргээр харьцуулан харуулбал:

Хүснэгт 2. Аймаг, дүүрэгт бүртгэсэн гэмт хэргийн өсөлт, бууралт

Д/д	Аймаг, дүүрэг	2018	2019	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Архангай	519	568	49	9.4
2	Баян-Өлгий	318	306	-12	-3.8
3	Баянхонгор	581	642	61	10.5
4	Булган	344	459	115	33.4

5	Говь-Алтай	203	235	32	15.8
6	Говьсүмбэр	176	154	-22	-12.5
7	Дархан-Уул	818	803	-15	-1.8
8	Дорноговь	517	550	33	6.4
9	Дорнод	602	605	3	0.5
10	Дундговь	266	211	-55	-20.7
11	Завхан	235	247	12	5.1
12	Орхон	794	747	-47	-5.9
13	Өвөрхангай	670	613	-57	-8.5
14	Өмнөговь	429	515	86	20.0
15	Сүхбаатар	366	525	159	43.4
16	Сэлэнгэ	779	767	-12	-1.5
17	Төв	779	865	86	11.0
18	Увс	332	327	-5	-1.5
19	Ховд	363	481	118	32.5
20	Хөвсгөл	787	743	-44	-5.6
21	Хэнтий	626	841	215	34.3
	Нийслэл	25652	20261	-5391	-21.0
22	Баянгол	4501	2834	-1667	-37.0
23	Баянзүрх	7522	5465	-2057	-27.3
24	Сүхбаатар	4132	3283	-849	-20.5
25	Сонгинохайрхан	3692	3470	-222	-6.0
26	Хан-Уул	2332	2055	-277	-11.9
27	Чингэлтэй	2776	2642	-134	-4.8
28	Багануур	253	167	-86	-34.0
29	Багахангай	24	14	-10	-41.7
30	Налайх	420	331	-89	-21.2
31	ИАТ	5	12	7	2.4 дах
32	Төмөр зам	53	49	-4	-7.5
33	Бусад	64	59	-5	-7.8
	Улсын хэмжээнд	36220	31524	-4696	-13.0

Гэмт хэргийн хөдөлгөөнийг Эрүүгийн хуулийн бүлгээр авч үзвэл, 10 бүлэгт заасан гэмт хэрэг 2.1-66.7%-иар өсч, 8 бүлэгт заасан гэмт хэрэг 1.8-70.7%-иар буурч, 1 бүлэгт заасан гэмт хэрэг өмнөх оны түвшинд, 1 бүлэгт заасан гэмт хэрэг бүртгэггүй байна.

Эрүүгийн хуулийн зарим бүлэгт заасан гэмт хэргийн өсөлт, бууралтын хувь нь өндөр харагдаж байгаа ч тоон үзүүлэлтээр нь авч үзвэл, өөрчлөлт нь харьцангуй бага байгааг тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал, хамгийн өндөр хувиар өссөн соёлын өвийн эсрэг гэмт хэрэг 2018 онд 3 байсан бол 2019 онд 5 болж 66.7%-иар, хүүхдийн эсрэг гэмт хэрэг 2018 онд 21 байсан бол 2019 онд 31 болж 47.6%-иар тус тус өсчээ. Хамгийн өндөр буюу 70.7%-иар буурсан үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2018 онд 99 байсан бол 2019 онд 29 болж 60 нэгжээр, хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг 2018 онд 6 байсан бол 2019 онд 3 болж 50%-иар буюу 3 нэгжээр тус тус буурчээ.

Хүснэгт 3. Бүртгэсэн гэмт хэрэг. (Эрүүгийн хуулийн бүлгээр, 2018-2019 он)

№	Эрүүгийн хуулийн бүлэг	2018	2019	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	714	636	-78	-10.9
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	9134	8265	-869	-9.5
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	621	610	-11	-1.8
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	115	115	0	0.0
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	6	3	-3	-50.0
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	33	39	6	18.2
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	21	31	10	47.6
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	22468	18341	-4127	-18.4
9	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	242	247	5	2.1
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	99	29	-70	-70.7
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	314	333	19	6.1
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	196	172	-24	-12.2
13	Авлигын эсрэг гэмт хэрэг	362	523	161	44.5
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	237	341	104	43.9
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг	366	489	123	33.6
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	3	5	2	66.7
17	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	42	57	15	35.7
18	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	1231	1276	45	3.7
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	15	12	-3	-20.0
20	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайваны эсрэг гэмт хэрэг	1		-1	
	Нийт	36220	31524	-4696	-13.0

Манай улс дахь гэмт хэргийн бүтцэд тогтмол өндөр хувь эзэлж ирсэн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 2019 онд 4127 нэгжээр буюу 18.4%-иар, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 869 нэгжээр буюу 9.5%-иар тус тус буурч, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 45 нэгжээр буюу 3.7%-иар өссөн байна.

Гэмт хэргийн хөдөлгөөнийг тодорхой зарим төрлийн гэмт хэргээр авч үзвэл, хүнийг алах гэмт хэрэг 5 нэгжээр буюу 2.6%-иар, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэрэг 62 нэгжээр буюу 31.8%-иар тус тус өсөж, бусдын бие махбодид гэмтэл учруулах, хүчиндэх, хулгайлах, дээрэмдэх, залилах, танхайрах гэмт хэрэг тус тус буурчээ.

Хүснэгт 4. Гэмт хэргийн зарим төрөл. (2018-2019 он)

№	Гэмт хэргийн төрөл	2018	2019	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Хүнийг алах	192	197	5	2.6
2	Бусдын бие махбодид гэмтэл учруулах	9134	8265	-869	-9.5

3	Хүчиндэх	519	481	-38	-7.3
4	Хулгайлах	12328	8968	-3360	-27.3
5	Дээрэмдэх	1497	868	-629	-42.0
6	Залилах	5358	4668	-690	-12.9
7	Танхайрах	58	29	-29	-50.0
8	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах	195	257	62	31.8

Гэмт хэргийн өсөлт, бууралтыг бүрэлдэхүүний зарим шинжээр нь авч үзвэл, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 1082 нэгжээр буюу 32.9%-иар, мансуурсан үедээ үйлдсэн гэмт хэрэг 71 нэгжээр буюу 40.3%-иар, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 91 нэгжээр буюу 5.3%-иар тус тус өсөж, галт зэвсгээр, гэр бүлийн хүчирхийллийн улмаас, зохион байгуулалттай бүлэг үйлдсэн гэмт хэрэг тус тус буурсан байна.


Хүснэгт 5. Гэмт хэргийн бүрэлдэхүүний зарим шинж. (2018-2019 он)

№	Гэмт хэргийн бүрэлдэхүүний зарим шинж	2018	2019	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Согтуугаар үйлдсэн	3289	4371	1082	32.9
2	Галт зэвсгээр үйлдсэн	39	36	-3	-7.7
3	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн	1069	985	-84	-7.9
4	Бүлэглэн үйлдсэн	1714	1805	91	5.3
5	Мансуурсан үедээ үйлдсэн	176	247	71	40.3
6	Зохион байгуулалттай бүлэг үйлдсэн	85	56	-29	-34.1

Гэмт хэргийн бүтэц

Улсын хэмжээнд 2019 онд бүртгэсэн гэмт хэргийн бүтцийг Эрүүгийн хуулийн бүлгээр авч үзвэл, нийт хэргийн 58.2% (18341)-ийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 26.2% (8265)-ийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 4% (1276)-ийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг, 2% (636)-ийг хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, бусад 16 бүлэгт заасан гэмт хэрэг 9.5%-ийг тус тус эзэлж байна.

График 8. Гэмт хэргийн бүтэц, Эрүүгийн хуулийн бүлгээр,



Гэмт хэргийн бүтцийг тодорхой төрлөөр авч үзвэл, нийт гэмт хэргийн 28.4% (8968)-ийг хулгайлах гэмт хэрэг, 23.4% (7391)-ийг хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг, 14.9% (4688)-ийг залилах гэмт хэрэг, 4.0% (1263)-ийг автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг, 2.8% (868)-ийг дээрэмдэх гэмт хэрэг, 1.5% (481)-ийг хүчиндэх гэмт хэрэг, 1.2% (377)-ийг хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг, 1% (319)-ийг хүний эрүүл мэндэд хүндэтгэр хохирол санаатай учруулах гэмт хэрэг, 0.8% (257)-ийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг, 0.8% (238)-ийг хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэрэг, 0.7% (207)-ийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, 0.6% (197)-ийг хүнийг алах гэмт хэрэг, 0.3% (89)-ийг улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг, 0.3% (85)-ийг хахууль авах гэмт хэрэг, 0.2% (54)-ийг мөнгө угаах гэмт хэрэг тус тус эзэлж байна.

График 9. Тодорхой төрлийн зарим гэмт хэргийн нийт гэмт хэрэгт эзлэх хувь. (2019 он)



Монгол Улсад 2019 онд бүртгэсэн нийт гэмт хэргийн 79.8% (25156)-ийг хөнгөн ангиллын гэмт хэрэг, 20.2% (6368)-ийг хүнд ангиллын гэмт хэрэг эзэлж байна.

Хөнгөн ангиллын гэмт хэрэг өмнөх оноос 10.5%-иар, хүнд ангиллын гэмт хэрэг 21.6%-иар тус тус буурчээ.

График 10. Гэмт хэргийн бүтэц. (ангиллаар)



Улсын хэмжээнд бүртгэсэн нийт гэмт хэргийн 47.4%-ийг нууц, далд аргаар үйлдсэн гэмт хэрэг, 13.9%-ийг согтуугаар үйлдсэн гэмт хэрэг, 9.9%-ийг эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэрэг, 3.4%-ийг насанд хүрээгүй хүн үйлдсэн гэмт хэрэг, 3.1%-ийг гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн гэмт хэрэг тус тус эзэлж байна.


Гэмт хэрэг үйлдэгч

2019 онд нийт 17110 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 721 буюу 4.4%-иар өссөн.

Нийт гэмт хэрэг үйлдэгчдийн 14823 буюу 86.6%-ийг эрэгтэй хүн, 2287 буюу 13.4%-ийг эмэгтэй хүн, 1356 буюу 7.9%-ийг насанд хүрээгүй хүн тус тус эзэлж байгааг 2018 онтой харьцуулбал эрэгтэйчүүдийн эзлэх хувь 0.2-оор, насанд хүрээгүй хүмүүсийн эзлэх хувь 2.1-ээр тус тус өсч, эмэгтэйчүүдийн эзлэх хувь 0.1-ээр буурчээ.

2018 онд бүртгэсэн 36220 гэмт хэрэгт 16389 хүн холбогдон шалгагдсан бөгөөд 2019 онд бүртгэсэн гэмт хэргийн тоо буурч, харин холбогдон шалгагдсан хүний тоо өссөн нь гэмт хэргийн илрүүлэлтийн хувь өмнөх оноос 8.9%-иар өссөнтэй холбоотой.

График 11. Гэмт хэрэг үйлдэгчдийн нас, хүйс, нийгмийн байдал. (2019 он)



Гэмт хэрэг үйлдэгчдийн 86.6% нь эрэгтэйчүүд, 13.4% нь эмэгтэйчүүд, 7.9%-ийг насанд хүрээгүй хүмүүс, 62% нь 18-40 насныхан, 52.2% нь тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс, 35.2% нь ажилчин, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчид буюу хувийн секторынхон, 3% нь төрийн албан хаагчид байна.

Гэмт хэргийн хохирогч, хохирол

Монгол Улсад 2019 онд гэмт хэргийн улмаас нийт 30782 хүн хохирсон нь өмнөх оноос 2784 буюу 8.3%-иар буурч, 85 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оноос 28 буюу 49.1%-иар өссөн байна.

Гэмт халдлагад өртөж хохирсон хүмүүсийн 42.9% нь эмэгтэйчүүд, 57.1% нь эрэгтэйчүүд, 5.2% нь насанд хүрээгүй хүмүүс байна.


2019 онд улсын хэмжээнд гэмт хэргийн улмаас 930 хүн нас барсан нь өмнөх оноос 4 буюу 0.4%-иар, 8727 хүн гэмтсэн нь өмнөх оноос 556 буюу 6%-иар тус тус буурчээ.

График 12. Гэмт хэрэгт хохирсон хүн, хуулийн этгээд (2018, 2019 он)



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 162.3 тэрбум төгрөгийн хохирлын 43.8 тэрбум төгрөг буюу 27%-ийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос 10.2%-иар өсөж, 7 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь 5.8 тэрбум төгрөг буюу 45.2%-иар буурсан байна.

График 13. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол (тэрбум төгрөгөөр)




Жич: Гэмт хэргийн хохирогч, хохирлын талаар энэ номын 1.4 дүгээр дэд бүлэгт дэлгэрэнгүй байдлаар авч үзсэн болно.

Монгол Улсад 2010-2019 онд бүртгэсэн гэмт хэрэгт хийсэн дүн шинжилгээ:

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 10 жилийн хугацаанд (2009-2019 он) нийт 268718 гэмт хэрэг бүртгэсэн бөгөөд дундчилж авч үзвэл, жилд 26872, сард 2239, хоногт 74 гэмт хэрэг бүртгэсэн байна.

График 14. Улсын хэмжээнд бүртгэсэн гэмт хэрэг. (2010-2019 он)



Дээрх графикаас үзвэл, манай улсад бүртгэсэн гэмт хэрэг 2011 онд бага зэрэг буурсан, 2012-2013 онд жилд дунджаар 15%-иар өссөн, 2014-2016 онд харьцангуй тогтвортой нэг түвшинд байсан, 2017 онд 18.7%, 2018 онд 12.3%-иар тус тус өссөн, харин 2019 онд 13%-иар буурсан байжээ.

2018 онд бүртгэсэн 36220 гэмт хэрэг нь одоогоор манай улсад нэг жилд бүртгэсэн хамгийн олон гэмт хэрэг бөгөөд ЦЕГ-ын хийсэн дүн шинжилгээний ажлын тайланд² дурьдсанаар тухайн онд бүртгэсэн гэмт хэргийн тоо өсөхөд нийгэм, эдийн засгийн хүчин зүйл төдийлөн нөлөөлөөгүй, харин 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн зарчмын шинжтэй өөрчлөлтүүд буюу эрх зүйн хүчин зүйлс голлох нөлөө үзүүлжээ. Тухайлбал, өмнөх Эрүүгийн хуулиар "бага бус хэмжээний хохирол" (хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний буюу 240.0 мянган төгрөгнөөс дээш хохирол), "үлэмж" болон "их хэмжээний хохирол" учирсан байхыг шаарддаг байсан хулгайлах, мал хулгайлах, бусдын эд хөрөнгийг илээр, хүч хэрэглэхгүйгээр хууль бусаар авах, залилах, хүрээлэн буй орчны эсрэг зэрэг гэмт хэрэгт шинэ Эрүүгийн хуулиар хохирлын хэмжээ шаардахгүй болсон, мөн залилах, хүчиндэх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж, үйлдлийн аргыг тодорхойлсон хэсгийг дэлгэрэнгүй байдлаар хуульчилсан, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулинд гомдол, мэдээлэл шалгах хугацааг 5 хоногоор тогтоосон, нэг яллагдагчийн үйлдсэн хэд хэдэн гэмт хэргийн

² ЦЕГ. Гэмт хэргийн өсөлт, бууралтад хийсэн дүн шинжилгээний ажлын тайлан. 2019 он

үйлдэл тус бүрт эрүүгийн хэрэг үүсгэж дугаар авах зохицуулалт орсон зэрэг нь нийт гэмт хэргийн тоо өсөхөд шууд нөлөөлсөн байна. Гэмт хэргийн түвшин буюу 16-аас дээш насны 10,000 хүн амд ногдох гэмт хэргийн тоо 2012 оноос эхлэн тогтмол өсч ирсэн ба 2018 онд хамгийн өндөр буюу улсын хэмжээнд 169, нийслэлийн хэмжээнд 263 байсан байна. 2019 онд энэ үзүүлэлт улсын хэмжээнд 147, нийслэлд 208 болж буурчээ.

График 15. Улсын хэмжээнд бүртгэсэн гэмт хэргийн түвшин. (2010-2019 он)



Гэмт хэргийн түвшинг статистикийн байгууллагын суурин хүн амын мэдээлэлд үндэслэн тооцоолж байгаа бөгөөд цаашид нийслэл Улаанбаатар хот, аймгуудад албан ёсны бүртгэлгүй, оршин сууж буй иргэдийн бодит тоонд харьцуулан гаргаж байх нь зүйтэй байна.

Улсын хэмжээнд сүүлийн 10 жилийн хугацаанд (2010-2019 он) нийт гэмт хэрэг 268718 бүртгэсэний 170817 (63.7%) нь нийслэл Улаанбаатар хотод, 96699 (36.1%) нь орон нутагт, 519 (0.2%) нь бусад газарт тус тус үйлдсэн байна.

График 16. Бүртгэсэн гэмт хэрэг. (нутаг дэвсгэрээр, 2010-2019 он)






График 17. Бүртгэсэн гэмт хэрэг. (2010-2019 он)



Нийслэл Улаанбаатар хотод 2010 онд бүртгэсэн гэмт хэрэг улсын хэмжээнд бүртгэсэн нийт гэмт хэргийн 54.8%-ийг эзэлж байсан бол 2018 онд 70.8%, 2019 онд 64.3%-ийг эзлэх болсон байна.

Сүүлийн 10 жилд нийслэлд болон аймгуудад бүртгэсэн гэмт хэргийн нийлбэрээс дундачилж тооцоход, нийслэлийн дундаж 18979, орон нутгийн дундаж 4604 гэмт хэрэг байна.

График 18. Нийслэлийн хэмжээнд бүртгэсэн гэмт хэрэг. (2010-2019 он)



Энэ графикаас үзвэл, сүүлийн 10 жилд нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт хамгийн олон гэмт хэрэг бүртгэсэн бол алслагдсан Багахангай, Багануур, Налайх дүүрэгт хамгийн цөөн гэмт хэрэг бүртгэжээ.

График 19. Аймгуудад бүртгэсэн гэмт хэрэг. (2010-2019 он)



Сүүлийн 10 жилийн хугацаанд Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Хөвсгөл, Орхон аймагт хамгийн олон гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд эдгээр 5 аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн нийлбэр орон нутагт бүртгэсэн нийт гэмт хэргийн 36.5%-ийг эзэлж байна.

Энэ хугацаанд Говьсүмбэр, Говь-Алтай, Дундговь, Завхан, Сүхбаатар аймагт хамгийн цөөн гэмт хэрэг бүртгэгдсэн нь орон нутагт бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 12.2%-ийг эзэлж байна.


Хүснэгт 6. Бүртгэсэн гэмт хэрэг нутаг дэвсгэрээр (2010-2019 он)

Д/д	Нутаг дэвсгэр	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
1	Архангай	458	385	418	437	469	512	536	514	519	568
2	Баян-Өлгий	378	345	467	349	287	279	281	319	318	306
3	Баянхонгор	436	347	336	431	430	360	356	563	581	642
4	Булган	243	249	300	387	352	295	265	362	344	459
5	Говь-Алтай	174	148	169	189	199	210	183	200	203	235
6	Говьсүмбэр	119	119	160	179	211	211	207	171	176	154
7	Дархан-Уул	614	557	619	754	888	792	675	768	818	803
8	Дорноговь	534	546	582	559	527	561	665	654	517	550
9	Дорнод	526	413	578	751	566	529	482	582	602	605
10	Дундговь	231	206	201	284	260	242	221	216	266	211
11	Завхан	294	320	354	300	312	225	259	221	235	247
12	Орхон	516	481	545	583	569	566	528	881	794	747
13	Өвөрхангай	439	473	545	519	492	542	508	492	670	613
14	Өмнөговь	314	323	358	421	429	396	409	462	429	515
15	Сүхбаатар	190	183	207	312	322	317	319	338	366	525

16	Сэлэнгэ	797	618	704	679	755	793	669	729	779	767
17	Төв	625	671	772	922	955	863	812	810	779	865
18	Увс	389	363	306	334	361	372	322	356	332	327
19	Ховд	295	281	271	366	357	498	398	433	363	481
20	Хөвсгөл	419	485	504	555	730	756	707	749	787	743
21	Хэнтий	670	727	631	429	578	460	420	453	626	841
22	Нийслэл	10863	10773	12910	15419	17144	17939	17909	21947	25652	20261
23	Баянгол	1938	2009	2372	2521	2775	2951	3137	3204	4501	2834
24	Баянзүрх	2188	2137	2739	3742	4263	4272	4218	5939	7522	5465
25	Сүхбаатар	1639	1643	2102	2416	2593	3085	2962	3816	4132	3283
26	Сонгинохайрхан	2081	1923	2127	2778	3039	3232	2811	3691	3692	3470
27	Хан-Уул	1090	1121	1175	1236	1484	1390	1639	1900	2332	2055
28	Чингэлтэй	1360	1469	1807	2115	2392	2254	2337	2719	2776	2642
29	Багануур	251	218	278	278	236	311	293	254	253	167
30	Багахангай	14	11	20	31	23	21	23	31	24	14
31	Налайх	302	242	290	302	339	423	489	393	420	331
32	ИАТ	14	11	13	82	11	10	10	4	5	12
33	Төмөр зам	144	122	99	89	98	90	92	82	53	49
34	Бусад	143	51	40	32	16	39	36	39	64	59
35	Улсын хэмжээнд	19825	19197	22089	25362	27318	27757	27167	32259	36220	31524

Сүүлийн 10 жилд бүртгэсэн гэмт хэргийн бүтцийг авч үзвэл, 49.7%-ийг өмчлөх эрхийн эсрэг, 30.3%-ийг хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг, 20%-ийг бусад төрлийн гэмт хэрэг эзэлж байна.

График 20. Улсын хэмжээнд бүртгэсэн гэмт хэргийн бүтэц (2010-2019 он)



Бүртгэсэн гэмт хэргийн бүтцийг Эрүүгийн хуулийн бүлгээр нь авч үзвэл, нийт хэргийн 133634 буюу 49.7%-ийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байна. 2002 оны Эрүүгийн хуулийн (2010-2017 он) өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг /145-155/ 92825 буюу тухайн хуулиар бүртгэсэн нийт хэргийн 46.2%, хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг /91-107/ 63975 буюу 31.8%-ийг, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг

гэмт хэрэг /215-225/ 15117 буюу 7.5%-ийг, 2015 оны Эрүүгийн хуулийн (2018-2019 он) өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 40809 буюу тухайн хуулиар бүртгэсэн нийт хэргийн 60.2%, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 17399 буюу 25.7%-ийг, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2507 буюу 3.7%-ийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 7. Бүртгэсэн гэмт хэргийн төрөл (2002 оны Эрүүгийн хууль)

№	Гэмт хэргийн төрөл	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
1	Үндэсний аюулгүй байдлын эсрэг 79-90	118	96	138	54	45	10	36	34
2	Хүний амьд явах эрхийн эсрэг 91-107	6813	6462	7155	8156	8697	8468	8691	9533
3	Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг 108-113	35	26	46	55	49	57	44	71
4	Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг 114-129	410	434	405	425	397	383	384	573
5	Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг 130-144	63	72	126	124	144	141	116	29
6	Өмчлөх эрхийн эсрэг 145-155	7944	7232	9023	11118	12551	13445	13336	18176
7	Аж ахуйн эсрэг 156-176	158	115	185	234	426	520	227	287
8	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг 177-191	1684	1873	1749	1894	1750	1630	1479	745
9	Хүн амын эрүүл мэндийн эсрэг 192-201	328	261	295	318	303	341	416	324
10	Байгаль хамгаалах журмын эсрэг 202-214	231	270	410	337	287	228	165	330
11	ТХХАБАЖ-ын эсрэг 215-225	1639	1870	1999	2148	2143	2010	1783	1525
12	Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг 226-229	3			1	13	9	10	44
13	Зохиргааны журмын эсрэг 230-244	228	280	332	278	249	269	268	262
14	Шүүн таслах ажиллагааны эсрэг 245-262	57	96	100	104	118	106	91	125
15	Албан тушаалын 263-273	101	101	110	106	135	128	111	150
16	Цэргийн албаны эсрэг 274-296	13	9	16	10	11	12	10	5
17	Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энх тайваны эсрэг 297-304								
18	Бусад								46
19	Нийт	19825	19197	22089	25362	27318	27757	27167	32259

Хүснэгт 8. Бүртгэсэн гэмт хэргийн төрөл. (2015 оны Эрүүгийн хууль)

№	Гэмт хэргийн төрөл	2018	2019
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	714	636
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	9134	8265
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	621	610
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	115	115
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	6	3
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	33	39
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	21	31
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	22468	18341

9	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	242	247
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	99	29
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	314	333
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	196	172
13	Авлигын эсрэг гэмт хэрэг	362	523
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	237	341
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг	366	489
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	3	5
17	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	42	57
18	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	1231	1276
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	15	12
20	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайваны эсрэг гэмт хэрэг	1	
	Нийт	36220	31524

Сүүлийн 10 жилийн нийлбэр дүнгээр, нийт гэмт хэргийн 49.7%-ийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 30.3%-ийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд энэ 2 төрлийн гэмт хэрэг нийт гэмт хэргийн 80.3%-ийг эзэлж байгаа нь 2019 онд нийт гэмт хэргийн 84.4%-ийг эзэлж байгаа үзүүлэлттэй ойролцоо байгаад үндэслэн манай улсын гэмт хэргийн бүтцэд Эрүүгийн хуулийн дээрх 2 бүлэгт заасан гэмт хэрэг үнэлэмлэхүй олонхи хувийг эзэлсээр байна гэж дүгнэхээр байна.


Гэмт хэргийн төрлөөр авч үзвэл, нийт бүртгэсэн хэргийн 85370 буюу 31.8%-ийг хулгайлах, 76411 буюу 28.4%-ийг бусдын биед гэмтэл учруулах, 22878 буюу 8.5%-ийг залилах, 7523 буюу 2.8 хувийг дээрэмдэх төрлийн гэмт хэрэг түлхүү үйлдэгдсэн бол хүнийг алах гэмт хэрэг 2094 буюу 0.8%-ийг, хүчиндэх гэмт хэрэг 3603 буюу 1.3%-ийг, танхайрах гэмт хэрэг 12509 буюу 4.7%-ийг, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэрэг 945 буюу 0.4%-ийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 9. Бүртгэсэн гэмт хэргийн зарим төрөл. (2010-2019 он)

№	Гэмт хэргийн зарим төрөл	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
1	Хүнийг санаатай алах	230	262	231	204	211	204	174	189	192	197
2	Бусдын бие махбодид гэмтэл учруулах	5817	5836	6542	7560	8133	8064	8248	8812	9134	8265
3	Хүчиндэх	342	367	305	344	300	279	290	376	519	481
4	Хулгайлах	5775	5274	6265	7881	8423	9169	9065	12222	12328	8968
5	Дээрэмдэх	520	536	552	620	686	537	474	1233	1497	868
6	Залилах	764	688	1098	1231	1843	2067	2165	2996	5358	4668
7	Танхайрах	1633	1824	1687	1839	1681	1582	1449	727	58	29
8	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах	20	11	75	32	54	72	101	128	195	257


Гэмт хэргийн бүрэлдэхүүний зарим шинжээр нь авч үзвэл, нийт гэмт хэргийн 18.7% нь согтуугаар, 19.7% нь гудамж талбайд, 13.4% нь олон нийтийн газарт, 31.9% нь гэр, орон сууцанд үйлдсэн байна.

График 21. Гэмт хэргийн бүрэлдэхүүний зарим шинж (2010-2019 он)



Сүүлийн 10 жилийн хугацаанд бүртгэсэн нийт гэмт хэргийн 150847 буюу 56.1% нь хөнгөн, 33559 буюу 12.5% нь хүнд, 80654 буюу 30.0% нь хүндэвтэр, 3658 буюу 1.4% нь онц хүнд гэмт хэрэг байна.

График 22. Бүртгэсэн гэмт хэргийн ангилал (2010-2019 он)




Тайлбар: 2015 оны Эрүүгийн хуульд гэмт хэргийг "хөнгөн", "хүнд" гэсэн хоёр ангилалтай байхаар тусгасан болно.

Монгол Улсад 1986-2019 онд бүртгэсэн гэмт хэргийн төлөв байдлын тойм

Манай улс 1967 оноос гэмт хэргийн тоо бүртгэлийг нэгтгэн хөтөлж эхэлсэн. 1968 онд улсын хэмжээнд 3436 гэмт хэрэг бүртгэж байсныг 2019 онд бүртгэсэн 31524 гэмт хэргийн тоотой харьцуулахад 9.2 дахин өсжээ³.

График 23. Монгол Улсад бүртгэсэн гэмт хэрэг. (1968-2019 он)



Гэмт хэргийн тоо чөлөөт зах зээлийн нийгэмд шилжих шилжилтийн эхэн үеэс огцом нэмэгдэж, улсын хэмжээнд бүртгэсэн гэмт хэргийн тоо 1992 онд 12467, 1997 онд 24657 болж өссөн байх ба 2002-2005 онд гэмт хэргийн тоо өмнөх жилүүдийнхээс буурч, 2007 оноос хойш ерөнхийдөө өсөх хандлагатай явж иржээ.

Дүгнэлт

1. Монгол Улсад 2019 онд нийт 31524 гэмт хэрэг бүртгэсэн нь 2018 оноос 13%-иар буурчээ. Энэ нь сүүлийн 3 жилд гэмт хэргийн статистикт гарч байгаа анхны эерэг үзүүлэлт бөгөөд 2019 онд бүртгэсэн гэмт хэргийн тоо 2017 онд бүртгэсэн гэмт хэргийн тооноос бага болсон байна.

2. Бүртгэсэн гэмт хэрэг улсын хэмжээнд 13%-иар, нийслэлд 21%-иар тус тус буурсан бол орон нутагт бүртгэсэн гэмт хэрэг 700-аар буюу 6.7%-иар өсчээ. Засаг захиргааны нэгжээр авч үзвэл, гэмт хэрэг 12 аймагт 0.5-43.4%-иар өсч, 9 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт 1.5-41.7%-иар буурсан байна.

3. Нутаг дэвсгэрийн хувьд авч үзвэл, нийт гэмт хэргийн 64.3%-ийг нийслэл Улаанбаатар хотод, 35.5%-ийг аймгуудад үйлдсэн бөгөөд тархацын энэ төлөв байдал олон жилийн хугацаанд хадгалагдаж иржээ. Нийслэлд бүртгэсэн гэмт хэргийн улсын хэмжээнд бүртгэсэн гэмт хэрэгт эзлэх хувь сүүлийн 10 жилийн хугацаанд тогтмол өндөр буюу 54.8-70.8% байсан байна.

4. Гэмт хэргийн түвшинг авч үзвэл, 2019 онд 16 ба түүнээс насны 10000 хүн амд ногдох гэмт хэрэг улсын хэмжээнд 147, нийслэлд 208, орон нутагт 95 байгаа нь 2018 оноос улсын хэмжээнд 22, нийслэлд 55-аар буурч, орон нутагт 5 нэгжээр өссөн байна.

5. 2019 онд улсын хэмжээнд бүртгэсэн гэмт хэргийн бүтцийг Эрүүгийн хуулийн бүлгээр авч үзвэл, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг нийт гэмт хэргийн 58.2%-ийг, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 26.2%-ийг тус тус эзэлж байна. Эрүүгийн хуулийн энэ 2 бүлэгт заасан гэмт хэрэг улсын хэмжээнд бүртгэсэн нийт гэмт хэргийн 80 ба түүнээс дээш хувийг тогтмол эзэлж ирсэн статистикаас үзвэл, манай улсад бүртгэж буй 10 гэмт хэрэг тутмын 5-6 нь өмчлөх эрхэд халдсан шунахайн сэдэлтэй, 2-3 нь бусдын бие эрүүл мэндэд халдсан танхайн сэдэлтэй гэмт хэрэг байна.

6. Гэмт хэрэг үйлдэгсдийн талаарх статистик мэдээлэлд тулгуурлан “өнөөгийн монгол гэмт хэрэгтэн”-ий ерөнхий дүр төрхийг тодорхойлбол: 86.6% нь эрэгтэйчүүд, 13.4% нь эмэгтэйчүүд, 7.9% нь насанд хүрээгүйчүүд байх ба 62% нь 18-40 насны, 52.2% нь тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс, 35.2% нь ажилчин, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 3% нь төрийн албан хаагчид байна.

³ ЦЕГ-ын мэдээлэл, судалгаа.

7.2019 онд гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 57.1%-ийг эрэгтэйчүүд, 42.9%-ийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд нийт хохирсон 30782 иргэнээс 930 буюу 3% нь нас барж, 8727 буюу 28.3% нь гэмтжээ. Үлдэж буй 70-аад хувийг эзэлж байгаа иргэдийн дийлэнх нь эд хөрөнгөөрөө хохирчээ.

8.Шунахай болон танхай сэдэлтээр үйлдсэн гэмт хэрэг зонхилсон манай улсын өнөө үеийн гэмт хэргийн төлөв байдал, гэмт хэрэгтний болон хохирогчийн ерөнхий шинжийг нэгтгэн авч үзвэл, манай улсын гэмт хэрэгт нөлөөлж буй шалтгаан, нөхцлийг тодорхой харж болно. Хөдөлмөрлөхөөс өөр аргаар “юм олох” шунахай зорилготой, ажилгүй, ажилгүй учраас тогтмол орлоггүй, аль аль нь байхгүй учраас “завтай” идэр насны эрчүүд хулгайлах, дээрэмдэх, залилах, бусдын эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг зонхилон үйлдэж байна гэж дүгнэж болохоор байна.

9.Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагаас гаргаж буй гэмт хэрэгтэй холбоотой статистик мэдээллийн сангууд нь хоорондын уялдаа, нийцэл муутай, гэмт хэрэгт нөлөөлдөг хүчин зүйлс шалтгаан, нөхцлийг бодитой тодорхойлох шаардлагыг хангаж чадахгүй байна. Иймд гэмт хэргийн болон гэмт хэрэг үйлдэгч, гэмт хэргийн улмаас хохирогчийн талаарх мэдээллийг илүү дэлгэрэнгүй, аль болох нарийвчилсан байдлаар цуглуулан боловсруулж, тэдгээрт хийсэн судалгаа, дүн шинжилгээний ажлын үр дүнг гэмт хэрэгтэй тэмцэх ажилд ашиглаж байх нь чухал байна.

10.Улсын хэмжээнд гэмт хэргийн тоо буурахад манай хүн амын ихэнх хувь нь оршин сууж буй нийслэл Улаанбаатар хотод бүртгэсэн гэмт хэрэг 5391-ээр буюу 21%-иар буурсан нь шууд нөлөө үзүүлжээ. Мөн ГХУСАЗЗ, ЦЕГ-аас 2019 онд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч, иргэд, олон нийтийн оролцоо, дэмжлэгт түшиглэн тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр “Та сэргийлж чадна”, “Яг одоо”, “Залилан”, “Нэг хором”, “Ойлогое, Хүндэлье”, “Зөв тусгал”, “Яараад яахав дээ”, “Дураараа биш, дүрмээрээ” зэрэг арга хэмжээ, нөлөөллийн аяныг зохион байгуулсан нь иргэдийн хандлага, олон нийтийн сэтгэл зүйд нийцэж, бодитой эерэг нөлөө үзүүлсэн үр дүнтэй арга хэмжээ болж, гэмт хэргийн тоо буурахад нөлөөлжээ. 2019 онд зохион байгуулсан дээрх арга хэмжээний үр дүн нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой арга, хэлбэр, хэрэгслээр зохион байгуулсанаар иргэд, олон нийт ухамсартайгаар хүлээн авч, идэвхтэй оролцон дэмжих хандлагатай байгааг илтгэн харуулж байна.

11.Улсын хэмжээнд сүүлийн 10 жилийн хугацаанд (2009-2019 он) нийт 268718 гэмт хэрэг бүртгэсэн бөгөөд дундчилж авч үзвэл, жилд 26872, сард 2239, хоногт 74 гэмт хэрэг бүртгэсэн байна. Манай улсад бүртгэсэн гэмт хэрэг 2011 онд бага зэрэг буурсан, 2012-2013 онд жилд дунджаар 15%-иар өссөн, 2014-2016 онд харьцангуй тогтвортой нэг түвшинд байсан, 2017 онд 18.7%, 2018 онд 12.3%-иар тус тус өссөн, харин 2019 онд 13%-иар буурсан байна.

12.Сүүлийн 10 жилийн нийлбэр дүнгээр, нийт гэмт хэргийн 49.7%-ийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 30.3%-ийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд энэ 2 төрлийн гэмт хэрэг нийт гэмт хэргийн 80.3%-ийг эзэлж байгаа нь 2019 онд нийт гэмт хэргийн 84.4%-ийг эзэлж байгаа үзүүлэлттэй ойролцоо байгаагаас үзвэл, манай улсын гэмт хэргийн бүтцэд Эрүүгийн хуулийн дээрх 2 бүлэгт заасан гэмт хэрэг үнэлэмлэхүй олонхи хувийг эзэлж байна. Энэ 2 бүлэгт заасан гэмт хэргийг бууруулахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн арга хэмжээг үе шаттай, оновчтой төлөвлөн, бодитой хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллалав гэмт хэргийн тоо мэдэгдэхүйц буурах боломжтой.

Санал

1.Монгол Улсад хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагад бүртгэж буй гэмт хэргийн статистик мэдээллийн маягт, програм хангамжийг орчин үеийн мэдээллийн технологийн дэвшилтэд тулгуурлан боловсронгуй болгон, хоорондын уялдаа, нийцлийг хангаж, олон төрөл чиглэлээр судалгаа, дүн шинжилгээ хийх боломжтой болгох асуудлыг судалж шийдвэрлэх;

2.Нийслэл, аймаг, дүүргийн гэмт хэргийн эрсдэл, аюулгүй байдлын зэрэглэлийн түвшин, түүнд нөлөөлж буй эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн хүчин зүйлсийг харгалзан үзэж, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлогыг төлөвлөх, төсвийн хөрөнгө, хүн хүчний нөөцийг хуваарилахдаа анхаарах;

3.Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх нэгдсэн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, мөрдүүлэх;

4.Монгол Улсад үйлдэгдэж буй гэмт хэргийн дийлэнх хувийг эзэлж буй өмчлөх эрхийн эсрэг, хүний эрүүл мэндийн эсрэг, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг болон өнөөгийн байдлаар харьцангуй цөөн бүртгэгдэж байгаа боловч нийгмийн хор аюулаар их хар тамхи, мөнгө угаах, хүрээлэн байгаа орчны эсрэг, цахим гэмт хэргээс урьдчилан

сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгон ойрын 5, 10 жилд эдгээр гэмт хэргийн гаралт, түвшинг бууруулах үндэсний хэмжээний зорилтот хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;

6.Хүн амын төвлөрөл, хотжилтыг даган гэмт хэргийн гаралт ихсэж байгаа тул иргэдийн бүртгэлийг бодитой болгох чиглэлээр засаг захиргааны анхан шатны нэгжүүд, бүртгэл, хяналт, статистикийн байгууллага тодорхой ажил зохион байгуулж, энэ ажилд мэдээллийн технологийн өргөн боломжийг ашиглах;

7.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах төсөв, зардлыг нэмэгдүүлэх, иргэд, олон нийтийн оролцоо, дэмжлэгт тулгуурлах, үр дүнтэй болох нь батлагдсан урьдчилан сэргийлэх аян, арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн зохион байгуулах;

8.Гэмт хэрэг үйлдэгсдийн дунд голлох хувийг эзэлж буй тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс, малчин, хувийн хэвшлийн болон төрийн албан хаагч, оюутан залуус, насанд хүрээгүй хүмүүст чиглэсэн хэсэгчилсэн нийгэм, эдийн засаг, эрх зүй, боловсролын нөлөөллийн арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх;

9.Гэмт хэрэгтэн бие хүн, гэмт хэргийн хохирогчийн онцлогийг нарийвчлан судлах суурь судалгааны ажлыг бодлогын хэмжээнд дэмжиж, үр дүнг практикт тусган хэрэгжүүлэх /профайлинг/;

10.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар гэмт хэрэгт хохирох эрсдлийн судалгааг НҮБ-аас гаргасан аргачлалын дагуу хийдэг болох зэрэг саналыг дэвшүүлж байна.

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ҮНЭЛГЭЭ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Д.Булган

Хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор,
цагдаагийн дэд хурандаа

Б.Хулан

ДХИС-ийн Эрх зүй, Нийгмийн ухааны сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахлах дэслэгч

Товч агуулга: Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг олон төрөл, хэлбэрээр зохион байгуулж байна. Манай улс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үнэлгээний талаар 1997 оны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль заагаагүй, харин 2019 оны Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд үнэлгээ хийхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг тусгасан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэхдээ үйл ажиллагааны, нөлөөллийн, зардал-үр ашгийн үнэлгээний төрөлд авч үзэж байна. Одоогийн байдлаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд: үйл ажиллагааны үнэлгээний хэлбэрийг ашиглаж байна. Цаашид нөлөөллийн үнэлгээ болон зардал-үр ашгийн үнэлгээний дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд үнэлгээ хийхдээ төрөлжүүлэх нь зүйтэй.

Түлхүүр үг: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үнэлгээ, үйл ажиллагааны үнэлгээ, нөлөөллийн үнэлгээ, зардал-үр ашгийн үнэлгээ.

Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 7 дах хэсэгт Засгийн газар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журам бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээг авч, хэрэгжүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан. Мөн хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсын иргэн Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэнэ"⁴ гэж Монгол Улсын иргэний үндсэн үүрэгт заасан. Эндээс үзэхэд, төрийн үндсэн чиг үүргийн нэг нь иргэдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж хамгаалах, хууль зөрчигчдөд хариуцлага тооцох, хэрэг маргааныг шүүн таслан замаар нийгэмд шударга ёс, дэг журмыг тогтоох бол Монгол Улсын иргэн, хуулийн этгээд нь хууль тогтоомжийг чандлан сахиж, гэмт хэрэг, зөрчил гаргалгүй үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх ёстой байдаг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг 1997 онд анх баталж байсан бөгөөд түүнд 5 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан хэдий ч 20 гаруй жилийн хугацаанд зарчмын шинжтэй өөрчлөлт тусгагдаагүй бөгөөд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд үнэлгээ хийж, түүний үр нөлөөг тодорхойлох заалт байхгүй байсан. Харин 2019 онд УИХ-аас Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг 8 бүлэг, 48 зүйлтэйгээр баталсан бөгөөд хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг улсын хэмжээнд болон Салбар болон Дэд зөвлөл, төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллагын түвшинд гурван жилд нэгээс доошгүй удаа хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлж, үйл ажиллагаанд нь дүгнэлт хийнэ." гэж зааснаар "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн тайлан, мэдээ гаргах, түүнд дүн шинжилгээ хийх болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх"⁵ журмыг баталсан.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын "Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам" гэсэн гуравдугаар бүлгийн дотоод аюулгүй байдал гэсэн гарчигтэй 3 дах зүйлийн 3.3.4.4-т "Нийгэмд хууль ёс, дэг журам, сахилга, хариуцлага суларч эмх замбараагүй байдал бий болохоос сэргийлнэ", 3 дугаар бүлгийн 3.4-т "Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, ...гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн"⁶ гэж заасан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үзэл баримтлалыг тодорхойлжээ.

Дээрх хууль тогтоомжоос гадна гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагааг Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль⁷, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль⁸, Мал

⁴ Монгол Улсын Үндсэн хууль 1992 он, ТМ №01.

⁵ Засгийн газрын 2020 оны 192 дугаар тогтоол

⁶ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол

⁷ Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль. 1998, //Төрийн мэдээлэл, 1998, №1

хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль⁹, Авлигын эсрэг хууль¹⁰, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль¹¹, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль¹², Терроризмтой тэмцэх тухай хууль¹³ зэрэг 20 шахам хууль тогтоомж хэрэгжиж байгаа хэдий ч гэмт хэрэг, зөрчлийн тоо жилээс жилд нэмэгдэж байгааг статистик судалгаанаас харж болно.

Статистик үзүүлэлтээс харахад, гэмт хэргийн гаралт 2009-2011 онд 9.7%-иар буурсан; 2011-2016 онд 41.5%-иар өссөн; 2016-2018 онд 20 орчим хувиар өссөн; 2019, 2020 онд 31524 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2018 онтой харьцуулахад 13 хувиар буурсан боловч яг ижил байна.

Гэмт хэргийн өсөлт, бууралтын шалтгаан, нөхцөлийг судлаачид Эрүүгийн хуулийн хэрэгжилтэд хийсэн судалгаагаар мөрдөн шалгах ажиллагааны онцлогтой холбон тайлбарлажээ. Тухайлбал, судлаач Г.Оюунболд¹⁴ нийт 5092 хэрэгт эрүүгийн хэрэг бүртгэлт нээсэн, эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татсан гэмт хэргийн 1000 орчим нь буюу 20 хувь нь шинэ Эрүүгийн хууль тогтоомжоос, 2500 буюу 40 хувь нь гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгаж, шийдвэрлэх талаарх зохицуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор, 1500 орчим буюу 35 хувь нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, гэмт хэргээс зөрчил рүү харьяаллын дагуу шилжүүлэн шалгах болсонтой холбоотой гэж тайлбарлажээ.

Ийнхүү гэмт хэргийн өсөлт, бууралтад шинээр батлагдсан Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт болон бусад ямар шалтгаан, нөхцөл нөлөөлснийг бодитоор тогтоох, үнэлэх шаардлага зайлшгүй байгаа боловч гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрхэн нөлөөлж байгааг судлах зайлшгүй юм.

Сүүлийн жилүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх маш олон арга хэмжээг эрчимтэй авч хэрэгжүүлсэн нь гэмт хэргийн гаралтад нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй. Тухайлбал; "Яарад яахав дээ", "Unfriend хөдөлгөөн", "Ятгах тусам нягтал", "Яг одоо", "Хайр өвтгөдөггүй", "Ногоон дуу хоолой", "Ойлгоё хүндэлье", "Зөвийг түгээе" гэмт мэт цахим гэмт хэрэг, залилан мэхлэх, замын хөдөлгөөн, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Эндээс үзэхэд, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг онолын гаргалгаанд суурилуулж, эрх зүйн зохицуулалтын уялдаа холбоог сайжруулах, практик хэрэгжилтийг сайжруулах, оновчтой арга зүйд үндэслэн боловсронгуй болгох, үр нөлөөг нь дээшлүүлэх зайлшгүй юм. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг тодорхойлж гаргах гол арга нь урьдчилан сэргийлэх арга хэмжээг үнэлэх аргачлал байна.

Үндсэн хэсэг

Үнэлгээний тухай ойлголт:

Аливаа үнэлгээний мөн чанар нь онол болон хэмжигдэхүүн дээр суурилсан гол хүчин зүйлүүдээс хамааралтай байдаг.

Үнэлгээ гэдэг нь зарим үйл явдлын болон үйл ажиллагааны үр дүнг судлах явц юм. Тиймээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үнэлгээ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ашглагдах техникийн нөлөөллийг судалдаг. Ингэхийн тулд хэд хэдэн арга техникуудийг ашиглах шаардлагатай.



Үйл ажиллагааны үнэлгээ:

⁸ Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, 2000, //Төрийн мэдээлэл, 2000, № 6

⁹ Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн мэдээлэл, 2004, № 23

¹⁰ Авлигын эсрэг хууль. 2006, //Төрийн мэдээлэл, 2006, №35

¹¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016, //Төрийн мэдээлэл, 2017, № 5

¹² Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Терроризмтой тэмцэх тухай хууль

¹³ Терроризмтой тэмцэх тухай хууль

¹⁴ Г.Оюунболд. Эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэл гэмт хэргийн өсөлт, бууралтад нөлөөлсөн нь. судалгааны тайлан. 2019. <https://www.prokuror.mn/a/3396>

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны үе шатуудыг тодорхойлох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хэрэгжилтийг үйл ажиллагааны үнэлгээ гэнэ. Энэхүү үнэлгээ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд явагдаж буй нийгмийн хүчин зүйлсүүдийг шалгах үндэслэл болдог.

Үйл ажиллагааны үнэлгээ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хэрэгжилтийн дэлгэрэнгүй тайлан юм. Тухайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эхлэл үеэс одоогийн явагдаж буй үйл ажиллагаа болон эцсийн төгсгөл хүртэлх олон төрлийн хувьсагчдыг¹⁵ авч үздэг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд зохион байгуулсан уулзалтууд түүнд оролцсон агентлаг, байгууллага, иргэд, олон нийтийн тоо нь ерөнхий хувьсагчдын тоонд ордог. Эдгээр бүх мэдээллүүд нь төлөвлөөгөөний дагуу хэрэгжилтийг хэр амжилттай хийгдсэн болохыг дүгнэхэд ашиглагддаг. Ихэнх үнэлгээнүүд зөвхөн үйл ажиллагааг авч үздэг бөгөөд нөлөөллийн үнэлгээг авч үздэггүй байна. Тиймээс ямар үйл ажиллагаа хэрэгжиж хэр үр дүнтэй байсныг үнэлж болох ч гэмт хэрэгт болон гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд ямар нөлөөтэй байсныг үнэлэх боломжгүй байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын ерөнхий дүгнэлтэд үйл ажиллагааны үнэлгээ нь чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Үйл ажиллагааны үнэлгээ нь 100% амжилттай хийгдэх боломжтой яагаад гэвэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг ямар хугацаанд, хэдий хэмжээний төсөв хөрөнгө зарцуулж, хэр их хүмүүсийг оролцуулсан гэх мэт бусад хүчин зүйлүүдийг тайлагнадаг учраас нөлөөллийн үнэлгээнээс алгаатай нь, үйл ажиллагааны үнэлгээ нь үр дүнд нөлөөлөх олон мэдээллүүдийг олох¹⁶ боломжтой байдаг. Үйл ажиллагааны үнэлгээ нь нөлөөллийн үнэлгээтэй хамт байх ёстой юм.

Нөлөөллийн үнэлгээ:

Нөлөөллийн үнэлгээ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хэрэгжүүлсний дараа ямар өөрчлөлт гарч байгаад төвлөрдөг (гэмт хэргийн гаралт буурах г.м).

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд нөлөөллийн үнэлгээ хийх нь ганцхан хөндлөнгийн оролцоо, хандлагад тулгуурладаггүй¹⁷. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлууд нь янз бүрийн үйл ажиллагаанаас бүрдэж нэгэн цогц болдог.

Тухайн дүүргийн нутаг дэвсгэрт ажиглалт хийж оршин суугчдын гэмт хэргийн дуудлагын тоо болон нийт дүүргийн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо хэмжээнд суурилна. Гэмт хэргийн өөрчлөлтүүд нь замын хөдөлгөөний, явган хүний замын, барилгын загваруудын, оршин суугчдын байршиж буй орон сууцнуудын өөрчлөлтүүдээс хамаардаг.

Нөлөөллийн үнэлгээг хэрэгжүүлэхэд дараах асуудлууд тулгардаг.

- Хамгийн том асуудал нь нөлөөллийн үнэлгээ нь бараг хэзээ ч ганц аргачлал болон арга зүй дээр тогтдоггүй. Ихэвчлэн олон төрлийн үйл ажиллагааг багцалж түүнээс хэд хэдийг нэг дор сонгож хэрэгжүүлдэг.
- Өөрчлөлтийг бий болгохын тулд олон төрлийн үйл ажиллагаа хийснээр эсхүл зөвхөн нэг арга хэмжээ л өөрчлөлтийг авчирсан эсхүл хэд хэдэн арга хэмжээнүүдийн цогц нь гэмт хэргийн гаралтад эергээс нөлөөлсөн байж болзошгүй. Хоёрдахь шатны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үнэлгээний асуудал нь үнэлгээ авах нэгж нь дүүрэг өөрөө буюу бусад газар зүйн нэгжүүд юм.
- Тухайн дүүргийг дан ганцаар нь тусгаарлан авч үзэх боломжгүй. Гэмт хэрэгт нөлөөлж буй олон гадаад хүчин зүйлүүд болох хүрээлэн буй орчин болон бусад хөрш дүүргүүд үнэлгээ авч буй дүүрэгтэй нягт холбоотой байдаг.
- Дүүрэгт оршин суух нийт оршин суугчид болон газарзүйн хувьд бүх хэсгийг хамруулж чаддаггүй. Үр дүн нь үйл ажиллагаанд оролцсон хэсэг бүлэг хүмүүсийн хувьд л гэмт хэрэг буурч, бодит байдал дээр энэ нь нийт зорилтот дүүргийг хамруулж чаддаггүй байдаг. Тиймээс урьдчилсан сэргийлэх ажлын үр дүнтэй байдлыг нийтийг бүхэлд нь хамарсан байдлаас нь хамаарч дүгнэх хэрэгтэй юм.

Зардал-үр ашгийн үнэлгээ:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үнэлгээнд гарч болох зардал болон үр ашгийн хоорондын уялдаа холбоог судлах нь чухал юм. Хязгаарлагдмал нөөцийн хүрээнд засгийн газраас болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хамгийн бага зардлаар хүссэн үр дүнгээ гаргаж авах явдал юм.

¹⁵ Crime Prevention: Approaches, Practices, and Evaluations, Routledge, 2019. ProQuest Ebook Central.42

¹⁶ Crime Prevention: Approaches, Practices, and Evaluations, Routledge, 2019. ProQuest Ebook Central.43

¹⁷ <http://ebookcentral.proquest.com/lib/qut/detail.action?docID=5838693>.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүлээгдэж буй өөрчлөлтийг хийх чадварыг хэмжихгүй бол зардлыг үндэслэлтэй эсэхийг тодорхойлох боломжгүй юм. Тиймээс зардал-үр ашгийн үнэлгээ хийхэд үйл ажиллагааны болон нөлөөллийн үнэлгээ хоёулаа шаардагдана.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зардал-үр ашигт дүн шинжилгээ хийх нь эрүүгийн болон бусад салбаруудад тэр бүр тохиолддоггүй зарим бэрхшээлийг үүсгэдэг.¹⁸

Зардал-үр ашгийн үнэлгээг хийхэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхэд тоон хэмжээнд хөрвүүлэх боломжгүй хүчин зүйлүүдэд мөнгөн дүн тавих нь хамгийн том асуудал юм. Жишээлбэл; Хулгай, дээрмийн хэрэгт мөнгөн дүн тавихдаа урьд нь орсон хулгайд алдагдсан эд зүйлийн дундаж мөнгөн дүнг авч, урьдчилан сэргийлэх ажил хийснээр хулгай бүрийг тухайн мөнгөн дүнгээр хэмнэсэн гэж тооцож болно.

Дүгнэлт

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үнэлгээний эрх зүйн зохицуулалт болон онолын талаар судлан үзэхэд Монгол Улсын хувьд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг олон арга хэмжээгээр, өргөн хүрээтэй зохион байгуулан явуулж байгаа хэдий ч үнэлгээ, үр нөлөөг тодорхойлох талаарх судалгаа, эрдэм шинжилгээний ажил хомс байна.

Мөн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн зохицуулалт саяхнаас батлагдаж, түүний дагуу үр нөлөөг тодорхойлсон нь ховор байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд үнэлгээ хийх талаар шинэ хуулинд зааснаар "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн тайлан, мэдээ гаргах, түүнд дүн шинжилгээ хийх болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх"¹⁹ журам батлагдсан нь чухал ач холбогдолтой юм. Одоогийн байдлаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд үйл ажиллагааны үнэлгээний хэлбэрийг түлхүү ашиглаж байгаа нь ажиглагдаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг үнэлэхдээ үйл ажиллагааны, нөлөөллийн, зардал-үр ашгийн үнэлгээний төрлүүдэд ангилан үзэж, түүний дагуу үнэлгээний арга, аргачлал боловсруулах хэрэгцээ шаардлагатай байна. Цаашид нөлөөллийн үнэлгээ болон зардал-үр ашгийн үнэлгээний дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилдаа үнэлгээ хийхдээ төрөлжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Санал

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үнэлэхдээ нөлөөллийн үнэлгээ, зардал-үр ашгийн үнэлгээ хийх төрлүүдээр холбогдох журмуудыг боловсруулж, аргачлал гаргах.

Ном зүй

Хууль, тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он, ТМ №01
2. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль. 1998, //Төрийн мэдээлэл, 1998, №1
3. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, 2000, //Төрийн мэдээлэл, 2000, № 6
4. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль¹, Төрийн мэдээлэл, 2004, № 23
5. Авлигын эсрэг хууль. 2006, //Төрийн мэдээлэл, 2006, №35
6. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016, //Төрийн мэдээлэл, 2017, № 5
7. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Терроризмтой тэмцэх тухай хууль
8. Терроризмтой тэмцэх тухай хууль
9. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол
10. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 192 дугаар тогтоол

Эрдэм шинжилгээ, судалгааны ажил, тойм

1. Г.Оюунболд. Эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэл гэмт хэргийн өсөлт, бууралтад нөлөөлсөн нь" судалгааны тайлан. 2019
2. Crime Prevention : Approaches, Practices, and Evaluations, Routledge, 2019. ProQuest Ebook Central

Цахим холбоос

1. <https://www.prokuror.mn/a/3396>
2. <http://ebookcentral.proquest.com/lib/qut/detail.action?docID=5838693>.

¹⁸ <http://ebookcentral.proquest.com/lib/qut/detail.action?docID=5838693>.

¹⁹ Засгийн газрын 2020 оны 192 дугаар тогтоол

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ТААМАГЛАЛ АШИГЛАЖ БУЙ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

М.Хүрэлбаатар
ДХИС-ийн магистрант, цагдаагийн ахмад

Товч агуулга. Статистик судалгаанаас харахад, гэмт хэргийн гаралт 2009-2011 онд 9.7%-аар буурсан; 2011-2016 онд 41.5%-аар өссөн; 2016-2018 онд 20 орчим хувиар өссөн; 2019, 2020 онд 31524 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2018 онтой харьцуулахад 13 хувиар буурсан байна. Гэмт хэргийн өсөлт, бууралтад УИХ-аас шинээр баталсан Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт болон бусад ямар шалтгаан, нөхцөл нөлөөлснийг бодитоор тогтоох, үнэлэх шаардлага зайлшгүй байгаа боловч гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрхэн урьдчилан таамаглаж түүний нөлөөнд хэрхэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг онолд суурилуулж, эрх зүйн зохицуулалтын уялдаа холбоог сайжруулах, практик хэрэгжилтийг сайжруулах, оновчтой арга зүйд үндэслэн боловсронгуй болгох нь зайлшгүй юм.

Энэхүү өгүүлэлд цагдаагийн байгууллага, алба хаагчаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил явуулахад таамаглал ашиглаж буй өнөөгийн байдал, түүнийг тодорхойлох зорилгоор алба хаагчаас авсан судалгааны үр дүн болон судлаачийн хувьд дэвшүүлсэн саналыг талаар товч өгүүлсэн болно.

Түлхүүр үг. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, таамаглал, орчин нөхцөл, өнөөгийн байдал.

Үндсэн хэсэг. Гэмт хэргийн өсөлт, бууралтын шалтгаан нөхцөлийг судлаачид Эрүүгийн хуулийн хэрэгжилтэд хийсэн судалгаагаар мөрдөн шалгах ажиллагааны онцлогтой холбон тайлбарлажээ. Тухайлбал, судлаач Г.Оюунболд²⁰ нийт 5092 хэрэгт эрүүгийн хэрэг бүртгэлт нээсэн, эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татсан гэмт хэргийн 1000 орчим нь буюу 20 хувь нь шинэ Эрүүгийн хууль тогтоомжоос, 2500 буюу 40 хувь нь гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгаж, шийдвэрлэх талаарх зохицуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор, 1500 орчим буюу 35 хувь нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, гэмт хэргээс зөрчил рүү харьяаллын дагуу шилжүүлэн шалгах болсонтой холбоотой гэж тайлбарлажээ. Тиймээс цагдаагийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд таамаглал ашиглах онол, практикийн асуудлын өнөөгийн нөхцөл байдалд шинжилгээ хийж үзлээ.

Цагдаагийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд таамаглал ашиглаж буй өнөөгийн нөхцөл байдлыг төв, орон нутгийн 104 цагдаагийн албан хаагчдыг хамруулан авч дүгнэлээ. Судалгаанд оролцогчид 18-25 насны 11,5%, 26-30 насны 25% болон 31-35 насны 40,4%, 36-40 насны 13,5%, 41-45 насны 8,7%-г эзэлж хүйсийн хувьд 90,4% нь эрэгтэй, цагдаагийн байгууллагад ажилласан ажлын туршлагыг харахад 10-12 жил 17,3%, 13-15 жил 17,3%, 16-20 жил 15,4%, 21-с дээш 20,2% нь байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж байсан эсэхэд 83,7% нь тийм, 16,3% нь үгүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд "Таамаглал" дэвшүүлж байсан эсэхэд 51,9% тийм, 48,1% нь үгүй гэж хариулсан.

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ "Таамаглал" дэвшүүлэн ажиллах боломжтой юу гэсэн асуултад:




График №1

Цагдаагийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилдаа "таамаглал" ашиглах шаардлагатай юу?


График №2

²⁰ Оюунболд Г. Эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэл гэмт хэргийн өсөлт, бууралтад нөлөөлсөн нь" судалгааны тайлан. 2019 он. <https://www.prokuror.mn/a/3396>




Гэмт хэрэг, зөрчлийн чиг хандлага, цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг ямар арга хэлбэрээр явуулах нь үр дүнд хүрэх боломжтой талаар таамаглал дэвшүүлж, эрэн сурвалжлах ажиллагаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд, гэмт хэрэг илрүүлэхэд, малын хулгайн хэрэгт, гэмт хэрэг зөрчилд холбогдож байсан хүмүүсийг дахин гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй, гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсон байж болзошгүй гэдэгт, гэмт хэрэг, зөрчил үйлдэж байсан эмзэг цэг, объектын судалгаанд хамруулж ажилласны хүрээнд урьдчилан сэргийлж, хариуцсан хэсэгтээ таамаглал дэвшүүлсний дараа урьдчилан сэргийлэх ажлаа төлөвлөж явуулж, хаана гэмт хэрэг зөрчил үйлдэгдэж болох талаар таамаглал дэвшүүлж эргүүлийг чанартай зохион байгуулах, гэмт хэрэг илрүүлэхэд нотлох баримтыг үндэслэн, онолоор авсан мэдлэгээ ашиглаж, замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар арифметик тооцооллын аргаар бодсон дүн, практикт маш ойролцоо батлагдаж байсан гэх мэт таамаглалуудыг албан хаагчид маань ашиглаж байсан талаараа бичжээ.

График №3




Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд "таамаглал" ашиглах нь ач холбогдолтой юу гэсэн асуултад:

График №4



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд таамаглал ашиглах тухай хичээл, сургалтаар үзэж байсан уу?

График №5



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд таамаглал ашиглах чиглэлээр сургалт, судалгаа, мэдээлэл хэрэгтэй юу?





График №6

Дээрх асуултад ирүүлсэн хариултын үр дүнгээс харахад ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн сонсгогч нарт онолоор тодорхой мэдлэг олгох нь зүйтэй санагдлаа.

График №7



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд таамаглал ашиглах боломж бүрддэг үү? /Жишээ нь: Гэр бүлийн хүчирхийлэл/

График №8



Таны ажиллаж буй нутаг дэвсгэр дээр гэмт хэргийн таамаглал хийж, түүнд тулгуурлаж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байна уу?

График №9



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд таамаглалыг ямар хэлбэрээр явуулбал илүү үр дүнтэй байх талаар дараах саналыг ирүүлжээ. Тухайлбал:

Урьдчилан сэргийлэх ажлыг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулж ямар арга хэлбэрээр явуулбал үр дүнтэй байх талаар таамаглал дэвшүүлэх нь үр дүнтэй. Жишээ нь:

- Карентинд байх үед гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажлыг тв, интернэтээр илүү явуулах;
- арифметик тооцооллын аргаар, цаашлаад эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулж, шинэ төрлийн судалгаа явуулах;
- танхимын сургалтаар тогтмол орох шаардлагатай, тухайн цаг үетэйгээ уялдуулан оновчтойгоор урьдчилан харж, гэмт хэрэг илрүүлэх таамаглал, гэмт хэрэг зөрчлийн судалгаанд үндэслэн судалгааны дагуу хэрэгжүүлж ажиллах;
- гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах дахин гэмт хэрэг гаргахгүй байх чиглэлээр таамаглал дэвшүүлэх;
- судалгаа шинжилгээнд тулгуурлан оновчтой таамаглалыг дэвшүүлэх нь зүйтэй гэх мэт.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд таамаглал хийх ажиллагааг боловсронгуй болгох талаар дараах саналыг ирүүлжээ. Тухайлбал: Зөв баг бүрдүүлж ганц тоон судалгаа дээрээс дүгнэлт гаргах биш практикт ажиллаж байгаа хүмүүсээс нэмэлт мэдээлэл авах, таамаглал нь криминологийн ШУ-тай холбоотой тусдаа ШУ болж хөгжиж болох юм.

Үйлдэгдсэн зөрчил гэмт хэрэг дээр түлхүү ашиглах, гарч болзошгүй тодорхой төрлийн гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх таамаглах зорилгоор нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж байх, техник технологийг илүү ихээр хөгжүүлэх, таамаглал зөв байвал эзэнгүй хэрэг илрүүлэх ажиллагаанд чухал хэрэгтэй зүйл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ашиглах нь, ДХИС-н эрдэмтэн багш нарыг сардаа нэг удаа газар хэлтэс дээрээ урьж энэ талын сургалтыг орох, мөн ганц хоёр өдрөөр ажиллуулах, хамтын хүчээр нэг бодол нэг саналтай байх, сургалт дадлагаар, эдийн засгийн нөхцөл байдал хүнд үед хулгайн гэмт хэрэг өсч, зам тээврийн гэмт хэрэг буурдаг бол эдийн засаг сайжрахад эсрэгээрээ, таамаглал дэвшүүлэх боломжтой.

Дүгнэлт

Цагдаагийн албаны тухай хуульд оруулж өгөх хэрэгтэй, сургалт явуулах, таамаглалыг оновчтой орчин нөхцөлд зөв гаргах, төрийн алба хаагч нартай хамтарч ажиллах нь чухал, судалгааг бодитой өндөр түвшинд хийж тухайн цаг үе, байршилдаа тохируулах, судалгааг оновчтой болгосноор үр дүнд хүрэх, таамагаар биш тоон судалгаан дээр магадлалын онолоор ажиллавал зүгээр, гэмт хэрэг илрүүлэх таамаглал, багийн ажиллагаа сайжруулах, ажлын ачаалал тэнцвэртэй байлгах, тухайн орон нутагт нь ямар гэмт хэрэг гарч байгаад нь дүгнэлт хийж ажиллах хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, аймаг сум орон нутагт сургалт хийж алба хаагч нарт мэдлэг боловсрол дээшлүүлэх зорилго хэрэгжүүлж ажил болгох, сум, орон нутгийн хүн ам нийгэм эдийн засаг дэд бүтэц амьжиргаа ажилгүйдлийн түвшинг сайтар судалж байж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр таамаглал дэвшүүлэх нь зүйтэй.

Шинэ орчинг бүрдүүлэх талаар хандлагыг өөрчлөх талаар хэрэгжүүлэх, шинэлэг судалгааны ажил тул гадаадын улс орны туршлагыг МУ-ын онцлогт тохируулж судалгааг хийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ сайн байж учрах хохирол болон хүмүүсийн сэтгэл зүйн байдал бэлтгэгдэхэд ч давхар нөлөөлнө.

Санал

Цагдаагийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд таамаглал ашиглаж буй өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээний үр дүнд дараах саналуудыг дэвшүүлж байна.

Үүнд:

- Гадаадын улс орны туршлагыг Монгол Улсын онцлогт тохируулж судалгааг хийх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд нэн тэргүүнд гэр бүлийн хүчирхийллийг урьдчилан таамаглах ажлын хүрээнд судалгааг маш нарийн оновчтой хийснээр хийх хариу арга хэмжээг тодорхойлох, шинэ хөтөлбөр аяны арга хэмжээг зохион байгуулан турших;
- Цагдаагийн байгууллага таамаглалын төрлүүдийг оновчтой сонгон хэрэглэх хэрэгцээ шаардлага байна гэж үзэн таамаглалын тухай ойлголт, түүнийг хийх онолын аргачлалыг ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн хичээлийн хөтөлбөрт тусгуулах.

ХУУЛЬ БУСААР АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХ, ОЛБОРЛОХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

П.Очбадрах

БЗД дэх Цагдаагийн газрын дарга, ДХИС-ийн докторант,
цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийн нөхцөл байдал, манай улсад хууль бус ашигт малтмал олборлогчид бий болсон шалтгаан, нөхцлийн талаар товч дурдсан.

Түлхүүр үг: ашигт малтмал, хууль бусаар ашигт малтмал олборлогч, ченж, нөхөрлөл.

Дэлхий нийтэд тулгарч буй томоохон асуудлын нэг нь экологийн тэнцвэрт байдал алдагдах явдал бөгөөд энэ нь байгалийн давагдашгүй хүчин зүйлээс гадна ихэвчлэн хүний буруутай үйл ажиллагаанаас учирч байна. Ийм асуудлын нэг хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг. Үр дагавар нь байгаль сүйтгэгдэж, байгаль цаг уур, мал, ан амьтан, ургамалын төрөлд зүйлд өөрчлөлт орсоор байгаа төдийгүй иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчины бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх зөрчигдөх болжээ.

1990 оноос манай улсын эдийн засаг хямрах тусам эрх мэдэл, албан тушаалтай нэг нь хууль бусаар хөрөнгөжих, иргэд нь гэмт хэрэг үйлдэж амьжиргаагаа залгуулах болсон нь нууц биш ээ. Чухам энэ л үеэс албан бус буюу хувиараа ашигт малтмал олборлогчдын тоо эрчимтэй нэмэгдэж, 2010 он гэхэд зөвхөн хувиараа алт олборлогчдын тоо 90 мянгад хүрчээ. Тухайн жилд цаг агаарын тааламжгүй байдлаас 9.7 сая мал хорогдож, 12.1 мянган малчин өрх амьжиргааны эх үүсвэрээ алдаж, амьдрахын эрхэнд хууль бусаар ашигт малтмал олборлогчид болон хувирсан билээ.

Ийнхүү манай улсын хэмжээнд ашигт малтмалын төрлөөр дагнасан хууль бусаар ашигт малтмал олборлогчид олноор төрж үйл ажиллагаа тогтмол явуулж эхэлсэн төдийгүй ашигт малтмалын төрлөөр дагнасан бүлэглэлүүд үүссэн байна. Тухайлбал: Алт олборлогчид үндсэн орд бүхий газруудад төвлөрөн хувиараа алт олборлолт явуулж байгаа ба алт олборлогчдын тоо өвлийн улиралд 3000 орчим, зуны улиралд 6000 хүрдэг²¹ ба алт, нүүрс, жонш, үнэт чулуу, чулуужсан мод олборлогчид болон төрөлжиж, түгээмэл тархацтай ашигт малтмал, барилгын материал олборлолт нийслэл хот, аймгуудын газар нутагт олборлолт явуулж байна.

Гар аргаар ашигт малтмал олборлогчид бий болсноор олон хүн амжиргааны эх үүсвэртэй болж, амьдралын нөхцөл сайжирсан, орон нутагт бараа эргэлт, тээвэрлэлтийн сүлжээг нэмэгдүүлсэн зэргээр зах зээлийн эдийн засаг хөгжихөд түлхэц болсон ч орон нутгийн бэлчээр, өвөлжөө хаваржааг сүйтгэх, худаг ус, булаг шандыг бохирдуулах, хог хаягдлаар орчныг бохирдуулах, олборлолт хийсэн газар нөхөн сэргээлт хийдэггүй зэргээр байгаль орчинг сүйтгэсээр байгаагийн зэрэгцээ архидан согтуурах, танхайрах, зодолдох, хулгай, дээрэм, биеэ үнэлэх, хүний амь насыг хохироох гэхчилэн гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж орон нутагт ихээхэн хүндрэл бэрхшээлийг бий болгож байна. Мөн манай улсын хилийн бүс, зурваст гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага ашигт малтмал, газрын тос олборлох явдал эрс нэмэгдэж, гадаадын ажиллах хүч олноор байрлаж ажиллах болсон нь орон нутгийн ард иргэдийн дургүйцлийг төрүүлж гадны иргэд, байгууллагын үйл ажиллагааг саатуулах, зогсоох, нутгаасаа хөөхийн зэрэгцээ ард иргэдийн үзэл бодол, үйл ажиллагааг дэмждэг зохион байгуулалттай бүлэг, эвсэл, холбоо байгуулагдсан²² нь тэдний хоорондын маргаанаас үүдэлтэй мөргөлдөөн, зөрчил түүгээр ч барахгүй гэмт хэрэг үйлдэгдэх болсон нь үндэсний аюулгүй байдалд ноцтой аюул занал учруулж болзошгүй орон зайг үүсээд байна.²³

Ийнхүү хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг улс орны тулгамдсан асуудлуудын нэг болов.

Цагдаагийн ерөнхий газрын /цаашид ЦЕГ гэх/ Мэдээлэл, технологийн төвөөс жил бүр эрхлэн гаргадаг гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээнээс үзэхэд сүүлийн 5 жилд Эрүүгийн хуульд

²¹ Хувиараа алт олборлогчдын хөдөлмөр аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн судалгааны тойм. УБ., 2005

²² Д.Дашдаваа, Ц.Ганболд, А.Муратхан. Хилийн аюулгүй байдал. Нэг сэдэвт бүтээл. 2021. 92 дахь тал

²³ Ш.Арвай. Хилийн аюулгүй байдал, тулгамдаж байгаа асуудал, шийдвэрлэх арга зам.

Хилийн аюулгүй байдал. 2021. 233 дахь тал

заасан хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргүүдээс хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, хууль бусаар ан агнах, хууль бусаар мод бэлтгэх, байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх гэсэн 4 төрлийн гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэгдэж, нийт бүртгэгдсэн гэмт хэргийн **92.7** хувийг эзэлж байна. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг ЦБ-д бүртгэгдсэн нийт гэмт хэргийн дотор эзлэх жин нь их биш ч байгаль экологид учруулж байгаа хор уршиг нь ихээх. Энэ бол том гэмт явдлыг илэрхийлж буй өчүүхэн тоо юм.

Хүрээлэн байгаа орчны эсрэг нийт гэмт хэргийн **28%-ийг** (439) хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг эзэлж байна. Гэмт хэрэг үйлдэгдсэн байдлыг он дарааллаар авч үзвэл: 2015 онд 38, 2016 онд 35, 2017 онд 104, 2018 онд 126, 2019 онд 136 гэмт хэрэг үйлдэгдсэн нь энэ төрлийн гэмт хэрэг цаашид ч өсөх хандлагтайн илрэл юм.

Манай улсын 20 аймгийн 78 суманд 214 газарт хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явагдаж байна. Үндэсний статистикийн хороо, Мянганы сорилын сантай хамтран хийсэн судалгаагаар улсын хэмжээнд 60.0 мянга орчим хүн гар аргаар ашигт малтмалын нэгэн төрөл болох алтыг олборлож байгаа ба тэдгээрийн 38.0-39.0 мянга нь тогтмол, 20.0 мянга орчим нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг аж.

Тогтмол үйл ажиллагаа явуулдаг иргэд нь ихэвчлэн малчид байх бөгөөд цаг агаарын тааламжтай нөхцөлд мал өссөн үед тоо нь буурч байдаг бол, улирлын чанартай ажиллагаад нь эмч, багш, оюутан голчлон ажилладаг төдийгүй хятад улсын иргэд ч гар аргаар олборлолт явуулж байна.

2017 онд Эрүүгийн цагдаагийн эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх албаныхан гар аргаар алт олборлодог орон нутгийн харъяалалтай 10768 иргэн, хувиараа алт худалдан авах, борлуулах хэлбэрээр тогтмол идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 201 ченж байгааг тогтоожээ.²⁴

Орон нутагт алт худалдан авах үйл ажиллагааг Монгол банкны салбар арилжааны банкаар гүйцэтгүүлэх боломж тэр бүр байхгүй байгаа нь алтны “ченж” нарыг төрүүлэх үндсэн шалтгаан болсон байна.

2002 онд Үйлдвэр худалдааны яамнаас “Үйлдвэрлэлийн бус аргаар ашигт малтмал олборлох журам”²⁵ гаргаж хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг бүртгэлжүүлэх, зохион байгуулалтад оруулах, үйл ажиллагааг нь хууль ёсны болгох, олборлосон ашигт малтмалын борлуулалт, байгаль орчинд нөхөн сэргээлт хийх, татвар ногдуулах, эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа зэрэг асуудлуудыг зохицуулах оролдлого хийсэн ч амжилтанд хүрээгүй. Тиймээс 2017 онд Засгийн газрын 151 дүгээр тогтоол гарч гар аргаар ашигт малтмал олборлогчдыг нэгдсэн зохион байгуулалтанд орж “Нөхөрлөл” байгуулж үйл ажиллагаа явуулж болох тухай журам гаргасан билээ. Энэ журам үйлчилж эхэлснээс хойш улсын хэмжээнд 271 нөхөрлөл байгуулагдаж, “Нөхөрлөл” нэрийн доор байгаль орчинд нөхөн сэргээлт хийх үүргээ биелүүлэхгүй, хууль бусаар ашигт малтмал олборлох үйлдэл үргэлжлэн үйлдэгдсээр байна.

Эрдэнэсийг худалдан авах ажиллагааг ихэвчлэн Солонгос, Хятад улсын иргэд зохион байгуулж, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх оролдлого хийх нь элбэг байна. БНХАУ-ын иргэд алт, эрдэнийн чулуунаас гадна голын өнгөт чулуу, ердийн чулууг ч манай иргэдээр зөөлгүүлэх болсон байна.²⁶ БНХАУ-ын Эрээн хотод чулууны зах, хувийн алт мөнгөний дарханы газрууд олноор бий болон манай иргэдээс алт, үнэт чулуу, амьтаны гаралтай түүхий эд (хүдрийн заар, бугын эвэр, чив, сүүл, баавгайн сарвуу, доньд, бөхөнгийн эвэр, ирвэс, шилүүсний арьс, тарвага, чоно, үнэг, хэрэмний арьс, чонын мах г.м.), эмийн чанартай ургамал зэрэг дотооддоо эрэлт хэрэгцээ ихтэй, өндөр үнэтэй дээрх зүйлсийг өндөр үнээр худалдан авах, алт, үнэт чулууг засч чимэглэн үнэт эдлэл болгон нутгийн гүн рүү болон манай улс руу эргүүлэн явуулж худалддаг төдийгүй тэдний алт, үнэт чулуу худалдан авах үнэ нь манай дотоодод худалдах үнээс дээгүүр байгаа зэрэг нь ухамсар дорой, хялбар аргаар баяжих сонирхол бүхий манай иргэд өөрсдийн санаачлагаар болон хятад иргэдийн захиалгаар эрдэнэс болон байгалийн чулуулагийг зөөвөрлөхөд хүргэж байна.

БНХАУ-ын иргэд алт, үнэт чулуу, амьтаны гаралтай түүхий эд, ховор эмийн чанартай ургамалыг их хэмжээгээр худалдан авах зорилгоор манай иргэдэд урьдчилсан захиалга өгөх, өөрсдөө биечлэн ирж цуглуулах, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, манай иргэдээр захиалгат зүйлсийг цуглуулан улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэн зөөлгөхдөө хил, гаалын ажилтнуудыг хахуулдах үйлдлийг гаргаж байгаа бол, Солонгос улсын иргэд манай иргэдээс ихээхэн хэмжээний алт худалдан авч улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх үйлдэл, оролдлого тасралтгүй гарсаар байгаа билээ. Тухайлбал, 2010 онд Замын үүд боомтоор

²⁴ Эрүүгийн цагдаагийн газрын тайлан. 2018

²⁵ Үйлдвэрлэлийн бус аргаар ашигт малтмал олборлох түр журам. 2002

²⁶ Д.Мягмарсүрэн. Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэргийг гүйцэтгэх ажлаар илрүүлэх онол, практикийн зарим асуудал. Хууль зүйн магистрын зэрэг горилсон бүтээл. 2015.50 дахь тал

БНХАУ-ын иргэн "Х."А" нар нь 11.6 кг алтыг, 2015 онд манай улсын 1 иргэн нэг удаагийн үйлдлээр 724 кг улаан өнгийн чулууг хууль бусаар хил нэвтрүүлсэн, 2019 онд солонгос иргэн Буянт-Ухаа боомтоор 13 кг алтыг биедээ нууж гаргахаар завдсан зэрэг олон баримт бий.

БНХАУ сүүлийн жилүүдэд алт олборлолтоороо дэлхийд тэгүүлдэг ӨАБНУ-ыг ардаа орхин тэргүүлж байгаа бөгөөд энэ нь баялаг нөөцтэй том уурхайнуудаас бу, харин олон жижиг бичил уурхайнууд болон гаднаас хуль бусаар авч байгаа алтны хэмжээтэй холбоотой.²⁷

ЦЕГ-аас гаргасан гэмт хэргийн тухай мэдээнд сүүлийн 3 жилийн байдлаар улсын хэмжээнд эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлсэн 258 гэмт хэрэг бүртгэгдсэн²⁸ ба тэдгээрийн дотроос 71 хэрэг буюу 27.5 % нь төрөл бүрийн эрдэнэсийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн гэмт хэрэг эзэлж байна. Эндээс үзэхэд ашигт малтмалын нэгэн төрөл болох алтыг олборлох тушаах үед ч нэг бус гэмт хэрэг дагалдан үйлдэгддэг жишээ нь энэ юм.

Ийнхүү улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон эрдэнэсийг хууль бусаар нэвтрүүлж байгаа нь зөвхөн эдийн засгийн утгаараа аюултай төдийгүй улсын хилийн халдашгүй, дархан байдлыг алдагдуулж, Гаалийн хууль тогтоомжийг зөрчдөгт түүний нийгмийн аюул оршино.

Өнөөгийн байдлаар ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа тусгай зөвшөөрөлтэйгээр явуулахад техник, эдийн засгийн зардал өндөр, ашиг бага, хууль бусаар ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа явуулах нь аж ахуйн нэгжээс гарах зардал бага, ашиг их байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн гаралтад нөлөөлж, **"бага зардлаар их ашиг олох"** иргэдийн сонирхолыг төрүүлж байна. Тухайлбал, 2017 онд Эрүүгийн цагдаагийн албаны эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх тасгаас орон нутагт явуулсан судалгаагаар хайгуулын болон ашиглалтын зөвшөөрөлгүй 12 аж ахуйн нэгж 112.1 кг алтыг стандарт хэмжил зүйн газраар сорьцлуулан Монгол банкинд тушаасан, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй боловч олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй гэх 19 аж ахуйн нэгж 597.9 кг алтыг стандарт хэмжил зүйн газраар сорьцлуулан Монгол банкинд тушаасан, мөн стандарт хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын хэлтсээр 5603.9 кг алтанд сорьц тогтоолгосноос 55.5% (3039.6кг) нь л Монгол банкинд тушаагджээ.²⁹ Ашигт малтмал хайх, ашиглах, олборлох зөвшөөрөлтэй зарим компаниуд үйл ажиллагаа явуулах бичиг баримтын бүрдэл дутуу, гэрээлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд ашигт малтмал олборлох эрх үүсээгүй зэргээр шалтгаан өөрийн зөвшөөрөл бүхий талбайг түрээслүүлэх нь тэдэнд ашигтай төдийгүй ямар ч үйл ажиллагаа явуулахгүйгээр жилд дунджаар 1.500.000.000-3.000.000.000 төгрөгийн ашиг олж байна.³⁰

Хууль хяналтын байгууллагынхан, гааль, хил, банкны ажилтнууд ашигт малтмал хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх, хахууль авах,³¹ гэмт хэрэг шалгах явцад нөлөөлөх оролдлого хийх³² нь цөөнгүйн дээр хууль бусаар уурхай ажиллуулдаг байж болзошгүй³³ мэдээлэл ч байна. Тухайлбал, Өмнөговь аймгийн Гашуун сухайтын гаалын дарга 30 тн зэс, 1 тн байгалийн чулууг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлсэн, Монголбанкны ахлах нягтан бодогч "Ц" 8.5кг алтыг Буянт-Ухаа боомтоор хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан³⁴ гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Ашигт малтмал хайх, олборлох, ашиглах тусгай зөвшөөрөлгүй этгээд энэ үйл ажиллагаа явуулбал, эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуультай ч, хэрэгжилт тааруу, хяналтын тогтолцоо сул, албан тушаалтны тусгай зөвшөөрлийг зохих журмын дагуу олгодоггүй, аж ахуйн нэгж, иргэд хувийн эрх ашгийг хуулиас дээгүүр тавьдаг нь хууль зөрчигсдийг өөгшүүлж гэмт хэрэг үйлдэгдэх үндсэн шалтгаан болж байна. Ялангуяа алтны компаниуд байгаль орчныг ихээр сүйтгэж, нөхөн сэргээлт хийдэггүй, зөвхөн цаасан дээр нөхөн сэргээлт хийсэн, төчнөөн төгрөг зарцуулсан мэтээр тайлагнаж байхад хууль хяналтын байгууллагууд энэ талаар мэддэг хэрнээ дуугүй өнгөрдөг нь хууль зөрчигсөдтэй ямар эрх ашгаар холбогдоод байна уу гэсэн эргэлзэх сэтгэгдэл эрхгүй төрүүлж байна.

²⁷ Eurasian mining 2015. № 1

²⁸ ЦЕГ-ын цахим мэдээллийн сан.

²⁹ Ц.Эхбаатар. Улсын хилээр алт хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийг гүйцэтгэх ажлаар илрүүлэх онцлог. Магистрын зэрэг горилсон бүтээл. 2017. 33 дахь тал

³⁰ Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтсийн танилцуулга. 2018

³¹ 1802002720210 дугаартай хэрэг

³² 1802002970163 дугаартай хэрэг, 1802003770266 дугаартай хэрэг

³³ 1818005340348 дугаартай хэрэг

³⁴ Эрдэнэсийн нууц гүйцэтгэх ажлын мөрдөн тагнах хэрэг. I боть

ХАРЬЦУУЛСАН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ТАЙЛАНД УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ, ТОГТОЛЦОО, ОНЦЛОГ

Г.Гантөмөр
ДХИС-ийн Гэмт явдал судлалын профессорын багийн
тэргүүлэх профессор, доктор (Ph.D), профессор

Гадаад орнуудын эрүүгийн хууль тогтоомжийн харьцуулсан судалгааны ажлын хүрээнд бичсэн Азийн орнуудын Эрүүгийн хууль тогтоомжийн талаарх эрдэм шинжилгээний өгүүллийг та бүхэнд цувралаар хүргэж байгаа³⁵ бөгөөд энэ удаад Тайландын Вант улсын Эрүүгийн хуулийн талаарх мэдээллийг хүргэж байна.

Тайланд улсын тухайд товчхон³⁶

Энэ орныг 1939 он хүртэл олон улсад Сиам (тай хэл бичигт สยาม - Саяам) гэдгээр нь мэддэг байв. Герман хэлний Thailand «Тай нутаг» гэдгээс уламжлан 1930-аад оноос эхлэн тус улсыг дэлхий нийтэд Тайланд улс гэж нэрлэх болжээ. Тай хэлээр ประเทศไทย - Тай улс, Тай орон гэсэн утгыг илэрхийлнэ.

Газар зүйн байрлал: Тайланд улс нь Дорно өмнөд Азийн бүсийн төв хэсэгт, Энэтхэг-Хятадын хойг болон Малайн хойг дээр оршдог. Далайд гарцтай орон.

Газар нутгийн хэмжээ - 513 мянган км². Өрнө өмнөд талаараа Андаманы тэнгис, өмнөд талаараа Сиамын булан, Өмнөд Хятадын тэнгисээр хүрээлүүлсэн. Өрнө захаараа Мьянмар (хилийн урт - 1800 км), дорнод талаараа Лаос (1754 км), Камбож (803 км), өмнөдөөр Малайз (506 км) дөрөвтэй 4,863 км урт зурвасаар хиллэдэг.

Нийслэл нь Бангкок, **Хүн ам** - 67 сая.

Засаглалын хэлбэр: Тайланд нь бүрэн эрхт, хэмжээт эрхт хаант засагтай вант улс юм. 1932 оноос эхлэн 20 удаа үндсэн хууль, нэмэлт өөрчлөлтийг баталсан. 1932 оны Хана Ратсадони удирдсан хувьсгалаар цус урсгалгүйгээр хэмжээгүй эрхт хаант засгийг хэмжээт эрхт хаант засаг болгож, анхны Үндсэн хуулийг баталжээ. Өнөөгийн хаан Чакрийн угсааны 10-р Рама (Важирапонкорн) нь 2016 онд хаан ширээнд заларсан. Үндсэн хуулиар хааны эрх мэдэл хязгаарлагдмал, үндсэндээ бэлгэдлийн төрийн тэргүүн байна. Хаан нь зэвсэгт хүчний ерөнхий командлагч бөгөөд буддын шашинтны хувьд сүсэг бишрэлийн хамгаалагч юм. Хаан нь өв залгамжлагчаа томилох, хаан угсааныхны хэрэг явдлыг шийдэх, хаанд зөвлөх зөвлөгч нарыг томилох эрх үүрэгтэй. Хэдий тийм боловч улс оронд үймээн үүссэн тохиолдолд хаан улс төрийн үйл ажиллагаанд оролцсон тохиолдол цөөнгүй бий. Хааны гэр бүлийг доромжилсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх хуультай.

Төрийн байгууламж: Тайланд нь нэгдмэл улс. Нутаг дэвсгэр нь 76 аймаг (จังหวัด, changwat), 2 тусгай нутаг (Бангкок, Паттая) болон хуваагддаг. Аймаг нь сум (อำเภอ, amphoe), цаашлаад сум нь баг (ตำบล, tambons) болж хуваагдана.

Хууль тогтоох эрх мэдэл: Улсын хурал нь Сенат (150 суудалтай дээд танхим), Төлөөлөгчдийн танхим (350 суудалтай доод танхим) хоёроос бүрддэг. Сүүлийн сонгууль 2019 онд болсон. Өнөөгийн ерөнхий сайд, генерал Прают Чан-Очагийн тэргүүлдэг Ардын төрийн эрх намын толгойлсон эвсэл олонхийн суудал авсан.

Гүйцэтгэх эрх мэдэл: Гүйцэтгэх эрх мэдлийг Ерөнхий сайд тэргүүлнэ. Тайландын ерөнхий сайд болон бусад 35 хүртэлх тооны сайдыг Улсын хурлаас томилдог. Сайд нарыг Ерөнхий сайд нэр дэвшүүлж, Эзэн хаан зөвшөөрч баталдаг.

Шүүх эрх мэдэл: Шүүх байгууллага Улсын хурал болон Засгийн газраас тусдаа хараат бус байна.

Эрх зүйн тогтолцоо: Тус улсын эрх зүйн тогтолцоо холимог эрх зүйн бүлд хамаарах ба эх газрын, нийтийн эрх зүйн болон Тайландын өөрийн уламжлалт эрх зүй холилдсон өвөрмөц эрх зүйн тогтолцоотой.

³⁵“БНАСАУ-ын Эрүүгийн хууль, түүний онцлог” Гэмт явдалтай тэмцэх асуудал. ДХИС-ийн ЦС-ийн онол, арга зүйн сэтгүүлийн 2020 оны № 2-т 48-56 дэх талд, “БНСВУ-ын Эрүүгийн хууль, түүний онцлог” Гэмт явдалтай тэмцэх асуудал. ДХИС-ийн ЦС-ийн онол, арга зүйн сэтгүүлийн 2020 оны № 4-д 42-49 дэх талд тус тус хэвлэгдсэн.

³⁶ <https://mn.wikipedia.org> сайтаас авсан мэдээллийг ашигласан болно.

Шашин шүтлэг: Үндсэн хуулинд улсын албан ёсны шашин гэж заагаагүй, шашин шүтэх эрх чөлөөтэй. Тайланд шашны хувьд бараг нэгэн төрөл буюу Буддын шашны *теравада* урсгал хүн амын дунд 95% дэлгэрчээ. Тус улсын соёл, уламжлал, нийгмийн харилцаанд буддын шашны нөлөө гүн шингэсэн. Нэг шашинд итгэдэг хувиараа дэлхийд тэргүүлдэг. Харин үлдсэн хүн амын 4.3% нь лалын шүтлэгтэй нутгийн өмнөд хэсэгт орших малай хүмүүс юм. Хиндү, сикх шүтлэгтэй хот газар цөөн тоотой байдаг.

Улсын цаг тоолол нь Буддын тооллоор явдаг. Одоо дэлхий нийтэд Грегорианы тооллоор³⁷ 2021 он болж байгаа бол Тайландад Буддын шашны тооллоор 2564 он болж байна.

Гадаад харилцаа: Тайланд нь НҮБ зэрэг олон улсын байгууллагуудын бүрэн эрхт гишүүн юм. Дорно өмнөд Азийн АСЕАН-ийн гишүүн бөгөөд бусад бүс нутгийн орнуудтай нягт холбоотой ажилладаг.

Эдийн засаг. Тайланд нь шинээр аж үйлдвэржиж буй орон юм. 2017 онд худалдан авах чадвараар тэгшитгэсэн ДНБ нь 1 тэрбум 390 сая ам.доллар буюу нэг хүнд 20474 ам.доллар ноогдож байна. Нийт ДНБ-ний хэмжээгээр Зүүн Өмнөд Азид Индонезийн дараа 2-рт, дэлхийд 20-рт орж байгаа нөлөө бүхий эдийн засаг юм. Нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээгээр бүс нутагтаа Сингапур, Бруней, Малайзын дараа 4-рт орж байгаа ба 1986-1996 оны жилийн дундаж өсөлт 12.4% байжээ. Азийн санхүүгийн хямралын дараа буюу 2000 оноос хойших жилийн дундаж өсөлт 4-5% байна. Улс төрийн тогтворгүй байдал нь гадаадын хөрөнгө оруулалтыг буурахад нөлөөлжээ.

Тайланд улсын Эрүүгийн хууль, бүтэц, тогтолцоо, онцлог³⁸

Тайландын Вант улсад Буддын тооллын 2499 онд буюу 1955 оны 11-р сарын 13 өдөр батлагдаж, 1956 оны 1-р сарын 1-нээс үйлчилсэн Эрүүгийн хууль хэрэгжиж байна. Үүнээс өмнө Буддын тооллын 2451 онд буюу 1908 онд батлагдсан Эрүүгийн хууль үйлчилж байв.

Тайланд улсын 1955 оны Эрүүгийн хуульд 1959, 1969, 1971, 1976, 1979, 1982, 1983, 1987, 1992, 1994, 1997, 2001, 2006, 2011, 2013, 2017 онуудад зохих нэмэлт өөрчлөлт орсон.

Эрүүгийн хуулийн бүтэц: Тус улсын Эрүүгийн хууль нь 3 дэвтрээс /хэсгээс/ тогтоно. 1-р дэвтр нь *"Нийтлэг үндэслэл"* гэсэн нэртэй ба бидний мэддэг Ерөнхий ангийн үүрэг гүйцэтгэнэ. 2-р дэвтр нь *"Гэмт хэргүүд"* буюу хүнд гэмт хэргүүд, 3-р дэвтр нь *"Ялимгүй гэмт хэргүүд"* буюу хөнгөн гэмт хэрэг гэсэн нэртэй, эдгээр нь нийлж Тусгай анги болно³⁹.

Ерөнхий анги нь *"Хүнд гэмт хэргийн бүлэгт хамаарах хэм хэмжээнүүд"*, *"Хөнгөн гэмт хэргийн бүлэгт хамаарах хэм хэмжээнүүд"* гэсэн хоёр хэсгээс тогтоно.

Тус улсын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн үүрэг гүйцэтгэж буй 1-р дэвтр нь бүтцийн хувьд манай улсын эрүүгийн хуулиас өөр, эрүүгийн хуулийн зорилт, зарчим, гэмт хэргийн ойлголтыг тодорхойлж өгөөгүй байна.

Гэмт хэргийн ангилал. Гэмт хэргийн ангилалыг албан ёсоор хуульчилж өгөөгүй боловч Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн бүтцээс, хэсгийн нэрээс харвал гэмт хэргийг хүнд хэрэг, хөнгөн /ялимгүй/ гэмт хэрэг гэж ангилдаг болох нь харагдана.

Ерөнхий ангийн 2-р хэсгийн 102-р зүйлд зааснаар нэг сар хүртэл хугацаагаар хорих, 1000 хүртэл бат⁴⁰-аар торгохоор заасан хэргийг **хөнгөн /ялимгүй/ гэмт хэрэг** гэх ба бусад хэргүүд нь **хүнд гэмт хэрэгт** хамаарна.

Ерөнхий ангийн *"Хүнд гэмт хэргийн бүлэгт хамаарах хэм хэмжээнүүд"* гэсэн 1-р хэсгийн 1-р бүлэг нь *"Тодорхойлолт"* гэсэн нэртэй ба хуульд заасан *"Нийтийн зам"*, *"олон нийтийн газар"*, *"шөнийн цаг"*, *"оршин суугаа газар"*, *"зэвсэг"*, *"бичиг баримт"*, *"албан бичиг баримт"*, *"эрх зүйн бичиг баримт"*, *"гарын үсэг"*, *"хууль бус үйлдэл хийх"*, *"хүч хэрэглэсэн үйлдэл хийх"*, *"шударга бусаар эд хөрөнгө олж авах"*, *"худалдан авах"*, *"хорих ял"* гэх мэт эрүүгийн хуулийг хэрэглэхэд шаардлагатай, нийтлэг хэрэглэгддэг 13 нэр томьёоны тайлбарыг өгсөн байна.

"Эрүүгийн хуулийг хэрэглэх" гэсэн 2-р бүлгийн 2-16-р зүйлүүдэд эрүүгийн хуулийн үйлчлэх цаг хугацаа, нутаг дэвсгэр, хамаарах этгээдтэй холбоотой хэм хэмжээнүүдийг дэлхийн

³⁷Дэлхийд Грегорианы, Славяны, Жулианы, Жүдийн (еврейн), Исламын шашны, Буддын шашны (Тайландын), Дорнын (Хятад, Монгол г.м), Селтикийн, Майягийн гэсэн нийт арван цаг тоолол байдаг.

³⁸2005 онд оросын эрдэмтэн А.И.Комиссаров, Ю.В.Голик нарын орчуулсан, "Юридический Центр Пресс" хэвлэлийн газраас ОХУ-ын Санкт-Петербург хотод хэвлэн гаргасан тус улсын Эрүүгийн хууль болон бусад цахим материал ашиглан Тайланд улсын эрүүгийн хуулийн талаарх мэдээллийг оруулж байгаа болно. Г.Г.

³⁹Уголовный кодекс Таиланда. Перевод и научное редактирование А.И.Комиссарова и Ю.И.Голика. СПб. изд Юридический центр Пресс.2005. 200 с

⁴⁰ Бат нь Тайланд улсын үндэсний мөнгөн тэмдэгт ба Монгол банкны 2021 оны 4-р сарын 4-ний өдрийн албан ёсны ханшаар нэг бат нь 90 төгрөг 76 мөнгөтэй тэнцэж байна.

улс орнуудын жишигт нийцүүлэн хуульчилжээ. Тухайлбал 2-р зүйлд *“nulla poena sine lege”* буюу гэмт хэрэг үйлдэх үед үйлчилж буй эрүүгийн хуульд заагаагүй үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх зарчмыг хуульчилсан ба эрүүгийн хуулийн үйлчлэх иргэний харьяалалын, нутаг дэвсгэрийн болон онцгой зарчмууд, түүнчлэн эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх журмыг заасан байна.

Онцлог зохицуулалт гэвэл 9-р зүйлийн 1 дэх хэсэгт *“...Засгийн газрын албан тушаалтан Тайландын вант улсын хилийн гадна Эрүүгийн хуулийн 147-166-р зүйлүүд (албан тушаалын гэмт хэрэг), 200-205-р зүйлүүдэд (албан тушаалтнаас үйлдсэн шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг) заасан гэмт хэргүүдийг үйлдсэн бол тус улсын хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.”* гэж заасан явдал юм.

Ерөнхий анги болох 1-р дэвтрийн 3-р бүлэгт **“Хүнд гэмт хэрэгт оногдуулах ял болон аюулгүй болгох арга хэмжээ”**⁴¹-г хуульчилсан бөгөөд уг бүлэг нь дотроо 3 хэсгээс тогтоно.

“Ял” гэсэн 1-р хэсэг нь 18-37-р зүйлээс тогтох ба ялын төрлүүд, тодорхой төрлийн ялуудын төрөл, хэмжээ, тэдгээрийг оногдуулах журам, онцлогийг хуульчилсан байдаг.

Тус бүлгийн 18-р зүйлд зааснаас гэмт хэрэг үйлдсэн этгээдэд дараахь 5 төрлийн ялыг оногдуулна. Энэ нь:

1. Цаазаар авах
2. Хорих
3. Эрхийг хязгаарлах
4. Торгох
5. Эд хөрөнгө хураах болно.

Ялын дээрх төрлийг хуульчилсан боловч ялын ангилалыг хуульчилаагүй, ямар ялын төрлүүд нь үндсэн ял болох, ямар ялыг нэмэгдэл ял болгон оногдуулах талаарх зохицуулалт алга байна.

Цаазаар авах ялыг буудан алах замаар хэрэгжүүлнэ. /19-р зүйл/

Ямар гэмт хэргүүдэд цаазаар авах ял оногдуулах талаар Ерөнхий ангид зааж өгөөгүй боловч Тусгай ангиас түүж үзэхэд дараахь гэмт хэрэгт оногдуулахаар байна. Ийм гэмт хэрэгт *Эзэн хааныг алах, /107-р зүйл/, Эзэн хааны бие махбодид халдах /108-р зүйл/, Хатан хаан болон угсаа залгамжлагч - Хунтайжийг алах /109-р зүйл/, Үндсэн хуулийг өөрчлөх, төрийн эрэгт хийх зорилгоор хүч хэрэглэх, хуйвалдаан зохион байгуулах /113-р зүйл/, Зэвсэгт үймээн дэгдээх /119-р зүйл/, Улс орны газар нутгийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулах /120-р зүйл/, Тайланд улсын иргэн дайны үед дайсны талд урвах, дайсны талд орж өөрийн улсын эсрэг байлдах /121-р зүйл/, Дайн өдөөх, Тайланд улсын эсрэг дайн гаргахад гадаад улсад туслах /122-р зүйл/, Төрийн нууцыг задруулах /124-р зүйл/, Албан тушаалтан албан тушаалын байдлаа ашиглан их хэмжээний эд хөрөнгийг хууль бусаар авах /148-р зүйл/, Шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлж буй албан тушаалтан /мөрдөгч, прокурор, шүүгч/ хууль бус шан харамж авах, эд хөрөнгө нэхэх замаар хууль бус шийдвэр гаргах, /201-р зүйл/, Галдан шатаах, тэсэлж дэлбэлэх аргаар олон нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэх /218-р зүйл/, энэ үйлдлийн улмаас хүний ам нас хохироосон /224-р зүйл/, хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хүчиндэх гэмт хэрэг үйлдэх буюу уг хэргийн улмаас хүний ам нас хохироох /277-2-р зүйл/, Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдэх /хүний ам нас хохирсон/ /280-р зүйл/, 15 насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн, ёс бусаар бэлгийн дур хүслээ хангах /283-р зүйл/, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүнийг алах /289-р зүйл/, хөрөнгө мөнгө авах, ашиг олох зорилгоор 15-аас доош насны хүнийг хулгайлсан, барьцаалсан, эрхшээлдээ байлгасны улмаас хүний бие махбодид гэмтэл учирсан, хүний ам нас хохирсон /313-р зүйл/, Дээрэмдэх гэмт хэргийн улмаас хүний ам нас хохироох /339-2-р зүйл/ зэрэг хэргүүд хамаарна.*

Хорих ял: Хорих ялтай холбоотой хэм хэмжээ тус улсын Эрүүгийн хуулийн 20-23-р зүйлд хуульчиллагдсан ба хорих ялыг шоронд эдлүүлэх /18-р зүйл/, Эрүүгийн хуулийн тусгай ангид гэмт хэрэгт хорих ял эсвэл торгох ял оногдуулахаар заасан тохиолдолд шүүх өөрийн дотоод итгэлээрээ хорих ялыг оногдуулах нь зүйтэй гэж үзвэл уг ялыг оногдуулах /20-р зүйл/, хорих ялын хугацааг тоолох (эхлэх, дуусах) журмыг /21-22-р зүйл/ тогтоох явдлаар хязгаарлагдаж байна.

Хорих ялын талаарх ЭЗЗүйн зохицуулалт тус улсын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангид хангалтгүй байгаа нь хорих ялын төрөл, хугацааг нарийвчлан хуульчилж өгөөгүйгээс харагдана.

⁴¹ Эрүүгийн хариуцлагын албадлагын арга хэмжээ Г.Г

Эрүүгийн хуулийн Тусгай ангиас буюу тус улсын Эрүүгийн хуулийн 2-р хэсэгт заасан хүнд гэмт хэргүүд, 3-р хэсэгт заасан хөнгөн /ялимгүй/ гэмт хэргүүд, тэдгээрт оногдуулах хорих ялыг хуульчилсан байдлыг судлахад хорих ялын доод хэмжээ 1 өдөр, дээд хэмжээ 20 жил байна. Үүнийг тус улсын Эрүүгийн хуулийн “**Хөнгөн /ялимгүй/ гэмт хэргүүд**” гэсэн 3-р дэвтрийн 376-р зүйлд “...зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд хүн олноор суурьшсан, цугласан хот, тосгон болон бусад олон нийтийн газар галт зэвсгээр буудсан бол 10 хүртэл хоногоор хорих эсвэл 500 хүртэл батаар торгоно.”, Эрүүгийн хуулийн тусгай ангийн “**Хүнд гэмт хэргүүд**” гэсэн 2-р дэвтрийн 340-р зүйлд “...Бусдын эд хөрөнгийг бүлэглэн дээрэмдэхдээ бусдын бие махбодид гэмтэл учруулахаар галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэн үйлдсэн бол 15-20 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл бүх насаар хорих ял шийтгэнэ...” гэж зааснаас мэдэж болно.

Хэрэв гэмт этгээд хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн, рецидив гэмт хэрэгтэн гэмт хэрэг шинээр үйлдсэн бол ялуудыг нэмж оногдуулах ба энэ тохиолдолд хорих ялын 50 жилээс хэтэрч болохгүй. /51, 91-р зүйл/ Бас нэг анхаарал татсан зүйл бол Ерөнхий ангид хорих ялын төрлийн талаар заагаагүй боловч Тусгай ангийн зүйлүүдийн санкцыг судалж үзэхэд хорих ял нь хугацаатай болон хугацаагүй буюу бүх насаар хорих гэсэн 2 төрөлтэй болох нь харагдана. Үүнийг дээр дурьдсан 340-р зүйлийн санкц гэрчилж байна.

Бүх насаар хорих ял: Эзэн хааныг алахаар бэлтгэх /107-р зүйлийн 3 дахь зурвас^{42/} хэрэгт бүх насаар хорих ялыг дангаар хэрэглэхээр зааснаас гадна уг ялыг цаазаар авах ялтай хэрэгт шүүхээс сонгон хэрэглэх хэргүүд цөөнгүй байна. Ийм гэмт хэргийн тоонд Эзэн хааны амь насанд халдах /108-р зүйл/ Үндсэн хуулийг өөрчлөх, төрийн эргэлт хийх зорилгоор хүч хэрэглэх, хувьалдаан зохион байгуулах /113-р зүйл/, Зэвсэгт үймээн дэгдээх /119-р зүйл/, Улс орны газар нутгийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулах /120-р зүйл/, Тайланд улсын иргэн дайны үед дайсны талд урвах, дайсны талд орж өөрийн улсын эсрэг байлдах /121-р зүйл/, Дайн өдөөх, Тайланд улсын эсрэг дайн гаргахад гадаад улсад туслах /122-р зүйл/ Төрийн нууцыг задруулах /124-р зүйл/ гэмт хэргүүд багтана. Мөн хугацаатай хорих ялтай хамт сонгон хэрэглэхээр заасан нь цөөнгүй. Жишээ нь: Хатан хаан болон уесга залгамжлагч - Хунтайжийг бие махбодид халдах /110-р зүйл/ гэмт хэрэг болно.

Эрхийг хязгаарлах ял: Уг ял нь тус улсын Эрүүгийн хуулийн 24, 26-р зүйлүүдэд зааснаас үзэхэд ялтны оршин суугаа газар эсвэл түүнийг асрамж, хараа хяналтандаа авахыг зөвшөөрсөн этгээдийн оршин суугаа газарт, тодорхой дэглэм бүхий энэ ялыг эдлүүлэх зорилгоор байгуулсан байранд албадан байлган, өөрийнх нь урьд эрхэлж байсан ажлыг эсвэл шүүхээс тогтоосон ажлыг хийлгэх, сургуульд суралцуулах, шүүхээс тогтоосон эрхийг хязгаарлах, үүрэг хүлээлгэх албадлага хэрэглэх замаар хэрэгжүүлдэг ялын төрөл юм. Ямар тодорхой эрхийг хязгаарлах, үүрэг хүлээлгэх албадлага хэрэглэхийг уг зүйлд нарийвчлан зааж өгөөгүй, үүнийг тухай бүр шүүхээс шүүгдэгчийн үйлдсэн хэргийн онцлог, түүний хувийн зан байдлыг харгалзан тогтоох зохицуулалттай.

Хэрэв уг ялаар шийтгүүлсэн ялан хэрэв санхүүгийн боломжтой бөгөөд хүсэлт гаргасан бол өөрийн мөнгөөр гаднаас хоол хүнс авах, хувийн хувцас хэрэглэх эрхтэй. Мөн өдөрт нэг удаа нэг цагийн хугацаагаар гадны зочидтой уулзах, илгээмж авах, захиа бичих, илгээх зэрэг эрх эдэлнэ. /25-р зүйл/

Эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн этгээд шүүхээр тогтоосон эрхийг хязгаарлах, үүрэг хүлээлгэх албадлагыг биелүүлээгүй, ажиллаж, сурч байгаа байгууллагын дүрэм журмыг зөрчсөн, гэмт хэрэг үйлдэж шүүхээр хорих ялаар шийтгүүлсэн бол эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солино. Хэрэв шүүхээр тогтоосон эрхийг хязгаарлах, үүрэг хүлээлгэх албадлагыг биелүүлээгүй, ажиллаж сурч байгаа байгууллагын дүрэм журмыг зөрчсөний улмаас уг ялыг хорих ялаар сольж байгаа бол 27-р зүйлд зааснаар хорих ялын хэмжээ түүний анх шийтгүүлсэн эрхийг хязгаарлах ялын хугацаанаас илүү байж болохгүй. Хэрэв гэмт хэрэг үйлдэж шүүхээр хорих ялаар шийтгүүлсэн бол эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солиход Эрүүгийн хуулийн 91-р зүйлийг баримтлана.

Торгох ял: Тайланд улсад торгох ялыг мөнгөн хэлбэрээр оногдуулах ба эрүүгийн хуульд заасан хэмжээний батаар торгодог.

Торгох ялын хэмжээг Ерөнхий ангид зааж өгөөгүй ба Тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж торгох ялаар шийтгүүлсэн этгээд шүүхийн шийтгэх тогтоолд заасан хэмжээний батыг төлөх үүрэг хүлээнэ. /28-р зүйл/

Торгуулийг шүүхийн шийтгэх тогтоол гарсанаас хойш 30 хоногийн дотор төлөөгүй бол ялтны өмч, эд хөрөнгийг хурааж, албадан гаргуулна. Торгох ялаас санаатайгаар зайлсхийвэл

⁴²Тайланд улсын Эрүүгийн хуулийн Ерөнхий ба Тусгай ангийн зүйлд нь хэсгийг дугаарлаагүй, шууд догол мөрнөөс шинээр эхлэн бичсэн тул зурвас гэж нэрлэсэн болно. Г.Г

шүүхийн шийдвэрээр тодорхой хугацаагаар хорьж албадан торгуулийг төлүүлнэ. Торгуулийг төлөх эд хөрөнгөгүй бол уг ялыг хорих ялаар солино. /29-р зүйл/

Торгох ялыг хорих ялаар солихдоо торгох ялын 70 батыг нэг өдрийн хорих ялтай тэнцүүлэн солино. 40000 батаас доош хэмжээний торгуулийг хорих ялаас сольсон бол хорих ялын хэмжээ 1 жилээс, 40000 батаас дээш хэмжээний торгох ялыг хорих ялаар сольсон бол хорих ялын хэмжээ 2 жилээс хэтэрч болохгүй гэж 30-р зүйлд заасан.

Эд хөрөнгө хураах ял: Гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан, гэмт үйлдлийн замаар бий болгосон эд хөрөнгийг уг эд хөрөнгө хэний эд хөрөнгө эсэх, уг этгээд ял эдэлж байгаа эсэхээс үл хамааран хуульд заасны дагуу заавал хураана. /32-р зүйл/

Тус улсын Эрүүгийн хуулийн 35-р зүйлд зааснаар хураагдсан эд хөрөнгийг улсын орлого болгож төрийн өмчлөлд авах ба хэрэв хураагдсан эд хөрөнгө муудсан, цаашид ашиглах боломжгүй болсон бол шүүх устгах шийдвэр гаргана.

"Нийтлэг үндэслэл" гэсэн 1-р дэвтрийн "Хүнд гэмт хэрэгт оногдуулах ял болон аюулгүй болгох арга хэмжээ"-г хуульчилсан 3-р бүлгийн 2-р хэсэгт **"Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ"**⁴³-г хуульчилсан бөгөөд тэдгээрийн заримыг нэмэгдэл ялын шинж чанартайгаар хэрэглэдэг нь сонирхол татаж байна.

Тус улсын эрүүгийн хуулийн 39-р зүйлд зааснаар уг арга хэмжээ нь дараахь төрөлтэй.

1. Цөлөх,
2. Тодорхой нутаг дэвсгэрт суухыг хориглох,
3. Өр зээлийг төлөх үүргийг даалгах, эвийн гэрээ байгуулахыг /эвлэрэхийг/ даалгах,
4. Эмнэлгийн байгууллагад хяналтын дор байлгах /эмчлэх/,
5. Тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах зэрэг болно.

Цөлөх нь ялтныг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилсэн сэргийлэх, засан хүмүүжүүлэх, ажил хөдөлмөр хийж дахин шинээр амьдрах боломж олгох зорилгоор тодорхой нутагт тусгай хяналтын доор байлгахыг хэлнэ./40-р зүйл/ Цөлөх аюулгүй болгох арга хэмжээг хорих ялд нэмэлтээр оногдуулна. 17 насанд хүрээгүй хүнд цөлөх арга хэмжээг хэрэглэхгүй./41-р зүйл/

Тодорхой нутаг дэвсгэрт суухыг хориглох нь шүүхийн шийтгэх тогтоолд заасан тодорхой нутагт дэвсгэрт гэмт хэрэгтнийг оршин суухыг хориглох явдлаар хэрэгжих ба 1-5 жил хүртэл хугацаагаар оногдуулна. /44-45-р зүйл/

Өр, зээлийг төлөх үүргийг даалгах, эвийн гэрээ байгуулахыг /эвлэрэхийг/ даалгах гэдэг нь гэмт этгээдэд 2 жил хүртэл хугацаанд гэмт хэргийн улмаас учруулсан 5000 хүртэл батын хохирлыг төлөх, бусдад төлөх өр зээлийг төлөх, хохирогчтой эвлэрэхийг шүүх даалгахыг хэлнэ. Ингэхдээ уг этгээдээр амлалт, бичгээр баталгаа гаргуулна. Энэ арга хэмжээг гэмт хэрэг үйлдсэн 17 насанд хүрээгүй хүнд хэрэглэхгүй. /46-р зүйл/

Өр, зээлийг төлөх үүргийг даалгах, эвийн гэрээ байгуулахыг /эвлэрэхийг/ даалгах арга хэмжээг хэрэглэсэн этгээд үүргээ хугацаанд биелүүлээгүй, зайлсхийсэн бол шүүх уг арга хэмжээг өөрчилж 6 сар хүртэл хугацаагаар хорино.

Эмнэлгийн байгууллагад хяналтын дор байлгах /эмчлэх/. 48-р зүйлд гэмт хэрэг хэрэг үйлдэх үедээ сэтгэцийн өвчний улмаас ажиллагаагаа удирдах жолоодох бүрэн чадваргүй байсан, эсвэл тус улсын Эрүүгийн хуулийн 65-р зүйлд заасан хэсэгчилсэн хэрэг хариуцах чадвартай байсан хүнд тусгай хяналтын доор сэтгэцийн эмнэлэгт эмчлэх арга хэмжээ авна гэж хуульчилжээ.

Мөн хорих ял шийтгүүлсэн ялтан болон ял хойшлуулсан архаг архичин эсвэл мансууруулах бодис байнга хэрэглэдэг этгээдэд 2 жил хүртэл хугацаагаар эмнэлгийн байгууллагад хяналтын дор байлгах, эмчлэх арга хэмжээг давхар хэрэглэж болно. /49-р зүйл/

Тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах. Тус улсын Эрүүгийн хуулийн 50-р зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдэхдээ өөрийн албан тушаалын байдлаа ашигласан, эсвэл албан тушаал ахих /дэвших/-ын тулд гэмт хэрэг үйлдсэн бөгөөд шүүх уг этгээд албан тушаалын байдлаа дахин ашиглаж дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй гэж үзвэл ял оноохын зэрэгцээ албан тушаал хаших, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг 5 жил хүртэл хугацаагаар хасна.

Тайланд улсын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 3-р бүлгийн 3 дахь хэсгийн 51-58-р зүйлүүдэд **ял оногдуулах, ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх, ял хойшлуулах** талаар зохицуулалт бий.

51-р зүйлд гэмт этгээд хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн, рецидив гэмт хэрэгтэн гэмт хэрэг шинээр үйлдсэн тохиолдолд бол **ялыг хүндрүүлж оногдуулах** ба хэрэв үйлдсэн гэмт

⁴³ Үгчилэн орчуулбаас аюулгүй болгох арга хэмжээ гэсэн утгатай. Г.Г

хэргүүдэд нь хорих ял оногдуулахаар заасан бол хорих ялыг хүндрүүлж цаазаар авах ял, бүх насаар хорих, 50-аас дээш жилийн хугацаагаар хорих ял оногдуулж болохгүй гэж заажээ.

Харин гэмт этгээдийн үйлдсэн хүнд хэрэгт цаазаар авах ял оногдуулахаар заасан бөгөөд хэргийн нөхцөл байдал, гэмт этгээдийн хувийн зан байдал, бусад хөнгөрүүлэх нөхцөл байдал байвал уг **ялыг хөнгөрүүлж** хугацаагүй хорих, эсвэл 25-50 жилийн хорих ял оногдуулж болно. /52-р зүйл/

Хэрэв бүх насаар насаар хорих ял оногдуулахаар заасан хэрэгт уг ялыг хөнгөрүүлж 25-50 жилийн хугацаагаар хорих ял оногдуулж болох зохицуулалт 52-р зүйлд байна.

Хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх боломжтой, эсвэл хоёр жил хүртэл хорих ял оногдуулсан бол урьд нь ял шийтгүүлж байсан эсэх, түүний нас, зан төлөв, мэдлэг боловсрол, эрүүл мэндийн байдал, амьдралын туршлага, ажиллаж хөдөлмөрсөн байдал, байгуулсан гавьяа, бусад хөнгөрүүлэх нөхцөл байдлуудыг харгалзан, **ял оногдуулахийг хойшлуулах** эсвэл оногдуулсан **ялыг биечлэн эдлэхийг тэнсэж** болно. Ингэхдээ уг этгээдэд шүүхээс тогтоосон байгууллагын хараа хяналтанд байх, сурч боловсрох, ажиллах, мэргэжлийн болон дадал олгох сургалтанд хамрагдах, түүний зан төлөв, хүмүүжилд муугаар нөлөөлж болох тодорхой газар очих, орчинд орох, тодорхой хүмүүстэй уулзах, харьцахыг хориглох, архинаас гаргах, мансуурах дон болон бусад өвчнийг эмчлэх зорилгоор эмнэлгийн байгууллагад шилжүүлэх, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах арга хэмжээг авна. /56-р зүйл/

Хэрэв ял тэнсэгдсэн этгээд шүүхээс хэрэглэсэн дээрх эрхийн хязгаарлалт, үүргийг биелүүлээгүй бол ялыг биечлэн эдлүүлнэ. /57-р зүйл/

Ерөнхий ангийн 4-р бүлэг нь **“Эрүүгийн хариуцлага”** гэсэн нэртэй ба уг бүлэгт эрүүгийн хариуцлагын үндэслэл, гэм буруугийн асуудал *гэмт хэргийг санаатай болгоомжгүй үйлдэх гэм буруугийн андуурал*, эрүүгийн хариуцлага хүлээх нас, насанд хүрээгүй хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага, хэрэг хариуцах чадвартай байдал, гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлуудыг заажээ.

Эрүүгийн хуульд заасан гэмт үйлдлийг санаатай эсвэл болгоомжгүй үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр 59-р зүйлд заасны зэрэгцээ гэм буруугийн санаатай ба болгоомжгүй хэлбэрийг тодорхойлсон байна.

61-64-р зүйлүүдэд гэм буруугийн андуурал, түүний төрөл, тэдгээрт эрүүгийн хариуцлага хүлээлгэх журмыг хуульчилсан байдаг. 61-р зүйлд хэргийн нөхцөл байдлаас гэмт хэрэгтэн тодорхой нэг хүний эсрэг халдаж гэмт үйлдэл хийсэн боловч хохирогчийг үнэхээр андуурсан тогтоогдвол зөвтгөх үндэслэл болохгүй ба болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэнээр яллахаар, 62-р зүйлд тодорхой этгээд өөрийн үйлдэл, түүний улмаас учирах үр дагавар, түүний шинж, төрөл, хэмжээг буруугаар ойлгож андуурсан нь бодитой тогтоогдвол хэргийн нөхцөл байдлаас хамаарч гэм буруутайд тооцохгүй байх, эсвэл ялыг хөнгөрүүлж оногдуулахаар заасан бол 64-р зүйлд хууль зүйн андуурал, тухайлбал: хууль мэдэхгүй байх явдал нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүйг дурьдаад хэргийн нөхцөл байдлаас тодорхой этгээд өөрийн хийсэн үйлдлийг гэмт хэрэг болохыг үнэхээр мэдэлгүйгээр үйлдсэн гэдгээ өөрөө бодитойгоор, шүүгчид итгэл үнэмшил төрүүлэхүйцээр нотолсон бол шүүгч хуульд зааснаас хөнгөн ял оногдуулж болохоор заасан нь манай улсад ЭЗЗүйн шинжлэх ухаанд тодорхойлдог гэм буруугийн андуурлын онолын асуудлыг эрүүгийн хуулийн түвшинд хуульчлахад туршлага болохуйц зохицуулалт гэж судлаачийн хувьд үзэж байна.

65-р зүйлд **хэрэг хариуцах чадваргүй байдлыг** гэмт хэрэг үйлдсэн этгээд сэтгэцийн өвчин, оюуны хомсдол, сэтгэцийн үйл ажиллагааны эмгэг байдлаас болж өөрийн үйлдлийн мөн чанар, хууль бус байдал, сөрөг үр дагаврыг ойлгох, дүгнэлт өгөх, удирдах чадваргүй байвал түүнд ял оногдуулж болохгүй гэж тодорхойлсон нь манай улсын эрүүгийн хуулийн холбогдох хэм хэмжээтэй үндсэндээ ижил төстэй.

Харин 65-р зүйлийн 2 дахь зурваст *“...хэрэг хариуцах чадвартай байдлыг бүрэн үгүйсгэхгүй боловч гэмт хэрэг үйлдэх санаа бодол үүсэхэд болон гэмт үйлдэл, хор уршигт хандах сэтгэхүйн харьцаанд нөлөөлөхүйц сэтгэцийн эмгэг өөрчлөлтийн улмаас гэмт хэрэг үйлдсэн бол шүүх энэ нөхцөл байдлыг харгалзан хуульд зааснаас ялыг хөнгөрүүлж оногдуулж болно.”* гэж дэлхийн бусад орнуудын Эрүүгийн хуульд байдагтай ойролцоо байдлаар **“хязгаарагдмал хэрэг хариуцах чадвартай байдал”**-ын ойлголт, ял оногдуулах журмыг хуульчилсан нь манай улсын эрүүгийн хуультай харьцуулахад онцлог, шинэлэг зохицуулалт гэж үзэх бүрэн үндэстэй.

Согтууруулах ундааны зүйл эсвэл мансууруулах, донтуулах /токсичный/ бодис санаатай хэрэглэсэн бол хэрэг хариуцах чадвартай гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Хэрэв хэрэглэсэн бодисын талаар мэдлэггүйн улмаас эсвэл өөрөө мэдэлгүйгэр, эсвэл түүний хүсэл

зоригийн эсрэг дээрх бодисыг хүч хэрэглэн согтуурсан, мансуурсан байдалд оруулсаны улмаас гэмт хэрэг үйлдсэн бол ял оногдуулахгүй, эсвэл хуульд зааснаас ялыг хөнгөрүүлж оногдуулах заалт 66-р зүйлд байна.

Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал нь **гарцаагүй байдал** /67-р зүйл/, аргагүй хамгаалалт /68-р зүйл/, **тушаал, захирамж биелүүлэх** /70-р зүйл/ гэсэн 3 төрлөөр хязгаарлагдах ба тэдгээрийг манай улсын эрүүгийн хуулийн холбогдох хэм хэмжээтэй ойролцоо, ижил төстэй байдлаар хуульчилсан.

Тус улсын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангид насанд хүрээгүй хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагатай холбоотой хэм хэмжээ нь манай улсын эрүүгийн хуультай адил тусгай бүлэгт бус, **“Эрүүгийн хариуцлага”** гэсэн 4-р бүлэгт нийтлэг байдлаар хуульчигдсан олон улсын жишиг, хандлагад зарим талаар нийцэхгүй, түүнээс хоцорч байгааг харуулна. 73-р зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдсэн 7 насанд хүрээгүй хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй, ял оногдуулахгүй, аюулгүй болгох арга хэмжээ хэрэглэхгүй, харин 7-14 насны хүүхэд гэмт хэрэг үйлдвэл ял оногдуулахгүй боловч шүүх ийм насны хүүхдэд өөрт нь болон эцэг эх, асран хамгаалагчид сануулах, эцэг эх, асран хамгаалагчийг шүүхээс 1000 хүртэл батаар торгох, 3 жил хүртэл хугацаагаар эцэг эх, асран хамгаалагчийн хатуу хараа хяналтад өгч, тэднээс бичгээр баталгаа гаргуулах, хүүхэд хохирол учруулсан бол түүнийг эцэг эх, асран хамгаалагчаар төлүүлэх, хэрэв 14-17 насны хүүхэд гэмт хэрэг үйлдвэл үйлдсэн хэргийн төрөл, хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, гэм буруугаа ойлгож гэмшиж байгаа байдал зэргийг харгалзан шүүх ял оногдуулах эсэхийг шийдвэрлэнэ. Шүүх ял оногдуулах нь зүйтэй гэж үзвэл хуульд заасан ялыг хөнгөрүүлж оногдуулах ба ингэхдээ хэргийн нөхцөл байдлыг харгалзан Тусгай ангийн зүйлийн санхцад заасан ялын дээд хэмжээний гуравны хоёрыг эсвэл хоёрын нэгийг оногдуулах ёстой.

78-р зүйлд зааснаар эрүүгийн хариуцлага, **ялыг хөнгөрүүлэх нөхцөл байдалд** мэдлэг боловсролгүйн улмаас гэмт хэрэг үйлдсэн, өөрт нь болон гэр бүлд өвчин, гай зовлон тохиолдсон, гэмт хэрэг үйлдэхээс өмнөх байгуулсан гавьяа, үлгэр жишээ зан төлөв, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг сайн дураар нөхөн төлсөн, хохирогчтой эвлэрсэн, түүнд зохих тусламж үзүүлсэн, гэмт хэргээ төрийн зохих байгууллага, албан тушаалтанд илчлэн ирсэн, мөрдөн шалгах байгууллага, шүүхэд шаардлагатай мэдээлэл, нотлох баримтыг сайн дураар гаргаж өгсөн зэрэг хамаардаг.

“Нийтлэг үндэслэл” гэсэн Ерөнхий ангийн үүрэг гүйцэтгэдэг 1-р дэвтрийн 5-р бүлэг нь **“Завдалт”** гэсэн нэртэй. Уг бүлэгт завдалтын ойлголт, түүнд оногдуулах ялыг хуульчилсан байна. 80-р зүйлийн нэгдэх зурваст гэмт этгээд гэмт хэрэг үйлдэж эхэлсэн эсвэл үйлдсэн боловч түүнээс үл хамаарах шалтгаанаар хүссэн хор уршигаа учруулж чадаагүй бол гэмт хэрэгт завдсан гэж үзнэ гэж завдалтын ойлголтыг тодорхойлж, хоёрдахь зурваст гэмт хэрэгт завдсан бол тусгай ангид заасан ялын дээд хэмжээний гуравны хоёрыг оногдуулахаар заажээ.

Түүнчлэн уг бүлгийн 82-р зүйлд тогтоосноор гэмт хэрэг үйлдэхээс сайн дураар татгалзсан бол ял оногдуулахгүй, хэрэв ийнхүү татгалзахын өмнө хийсэн үйлдэл нь өөр гэмт хэргийн шинжийг агуулж байвал зөвхөн хэрэгт нь ял шийтгэнэ.

Ерөнхий ангийн 6-р бүлэгт гэмт хэрэгт хамтран оролцох институтыг хуульчилсан ба **“Гүйцэтгэгч, гэмт хэрэгт хамтран оролцогчид”** гэж уг бүлгийг нэрлэсэн ба ингэж нэрлэх ч шалтгаан бий. Учир нь тус улсын Эрүүгийн хуулиар гэмт хэрэг үйлдэхэд шууд оролцсон этгээдийг **гүйцэтгэгчид**, бусад байдлаар оролцсон бол этгээдүүдийг **гэмт хэрэгт хамтран оролцогчид** гэж үзнэ гэж заасан байдаг. /83-р зүйл/

Гэмт хэрэг хамтран оролцогчид хатгагчийг хамааруулж, 84-р зүйлд **“...Гэмт этгээдийг гэмт хэрэгт ажилд авах, хурч мэхлэх, гуйх замаар татан оролцуулсан, айлган сүрдүүлэх, хөлслөх, хөрөнгө мөнгө, эд зүйл өгнө, бусад дэмжлэг үзүүлнэ гэж амлах зэргээр гэмт хэрэг үйлдүүлсэн этгээдийг хатгагч гэнэ.”** гэж түүнийг ойлголтыг тодорхойлжээ.

Энэ зүйлийн 2 дахь зурваст захиалагчид гүйцэтгэгчтэй ижил хэмжээний ял онооно, хэрэв хөлслөгдсөн этгээд захиалагчийн хүссэн хэргийг үйлдээгүй, үйлдэхээс татгалзсан бол захиалагчид Тусгай ангид оногдуулахаар заасан ялын гуравны нэгтэй тэнцэх хэмжээний ял оногдуулахаар хуульчилсан нь анхаарал татна.

Тайланд улсын Эрүүгийн хуульд **олонлог гэмт хэргийг** нэг бүлэгт бус, түүний төрлүүдийг бие даасан бүлгүүдэд хуульчилсан нь онцлог юм. Ерөнхий ангийн 7-р бүлэгт **нийлмэл гэмт хэргийн** ойлголт, төрөл, ял оногдуулах журмыг тодорхойлсон байна. Тухайлбал 90-р зүйлийн 1 дэх зурваст нэг үйлдэлтэй нийлмэл гэмт хэргийн, 2 дахь зурваст хэд хэдэн үйлдэлтэй нийлмэл гэмт хэргийн ойлголтыг өгсөн нь манай ЭЗЗүй дэх олонлог гэм хэргийн ойлголтоос зарчмын хувьд ялгаагүй, харин ял оногдуулах журам нь өвөрмөц онцлогтой болохыг харж болно.

Нэг үйлдэлтэй нийлмэл гэмт хэрэгт ял оногдуулахдаа гэмт этгээдийн үйлдсэн хэргүүдээс хамгийн хүнд ялтай зүйлийн ялын дээд хэмжээтэй тэнцүү ял оногдуулахаар заасан нь анхаарал татна. /90-р зүйл/

Харин хэд хэдэн үйлдэлтэй нийлмэл гэмт хэрэг үйлдсэн бол хэрэг тус бүрт ял оногдуулж заасан нь ялуудыг хооронд нь нэмэх ба шүүгдэгчид оногдуулах ялын эцсийн хэмжээ нь:

а/ үйлдсэн хэргүүдээс хамгийн хүнд гэмт хэргийн ялын хэмжээ нь 3 хүртэл жилийн хорих ялтай бол нэмж нэгтгэсэн ялын хэмжээ 10 жилээс хэтрэхгүй байх,

б/ үйлдсэн хэргүүдээс хамгийн хүнд гэмт хэргийн ялын хэмжээ нь 3-аас 10 хүртэл жилийн хорих ялтай бол нэмж нэгтгэсэн ялын хэмжээ 20 жилээс хэтрэхгүй байх,

в/ үйлдсэн хэргүүдээс хамгийн хүнд гэмт хэргийн ялын хэмжээ нь бүх насаар хорих ялгүй, 10-аас дээш жилийн хорих ялтай бол нэмж нэгтгэсэн ялын дээд хэмжээ 50 жилээс хэтрэхгүй байхаар заасан байна.

Рецедив гэмт хэргийг 8-р бүлэгт хуульчилж түүний ойлголт, ял оногдуулах журмыг тодорхойлсон байна. 92-р зүйлд зааснаар урьд нь гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээд ялаа эдэлж байхдаа эсвэл ялаа эдэлсэнээс хойш 5 жилийн дараа шинээр гэмт хэрэг үйлдсэн бол *рецидив гэмт хэрэг* үйлдсэн гэж үзэх ба сүүлийн үйлдсэн гэмт хэрэгт хорих ял оногдуулахаар заасан тохиолдолд уг ял дээр тухайн ялын 1/3-ийг нэмж оногдуулдаг.

93-р зүйлд "...хэрэв урьд нь гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээд ялаа эдэлж байхдаа эсвэл ялаа эдэлж дууссанаас хойш 3 жилийн дараа Тайландын вант улсын аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгүүд /107-135-р зүйл/, төрийн албан тушаалтны эсрэг гэмт хэрэг /136-146-р зүйл/, албан тушаалын гэмт хэрэгүүд /147-166-р зүйл/, нийгмийн хэв журмын эсрэг гэмт хэрэгүүд /209-216-р зүйл/, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгүүд /217-238-р зүйл/, эдийн засгийн гэмт хэрэг / 240-249, 270-275-р зүйл/, бэлэгсийн гэмт хэрэг /276-285-р зүйл/, хүн амины болон эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгүүд /288-294, 295-299-р зүйл/, өмчийн эсрэг гэмт хэрэгүүд /334-365-р зүйл/-ийг үйлдсэн бол сүүлийн хэрэгт ял оногдуулахдаа оногдуулахаар заасан уг ял дээр уг ялын хоёрын нэгийг нэмж оногдуулна." гэжээ

"Хүнд гэмт хэргийн бүлэгт хамаарах хэм хэмжээнүүд" гэсэн 1-р хэсэг нь **хэргийн хөөн хэлэлцэх хугацааг** заасан 9-р бүлгээр төгсөж байна. Хэрэв гэмт хэрэг үйлдсэнээс хойш дор дурьдсан хугацаанд гэмт хэрэгтнийг мөрдөн шалгаж шүүхэд шилжүүлээгүй бол эрүүгийн хариуцлага /ял/ хүлээлгэхгүй.

1. Хорин жил хүртэл хугацаагаар хорих, бүх насаар нь хорих, цаазаар авах ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн бол,

2. Долоогоос хорин жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван таван жил өнгөрсөн бол,

3. Нэгээс долоон жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил өнгөрсөн бол,

4. Нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн бол,

5. Нэг сар хүртэл хугацаагаар хорих ял, эсвэл өөр төрлийн хөнгөн ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн бол гэж заасан байна.

Ерөнхий ангийн **"Хөнгөн гэмт хэргийн бүлэгт хамаарах хэм хэмжээнүүд"** гэсэн 2-р хэсэг нь 102-106-р зүйлээс тогтоно. 102-р зүйлд хөнгөн /ялимгүй/ гэмт хэргийн ойлголтыг тодорхойлсоны зэрэгцээ хөнгөн гэмт хэрэг санаатай болон болгоомжгүйгээр үйлдэгдэж болох /104-р зүйл/, хөнгөн гэмт хэрэг үйлдэхээр завдсан бол ял оногдуулахгүй /105-р зүйл/, хөнгөн гэмт хэрэгт гүйцэтгэгчээс бусад байдлаар хамтран оролцсон бол ял оногдуулахгүй /106-р зүйл/ гэж заажээ.

Тусгай анги: Тайланд улсын Эрүүгийн хуулийн Тусгай анги нь хүнд гэмт хэргүүд, хөнгөн /ялимгүй/ гэмт хэргүүд гэсэн хоёр дэвтрээс бүрдэнэ.

Хүнд гэмт хэргүүд гэсэн 2-р дэвтр нь дараахь хэсэг, бүлгээс тогтоно. Энэ нь:

1-р хэсэг. Тайландын Вант улсын аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүд

1-р бүлэг. Эзэн хаан, Хатан хаан, Угсаа залгамжлагчийн эсрэг гэмт хэргүүд /107- 112-р зүйл/

2-р бүлэг. Тайландын Вант улсын дотоод аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг /113-118-р зүйл/

3-р бүлэг. Тайландын Вант улсын гадаад аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг /119-129-р зүйл/

4-р бүлэг. Тайландын Вант улстай найрамдалт харилцаатай улс орны эсрэг гэмт хэрэг / 130-135-р зүйл/

2-р хэсэг. Төрийн удирдлагын эсрэг гэмт хэргүүд

1-р бүлэг. Төрийн албан тушаалтны эсрэг гэмт хэрэг /136-146-р зүйл/

2-р бүлэг. Албан тушаалын гэмт хэрэг /147-166-р зүйл/

3-р хэсэг. Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг

1-р бүлэг. Шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлж буй албан тушаалтны эсрэг гэмт хэрэг /167-199-р зүйл/

2-р бүлэг. Шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлж буй албан тушаалтнуудаас үйлдэх гэмт хэрэг /200-205-р зүйл/

4-р хэсэг. Шашны эсрэг гэмт хэрэг /206-208-р зүйл/

5-р хэсэг. Нийгмийн хэв журмын эсрэг гэмт хэргүүд /209-216-р зүйл/

6-р хэсэг. Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүд /217-238-р зүйл/

7-р хэсэг. Хуурамчаар үйлдэх гэмт хэргүүд

1-р бүлэг. Мөнгөн тэмдэгийг хуурамчаар үйлдэх гэмт хэргүүд /240-249-р зүйл/

2-р бүлэг. Тамга, тэмдгийг хуурамчаар үйлдэх гэмт хэргүүд /250-263-р зүйл/

3-р бүлэг. Бичиг баримттай холбоотой гэмт хэргүүд /264-269-р зүйл/

8-р хэсэг. Худалдааны журам зөрчсөн хэргүүд /270-275-р зүйл/

9-р хэсэг. Бэлэгсийн гэмт хэрэг /276-287-р зүйл/

10-р хэсэг. Хүн амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг

1-р бүлэг. Хүний амь насыг хохироосон гэмт хэрэг /288-294

2-р бүлэг. Хүний мэндийн эсрэг гэмт хэргүүд /295-300-р зүйл/

3-р бүлэг. Үр хөндөхтэй холбоотой гэмт хэргүүд /301-305-р зүйл/

4-р бүлэг. Хүүхэд, өндөр настай болон өвчтэй хүнийг орхих, тусламж үзүүлэхгүй байх хэргүүд /306-308-р зүйл/

11-р хэсэг. Хүний эрх чөлөө, нэр хүндийн эсрэг гэмт хэргүүд

1-р бүлэг. Хүний эрх чөлөөний эсрэг гэмт хэргүүд /309-321-р зүйл/

2-р бүлэг. Хүний хувийн нууцтай холбоотой гэмт хэргүүд /322-325-р зүйл/

3-р бүлэг. Хүнийг гүтгэх гэмт хэрэг /326-333-р зүйл/

12-р хэсэг. Өмчийн эсрэг гэмт хэргүүд

1-р бүлэг. Хулгайлах, булаах гэмт хэрэг /334-336-2-р зүйл/

2-р бүлэг. Дээрэмдэх, заналхийлэх, далайлган сүрдүүлэх гэмт хэрэг /337-340.3-р зүйл/

3-р бүлэг. Залилан мэхлэх гэмт хэрэг /341-348-р зүйл/

4-р бүлэг. Зээлдүүлэгчийг мэхлэх гэмт хэрэг /349-351-р зүйл/

5-р бүлэг. Эд хөрөнгийг хууль бусаар олж авах гэмт хэрэг /352-356-р зүйл/

6-р бүлэг. Хулгайлсан эд хөрөнгийн нуух гэмт хэрэг /357-р зүйл/

7-р бүлэг. Эд хөрөнгийг устгах, гэмтээх хэрэг /358-361-р зүйл/

8-р бүлэг. Өмчлөгчийн эрхийг зөрчих гэмт хэрэг /362-366-р зүйл/ болно.

Тусгай ангийн “**Хөнгөн /ялимгүй/ гэмт хэрэг**” гэсэн 3-р дэвтэр нь ямар нэгэн хэсэг, бүлэгт хуваагдахгүй, 367-398-р зүйлээс тогтоно.

Дүгнэлт

Тайланд улсын Эрүүгийн хууль тогтолцоо, бүтцийн хувьд Ром-Германы эрх бүлийн, түүний дотор Францын эрүүгийн хуулийн загвартай ойролцоо ижил байна. Энэ нь Тайланд хэдий 18-19-р зуунд Энэтхэг Хятадын хойгийн орнуудаас Францын колони болоогүй ганц орон боловч хөрш зэргэлдээ Вьетнам, Кампучи, Лаос орнуудыг эрхшээсэн Францын эрүүгийн хууль тус улсын эрүүгийн хуульд тодорхой хэмжээнд нөлөөлсөнтэй холбоотой юм.

Тус улсын Эрүүгийн хуулийн тогтолцоо нь гэмт хэргийн ангилалтай шууд хамааралтайгаар хуульчилагдсан ба манай улсын Эрүүгийн хуультай харьцуулбал ЭЗЗүйн гэмт хэрэг, эрүүгийн хариуцлага /ялтай/ холбоотой зарим институтууд нь бүрэн системчлэгдээгүй болох нь харьцуулсан судалгааны хүрээнд нь ажиглагдаж байна.

Мөн Эрүүгийн хуулийн Ерөнхий ангид тодорхой төрлийн ялын хэмжээг хуульчилаагүй, зарим төрлийн ялуудыг хэрхэн оногдуулах нь тодорхой бус, аюулгүй болгох арга хэмжээ нь эрүүгийн хариуцлагын албадлагын арга хэмжээ гэхээсээ илүү ялын шинжийг агуулсан зэрэг нь анхаарал татна. Түүнчлэн, манай улсын эрүүгийн хуулийг боловсронгуй болгох, зохих нэмэлт, өөрчлөлт оруулахад санаа авч болохоор зохицуулалт цөөнгүй байгаад анхаарал хандуулах хэрэгтэй юм. Эдгээрээс эрүүгийн хуулийг хэрэглэхэд зайлшгүй шаардлагатай нэр томъёонуудын тайлбарыг хууль тогтоогч эрүүгийн хуульд өгсөн, хязгаарагдмал хэрэг хариуцах чадвартай байдал, гэм буруугийн андуурал, түүний төрөл, тэдгээрт ял оногдуулах журмыг тодорхойлсон, хэргийн хөөн хэлэлцэх хугацааг ялгавартайгаар оновчтой хуульчилсан зэргийг дурьдаж болох юм.

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ХУУЛЬ САХИУЛАГЧИЙГ ЭСЭРГҮҮЦЭХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЗҮЙЛЧЛЭЛИЙН АСУУДАЛ

Л.Бат-Очир

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн
ахлах багш, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа*

Дэлхий нийтээр аюулт цар тахал өвчинд нэрвэгдсэнээс хойш хоёр жил өнгөрсөн ч нийгэм, эдийн засаг, хүн амын эрүүл мэнд, амь насанд түүний хохирол учруулсаар байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар зарлиг, Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссоос гарсан шийдвэрийн дагуу урьдчилан сэргийлэх, хамгаалах дэглэмийг хэрэгжүүлэхээр Улаанбаатар хот, аймаг сум сууринаас орох, гарах хөдөлгөөнд хяналт тавих болон гадаад улсаас татан авах иргэдийг тусгаарлан ажиглах цэг, бүсийг хамгаалах, олон нийтийн хөл хориог тогтоон Цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдал, төрийн байгууллага, ДХИС-ийн багш, сонсогч нийт 12500 орчим алба хаагчид тээврийн хэрэгслийн болон явганаар зорчиж буй хөдөлгөөн болон тусгаарлах байруудын хамгаалалт, нисэх буудлын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан⁴⁴.

Цар тахлын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж буй хатуу хөл хорио, зарим хязгаарлалт, арга хэмжээнүүдэд иргэд тааламжгүй хандаж буйг хэвлэл мэдээллийн бүхий л хэрэгслээр илэрхийлсээр байна.

Ахуйн хүрээнд архидаг согтуурч гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэргүүд үйлдэгдэж, иргэдийн бухимдал, стресс нэмэгдсэн. Ийм цаг үед цагдаагийн алба хаагчид өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж, ард иргэдийнхээ амгалан тайван амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхийн сацуу эрүүл мэндийг нь сахин хамгаалах үүргийг нэр төртэй биелүүлсээр байна. Гэтэл сүүлийн үед цагдаагийн албан хаагчид иргэдийн хууль бус үйлдэлд хүлээцтэй, тэвчээртэй хандаж байгаа хэдий ч тэдний эсрэг хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцэх, албан үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулах, төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааг буруутгах, “харлуулах”, тэдний бие, эрүүл мэндэд халдах, тохиолдол цөөнгүй гарсан. Тийм учраас нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хууль хэрэгжүүлэх үүднээс төрийн албан хаагчийг эсэргүүцсэн, биед нь халдсан үйлдлийг гэмт хэрэг, зөрчилд тооцож, зохих хариуцлага хүлээлгэх нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, нийтийн дэг журам, сахилгыг чанд сахиулах, албан хаагчын хууль ёсны ажиллагааны эрх зүйн баталгааг хангах чухал ач холбогдолтой. Хууль сахиулагчийг эсэргүүцсэн аливаа үйлдэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй эсэхийг ялган зүйлчилж, зохих ял, шийтгэл оногдуулах нь тэдгээрийн ойлголт, мөн чанар, шинж, тэдгээрийн ялааг нэг мөр ойлгож хуулийг зөв хэрэглэхээс ихээхэн шалтгаална.

Төрийн албан хаагч, хууль сахиулагчийн албан үүргээ гүйцэтгэх хууль зүйн баталгааг хангах үүднээс Эрүүгийн хуулийн⁴⁵ 23.1 дүгээр зүйлд заасан “Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг”, Зөрчлийн тухай хуулийн⁴⁶ 15.2 дугаар зүйлд заасан “Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах зөрчил”-ийг тус тус хуульчилсан.

Эдгээр гэмт хэрэг, зөрчил нь төрийн албан хаагч, хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан эсэргүүцэж, тэдний үйл ажиллагаанд саад учруулдаг объектив талын шинжээрээ төсөөтэй боловч дор дурдсан шинжээр нь ялгаж зүйлчилнэ.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг нь гэмт этгээд хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцснээр төгсдөг хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг юм. Өөрөөр хэлбэл, хууль сахиулагчийн эрүүл мэндэд ямар нэгэн хохирол учирсан байхыг шаардахгүй. Хэрэв хууль сахиулагчийг

⁴⁴ МОНЦАМЭ. УБ., 2021.1921 мэдээллийн агентлаг. 01 дүгээр сарын 13-ны өдөр 15:58:13

⁴⁵ Эрүүгийн хууль.УБ.2015.Төрийн мэдээлэл эмхтгэл.2016. №7.

⁴⁶ Зөрчлийн тухай хууль.УБ.2017.Төрийн мэдээлэл эмхтгэл.2017.№24.

албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэснээр амь насаа алдсан, эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд хүний амьд явах эрхийн эсрэг болон хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн холбогдох зүйл, хэсгээр зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Тухайлбал, цагдаагийн албан хаагчийн албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэж, эрүүл мэндэд хөнгөн, хүнд, хүндэвтэр хохирол санаатай учруулсан, амь насыг хохироосон бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.9, 11.1 дүгээр зүйлийн 2.1, 11.4 дүгээр зүйлийн 2.1, 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгээр (эрхэлж буй ажил, албан үүрэгтэй нь холбогдуулж) зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан **“Албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн”** гэдэгт гүйцэтгэж буй албаны үйл ажиллагаа буюу хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсэнтэй нь холбогдуулан хууль сахиулагчийн бие махбодид халдах, хүчирхийллийн аливаа идэвхтэй үйлдэл хийснийг ойлгоно. **“Хууль сахиулагчийн эрүүл мэндэд халдах”** гэдэгт хууль сахиулагчийг зодох, хоолойг боох, түлхэх, хувцасыг ураг, тусгай хэрэгслийг булаах, устгах, хорт бодис, араатан амьтан, хэрэг хариуцах чадваргүй хүн ашиглах зэрэг хууль сахиулагч руу шууд чиглэсэн аливаа үйлдлээр илэрч болно. Харин Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-д заасан **“Хийсэн үйл ажиллагаанд нь саад учруулсан”** гэдэгт хууль сахиулагчийн үйл ажиллагааг тасалдуулах, зогсооход чиглэсэн хууль сахиулагчид хүч хэрэглээгүй аливаа үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно. Тухайлбал, хууль сахиулагчийг байр, объектдоо нэвтрүүлэхгүй байх, зам тавьж өгөхгүй байх, үл ойшоох, зөрчлийн талаар тайлбар, мэдээлэл өгөхгүй байх, дуудсан цагт очихгүй байх зэрэг хэлбэрээр илэрч болно.

Мөн зүйлийн 2 дахь хэсгийн 2.3-д **“Төрийн албан хаагчийг хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн”** гэдэгт хууль сахиулагчид хүч хэрэглэх зорилго, сэдэлтгүй боловч түүний хууль ёсны шаардлага, шийдвэрийг биелүүлэхээс татгалзсан, зайлсхийсэн үйлдэлийг ойлгоно. Тухайлбал, замын цагдаагийн албан хаагч жолоочийг жолоодох эрхийн үнэмлэхээ шалгуулах шаардлага тавих үед автомашины цонхыг буулгахгүй, бичиг баримтаа шалгуулахгүй байх, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлөө шалгуулахаас татгалзаж, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, хууль бус жагсаал цуглаанаа тараахаас татгалзаж, үргэлжлүүлэх, суулт хийх, хууль бус тайлбар тавих, хууль ёсны шаардлагатайн холбогдуулан бусдыг хууль бус үйлдэл уриалах байдлаар эсэргүүцэх зэрэг хэлбэрээр илэрч болно.

Мөн зүйлийн 2 дахь хэсгийн 2.3-д заасан **“Доромжилсон”** гэдэгт нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны болон ёс суртахууны хэм хэмжээ, зан заншил, уламжлалд харшилсан, төрийн албан хаагч, хууль сахиулагчийн нэр төр, алдар хүнд, албаны нэр хүндийг гутаахыг ойлгоно. Энэ нь төрийн албан хаагч, хууль сахиулагчийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, эрүүл мэнд, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, гадна төрх, хөгжлийн бэрхшээлтэй болон гэр бүлийн байдалтай нь холбогдуулан үг, үйлдэл, бичгээр, дохио зангаагаар, зураг, дүрсээр гутаах зэргээр илэрч болно. Доромжлох, эсэргүүцэх, уриалах үйлдэлдээ хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээг ашиглаж болно.

Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан **“Хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн”** гэж гүйцэтгэж буй албаны үйл ажиллагаа буюу хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсэнтэй нь холбогдуулан хууль сахиулагчийг болон ойр дотны хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хохирол учруулахаар сүрдүүлсэн сэтгэл санааны хүчирхийллийг ойлгоно. Энэ нь хууль сахиулагчийг үүргээ хуульд заасны дагуу шударгаар биелүүлж байгаад нь дургүйцэж, үйл ажиллагааг нь тасалдуулах, саатуулах зорилготой, эсхүл шударга ажилласан, хууль ёсны үйлдлийнх нь төлөө ёс хонзонгийн сэдэлтээр илэрч болно. Шүүхийн практикт хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт ял шийтгэсэн тохиолдол сүүлийн 2 жил харин төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах зөрчил 2019 онд 1453 (Баянгол 1, Баянзүрх 1, 2, Дорноговь, Баян-Өлгий, Ховд аймагт хамгийн их), 2020 онд 1473 (Баянгол 1, Баянзүрх 1, 2, Хөвсгөл, Төв аймагт хамгийн их), 2021 оны 4 сарын байдлаар 321 (Баянгол 1, Баянзүрх 1,2, Хөвсгөл, Сэлэнгэ аймагт хамгийн их) бүртгэгдсэн⁴⁷. Нийслэлийн хувьд хүн амын нягтаршил, орон сууц, аж ахуйн нэгж байгууллагын төвлөрөл ихтэй дүүрэгт их үйлдэгдэж байна. Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах зөрчлийн тоо өмнөх 2 онд тогтвортой байсан бол 2021 онд орон нутагт буурах нийслэд өсөх төлөвтэй байгаа нь нэг талаар зөрчлийн шийдвэрлэлт, гэмт хэргийг ялгахгүй, нөгөө талаар хохирлыг барагдуулж эвлэрүүлэх, эрүүгийн

⁴⁷ <https://police.gov.mn>

хэрэг үүсгэхээс төвөгшөөх, удирдах албан тушаалтны шахалт, шаардлага, иргэдийн сөрөг хандлагаас зайлсхийж байгаатай холбоотойг үгүйсгэх аргагүй.

Гадаадын зарим орны эрүүгийн хуульд, хууль сахиулагч эсэргүүцэх гэмт хэргийг хэрхэн хуульчилж ямар төрөл, хэмжээний ял оногдуулж байгааг харьцуулж үзэв. Тухайлбал ОХУ-ын эрүүгийн хуулийн⁴⁸ 137 дугаар зүйлд "Хууль сахиулах байгууллагын ажилтны амь насанд халдах гэмт хэргийг заажээ."Нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хууль ёсны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нь саад учруулах, эсхүл энэ үйл ажиллагааных нь төлөөшөө авах зорилгоор хууль сахиулах байгууллагын ажилтан, цэргийн алба хаагч, түүнчлэн тэдний төрөл садангийн хүний амь насыг хохироосон бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, арван хоёроос хорин жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл бүх насаар нь хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ" гэж заасан.

Хууль сахиулагчийн хууль ёсны үйл ажиллагаа эсэргүүцэж амь насыг хохироосон бол онц хүнд гэмт хэрэгт⁴⁹ тооцож "хүнд" ял оногдуулж байгаа нь давхар зүйлчлэл шаардахгүйгээс гадна, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх төрийн эрүүгийн бодлого нь "хатуу" гэдгийг илтгэнэ.

БНХАУ-ын эрүүгийн хуулийн зургаадугаар бүлгийн (Олон нийтийн эмх журмыг самууруулсан ял) 277 дугаар зүйлд⁵⁰ :Төрийн байгууллагын ажилтны хууль ёсоор үүрэг тушаалаа гүйцэтгэхэд хүчирхийлэл, сүрдүүлгийн аргаар харшилсан байвал гурван жилээс доош хугацаатай хорих, хорж хөдөлмөрлүүлэх, захиран хамаарах буюу зоосоор⁵¹ торгохоор шийтгэнэ.

Бүх улсын ардын төлөөлөгчдийн их хурал ба орон нутгийн эл шатны ардын төлөөлөгчийн хууль ёсоор төлөөлөгчийн үүрэг, тушаалаа гүйцэтгэхэд хүчирхийлэл, сүрдүүлгийн аргаар харшилсан байвал өмнөх бадгийн тогтоол ёсоор гүйцэтгэнэ.

Байгалийн гамшиг болон гэнэт гарсан хэрэг явдлын дунд улаан загалмайн нийгэмлэгийн ажилтны хууль ёсоор үүрэг хариуцлагаа гүйцэтгэхийг хүчирхийлэл, сүрдүүлгийн аргаар харшилсан байвал нэгдүгээр бадгийн тогтоол ёсоор шийтгэнэ.

Улсын амрыг хамгаалах байгууллага, дотоодыг хамгаалах байгууллагын хууль ёсоор улсын амар түвшнийг хамгаалах ажил үүргээ гүйцэтгэхэд зориуд харшилж, хүчирхийлэл, сүрдүүлгийн аргыг хэрэглээгүй боловч хүнд ноцтой уршиг татсан байвал нэгдүгээр бадгийн тогтоол ёсоор шийтгэнэ.

27, дугаар зүйлд олон нийтийг өдөөн турхирч төрийн байгууллагын хууль ёсны ажиллагааг хүчирхийллийн аргаар эсэргүүцсэн бол мөн гурван жилээс доош хугацаагаар хорих, хүнд ноцтой уршиг татсан бол гурван жилээс дээш долоон жилээс доош хугацаагаар хорих ял шийтгэхээр заажээ. Хятад улсад энэ гэмт хэрэгт зөвхөн торгох, хорих ял оногдуулхын зэрэгцээ төрөл, хэмжээний хувьд манай улстай төстэй. Мөн хууль сахиулагч субъектийг тусгайлан, хэлбэрийн шинжтэй байхаар хуульчилжээ.

ХБНГУ-ын эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд:(Хууль сахиулах албан тушаалтныг эсэргүүцэх) Хууль тогтоомж, шүүхийн дүгнэлт, шийдвэр эсхүл захирамж, тушаал гүйцэтгэж байгааалбан тушаалтан эсвэл Холбооны зэвсэгт хүчний цэргийн үйл ажиллагааг хүч хэрэглэж эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих эсхүл торгох ял шийтгэнэ. Гэмт этгээд зэвсэг, аюултай хэрэгсэл биедээ авч явсан, хүний амь нас хохироосон, хүний эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулсан, хамтран оролцсон бол зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан⁵².

Харин 114 дүгээр зүйлд хууль сахиулах албан тушаалтанд халдсан бол гурван сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр, 115 дугаар зүйлд хууль сахиулах албан тушаалтантай ижил албан тушаалтныг эсэргүүцэх, түүнд халдсан бол дээрх гэмт хэргүүдэд оногдуулхаар заасан ялаар шийтгэхээр тус тус заажээ. ХБНГУ-ын эрүүгийн хуулийн онцлог нь хууль сахиулагч эсэргүүцсэн, халдсан үйлдлийг бие даасан, хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг болгон хуульчилж, хүндрүүлэх шинжийг ОХУ-ын эрүүгийн хуулийн зохицуулалттай адил материаллаг шинжтэй байхаар заасан. Дээрх улсуудын эрүүгийн хуульд хууль сахиулагч эсэргүүцэх гэмт хэрэг үйлдсэн этгээдэд 2 төрлийн ял буюу хорих ял оногдуулах явдал зонхилж байгаа бол манай улсад 3 төрлийн ялаас сонгож оногдуулхаар хуульчилсан.

Төрийн тусгай албан хаагч хууль ёсны үүргээ зохих ёсоор биелүүлэхэд эрх зүйн баталгаа чухал. Цагдаагийн албан хаагчийг аливаа хууль бус үйлдлээс хамгаалах, тэдний гэмт

⁴⁸ МУИС-ХЗС.Монгол, ОРОС, Хятад, Герман улсын эрүүгийн хууль.УБ.2021.250 дахь тал.

⁴⁹ Дурдсан бүтээл. 251 дэх тал

⁵⁰ МУИС-ХЗС.Монгол, ОРОС, Хятад, Герман улсын эрүүгийн хууль.УБ.2021.314 дахь тал

⁵¹ 52 дугаар зүйлд:Зоосоор ялдахаар шийтгэхдээ ял хийсний үйл байдлыг харгалзаж ялдах оосоор тоог тогтоох хэрэгтэй.

⁵² МУИС-ХЗС.Монгол, ОРОС, Хятад, Герман улсын эрүүгийн хууль.УБ.2021. 409 дэх тал.

хэрэг, зөрчлийг таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаандаа итгэл үнэмшилтэй байх, эрүүгийн хуулийн хэм хэмжээг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх нь олон хүчин зүйлээс хамаарна. Тухайлбал албан хаагчийн албаны хандлага, итгэл үнэмшил, үйл ажиллагаа, иргэдийн эрх зүйн ухамсар, соёл, ачаалал, хуулийн хэрэгжилт гэх мэт. Цар тахлын үеэр цахим худалдаа, залилан, гүтгэлэг, доромжлол, хувийн нууц, хувь хүний нэр төр, худал мэдээлэл, хууль бус уриалга, цуглаан, бусдыг өдөөн турхирах гэх мэт олон хууль бус үйлдлийг хэрхэн шийдвэрлэх талаар эргэлзээтэй олон асуудал бий болж буйг цаашид анхаарах шаардлага тулгарч байна.

Тэд төрийн тусгай албан хаагчид цар тахлын эрсдэлтэй үед аюулыг даван туулж, зориг тэвчээр гарган өргөсөн тангартааа үнэнчээр үүрэг гүйцэтгэлээ.

КРИПТОВАЛЮТЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ УЛС, ОЛОН УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Ж.Болд
ДХИС-ийн докторант

Товч агуулга: Эдийн засаг, санхүү, хөрөнгийн зах зээлийн салбарт өрнөж буй олон арван технологийн дэвшилтэт шийдлүүдийн нэг нь криптовалют юм. Криптовалют нь шинэ технологийн үндсэн дээр үүссэн бөгөөд цаашид ч техник, технологийн хөгжлийг дагаад шинээр санхүүгийн үйлчилгээний тоо ихсэж, түүнийг дагасан эрх зүйн зохицуулалтууд нэмэгдэх хандлагатай байна. Иймд криптовалютын талаарх олон улсын болон гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалж, судалгааны эргэлтэнд оруулах зорилгоор дараах судалгааны үр дүнд олон нийтийн хүртээл болгож байна.

Түлхүүр үг: Америкийн Нэгдсэн Улс, Европын холбоо, эрх зүйн зохицуулалт криптовалют, биткойн.

Сүүлийн үед технологийн дэвшилүүд хурдацтай хөгжин нийгмийн амьдралд шинэ төрлийн үйлчилгээ нэвтэрч, эдийн засаг, санхүү, мөнгөний бодлогод инноваци болж үр ашигтай байдал, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж буй хэдий ч нөгөө талаараа нийгэмд аюултай, гэмт болон террорист бүлэглэлд мөнгө угаах, хууль бус гэмт үйлдлээ санхүүжүүлэх арга замуудыг бий болгож байгаа нь олон арван судалгааны ажлын тайлан мэдээнээс харж болно.

Анх Биткойн-ыг 2008 онд Сатоши Накамото нэртэй автор⁵³-ын бичсэн загвар, томьёоны дагуу явагдаж "Аи Ти" компани, хувь хүмүүс олборлон зах зээлд нийлүүлж эхэлсэн байна. Аливаа гүйлгээ, шилжүүлэг хийхэд завсрын зуучлагч буюу банк, санхүүгийн байгууллага шаардлагагүй бөгөөд гүйлгээнд оролцогчид хоорондоо шууд харьцах буюу peer-to-peer (тус тооцоолол нь компьютерын хэрэглээний ойлголт ба шууд компьютероос компьютерлуу буюу хувийн компьютер нь төв серверийг тойрч бусад компьютеруудтай шууд хамтран ажиллах боломжийг хангаж чаддаг)⁵⁴ гүйлгээ хийдгээрээ онцлог юм. Мөн төлбөр тооцоо хийж буй хүний хувийн мэдээлэл нууцлагддаг, хэн нэгэн зохицуулагчийн зүгээс хяналт багатай зэргээрээ онцлогтой. Мөнгийг анх төв банк хэвлээд, харин гүйлгээг санхүүгийн байгууллагуудаар дамжуулж хийдэг, сэжигтэй гүйлгээг хянадаг уламжлалт ойлголтыг криптовалюта эвдсэн санхүүгийн гүйлгээ болсон нь олны анхаарлыг татаж эхэлсэн байна. Сүүлийн үед криптовалютыг цахим мөнгө шиг төлбөрийн хэрэгсэл болохоос гадна, хувьцаа бонд зэрэг үнэт цаас шиг чөлөөт арилжаалагддаг, ханшийн зөрүүнээс нь ашиг хийж болдог санхүүгийн, хөрөнгө оруулалтын хэрэгсэл болгож байна.

Криптовалют бол өндөр нууцлал бүхий цахим тооцооны хэрэгслийн нэг хэлбэр юм. Гэхдээ доллар, евро, иен зэрэг валютаас ялгаатай нь криптовалютыг аль нэг улсын төв банк эсвэл санхүүгийн байгууллагаас гаргадаггүй бас хэвлэдэггүй. Кripto валютын цахим гүйлгээ, төлбөр тооцооны аюулгүй байдал нууцлалыг хангахад криптограф ашигладаг. Энэ бол тодорхой мэдээллийг тайлахад хэцүү код болгон хөрвүүлэх математикийн процесс юм. Дэлхийн хоёрдугаар дайны үед нууц мэдээллийг шифрлэх хэрэгцээ шаардлагын дагуу криптографыг ашиглаж байсан бол харин цахим эринд математик онолын элементүүд болон компьютерын тусламжтайгаар криптограф цахим мэдээлэл, харилцаа холбоо болон мөнгөний нууцлал, аюулгүй байдлыг хангах аргачлал болсон байна.

Блокчэйн технологид суурилсан биткойноор Монгол Улсад албаны ёсны бараа, үйлчилгээний төлбөрт ашигладаггүй, харин иргэд хоорондоо арилжааны хэрэгсэл болгон ашиглаж байна. Өнөөгийн байдлаар банк, санхүүгийн салбарын зохицуулагч байгууллага бүх төрлийн криптовалютыг төлбөрийн хэрэгсэл гэж үздэггүй, үүнд зөвшөөрөл олгодоггүй, үйл ажиллагааг хянан зохицуулдаггүй боловч Монгол Улсад криптовалютын арилжаа хийдэг нууцлал бүхий хэд хэдэн цахим хуудас ашиглагдаж байна. Санхүүгийн хэрэглэгч өөрийн сонголтын хүрээнд биткойн арилжааг хийж, цахим хуудсаар дамжуулан криптовалютыг биржийн зарчмаар арилжаалж байна.

Орчин үеийн техник, технологийн дэвшлийн хөгжлийг даган цахим орчны хэрэглээ нэмэгдэн, олон төрлийн цахим төлбөр тооцооны хэрэгсэл бий болж байгаагийн нэг илрэл нь криптовалют юм. Дэлхийд биткойн анх гарч, түүнийг дагасан олон төрлийн криптовалют дэлгэрч, олон улсад хэрэглэгдэж эхэлснээс хойш гэмт хэргийн шинжтэй үндэстэн дамнасан

⁵³ Программист

⁵⁴ https://mn.wikipedia.org/wiki/Peer_to_peer_computing, 2021 оны 03 дугаар сарын 05

зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн тоо, тэдгээрийн үйлдэж буй гэмт үйлдэл нэмэгдсээр байна. Криптовалютын зах зээл, эрх зүйн зохицуулалт нь дэлхийн олон улсад болон манай улсад шинээр үүсэж байгаа зохицуулагдах ёстой салбарын нэг юм.

Өнөөдрийн байдлаар дэлхийн зах зээлд 7092 төрлийн криптовалюта эргэлтэд орж байна. Судлаачдын үзэж байгаагаар криптовалюта 2018 онд 213.289.302.529 ам.долларын хөрөнгө оруулалтыг татсан. Энэ талаар тодруулбал биткойн (111 тэрбум ам.доллар), Ethereum (21 тэрбум ам.доллар), Ripple (20 тэрбум ам.доллар) хөрөнгө оруулалт татсан байна⁵⁵. Кripto валютыг иргэд хамгийн алдартай “Биткойн” нэрээр анх мэдэх болсон ба 2021 оны байдлаар дэлхийд 1 биткойн 54,388 ам.долларын ханштай⁵⁶ байна.

Криптовалютын талаарх ойлголт нь Монгол Улсын хувьд шинэхэн, түүний хэрэглээ тодорхой хэмжээгээр санхүүгийн зах зээлд нэвтэрсэн ч үүнтэй холбогдох харилцааг зохицуулсан хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг одоогоор байхгүй бөгөөд зайлшгүй зохицуулах эрх зүйн орчин байх шаардлага тулгарч байна.

Түүнчлэн криптовалютын хэрэглээг албан ёсоор зөвшөөрөөгүй, хууль тогтоомжоор зохицуулаагүй үед иргэн, хуулийн этгээд нь криптовалютын ашиглан Монгол Улсын эдийн засаг, тухайн үйлчилгээг хэрэглэгчийг эрсдэлд оруулж болзошгүй бөгөөд гэмт хэргийн шинжтэй үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийг санхүүжүүлэх эрсдэлд Монгол Улс өртөх сөрөг үр дагавар бий болж болзошгүй байгаа бөгөөд одоогоор крипто валютын эрх зүйн орчин, эрсдэл, гэмт явдлын криминологийн харьцуулсан судалгааны ажил хийгдээгүй байна.

Иймд крипто валютын талаарх олон улсын болон гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалж, судалгааны эргэлтэд оруулах зорилгоор дараах судалгааны үр дүнд олон нийтийн хүртээл болгож байна.

Америкийн Нэгдсэн Улс нь крипто валютын үндэсний хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар тодорхой арга хэмжээг амжилттай авч хэрэгжүүлж байгаа учир энэхүү хэсэгт АНУ крипто валютын харилцааг хэрхэн зохицуулсан тухай жишээ болгон авлаа. АНУ-д виртуал хөрөнгийн зохицуулалт хамгийн төвөгтэй бөгөөд зохицуулагч байгууллагууд бараг сар бүр шинэ журам болон виртуал хөрөнгийн удирдамж боловсруулан гаргадаг учир энэхүү судалгааны ажил нь АНУ-н хууль, эрх зүйн зохицуулалтыг тайлбарлахыг хичээлээ. Мөн энэ хэсэгт ЕХ-ны улс орнуудын олон улсын түвшинд хэрэгжүүлж арга хэмжээний ач холбогдолтой болон дутагдалтай талуудыг товч тайлбарлах болно.

1.Америкийн Нэгдсэн Улс

АНУ нь виртуал хөрөнгийг зохицуулах хамгийн төвөгтэй боловч чанга стандартуудыг хэрэгжүүлдэг. Кripto валютын нэр томьёо хялбархан тодорхойлогдох боломжгүй ба одоо байгаа хуулиудын дагуу амархан ангилах боломжгүй тул АНУ-ын олон тооны зохицуулах байгууллагууд өөрийн иргэдийн крипто валютын гүйлгээ, хөрөнгө оруулалт, өмчлөлийн талаарх өөрийн удирдамж, зөвлөмжийг бэлтгэн гаргасан. Түүхий эдийн фьючерсийн арилжааны комиссын (CFTC) 2018 оны тайланд дурдсанаар “АНУ-ын хууль тогтоомжид биткойн эсвэл виртуал валютын спот зах зээлд шууд оролцох, иж бүрэн хяналт тавих талаар тусгаагүй болно. Үүний үр дүнд АНУ-ын хууль тогтоомжид виртуал валютын зохицуулалт нь олон талт болон олон зохицуулалтын арга хэлбэрт шилжсэн”⁵⁷. АНУ-ын хууль тогтоомжид виртуал валют нь өмч хөрөнгө, бараа, бүтээгдэхүүн, болон аюулгүй байдлын хэрэгсэл болох нь АНУ-ын ямар төрийн байгууллага зохицуулж байгаагаас хамаарна.

а.Хууль сахиулах төрийн байгууллагууд (Law Enforcement Agencies)

Холбооны мөрдөх товчоо (FBI)-нд Silk Road буюу зөвхөн биткойныг төлбөрийн хэрэгслээ болгосон хууль бус цахим худалдааны зах зээлийг хаах үүрэг ногдсон билээ⁵⁸. Хоёр жилийн турш судалгаа хийж, эрэл хайгуул хийсний эцэст 2013 оны 10-р сарын 1-ний өдөр Холбооны мөрдөх товчоо Silk Road-н үндэслэгч, оператор Росс Ульбрихт-ийг тогтоон баривчлах боломжтой болов. Silk Road-г хар тамхи, мансууруулах бодисын наймаа, мөнгө угаасан хуйвалдаанд буруутгаж байна. Холбооны мөрдөх товчоо тухайн вэбсайтад хадгалагдсан бүх биткойнуудыг хураан авсан ба 29,655 биткойныг дуудлага худалдаагаар зарах эрхтэй болов⁵⁹. Ульбрихтыг баривчилж, Silk Road вэбсайтын уналт нь крипто валюттай

⁵⁵ <https://coinmarketcap.com/ru/all/views/all/> Хандалт: 2021 оны 04 дүгээр сарын байдлаар/

⁵⁶ <https://www.investing.com/crypto/bitcoin/btc-usd/>Хандалт: 2021 оны 05 дугаар сарын байдлаар/

⁵⁷ U.S. Commodity Futures Trading Commission, CFTC Backgrounder on Oversight of and Approach to Virtual Currency Futures Markets (Washington DC: U.S. Commodity Futures Trading Commission, 2018), https://www.cftc.gov/sites/default/files/idc/groups/public/%40customerprotection/documents/file/backgrounder_virtualcurrency01.pdf, 1. Хандалт: 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдөр

⁵⁸ Huang, “Reaching within Silk Road,” 2105. Хандалт: 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдөр

⁵⁹ Huang, “Reaching within Silk Road,” 2105. Хандалт: 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдөр

холбоотой гэмт хэргийн шинжтэй анхны том хэмжээний эрүүгийн мөрдөн байцаалт байв. Үүний үр дүнд 2013 оны Торгоны замын хэрэг крипто валютыг хууль бусаар ашиглахтай холбоотой нь тогтоогдож, хууль тогтоогчид болон эрдэмтэн, судлаачийн анхаарлыг биткойны тухай хууль ёсны байдал, хууль эрхзүйн зохицуулалтыг судлах нэн шаардлагатай болгосон.

б.Дотоод орлогын алба (Internal Revenue Service)

2014 оны 3-р сард Дотоод Орлогын Алба (IRS) нь Биткойн зэрэг виртуал валютын татварын удирдамжийг гаргаж, виртуал валютыг АНУ-ын холбооны хуулийн дагуу өмч гэж тодорхойлжээ⁶⁰.

IRS-ийн удирдамжийн дагуу крипто валютын гүйлгээ хийдэг, төлбөр тооцоо хийдэг эсвэл арилжаалдаг хувь хүмүүс крипто валютаар гүйлгээ хийх эсвэл арилжаа хийх явцад олсон ашгийн талаар мэдээлэх үүрэг хүлээх болсон. Үүнтэй адил виртуал валютаар санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний төлбөрийг АНУ-ын татварын хуулиар үл хөдлөх хөрөнгөөр хийсэн төлбөрийн нэгэн адил хариуцлага хүлээнэ.

в.Түүхий эдийн фьючерс арилжааны комисс (Commodities Futures Trading Commission)

Түүхий эдийн фьючерс арилжааны комисс (CFTC) нь "нээлттэй, ил тод, өрсөлдөх чадвартай, санхүүгийн хувьд тогтвортой зах зээлийг дэмжих"⁶¹ өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний зах зээлийг хянах, зохицуулах үүрэгтэй АНУ-ын хараат бус зохицуулах байгууллага юм. CFTC нь 2014 онд Түүхий эдийн арилжааны акт (CEA) -ын хяналтын дагуу виртуал валютыг "бараа, бүтээгдэхүүн" гэж тодорхойлсон юм⁶². Түүнээс хойш CFTC нь крипто валютын талаар олон нийтийн мэдлэгийг тэлэх, крипто валютын экосистем дэх АНУ-ын одоогийн зохицуулалтыг боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэж ирсэн.

CFTC нь виртуал валютыг зохицуулах эрх зүйн арга барилаа таван үндсэн ангилалд хуваадаг байна. Үүнд: виртуал валютын талаар олон нийтэд илүү их мэдээлэл өгөх буюу *хэрэглэгчийн боловсрол*; виртуал валютын деривативын талаар залилан болон залилангийн эсрэг зохицуулалтыг хангах *хууль ёсны эрх мэдлийг баталгаажуулах*; виртуал валютын деривативын талаар мэдээлэл, өгөгдөл цуглуулах *зах зээлийн мэдээлэл өгөх*; *хууль сахиулах* "виртуал валютын дериватив болон суурь спот арилжаа эрхлэх зорилгоор зах зээл дээр залилан мэхлэх, зүй бусаар ашиглах, хуурамч нэхэмжлэл гаргахыг *хууль сахиулах, эрүүгийн хэрэг үүсгэх*; засгийн газрын хэмжээнд виртуал валютыг холбооны *бусад төрийн зохицуулагч байгууллагуудтай уялдуулах* гэх мэт.

CEA-д заасан хуулиар олгогдсон эрх мэдлийн дагуу, CFTC нь криптовалют дээр хэд хэдэн албадлагын арга хэмжээ авсан ба үүнд дотоодод болон гадаадад зохицуулалтгүй гүйлгээний эсрэг ажиллах, үүсмэл платформ дээр хууль бус худалдаа хийхийг хориглох тухай хуулийг хэрэгжүүлэх, виртуал валюттай холбоотой зохицуулалтын асуудлаар удирдамж гаргах зэрэг багтана. CFTC-ээс гаргасан журмыг хэрэгжүүлэх зорилгоор виртуал валютыг өөрөө баталгаажуулах үйл явцыг бий болгож, ингэснээр АНУ-ын бирж дээр фьючерс арилжаа буюу ирээдүйд гэрээ хийх боломжийг олгов⁶³. 2017 оны 12-р сарын 1-ний өдрөөс эхлэн виртуал хөрөнгө эзэмшигч нь Чикаго Худалдааны бирж (Chicago Mercantile Exchange Inc.) болон Чикаго дахь Опционы Биржийн зөвлөл (Chicago Board of Options Exchange) хоёр томоохон зах зээлийн бирж дээр баталгаажилт хийлгэн биткойны фьючерс арилжаа буюу ирээдүйд хийх гэрээг хийх боломжтой болсон байна⁶⁴.

г.Аюулгүй байдал болон солилцооны комисс (Security and Exchange Commission)

Крипто валютын тухай хууль, эрх зүйн зааварчилгаа, зөвлөмж өгдөг АНУ-ын төрийн агентлагуудын нэг бол Аюулгүй байдал болон солилцооны комисс (SEC) бөгөөд түүний зорилго нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, шударга, эмх цэгцтэй, үр ашигтай зах

⁶⁰ Internal Revenue Service, IRS Virtual Currency Guidance: Virtual Currency Is Treated as Property for U.S. Federal Tax Purposes; General Rules for Property Transactions Apply (Washington DC: Internal Revenue Service, 2014), <https://www.irs.gov/newsroom/irs-virtual-currency-guidance>. Хандалт 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдөр

⁶¹ "Mission & Responsibilities," U.S. Commodity Futures Trading Commission, accessed April 22, 2018, <https://www.cftc.gov/About/MissionResponsibilities/index.htm>. Хандалт 2020 оны 10 дугаар сарын 23

⁶² U.S. Commodity Futures Trading Commission, CFTC Backgrounder, 1. Хандалт 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр

⁶³ U.S. Commodity Futures Trading Commission, 1. Хандалт 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр

⁶⁴ U.S. Commodity Futures Trading Commission, CFTC Backgrounder, 2. Хандалт 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр

зээлийг хадгалах, үнэт цаасны арилжаа, хөрөнгө бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршдог.⁶⁵ Мөн крипто валютын зах зээл дэх хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах зорилгоор SEC нь анхны олон нийтэд крипто валютын зоосон хувьцаа босгох (Initial coin offering) үйл ажиллагааг хэрхэн явуулах талаарх удирдамж, зөвлөмжийг гаргажээ.

Олон нийтэд компанийн хувьцаа босгох (IPO)-ийн үзэл баримтлалтай адилаар криптовалют хөгжүүлэгч байгууллага олон нийтэд крипто валютын зоосон хувьцаа (ICO)-г санал болгох буюу ингэснээр хөгжүүлэгч талын тогтоосон үнээр капитал (ам.доллар эсвэл бусад криптовалют хэлбэрээр) босгох үйл ажиллагаа юм. Энгийнээр тайлбарлавал, крипто валютын зоосон хувьцаа санал болгож буй байгууллагууд хэрэглэгч нарт крипто валютыг зах зээлийн тогтоосон эсвэл бага үнээр хөрөнгө оруулагч нарт санал болгож хөрөнгө оруулалт авах үйл ажиллагаа юм.

SEC нь ICO-ийн талаар удирдамж, аргачлал гаргасан боловч уг байгууллага криптовалют урт хугацаанд аюулгүй, найдвартай үнэт цаас эсэхийг тогтоож чадаагүй ба энэ ирээдүйд SEC крипто валютын зах зээлд хөндлөнгөөс оролцож болзошгүй болох ойлголтыг үлдээж байна. SEC-ийн дарга Жей Клейтон крипто валютын давуу болон сул тал дээр дүн шинжилгээний хийсний дараа криптовалют ба ICO-ийн талаарх 2017 оны албан ёсны мэдэгдэлдээ ингэж бичжээ:

Криптовалют нь албан ёсны үнэт цаас биш бөгөөд крипто валютыг олон нийтэд санал болгох, борлуулах нь SEC-ийн эрх үүргийн харьяаллаас гадуур байна гэж мэдэгдэв. Криптовалют гэж бүртгэгдсэн аливаа дижитал хөрөнгийн талаар үнэн зөв мэдээлэл нь тухайн хөрөнгийн шинж чанар, ашиглалтаас хамаарна⁶⁶.

2017 оны энэхүү мэдэгдэлээс хойш SEC нь оруулагч нарт крипто валютын арилжаа хэрхэн хийх талаар дэлгэрэнгүй зааварчилгаа өгсөөр байна. SEC-ээс гаргасан хамгийн сүүлийн үеийн буюу 2018.03.07-ны өдрийн олон нийтэд мэдээлсэн тайланд SEC стандартыг дагаж мөрддөггүй хэд хэдэн крипто валютын биржүүд байгааг онцолсон байна. SEC-н бүртгэлгүй байгаа биржүүд дээр гүйлгээ хийж эрсдэл хүлээвэл тогтоосон хууль журмын дагуу хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах боломжгүй байна. Энэхүү тайланд крипто валютын ямар бирж дээр гүйлгээ хийхээс шалтгаан SEC-д бүртгүүлснээр хөрөнгө оруулагчдын эрхээ хуулиар хамгаалуулах боломжтой болж байна.

д.Гадаадын активыг хянах алба (Office of Foreign Asset Control)

АНУ-ын Төрийн Санхүүгийн Албанаас Гадаадын активыг хянах албанд (OFAC) АНУ-д заналхийлж буй нь тогтоогдсон крипто валютын биржүүд болон хөрөнгө оруулагчдыг хар жагсаалтад оруулж болох эрх үүргийг ногдуулсан байна⁶⁷. OFAC нь тодорхой нэг улс руу хандахгүй бөгөөд крипто валютын харилцааны үйл ажиллагаа нь буруу гэж тогтоосон хувь хүн, албан байгууллага, бүлэглэл, компаниудыг хар жагсаалтад оруулах чиглэлтэй байна.

е.Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ (Financial Crimes Enforcement Network)

Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ (FinCEN) нь АНУ-ын Төрийн санхүүгийн хууль сахиулах байгууллагын үүрэг гүйцэтгэдэг бөгөөд виртуал валютын зохицуулалт, хэрэгжилтийг удирдан чиглүүлэх үүрэгтэй. FinCEN-ийн албан ёсны цахим хуудсанд "FinCEN-ийн эрхэм зорилго нь санхүүгийн системийг хууль бус ашиглалтаас хамгаалах, мөнгө угаахтай тэмцэх, санхүүгийн тагнуул, санхүүгийн эрх мэдэлтнүүдийн мэдээллийг цуглуулах, шинжлэх, түгээх замаар үндэсний аюулгүй байдлыг хангахад оршино⁶⁸ гэж тэмдэглэжээ.

FinCEN нь виртуал валютыг зарим санхүүгийн нөхцөлд валют шиг тооцогддог боловч бодит валютын бүх шинж чанарыг агуулдаггүй солилцооны хэрэгсэл юм гэж томъёолжээ. Виртуал валют нь харьяаллын дагуу хууль ёсны төлбөрийн статус байдаггүй.⁶⁹ Виртуал хөрөнгө эзэмшигч АНУ-ын фиат долларын арилжааг маш хурдан крипто валютаар сольж

⁶⁵ "SEC What We Do," U.S. Security and Exchange Commission, June 10, 2013, <https://www.sec.gov/Article/whatwedo.html>. Хандагт 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

⁶⁶ Clayton, "Statement on Cryptocurrencies." Хандагт: 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдөр

⁶⁷ Oily Jackson, "Ofac's Crypto Blacklist Could Drive Investors to Riskier Exchanges," International Financial Law Review, April 6, 2018, <http://www.iflr.com/Article/3799007/%5bOPEN: ACCESS%5d-Ofacs-crypto-blacklist-could-drive-investors-to-riskier-exchanges.html>. Хандагт: 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдөр

⁶⁸ "What We Do," United States Department of the Treasury Financial Crimes Enforcement Network, accessed April 22, 2018, <https://www.fincen.gov/what-we-do>. Хандагт: 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдөр

⁶⁹ Financial Crimes Enforcement Network, Application of FinCEN's Regulations to Persons Administering, Exchanging, or Using Virtual Currencies, FIN-2013-G001 (Washington, DC: Department of the Treasury, 2013), <https://www.fincen.gov/sites/default/files/shared/FIN-2013-G001.pdf>. 1. Хандагт 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр

байгаа, хэрэглэгчдийн эрэлт их байгаа учир FinCEN мөн виртуал валют харилцааг ихээр сонирхон судалж байна.

Виртуал валютын харилцаа нь Банкны нууцын тухай хууль (BSA)-н хууль тогтоомжийг дагадаг ба FinCEN-аас гаргасан акт нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай заалтуудын илүү оруулж өгөхийг хичээж байна.⁷⁰ 2013 оны удирдамжид тусгасны дагуу, албан ёсоор виртуал валютын харилцаанд FinCEN-ийн журмуудыг ашиглаж байна.

FinCEN нь виртуал валютын харилцаанд оролцогч талуудыг үндсэн гурван ангилал болох *хэрэглэгч*, *администратор* болон *мөнгө дамжуулагч* тал гэж хуваан тодорхойлдог байна.⁷¹ Одоогийн хэрэгжүүлж байгаа FinCEN-ийн журам нь зөвхөн виртуал валютын үйлчилгээ үзүүлэгч буюу администратор болон мөнгө дамжуулагч талтай хамаатай байна. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч виртуал хөрөнгийн албан ёсны мөнгөн дэвсгэртэд хөрвүүлэх, олон төрлийн виртуал хөрөнгийг хооронд нь арилжих, виртуал хөрөнгийн шилжүүлэг гүйцэтгэх, виртуал хөрөнгийг удирдах хэрэгслийг зохицуулахтай холбоотой санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч юм.

2.Европын Холбооны эрх зүйн зохицуулалт

Одоогийн байдлаар Европын Холбоонд олон улс орныг хамарсан (supernational) крипто валютын эрх зүйн зохицуулалт хууль ёсных бөгөөд энэхүү хуулиар Европын Холбооны улс орнууд крипто валютын хуулийн зохицуулалт хийдэг байна. АНУ-тай харьцуулахад ЕХ-ны Төв банк (ECB) нь крипто валютыг зохицуулахдаа *laissez-faire* аргачлал ашигладаг бөгөөд "биткойн болон бусад крипто валютыг хориглох, зохицуулах нь ECB-ийн үүрэг биш юм" гэж албан ёсоор мэдэгджээ. ECB нь олон нийтэд виртуал валютын талаар мэдээлэл, крипто валютад хөрөнгө оруулах, ашиглах эрсдэлийг тодруулсан мэдээллийг хүргэхээр ажиллаж байна. ECB нь биткойн болон бусад виртуал валютуудыг жинхэнэ валют гэж үзэхгүй байгаа бөгөөд дараах дөрвөн үндэслэлийг дурдаж байна. Нэгдүгээрт, виртуал валютад төв эрх мэдэл /төрийн/ байдаггүй. Хоёрдугаарт, виртуал валютын үйлчлүүлэгч болон хэрэглэгчийн тоо хязгаарлагдмал байдаг. Гуравдугаарт, ЕХ-ноос крипто валютын харилцааны албан ёсны хууль эрх зүйн хамгаалалт байхгүй байгаа. Эцэст нь, крипто валютын хэлбэлзэл хэт их, урьдчилан таамаглах боломжгүй, найдвартай төлбөрийн хэлбэр биш юм.

2017 оны 11-р сард, ЕХ-ны Европын аюулгүй байдал, зах зээлийн удирдах газраас (ЕСМА) ICO-ийн үүсэж болон эрсдэлийн тухай ЕХ-ны иргэдэд зориулсан олон нийтийн удирдамж бэлтгэн гаргасан.⁷² ЕСМА нь виртуал валютын худалдаж авах, арилжаалах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг өргөжүүлж зорилгоор иргэд, олон нийтэд мэдээлэл түгээх зорилготой гарын авлага, удирдамжаа тогтмол бэлтгэн гаргасаар байна.

3.Олон улсын хууль, эрх зүйн зохицуулалт

ОУВС болон BIS зэрэг олон улсын стандарт тогтоогч санхүүгийн байгууллагууд виртуал хөрөнгийн харилцаа, зохицуулалтад анхаарал хандуулж, судалгаа шинжилгээ хийсээр байна. Энэхүү судалгааны ажилд крипто валютын харилцаатай холбоотой улс, орнуудад үүсгэж болзошгүй нийтлэг асуудлуудын бодитой мэдээллийг ОУВС, BIS-ийн гаргасан судалгааны тайлангаас иш татан авав. Жишээлбэл, ОУВС-н Донг Хэ болон бусад судлаачдын хийсэн судалгааны ажилд Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага ФАТФ (FATF) болон НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас гаргасан AML/CFT олон улсын стандартад Хөрөнгө оруулагч компаниудын мөнгө угаах үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, хэрхэн олон улсын хуулиар хамгаалах зааварчилгааг нэгтгэсэн байдаг.⁷³ Олон улсын шинэ стандарт баталсан ч гэсэн тухайн улс энэхүү стандартын хүлээн зөвшөөрсөн эсэхээс хамаарч олон улсын эрхзүйн зохицуулалт хийгддэг байна. Энэхүү мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх олон улсын стандарт үйлчилдэг ч, крипто валютын олон улсын хууль эрхзүйн зохицуулалт дутмаг хэвээр байна.

⁷⁰ Financial Crimes Enforcement Network, Application of FinCEN's Regulations. Хандалт 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр

⁷¹ Financial Crimes Enforcement Network, Application of FinCEN's Regulations, 2. Хандалт 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр

⁷² "ESMA Highlights ICO Risks for Investors and Firms," European Securities and Markets Authority, November 13, 2017, <https://www.esma.europa.eu/press-news/esma-news/esma-highlights-ico-risks-investors-and-firms>. Хандалт: 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

⁷³ He et al., Virtual Currencies and Beyond, 26. Хандалт: 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

Дүгнэлт

Дэлхийн улс орнуудын төрийн зохицуулах агентлагууд крипто валютыг хязгаарлах, батлах тал дээр хатуу чанга байр суурьтай байдаг. Хэд болон бусад судлаачдын хийсэн судалгаагаар бодлого боловсруулагчдад тулгарч буй гол бэрхшээл нь крипто валютын эрсдэлийг тодорхойлох болон шинэ хөрөнгө оруулалтыг тогтвортой байлгах хоёрын тэнцвэрийг олох юм.⁷⁴ Үүнээс гадна, крипто валютыг хязгаарлах эсвэл хориглох тал дээр либерал ардчилсан орнуудад хувь хүний хууль ёсны ашиг сонирхол гэж илүүтэйгээр үзэж байна. Тиймээс улс орнууд одоо хүчин төгөлдөр байгаа хуулиа илүү судалж өөрчлөлт, зохицуулалт хийх /АНУ-д хэрэгжүүлж байгаагаар адил/ эсвэл шинээр хууль батлах замаар виртуал валютын хууль, эрхзүйн зохицуулалт хийх боломжтой байна.

Криптовалютын хууль, эрх зүйн зохицуулалт нь хийж батлах нь ихэнх улс орны хувьд өмнө нь хийж байгаагүй шинэ байгаа учир засгийн газрууд санхүүгийн хууль бус үйл ажиллагааг багасгахын тулд виртуал валютын талаар хуулийн шинэ зохицуулалт хийх зайлшгүй шаардлагатай болж болно. Засгийн газрын удирдах байгууллагууд виртуал валютын талаар баримтлах бодлогыг үл харгалзан хамгийн түрүүнд мөнгө угаах, мөнгөний бодлого, хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Крипто валютын хууль, эрх зүйн зохицуулалтын чиглэл нь нийгэм, улс төр, эдийн засгийн олон хүчин зүйлээс хамаарна. Виртуал валютын зохицуулалтыг хэрхэн хийх нь АНУ-д ажиглагддаг практик, олон талт хандлага, ЕХ-ны хувь хүний хууль ёсны ашиг сонирхлыг илүүд үзэх үзэл, эсвэл илүү өргөн хүрээтэй зохицуулалтыг шинээр бий болгох зэргийг харгалзан мөн тухайн улс крипто валютыг сөрөг нөлөөг хэрхэн үнэлж байгаагаас хамаарна. Энэхүү өгүүллэгт бүрэн эрхт улс ямар шалтгаанаар крипто валютыг үндэсний хууль, эрх зүйн зохицуулалтаар зохицуулах эрмэлзэх болсныг онцлон авч, улс орнуудад хэрэгжүүлж болох хэд хэдэн зохицуулах арга хэмжээний талаар дурдав.

Ном зүй

1. https://mn.wikipedia.org/wiki/Peer_to_peer_computing. 2021 оны 03 дугаар сарын 05
2. <https://coinmarketcap.com/ru/all/views/all/> Хандалт: 2021 оны 04 дүгээр сарын байдлаар/
3. <https://www.investing.com/crpto/bitcoin/btc-usd/> /Хандалт: 2021 оны 05 дугаар сарын байдлаар/
4. U.S. Commodity Futures Trading Commission, CFTC Backgrounder on Oversight of and Approach to Virtual Currency Futures Markets (Washington DC: U.S. Commodity Futures Trading Commission, 2018), https://www.cftc.gov/sites/default/files/ido/groups/public/%40customerprotection/documents/file/backgrounder_virtualcurrency01.pdf, 1. Хандалт: 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдөр
5. Huang, "Reaching within Silk Road," 2105. Хандалт: 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдөр
6. Internal Revenue Service, IRS Virtual Currency Guidance: Virtual Currency Is Treated as Property for U.S. Federal Tax Purposes; General Rules for Property Transactions Apply (Washington DC: Internal Revenue Service, 2014), <https://www.irs.gov/newsroom/irs-virtual-currency-guidance>. Хандалт 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдөр
7. "Mission & Responsibilities," U.S. Commodity Futures Trading Commission, accessed April 22, 2018, <https://www.cftc.gov/About/MissionResponsibilities/index.htm>. Хандалт 2020 оны 10 дугаар сарын 23
8. "SEC What We Do," U.S. Security and Exchange Commission, June 10, 2013, <https://www.sec.gov/Article/whatwedo.html>. Хандалт 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр
9. Clayton, "Statement on Cryptocurrencies." Хандалт: 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдөр
10. Olly Jackson, "Ofac's Crypto Blacklist Could Drive Investors to Riskier Exchanges," International Financial Law Review, April 6, 2018, <http://www.iflr.com/Article/3799007/%5bOPEN-ACCESS%5d-Ofacs-crypto-blacklist-could-drive-investors-to-riskier-exchanges.html>. Хандалт: 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдөр

⁷⁴ He et al., Virtual Currencies and Beyond, 28. Хандалт: 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

11. Financial Crimes Enforcement Network, Application of FinCEN's Regulations to Persons Administering, Exchanging, or Using Virtual Currencies, FIN-2013-G001 (Washington, DC: Department of the Treasury, 2013), https://www.fincen.gov/sites/default/files/shared/FIN-2013-G001.pdf_1. Хандалт 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр
12. "ESMA Highlights ICO Risks for Investors and Firms," European Securities and Markets Authority, November 13, 2017, <https://www.esma.europa.eu/press-news/esma-news/esma-highlights-ico-risks-investors-and-firms>. Хандалт: 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЭРҮҮ БА ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН НЭР ТОМЬЁНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Н.Манлайбаатар

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн
тэнхимийн эрхлэгч, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: Эрүүгийн эрх зүй дэх нэр томьёоны асуудал нь эрүүгийн процессын эрх зүйд хэрхэн хуульчлагдсан тухай зарим асуудлыг товч авч үзлээ. Материаллаг болон процессын эрх зүйн нэр томьёо нь хууль агуулгаараа харилцан хамааралтай, салаа утгатай байж болохгүй боловч, эрүүгийн хууль тогтоомжийн практикт томъёолол өөр боловч нэг утгаар ойлгогдож буй байдал буйг бид анхаарах шаардлагатай.

Түлхүүр үг: Эрүүгийн эрх зүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, мөрдөн байцаалт, эрүүгийн процессын эрх зүй, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа

Хууль зүйн шинжлэх ухааны нэр томьёоны асуудал нь эрх зүйн онолд хууль зүйн техникийн судлагдахуун болохын зэрэгцээ хууль тогтоомжийн агуулга, үзэл санааны талаасаа нэршил, томъёолол нь хатуу тогтсон, нэгдмэл утгатай байхаас гадна, ойлгомжгүй, ярины болон бусад харь үг хэрэглэхийг аль болох хязгаарладаг.

Гэсэн хэдий ч хууль зүйн шинжлэх ухааны хэрэглэх нэр томьёо өнөөдөр багагүй интеграцилагдлаа. Өөрөөр хэлбэл өмнөх зуунд хэрэглэж байсан нэр томьёо нь агуулгын хувьд нийгмийн хөгжлийн сэтгэлгээ, оюун санааны сан хөмрөгт тэр бүр тохирохгүй байх, тухай нэр томьёоны агуулга, үзэл санааг дахин авч үзэх, философидох нь түгээмэл болжээ.

Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор Д.Баярсайхан “Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйгээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо”-нд шилжих тухай тэмдэглэн хэлсэн нь судлаачдын анхаарлыг татдаг. Тийм ч учраас өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль⁷⁵ нь нэршил, томъёололын хувьд ийнхүү хуульчлагдсан нь манай улсын эрх зүйн шинэчлэл нь хууль зүйн шинжлэх ухаан дахь тогтсон үзэл баримтлал, сэтгэлгээнд өөрчлөлт оруулах, улмаар хууль сахиулах, шүүн таслах ажиллагааны тогтолцоог эргэн харах үндэслэл болжээ.

Эрүүгийн процессын шинэчлэл өөрчлөлт нь 1992 онд Монгол Улсын Үндсэн хууль⁷⁶ батлагдснаас хойш эхлэсэн хэдий ч 2012 оноос нийгмийн баримжаа, олон улсын гэрээ, конвенци зэргээс хамааран нэлээд өвөрмөц өөрчлөлт, шинэчлэлтийг хийсэн билээ. Энэ утгаараа бидний хувьд нэршил, томъёололын хувьд эргэж харах, анхаарууштай зүйлс байгааг нарийвчлан судлахгүй орхигдуулсаар байна. Эрүүгийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хэрэглэж буй үг, түүний хууль зүйн агуулга ягшмал нэг ойлголт, агуулгыг илэрхийлж байх ёстой гэсэн үзэл санааны сургаалиуд⁷⁷ одоо ч онолын хувьд баримтлагдаж буй билээ.

Нэгэнт судлаачдын хувьд хууль зүйн техникийн тэр дундаа эрх зүйн актын хэлэнд тавигдах шаардлагыг хууль зүйн доктор (Ph.D), профессор Ч.Нямсүрэн тэмдэглэжээ. Үүнд:

1. Эрх зүйн хэм хэмжээний томъёолол нь хатуу тогтсон, нэгдсэн стандарт, хэл зүйн дүрэмтэй байх,

2. Эрх зүйн хэм хэмжээний актын нэр томьёо нэгдсэн нэг байх: актын нэг нэр томьёо, нэг үг нь нэг л утгыг илэрхийлсэн байх; нэг ойлголт нь нэг л нэр томьёог илэрхийлсэн байх; нэр томьёо тодорхой ойлгомжтой байх. Тэдгээр нэр томьёог нэг хэв загвараар ойлгоход нэр томьёоны утгыг тодорхойлсон хуульчилсан тодорхойлолт буюу дифинитив хэм хэмжээг ашиглаж болно,

3. Эрх зүйн хэм хэмжээний актад шинжлэх ухаан, практикт нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нэр томьёон хэрэглэх,

⁷⁵ Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2017 он. <https://legalinfo.mn/law/details/12694?lawid=12694> үзнэ үү.

⁷⁶ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. УБ., 1992 он. №1.

⁷⁷ Эрх зүйн онолын чиглэлээр өргөн, далайцтай судалгаа хийсэн эрдэмтэд болох хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор Ч.Нямсүрэн, Д.Баярсайхан нарын бүтээлд энэ талаар нэгдмэл байр суурьтай байдгийг энд тэмдэглэв.

4. Гадаад үг, шинэ үн хэллэг, хуучирсан үг, цэцэн үг, зүйр үг, болон оновчтой бус хоёр буюу олон салаа утгатай үг хэрэглэхээс аль болох зайлхийх зэрэг шаардлага тавигддаг⁷⁸ гэж тэмдэглэжээ. Дээрхээс үзвэл эрх зүйн хэм хэмжээний актын гадаад илрэх хэлбэр болох хууль, хуульчилсан актын үг, нэр томьёо, илэрхийлэх дэг нь онолын хувьд үндсэндээ шийдвэрлэх шалгуураа тавьсан байна.

Бидний авч үзэж байгаа хууль зүйн шинжлэх ухааны нэр томьёо нь эрх зүйн хэллэгээр дамжин, эрх зүйн мэргэжлийн ойлголт, нэршил, категориор тэмдэглэгдэн илэрхийлэгдэж тусгагдсан байдаг⁷⁹ нь хэл шинжлэлийн болон хууль зүйн ухааны салбар дундын шинжтэй судлагдахууныг бүтээнэ. Эрх зүй хэллэг гэдэг нь олон улсын болон тухай улсын хэл зүйн онцлогыг тусгасан, хууль зүйн мэргэжлийн зориулалтаар хэрэглэгдэж буй нэр томьёо, томъёолол, утгын гаргалгаа бүхий өгүүлэгдэхүүн мөн гэснийг дэмжиж байна.

Дурьдан буй үзэл санааны үүднээс авч үзвэл хууль зүйн шинжлэх ухааны агуулгыг илэрхийлдэг хүлээн зөвшөөрөгдсөн нэр томьёо нь салбар мэдлэгийн тогтолцооны үнэт зүйл, зарчмын илрэл болно. Үүнээс үзвэл эрүүгийн болон эрүүгийн процессын эрх зүйн хэллэг, нэр томьёо нь өргөн агуулгаар ойлгогдохоос гадна өөр хоорондоо харилцан уялдаатай, хэрэглэхэд хоёрдмол утгагүй, онолын хувьд ч нэг мөр ойлгогдох, сургалт, эрдэм шинжилгээний явцад мөн агуулгын зөрүүгүй байх шаардлагатай.

Эрүүгийн хууль⁸⁰-ийн шинэчилсэн найруулгыг 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлан гаргасан бөгөөд хуулийн зарим нэр томьёо нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль⁸¹-д хэрэглээгүй нэр томьёог хэрэглэсэн нь бидний анхаарлыг татаж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь нэршил, томъёололын хувьд “эрүүгийн байцаан шийтгэх” гэсэн уламжлалт нэршлээс татгалзаж, бусад салбар процессын эрх зүйн нэршил, томъёололыг хэрэглэх болсон. Тухайлбал; Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай⁸², Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай⁸³, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай⁸⁴ зэргээр нэгдмэл томъёололтой байгааг хэрэглэх нь зүйтэй гэсэн агуулгаар ийнхүү хууль тогтооchoос үзсэн. Гэвч Зөрчил шалган шийдвэрлэх тухай⁸⁵ хууль нь уг үзэл санаа, томъёололыг хэрэглээгүй нь хууль тогтоогчийн үзэл баримтлал нэгдмэл бус байсныг илтгэдэг. Өөрөөр хэлбэл, зөрчлийг шалгаж шийдвэрлэх гэсэн томъёолол нь эрүүгийн процесст хэрэглэгдэх эсэх асуудлыг хөндөж байгаа юм. Хууль дээдлэх зарчим, хууль зүйн шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоон дахь хууль зүйн техникийн асуудал нь сүүлийн жилүүдэд ийнхүү эмх цэгц, нэгдмэл үзэл санааны агуулгаа бүрэн илэрхийлэхгүй байгааг бид анхаарах шаардлагатай.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйл⁸⁶-ийн 3 дахь хэсэгт, мөн хуулийн тусгай ангийн 13.4 дүгээр зүйл⁸⁷-ийн 1 дэх хэсэгт, мөн хуулийн 21 дүгээр бүлэг⁸⁸ нь “Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг” гэж, мөн 21.6 дугаар зүйл⁸⁹-ийн 1 дэх хэсэгт “Шүүгч, прокурор, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчийг хэрэг шалган шийдвэрлэх

⁷⁸ Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. УБ., 2017 он. 205 дахь тал.

⁷⁹ Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ., 2018 он. 109 дэх тал.

⁸⁰ Монгол Улсын Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/ <https://legalinfo.mn/law/details/11634?lawid=11634> үзнэ үү.

⁸¹ Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ <https://legalinfo.mn/law/details/12694?lawid=12694> үзнэ үү.

⁸² Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль нь 1997 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байна.

⁸³ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байна.

⁸⁴ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байна.

⁸⁵ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль нь 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байна.

⁸⁶ Монгол Улсын Эрүүгийн хууль. /Шинэчилсэн найруулга/ 2015.12.03-ны өдөр. 7.5 дугаар зүйл “Хөрөнгө, орлогыг хураах албадлыг арга хэмжээ” гэсэн нэр томъёог хэрэглэсэн.

⁸⁷ Монгол Улсын Эрүүгийн хууль. /Шинэчилсэн найруулга/ 2015.12.03-ны өдөр. 13.14 дүгээр зүйл “Хүнийг хүчээр алга болгох” гэсэн нэр томъёог хэрэглэсэн.

⁸⁸ Эрүүгийн хуулийн 21 дүгээр бүлэг “Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг” гэсэн агуулгаар томъёологдсон нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэсэн процессын эрх зүйн агуулгыг илэрхийлэхгүй байна. Энэ нь төдий л хууль хэрэглэхэд хүндрэл үүсгэхгүй, өөр өөр утга, агуулгатай нэр, томъёог нэгдмэл утгаар хэрэглэж байгаагийн илэрхийлэл гэж үзэхэд хүргэж байна.

⁸⁹ Монгол Улсын Эрүүгийн хууль. /Шинэчилсэн найруулга/ 2015.12.03-ны өдөр. 21.6 дугаар зүйл “Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх” гэмт хэрэгт мөн нэр томъёог хэрэглэсэн.

ажиллагааг...”, мөн 21.9 дүгээр зүйл⁹⁰-ийн 2 дахь хэсэг, мөн 21.14 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт тус тус “хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаа” гэж томъёолжээ. Өөрөөр хэлбэл, “хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаа” гэсэн томъёолол нийт долоон удаа хэрэглэсэн байгааг эрүүгийн процессын хууль тогтоомжтой улдаа холбоо нь хангагдаагүйг илэрхийлэх, хууль тогтоомжийн нэршил, томъёолол нэгдмэл байх, нэг мөр байх, агуулга нь өөр хоорондоо тохирох, хоёрдмол утга илэрхийлэхгүй байх зэрэг шаардлагаас зөрүүтэй байгаа нь ийнхүү хуульчлагдан бэхжигдсэн байна. Мөн эрүүгийн хуульд “хэрэг шалган шийдвэрлэх” гэсэн томъёолол ч хэд хэдэн зүйлд хуульчлагдсан. Ийм учраас гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг шалгах, шийдвэрлэх, шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд ч хэрэг шалган шийдвэрлэх гэсэн томъёоллыг хэрэглээгүй, хуульчлаагүй атал Эрүүгийн хуулийн ерөнхий ба тусгай ангийн аль алинд хэд хэдэн удаа хэрэглэсэн байна.

Энэ нь эрх зүйн шинэчлэлийн явцад эрдэмтэн судлаачдын гаргаж байсан санаа бодол хуульд шууд туссаныг илэрхийлнэ. Тухайлбал, хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, цагдаагийн хурандаа Ж.Болдбаатар “эрүүгийн хэргийг хянаж шийдвэрлэдэггүй бөгөөд, шалгаж шийдвэрлэдэг юм” гэж эрх зүйн шинэчлэлийн ажлын хэсэгт саналаа тодорхой хэлж, хуулийн нэршил, томъёоллыг шүүмжилсэн билээ. Уг шүүмжийг ажлын хэсэг хүлээн авч 2014 оны сүүлчээр “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх” гэснийг “Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх” гэсэн томъёололоор сольж, хуулийн төслийг боловсруулж байсан нь Эрүүгийн хуульд тусгалаа олсон байгааг бид дээр авч үзлээ.

Хэдийгээр өөр хоорондоо харилцан хамааралгүй мэт боловч эрх зүйн процессын хэллэг, нэр томъёо нэг мөр төлөвшин тогтоогүй, салбарын дуу хоолой, байгууллага, институт хоорондын тус тусын амбиц, эрх мэдлийн нөлөөлөл ч хууль зүйн техник, хэллэгт ийнхүү хэлбэржин хуульчлагддаг болохыг цухас дурьдая.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйл “Нотолбол зохих байдал”-ын 1.5 дахь хэсэгт “гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар” зэргийг нотолгооны зүйл болгон хуульчлан бэхжүүлсэн. Үүнээс анхаарах зүйл нь “хор уршиг” нотолгооны зүйл гэж үзсэн нь өмнө үйлчилж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудад байгаагүй жишиг билээ. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн улмаас учирсан хохирол буюу шууд үр дагаврыг нотолгооны зүйл гэж үзэж, хор уршиг нь хохирлоос үүссэн үр дагавар гэж онолын хувьд үзэж ирсэн.

Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлд “Гэмт хэргийн хохирол, хор уршиг” гэж томъёолсон ба 2 дахь хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршигт тооцно”, мөн 3 дахь хэсэгт “Энэ хуульд заасан “ноцтой хохирол, хор уршиг” гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эд хөрөнгийн эрхэд, эсхүл улс орон, хүн амын аюулгүй байдалд ач холбогдол бүхий эрхэд хохирол, хор уршиг учирсныг ойлгоно” гэж тус тус заасан нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэг мөр тусгалаа олжээ гэж үзэх үндэслэлтэй байна. Эрүүгийн хуулийн тусгай ангид “ноцтой хохирол” учруулсан бол гэсэн нийт 10 гэмт хэрэг⁹¹ байгаа нь нэг мөр ойлгогдохоор байгаа. Гэсэн хэдий ч “ноцтой хор уршиг” гэсэн агуулгыг нэг мөр ойлгох, хэрэглэх талаарх утга бүрэн илэрхийлэгдэхгүй байгаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нотолгооны зүйлийг нотлоход хүндрэл үүсгэж болох юм.

Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ хуульд заасан “ноцтой хохирол, хор уршиг” гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эд хөрөнгийн эрхэд, эсхүл улс орон, хүн амын аюулгүй байдалд ач холбогдол бүхий эрхэд хохирол, хор уршиг учирсныг ойлгоно” гэсэн нь ноцтой хор уршигийг тодорхойлоогүй байна гэх үндэслэлийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, “ноцтой хохирол” гэсний ард таслал⁹² тавьсан нь “ноцтой хор уршиг” гэсэн утга илэрхийлээгүй, “ноцтой хохирол”-ын агуулгаар “хор уршиг”-ийг ойлгохоор хуульчлан

⁹⁰ Монгол Улсын Эрүүгийн хууль. /Шинэчилсэн найруулга/ 2015.12.03-ны өдөр. 21.9 дүгээр зүйл “Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах” гэмт хэрэгт мөн нэр томъёог хэрэглэсэн.

⁹¹ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйл “Хулгайлах”, 17.9 дүгээр зүйл “Бусдын эд хөрөнгийг хамгаалахад хайнга хандах”, 17.12 дугаар зүйл “Мал хулгайлах”, 19.6 дугаар зүйл “Хорлон сүйтгэх”, 20.16 дугаар зүйл “Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах”, 21.5 дугаар зүйл “Гэрч, хохирогч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөлөх”, 22.11 дүгээр зүйл “Дураараа аашлах”, 23.2 дугаар зүйл “Хуурамч бичиг баримт үйлдэх”, 23.4 дүгээр зүйл “Улсын бүртгэлд зориуд худал мэдээлэл оруулах, хуурамч баримт бичиг үйлдэх”, 27.1 дүгээр зүйл “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, усан онгоц, агаарын хөлгийн хөдөлгөөнд аюултайгаар халдах” зэрэг гэмт хэргүүд.

⁹² Бичигт өгүүлбэрийн гишүүдийг тусгаарлах, өгүүлбэрийн утга санааг тодруулах зорилгоор гох мэт хэлбэртэй тэмдэглэгээг хэрэглэх, өгүүлбэрийн утга ялгах тэмдэглэгээ гэжээ. https://mongolpoli.mn/search.php?uq_id=B5158&opt=1&word=%D0%A2%D0%90%D0%A1%D0%9B%D0%90%D0%9B үзнэ үү.

бэхжүүлсэн гэж бид үзэж байна. Гэтэл Эрүүгийн хуулийн тусгай ангид нийт 5 гэмт хэрэг⁹³, т “ноцтой хор уршиг” гэсэн томъёолол байгааг бид амьдралд хэрхэн хэрэглэх талаар нэгдсэн ойлголтгүй, тайлбаргүй хэрэгжүүлж буй нь цаашид анхаарах асуудал болж байгааг энд мөн тэмдэглэх нь зүйтэй. Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хувьд харьцангуй төлөвшсөн, судалгаан шинжилгээний ажил өргөн хийгддэг тул харьцангуй тогтвортой нэршил, томъёолол нь тогтсон. Гэсэн хэдий ч эрх зүйн шинэчлэл нь хууль тогтоомжийг өөрчлөн найруулахад алдаа гарч буй нь бидний анхаарлыг татаж байна. Хууль тогтоомжийн уялдаа холбоо, нэгдмэл ойлголттой байх, нэг нэр томъёогоор илэрхийлэх ойлголтыг нэг томъёололтой илэрхийлэх, өөр хооронд нь харьцуулан шинэчлэл хийх, салбарын эрдэмтдийг хууль тогтоох үйл хэрэгт оруулах, тэдний үзэл санааг тусгаж байх нь батлан гаргаж байгаа хуулийн хэл, нэршил, томъёололыг нэг мөр болгох ач холбогдолтой гэж үзэж байна.

Эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг боловсронгуй болгох, шинэчлэх явцад гарсан нэг асуудал бол хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг нь тус тусдаа байсны илрэл гэж үзэх үндэслэлтэй. Өөрөөр хэлбэл, 2021 оноос эрх зүйн шинэчлэлийн үйл хэрэг эхлэсэн цагаас эрүүгийн хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ажлын хэсгээс тус тусдаа боловсруулсан бөгөөд хуулийн төслийг өөр хооронд харгуулах талаар дорвитой үйл ажиллагаа явуулаагүй нь дурьдан буй нөхцөл байдлыг бий болох үндэслэл нь болжээ.

Гэмт хэрэгтэй тэмцэхэд төрөөс тогтоосон хууль тогтоомжийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх нь чухал тул хууль зүйн техникийн асуудалд салбарын эрдэмтийг чиглүүлж, тэдний дэмжлэг, санаа бодолыг хууль тогтоох эрх мэдлийн байгууллагад хүргэх, салбар дундын шинжтэй асуудал тул хуулийн их, дээд сургуулиудын оролцоонд тулгуурласан эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнийг зохион байгуулах шаардлагатай. Түүний мөрөөр мэргэжлийн тэнхим, төвүүд тодорхой үйл ажиллагаа төлөвлөх, зохион байгуулах нь хууль тогтоомжийг боловсронгуй болгоход томоохон түлхэц болно.

Эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход хэл шинжлэлийн ухааны салбарын эрдэмтэн судлаачидтай хамтран ажиллах шаардлагатай байгаа нь нэгэнт илэрхий болжээ. Хууль зүйн шинжлэх ухаанд хэрэглэгдэж буй үгийн утга хөөх, цуваа утга тодорхойлох, харь үгийн нутагшсан байдлыг судлан тогтоох, зарим талаар ажлын хэллэг хуульчлагдаж байгаа нь бидний хувьд анхаарал татаж байна. Хууль зүйн шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоо нь салбар салбарын чиглэлээр мэргэших, глобалчлагдах хандлагатай болсон нь мэдлэгийн тогтолцооны ялгарал ихээхэн явагдаж байгааг илэрхийлнэ. Энэ нь эрүүгийн хууль тогтоомжийн хэллэг, нэр томъёог ч өргөтгөх, шинэ институт хөгжих байдлаар илэрч байна. Тухайлбал, Эрүүгийн хэргийг хялбаршуулан шийдвэрлэх процесс, хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэх зэргээр улам бүр хөгжиж байгаа боловч хууль зүйн техникийн асуудал орхигдож байгааг бид авч үзлээ.

Цаашид эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн уялдаа холбоог хангах, хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжуудын нийцэл, нэр томъёоны асуудлаар өргөн хүрээтэй хэлэлцүүлэг зохион байгуулж, хууль тогтоох байгууллагад байр сууриа илэрхийлэх нь чухал гэж үзэж байна.

⁹³ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.3 дугаар зүйл “Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах”, 14.4 дүгээр зүйл “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд саад учруулах”, 17.6 дугаар зүйл “Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх”, 21.6 дугаар зүйл “Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх”, 23.7 дугаар зүйл “Нийтийн албан тушаалтныг заналхийлэх” зэрэг гэмт хэргүүд.

ГЭМТ ХЭРЭГ ИЛРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН МЭДЭЭ, БАРИМТ СЭЛТ

М.Цогтмоо Доктор, профессор
Б.Оргилдорж Докторант

Товч агуулга. Гэмт хэрэг илрүүлэх, бүрэн илрүүлэх үйл ажиллагаанд товч тодорхойлолт өгч, тухайн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалттай холбоотой зарим асуудлыг хөндөж, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай санал дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг. Гэмт хэрэг илрүүлэх, гэмт хэргийг бүрэн илрүүлэх, гүйцэтгэх ажил, гүйцэтгэх байгууллага, гүйцэтгэх ажилтан, гүйцэтгэх ажлын буюу тагнуулын арга, гэмт хэргийн тухай гүйцэтгэх ажлын мэдээ, баримт сэлт, мөрдөн шалгах нууц ажиллагаа, мөрдөгч, прокурор, эрэн сурвалжлах ажил, нотолбол зохих байдал, хэргийн илрүүлбэл зохих нөхцөл байдал.

1. Гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагааны тухай товч ойлголт

Гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын эрх зүйн салбарт сайн судлагдаагүй асуудлын нэг юм. Гүйцэтгэх ажлын тухай хууль⁹⁴, Тагнуулын байгууллагын тухай хууль⁹⁵, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх (ЭХХШ) тухай хууль⁹⁶, Авлигын эсрэг хууль⁹⁷ зэрэг хуульд “гэмт хэрэг илрүүлэх” гэдэг нэр томъёог, Терроризмтой тэмцэх тухай хуульд “Террорист үйлдлийг илрүүлэх” хэмээх нэр томъёог тус тус хэрэглэсэн боловч тэдгээрийг илрүүлэх гэж юуг хэлэх тухай албан ёсны тайлбар байхгүй байна. Манай улсын эрдэмтэд, судлаачдаас академич С.Нарангэрэл гуай л тэр тухай тодорхойлолт өгсөн аж. Тэрээр, гэмт хэрэг илрүүлэхийг “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тогтоох ба энэ нөхцөл байдлыг байцаан шийтгэх ажиллагааны баримт бичигт бэхжүүлэх”⁹⁸ хэмээн тодорхойлжээ.

Манай улсын ЭХХШ тухай хуульд “... гэмт хэргийг ... бүрэн илрүүлэх”⁹⁹ “... гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг илрүүлэх, олж тогтоох”¹⁰⁰, “... гэмт хэргийн шинжийг өөрөө илрүүлсэн...”¹⁰¹ гэх зэрэг нэр томъёо хэрэглэсэн байна. Тэдгээрийг тусгасан заалтуудыг харьцуулан ажиглахад манай хууль тогтоогчид **гэмт хэргийг илрүүлэх** гэдэг ойлголтод “гэмт хэргийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг илрүүлэх, олж тогтоох” зэрэг ажиллагааг хамааруулаагүйн гадна “гэмт хэргийг илрүүлэх” гэдэг нэр томъёог чухам ямар утгаар хэрэглэсэн нь ойлгомжгүй, тодорхой бус байна гэж хэлж болмоор.

Тухайн асуудлаар ОХУ-ын судлаачдын байр суурийг авч үзье. Хууль зүйн ухааны дэд доктор Е.С.Дубоносов “Гэмт хэргийг илрүүлэх гэж тодорхой этгээдийн үйл явдал буюу үйлдэлд эрүүгийн хуульд заасан ямар нэг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж тэмдгүүдийг тогтоохыг хэлнэ”¹⁰² гэсэн бол хууль зүйн ШУ-ны доктор К.Ф.Гуценко болон М.А.Ковалёв нар “гэмт хэргийн шинж бүхий үйлдэл, эс үйлдэл, үйл явдлыг олж илрүүлэх (обнаружить)-ийг гэмт хэрэг илрүүлэх гэнэ”¹⁰³ гэж тодорхойлсон байна. Харин хууль зүйн шинжлэх ухааны доктор А.Ю.Шумилов “Эрүүгийн хуулиар хориглосон, нийгэмд аюултай үйлдэл болон түүнийг хийсэн этгээдийг олж илрүүлэх (обнаружение)-ийг гэмт хэрэг илрүүлэх гэнэ”¹⁰⁴ гэж үзсэн байна.

Дээрх судлаачдын тодорхойлолтуудыг харьцуулан үзэхэд Оросын судлаач, дэд доктор Е.С.Дубоносов, шинжлэх ухааны доктор А.Ю.Шумилов нар эрүүгийн хуулиар хориглосон, нийгэмд аюултай үйл явдал, үйлдэл зэрэг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж тэмдэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж илрүүлэхийг гэмт хэрэг илрүүлэх гэж үзэж байгаа бол К.Ф.Гуценко, М.А.Ковалёв нар уг ойлголтод зөвхөн гэмт хэргийн шинж бүхий үйлдэл, эс үйлдэл, үйл явдлыг олж илрүүлэх (обнаружить)-ийг ойлгож байна. Сүүлчийн хоёр судлаачийнхаар гэмт хэрэг

⁹⁴ Гүйцэтгэх ажлын тухай хууль. 9.1.1, 9.1.3, 9.1.4, 12.1.2, 12.3

⁹⁵ Тагнуулын байгууллагын тухай хууль. 11.1.2, 11.1.4

⁹⁶ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 1.1.1, 6.1.1.2, 6.1.2.6.2.2.5, 6.2.4.6.3.1.1, 13.3.1.1, 16.4.1

⁹⁷ Авлигын эсрэг хууль. 9.16, 18.5.4

⁹⁸ С. Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. Хоёр дахь хэвлэл. Улаанбаатар. 2008, 36-р тал

⁹⁹ ЭХХШ тухай хууль. 1.1.1

¹⁰⁰ Мөн тэнд. 6.2.2.5, 6.2.4.6.3.1.1, 16.4.1, 30.1.1.21.1, 30.1.30.2-р зүйл

¹⁰¹ ЭХХШ тухай хууль. 4.1.2.2

¹⁰² Е.С. Дубоносов. Основы оперативно-розыскной деятельности. Москва, 2002 с 30

¹⁰³ Г.Ф.Гуценко, М.А.Ковалёв. Правоохранительные органы. Издание седьмое. Москва, 2002, с 333

¹⁰⁴ А.Ю.Шумилов. Оперативно-розыскная энциклопедия. Москва, 2002, с 43

илрүүлэх гэдэг ойлголтод зөвхөн гэмт үйлдэл (эс үйлдэл), үйл явдлыг илрүүлэхийг хамааруулж, харин тэдгээрийг үйлдсэн этгээдийг олж тогтоосон байхыг шаардахгүй байна.

Гэмт хэрэг илрүүлэх тухай бидний ойлголт дэд доктор Е.С.Дубоносов, шинжлэх ухааны доктор А.Ю.Шумилов нарынхтай үндсэндээ ижил байгаа бөгөөд энэ нь манай хууль сахиулах байгууллага, хуульчдын практикт байдаг нийтлэг ойлголт гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, **гэмт хэрэг илрүүлэх** гэж гэмт хэргийн шинж бүхий үйлдэл, эс үйлдэл, түүнийг хийсэн гэж сэжиглэгдэгч этгээдийг илрүүлэн олж тогтоосон байхыг хэлж болох юм. Гэхдээ гэмт хэргийг илрүүлэх нь нэн харьцангуй ойлголт болохыг тэмдэглэх нь зүйтэй. Учир нь гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэгч этгээд, түүний сэжиг бүхий үйлдлийг шалгах явцад тухайн гэмт үйлдлийг сэжигтэн этгээд үйлдээгүй, эсвэл сэжиг бүхий үйлдэл гэмт хэргийн шинжгүй болох нь тогтоогдох явдал нэг биш байдаг.

Дээр дурдсанчлан, ЭХХШ тухай хуульд гэмт хэрэг илрүүлэх гэдэг ойлголтод гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлэн олж тогтоохыг хамааруулахгүй байгаа нь "...гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг илрүүлэх, олж тогтоох"¹⁰⁵ хэмээх олон заалтаас илэрхий байна. ЭХХШ тухай хуульд "гэмт хэргийг бүрэн илрүүлэх" гэдэг нэр томъёог тайлбарлаагүй, холбогдох заалтуудыг харьцуулан ажиглахад ойлгомж муутай гэж хэлмээр... Учир нь тухайн хуульд зааснаар "... гэмт хэргийг ... бүрэн илрүүлэх"¹⁰⁶ гэдэг ойлголтод "...гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох..." ажиллагааг мөн л хамааруулаагүй байна. ЭХХШ тухай хуульд зааснаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь юуны өмнө "...гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх,..."-эхэд орших атал тийнхүү гэмт хэргийг илрүүлэх, бүрэн илрүүлэх гэж чухам юуг ойлгох талаар албан ёсны тайлбар, тодорхойлолт байхгүй байгаад анхаарахгүй байж боломгүй. Гэмт хэрэг илрүүлэх талаар нэгдсэн, зөв ойлголттой байх нь онолын ч, практикийн ч багагүй ач холбогдолтой нь ойлгомжтой. Зөвхөн практикийн талаас нь л цухас тэмдэглэхэд, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгтэй цагдаа, тагнуул, АТГ зэрэг цөөнгүй байгууллага, тэдгээрийн холбогдох нэгж, ажилтнуудын ажлын үр дүнг үнэлдэг нэг гол үзүүлэлт нь илрүүлсэн гэмт хэрэг байх жишээтэй. Энэ бүхний тухай нурушихаа азная.

Бидний үзэж байгаагаар, **гэмт хэргийг бүрэн илрүүлэх** гэж гэмт хэргийг хэн, хэзээ, хаана, хэрхэн үйлдсэн; гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр; гэмт хэргийн улмаас учирсан хор хохирол, түүний шинж чанар, хэмжээ; яллагдагч, шүүгдэгчийг яллах, тэдэнд оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал; гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл зэргийг нотлох баримтаар нотлон тогтоохыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, тэр нь хэргийн бодит байдлыг тогтоох¹⁰⁷-од чиглэсэн мөрдөгч, прокурор, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий гүйцэтгэх ажилтан болон шүүгчийн цогц үйл ажиллагааны, яллагдагч, шүүгдэгчийг яллах, ялыг хүндрүүлэх нөхцөл байдлыг нотлон тогтооход чиглэсэн бүрэлдэхүүн хэсэг нь гэж хэлж болно. Гэмт хэргийг илрүүлэх, бүрэн илрүүлэх үйл ажиллагааны мөн чанар нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой мэдээ, баримт сэлтийг ЭХХШ тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу олох, цуглуулахад оршино. Гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагаа нь түүнд ашиглаж байгаа аргаас хамаарч мөрдөн шалгах шалгах ажиллагаагаар илрүүлэх, гүйцэтгэх ажлын буюу тагнуулын аргаар илрүүлэх гэсэн үндсэн хоёр хэлбэртэй байж болох юм. Гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагааг нарийвчлан судлах, түүний дотор тэр нь хэргийн нөхцөл байдлыг нотлох үйл ажиллагаанаас ямар ялгаатай гэх зэрэг асуулт зохих судалгаа, хариултыг хүлээж байна.

Гэмт хэргийг илрүүлэх нь ил, эсхүл далд үйлдэлтэй гэх зэрэг тухайн гэмт хэргийн нөхцөл байдлаас багагүй хамаардаг байна. **Ил үйлдэлтэй гэмт хэрэг** гэж хэрэг үйлдсэн нь ямар ч эргэлзээгүй ил тод, түүнийг үйлдсэн этгээд тодорхой байгаа гэмт хэргийг нэрлэж болох юм. Далд үйлдэлтэй гэмт хэрэг гэж гэмт хэргийн бүрэлдэхүүний зарим шинж байгаа боловч гэмт хэрэг үйлдэгдсэн нь эргэлзээтэй, эсвэл гэмт хэргийн үйл баримт (факт преступления) байгаа ч түүнийг хэн үйлдсэн нь тодорхойгүй байгаа тийм гэмт хэргийг ихэвчлэн хэлдэг байна.¹⁰⁸ Харин биднийхээр гэмт хэргийн үйл баримт ил байхгүй, гэмт хэрэг үйлдэгчдэд байж болох шууд бус шинж тэмдгээс өөр гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж тэмдэг тэр бүр илэрдэггүй, далд үйлдэлтэй гэмт хэрэг ч байж болно. Түүнд "Гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах" "Эх орноосоо урвах", "Хахууль авах", "Хахууль өгөх" гэх зэрэг цөөнгүй гэмт хэргийг хамааруулж болно.

¹⁰⁵ ЭХХШ тухай хууль. 6.2.2.5, 6.2.4, 6.3.1.1,

¹⁰⁶ ЭХХШ тухай хууль. 1.1.1

¹⁰⁷ ЭХХШ тухай хууль. 1.7 дугаар зүйл

¹⁰⁸ Д.Мунжжаргал. Оперативно-розыскное раскрытие убийств, совершаемых с корыстной мотивацией. Диссертация кандидата юридических наук. СПб, 2007, с 143

2.Гэмт хэргийг илрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч төрийн зарим байгууллага, албан тушаалтан ба гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий гүйцэтгэх байгууллага

Гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагааг биечлэн хэрэгжүүлэгч үндсэн субъект нь мөрдөгч гэж хэлж болно. Мөрдөгч нь хуульд заасан эрх, үүргийн дагуу, эсхүл прокурорын даалгавраар хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, өөрөөр хэлбэл, гэмт үйлдлийг илрүүлэх,түүнийг хийсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох мөрдөн шалгах ажиллагаа явуулна. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны дарга нь мөрдөн шалгах ажиллагааг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах замаар гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоохын тулд шуурхай зохицуулалт хийх, хэргийн материалтай биечлэн танилцах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцох, мөрдөгчийг бичгээр зааварлан биелэлтийг хангуулах, мөрдөгч хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх,шаардлагатай тохиолдолд мөрдөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх замаар гэмт хэргийг илрүүлэхэд оролцдог гэж үзэж болно.

ЭХХШ тухай хуульд зааснаар,прокурор нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьж, төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцоно. Тэрээр "... хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын явцад мөрдөгч,эрх бүхий албан тушаалтан ЭХХШ тухай хуулийг хэрэгжүүлж байгаад хяналт тавьж, хууль зөрчсөн шийдвэрийг ...хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүчингүй болгож, хариуцлага тооцуулна."¹⁰⁹ Судлаачдын үзэж байгаагаар, прокурор нь "... мөрдөн шалгах бүхий л ажиллагаанд хяналт тавихдаа гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хүлээн авах,шалгаж, хэрэг бүртгэлтийн хэрэг нээх,хаах, харьяаллын дагуу шилжүүлэх,эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах процессын хугацаа, хуулийн холбогдох заалтуудыг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх шаардлага, журмыг чанд сахих биелүүлэх үүрэг хүлээнэ"¹¹⁰. Прокурор ийм байдлаар гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагаанд оролцдог гэж үзэж болно.

Шүүх нь ЭХХШ тухай хуульд зааснаар шүүх хуралдаанаар мөрдөн шалгах ажиллагааг нөхөн гүйцэтгэх¹¹¹ болон мөрдөгчид хүн, хуулийн этгээд, эд зүйл, эд хөрөнгийг олох зорилгоор эрэн сурвалжлах ажил явуулах шийдвэр¹¹² өгөх зэргээр гэмт хэргийг илрүүлэхэд оролцож байна гэж үзэх үндэстэй юм. Энэ талаас нь авч үзвэл, шүүх нь "байцаан шүүх, нотлогч шүүх"-ийн журмаар гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагаанд оролцож байна гэж хэлж болно.

Гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэгддэг хүч, арга, хэрэгсэл, заль мэх, гэмт хэрэгтэй тэмцэх, түүний дотор илрүүлэх бололцоо нөхцөл зэрэг гэмт хэргийн нөхцөл байдлыг үндэслэл болгон түүнийг илрүүлэх байгууллага, илрүүлэхдээ ашиглах хүч, арга, хэрэгслийг ЭХХШ тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Тагнуулын байгууллагын тухай хуулиар тус тус тогтоож өгсөн байна. Тухайлбал, ТЕГ-ын мөрдөн шалгах нэгжид гадаадын тагнуулын алба,байгууллага,иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах, эх орноосоо урвах, төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах, хорлон сүйтгэх, үндэсний эв нэгдлийг бусниулах гэх зэрэг илрүүлэхэд нэн төвөгтэй гэмт хэргүүдийг харьяалуулжээ. Далд аргаар үйлдэгддэг тэдгээр гэмт хэргийг зөвхөн мөрдөн шалгах ажиллагаагаар илрүүлэх боломжгүй учраас тэдгээр гэмт хэрэгтэй нууц хүч, арга, хэрэгсэл ашиглан тэмцэх, түүний дотор илрүүлэх эрх, үүргийг ТЕГ, түүний сөрөх тагнуулын зэрэг холбогдох нэгжид оногдуулсан гэж үзэж болох юм.

Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгтэй цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажил эрхэлдэг нэгжүүдэд хуулиар харьяалуулсан гэмт хэргүүдээс зөвхөн "...далд аргаар үйлдэгдсэн, эсхүл тодорхой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох..."¹¹³ зорилгоор гүйцэтгэх ажил явуулж, дээр дурдсан тусгай хүч, арга, хэрэгсэл ашиглах эрх олгосон ажээ.

Авлигатай тэмцэх газрын холбогдох нэгжид "...авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах ..." ¹¹⁴ тусгай хүч, арга, хэрэгслийг ашиглах эрх олгосон нь далд аргаар үйлдэгддэг авлигын гэмт хэргийг үндсэндээ өөр аргаар илрүүлэх боломж маш багатай холбоотой юм.

¹⁰⁹ ЭХХШ тухай хууль.4.2.1

¹¹⁰ Жавхлангийн Бямбаа, Жамбаачүлтэмийн Эрхэсхулан. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн үндсэн асуудлууд. УБ. 2018. тал 107

¹¹¹ ЭХХШ тухай хууль.33.3.1.2

¹¹² ЭХХШ тухай хууль.12.4.1

¹¹³ Гүйцэтгэх ажлын тухай хууль.9.1.3

¹¹⁴ Авлигын эсрэг хууль. 10.4.5

Гэмт хэргийг илрүүлэх үйл ажиллагааг тийнхүү мөрдөгч, прокурор, шүүхээс гадна дээр дурдсанчлан, илрүүлэхэд илүү төвөгтэй, учруулах хор хохирол, аюул нь нэн их, тодорхой төрлийн гэмт хэрэгтэй ихэвчлэн нууц хүч, арга, хэрэгслийг ашиглан тэмцэх чиг үүрэг бүхий тагнуулын үйл ажиллагаа буюу гүйцэтгэх ажил эрхэлдэг зарим байгууллага ч явуулдаг.

Гүйцэтгэх ажлын тухай хуульд мөрдөгч, прокурор, шүүгч гүйцэтгэх ажил эрхлэх байгууллагад даалгавар өгч болохоор тусгасан¹¹⁵ бол ЭХХШ тухай хуульд гүйцэтгэх байгууллагад тийм даалгаврыг зөвхөн мөрдөгч өгөхөөр тусгасан юмуу даа гэлтэй. Дээрх байдлууд нь өнгөц харахад зөвхөн нэр заасан хоёр хуулийн хоёр гурван заалт зөрүүтэйг харуулж буй мэт боловч нарийвчлан авч үзвэл, ЭХХШ ажиллагаанд гэмт хэрэгтэй тагнуулын буюу гүйцэтгэх ажлын аргаар тэмцэх байгууллага, ажилтан, гүйцэтгэх ажлын эзлэх байр суурийн тухай асуудал хөндөгдөж байгаа юм. Шүүх гүйцэтгэх байгууллагад даалгавар өгөх эрхтэй бол хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны шатанд гэмт хэрэг илрүүлэхэд гүйцэтгэх байгууллага бас оролцох нь хэмээн ойлгож болно.

Энэ бүхнээс улбаатайгаар гэмт хэрэгтэй тэмцэхээр зохиох гүйцэтгэх ажил буюу дотоод тагнуулын үйл ажиллагаа нь гэмт хэрэг илрүүлэх бие даасан үйл ажиллагаа юу, эсхүл хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурорын байгууллага, шүүхээс гэмт хэрэг илрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зориулалттай үйл ажиллагаа юу? гэдэг асуулт гарч таарна. ҮАБ, түүний дотор тагнуулын зэрэг олон төрлийн асуудлын судалгаагаар мэрэгшсэн АНУ-ын "РАНД" хэмээх судалгааны байгууллагын судлаачдын үзэж байгаагчлан тагнуул болон хууль сахиулах үйл ажиллагааны ялгааны асуудал нь ихээхэн маргаантай юм¹¹⁶. Манай зарим нэг хуульч энэ асуудлыг хөндсөн¹¹⁷ ба ОХУ-ын эрдэмтэд нэгдмэл ойлголтод хүрээгүй байна. ОХУ-ын Н.А.Виниченко, С.И.Захарцев гэх зэрэг эрдэмтэд гэмт хэргийг гүйцэтгэх ажлын аргаар илрүүлэх нь ЭХХШ үйл ажиллагааны нэг элемент, өөрөөр хэлбэл бие даасан үйл ажиллагаа биш, харин дээрх үйл ажиллагааны нэг хэсэг гэж үзжээ.¹¹⁸ Харин А.Ю.Шумилов, А.С.Соколов гэх зэрэг цөөнгүй эрдэмтэн судлаачид уг үйл ажиллагааг ЭХХШ ажиллагаанд дэмжлэг үзүүлэх төдий хавсрага биш, бие даасан үйл ажиллагаа¹¹⁹, өөрөөр хэлбэл, гэмт хэргийг илрүүлэх нь ЭХХШ ажиллагаа, гүйцэтгэх буюу тагнуулын үйл ажиллагаа гэсэн бие даасан хоёр төрлийн үйл ажиллагааны явцад хэрэгждэг хэмээн үзэж буй болно.

Харин бид сүүлчийн эрдэмтэн судлаачдын байр суурийг үндсэнд нь дэмжиж байна. Гэхдээ тагнуулын аргаар гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагаа нь хоёрдмол шинжтэйг тэмдэглэвэл зохино. Уг үйл ажиллагаа нь "... гэмт хэргийг шуурхай бүрэн илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоох..." зэрэг ЭХХШ ажиллагааны нийтлэг зорилтын хүрээнд, цөөнгүй тохиолдолд ЭХХШ ажиллагаанаас өмнө буюу түүнтэй зэрэг эхэлж, далд үйлдэлтэй гэмт хэргийг нууц болон бусад хүч, арга, хэрэгслийг ашиглан илрүүлэх замаар гэмт хэрэг үйлдсэн этгээд болон бусад байдлыг олж тогтоодог. Гүйцэтгэх ажлын тухай хуульд зааснаар гэмт хэргийг бүрэн илрүүлэхэд гүйцэтгэх байгууллага хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд ч гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох, барьцаанд байгаа хүнийг суллах, сураггүй алга болсон хүн болон алга болсон эд зүйл, баримт бичгийг эрж олох, түүнчлэн " гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг эрэн сурвалжлах, нотлох баримт цуглуулах, тэдгээрийн эх сурвалжийг олж тогтоох..."¹²⁰ зорилгоор гүйцэтгэх ажлын буюу тагнуулын арга хэмжээнүүдийг зохиодог. Гэмт хэрэг илрүүлэхээр зохиох гүйцэтгэх ажлын буюу тагнуулын арга хэмжээг тийнхүү ЭХХШ ажиллагаатай зэрэгцэн болон түүнээс өмнө явуулахаас гадна холбогдох үндэслэл болох мэдээ олсон тохиолдолд Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан "...урьд үйлдсэн ... хэргийг илрүүлэх, ..." зорилгоор¹²¹ явуулдаг ажээ.

Сөрөх тагнуул, эрүүгийн тагнуулын байгууллагын ажлын практикаас үзэхэд, гүйцэтгэх ажлын буюу тагнуулын аргаар илрүүлсэн зарим тагнуулч, туршуул болон шаардлагатай бусад этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хариуцлагад татахгүй???, харин ҮАБ-ыг тагнуулын аргаар хангах, тодорхой төрлийн гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлын буюу тагнуулын

¹¹⁵ Гүйцэтгэх ажлын тухай хууль. 11.2.3

¹¹⁶ Reorganizing U.S. Domestic Intelligence: Assessing the Options By Gregory F. Treverton, Steven W. Popper, Steven C. Bankes, Gerald P. Frost

¹¹⁷ М.Цогтоо. "Тагнуул үйлдэх гэмт хэргийг сөрөх тагнуулын аргаар илрүүлэх онол, арга зүйн асуудал" нэг сэдэвт бүтээл. УБ.2011.

¹¹⁸ Т.Оюунчимэг. Использование результатов оперативно-розыскной деятельности в уголовном процессе Монголии. Диссертация кандидата юридических наук. УБ, 2010, с 10

¹¹⁹ А.Ю.Шумилов. Оперативно-розыскная деятельность как разновидность юридической деятельности. Москва, Фирма АВС, 1997, сс 22-23

¹²⁰ Гүйцэтгэх ажлын тухай хууль. 12.1,6,18.1.2

¹²¹ Гүйцэтгэх ажлын тухай хууль. 9.1.4

аргаар тэмцэх зорилгод ашиглах, үл халдах эрх дархтай гадаадын иргэнийг "тааламжгүй этгээд" хэмээн мэдэгдэж, улс орноосоо явуулах захиргааны арга хэмжээ авах нь бий... Энэ бүхнээс үзвэл, гэмт хэрэгтэй тэмцэх, түүний дотор гэмт хэргийг илрүүлэхээр зохиох гүйцэтгэх ажил буюу тагнуулын үйл ажиллагааг ихэнхдээ ЭХХШ ажиллагаанаас өмнө буюу түүнтэй зэрэгцэж болон зарим тохиолдолд түүний дараа ч хэрэгжүүлдэг илрүүлэх үйл ажиллагааны үр дүн нь хуулиар тогтоосон зарим нэг тохиолдолд ЭХХШ ажиллагаанаас гадна тагнуулын болон захиргааны арга хэмжээ авах үндэслэл болж ашиглагддаг, холбогдох хуулийн дагуу төрийн эрх бүхий байгууллагаас явуулдаг төрийн тусгай үйл ажиллагаа болох нь харагдаж байна.

Нийгэмд хэрэгтэй ямар ч төрлийн үйл ажиллагаа нь 1920-1930-аад онд, тухайн үеийн ЗХУ-ын эрдэмтэн Выготский, С.Л.Рубенштейн, А.Н.Леонтьев нар үндэс суурийг нь тавьсан үйл ажиллагааны онолын хүрээнд явагддаг байна. Уг онол ёсоор нийгэмд хэрэгтэй тодорхой төрлийн үйл ажиллагааг зөвхөн холбогдох субъект тодорхой зорилго, чиглэлээр тодорхой объект руу чиглүүлэн явуулдаг; субъектын ашиглах хүч, арга, хэрэгсэл нь түүнээс үйл ажиллагаагаа чиглүүлэх объект, тухайн объектоос үйл ажиллагаандаа ашиглаж буй хүч, арга, хэрэгслийн онцлогийг харгалзсан байдаг; субъект, объектын хооронд явагдах харилцан хамаарал бүхий үйл ажиллагаа нь тодорхой орчин нөхцөлд явагддаг байх ёстой. Нийгэмд ашигтай аливаа үйл ажиллагааны субъектын ашигладаг хүч, арга, хэрэгсэл нь тэрээр үйл ажиллагаагаа чиглүүлэх объект, тэрхүү объектын үйл ажиллагаа, хүч, арга, хэрэгслийн онцлогийг харгалзсан, түүнд дүйцсэн байдаг нь тухайн онол хийгээд хүн төрөлхтөний түүхийн олон зуун жилийн практикаар нэгэнт нотлогдсон зүйл юм. Нэлээд болхидуухан боловч илүү ойлгомжтой жишээг хэлбэл, гаднын зэвсэгт түрэмгийллийн эсрэг гав, бороохой, нулимс асгаруулагч, гар буу зэрэг хэрэгсэл, зэвсэг бүхий цагдаагаа биш, харин зэвсэгт хүчнээ ашигладаг.

Зөвхөн мөрдөн шалгах ажиллагаагаар илрүүлэх боломжгүй, нууц далд аргаар үйлдэгддэг тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэдгээрт дүйцэх нууц буюу гүйцэтгэх ажлын аргаар тэмцэхээр манай улсын Гүйцэтгэх ажлын тухай хууль, Тагнуулын байгууллагын тухай хууль хийгээд холбогдох бусад хууль тогтоомжоор тогтоосон нь дээрх онол болон хүн төрөлхтөний тухайн чиглэлийн практик үй ажиллагаатай бүрнээ нийцэж байна.

3.Гэмт хэргийн талаарх гүйцэтгэх ажлын мэдээ, баримт сэлтийг нотлох баримтад тооцох шаардлага ба анхаарах зарим асуудал

Гүйцэтгэх ажлын тухай хуульд, тухайн хуульд заасан"...үндэслэлээр цуглуулсан, эсхүл иргэн, хуулийн этгээдээс... ирүүлсэн мэдээ, мэдээллийг судалж шалган шийдвэрлэх..."¹²², түүнийхээ үр дүнг "... гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг эрэн сурвалжлах, нотлох баримт цуглуулах, тэдгээрийн эх сурвалжийг олж тогтоох"¹²³ зорилгоор ашиглахаар заасан. Мөн хуульд бас "Прокурор гүйцэтгэх ажлын явцад авагдаж, эрүүгийн хэргийн нотлох баримт болгосон баримт сэлтийг хуульд заасан үндэслэл, нөхцөл, журмын дагуу цуглуулсан эсэхэд хяналт тавина"¹²⁴ гэж заасан нь бий.

ЭХХШ тухай хуульд мөрдөгч эрх бүхий байгууллагад захиалга буюу даалгавар өгч гүйцэтгүүлж болох мөрдөн шалгах нууц ажиллагааны төрөл, зорилго, зарим нэгийг нь явуулах үндэслэл, түүнчлэн тэдгээрийн үр дүнг нотлох баримтад тооцож болох тухай зэрэг асуудлыг анх удаа хуульчлан тогтоох оролдлого хийсэн нь ЭХХШ ажиллагаа, ялангуяа гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагаа, түүний явцад хүний эрхийг хангах эрх зүйн зохицуулалт дахь том алхам болсон гэж хэлж болно.

Харин гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлын буюу тагнуулын¹²⁵ аргаар тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагууд гүйцэтгэх ажлын арга хэмжээний үр дүн буюу гэмт хэрэгтэй холбоотой гүйцэтгэх ажлын мэдээ, баримт сэлтийг "... гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг эрэн сурвалжлах, нотлох баримт цуглуулах, тэдгээрийн эх сурвалжийг олж тогтоох"¹²⁶ зорилгод ашиглах боломжийг ЭХХШ тухай хуулиар хязгаарлаж, Гүйцэтгэх ажлын тухай хуулиас холбогдох заалтыг хассан нь ЭХХШ тухай хуулийн холбогдох

¹²² Гүйцэтгэх ажлын тухай хууль. 17.1

¹²³ Гүйцэтгэх ажлын тухай хууль. 18.1.2

¹²⁴ Мөн тэнд. 23.5

¹²⁵ Бид "гүйцэтгэх ажил" гэдэг нэр томъёог оновчгүй гэж үзэж, түүний оронд агуулгаа яв цав илэрхийлсэн "тагнуулын үйл ажиллагаа" хэмээх нэр томъёог хэрэглэх нь зүйтэй гэж үзэж буй. Энэ тухай "М.Цогтоо. Тагнуулын нэр томъёоны асуудалд" өгүүллийг "Тусгаар тогтнол" сэтгүүлийн 2017 оны №7(37)-оос уншина уу.

¹²⁶ Гүйцэтгэх ажлын тухай хууль. 18.1.2

заалтуудыг Гүйцэтгэх ажлын тухай хуулийн бодлогын шинжтэй, зарчмын чухал ач холбогдолтой зүйл, олон заалттай илэрхий зөрчилтэй болгосон байна. ЭХХШ тухай хуулийн тэрхүү заалтууд нь гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлын буюу тагнуулын аргаар тэмцэх чиг үүрэг бүхий ТЕГ-ын Сөрөх тагнуулын нэгж, ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн алба, Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх газар, ШШГЕГ-ын Гүйцэтгэх хэлтэс, АТГ-ын Гүйцэтгэх хэлтэс зэрэг байгууллага, тэдгээрийн гүйцэтгэх ажилтнуудын гэмт хэрэгтэй нууц хүч, арга, хэрэгслийг ашиглан тэмцэх үйл ажиллагаа, түүний үр дүнг үл хэрэгссэн явдал болжээ гэж дүгнэхэд хилсдэхгүй бол уу.

Гүйцэтгэх ажлын арга хэмжээний үр дүн буюу гүйцэтгэх ажлын мэдээ, баримт сэлт гэж мөрдөгчийн даалгавраар явуулахаар ЭХХШ тухай хуульд нэр заасан мөрдөн шалгах нууц ажиллагаа, тэдгээрийн үр дүн биш гэдэг нь ойлгомжтой. Мөрдөгчийн даалгавраар мөрдөн шалгах нууц ажиллагааг хэрэгжүүлж буй ТЕГ зэрэг гүйцэтгэх байгууллагын нууц ажиглалт, тусгай техникийн нэгжүүд нь гүйцэтгэх ажилд зөвхөн дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэйг санавал гүйцэтгэх ажлын талаар төсөөлөл авахад нэмэртэй байж болох юм. Гүйцэтгэх ажил буюу тагнуулын үйл ажиллагааны амин сүнс нь гүйцэтгэх ажилтан буюу тагнуулч, нууц ажилтан, туслагчийг нууцаар ашиглахад оршдог. Тэдгээрийг гэмт хэрэг үйлдэгчид, сэжиг бүхий этгэдүүд болон гэмт бүлэглэл,түүнчлэн ихэвчлэн далд үйлдэлтэй гэмт хэрэг үйлдэгддэг объект хийгээд шаардлагатай бусад газарт янз бүрийн халхавч, арга, заль мэхийг хэрэглэн нэвтрүүлж, ашиглах арга замаар нууц далдуур гэмт хэрэг үйлдэгчдийг илрүүлэн тогтоодог. Түүний явцад тэдгээрийг хуурч мэхлэх, задлан бутаргах, халдлагыг нь хуурамч объектод чиглүүлэх, гэмт үйл ажиллагаанаас нь татгалзуулах болон гэмт хэргийг далдуур санаачлан зохион байгуулагч гэх зэрэг хамтран оролцогчид, тэдгээрийн гэмт хэргийн оролцоог тогтоох гэх зэргээр урьчилан сэргийлэх, гэмт халдлагыг нь таслан сэргийлэх, таслан зогсоох, үйлдлийг нь баримтжуулах, гэрчилж болох хүмүүсийг олж мэдэх гэх зэрэг олон талын цогц арга хэмжээг хэрэгжүүлдэг. Энэ бүхэн нь гүйцэтгэх ажилтнаас ихээхэн хүч, хөдөлмөр, өвөрмөц сэтгэлгээ, арга,ухаан, заль мэхийг шаарддаг.

Гэмт бүлэглэлүүдийн дотор тиймэрхүү ажиллагааг хэрхэн явуулдгийг “Лео Мартин” гэх зэрэг янз бүрийн нууц нэрээр ажиллаж, ихээхэн үр дүнд хүрсэн Германы эрүүгийн нэрт тагнуулчийн герман,орос, англи, солонгос зэрэг нэлээд хэдэн хэлээр хэвлэгдсэн Leo Martin. Ich krieg dich(“Би таныг элсүүлнэ”) номоос уншиж болно. Түүнийг монгол хэлнээ “Элсүүлэгч”¹²⁷ хэмээн орчуулж, хэвлүүлсэн нь ч бий. Лео Мартин, “Гэмт бүлэглэлийн бүтэц зэргийг мэдээллийн нууц эх сурвалжийн тусламжтайгаар илрүүлэх нь тагнуулын байгууллагын ажлын үндсийн үндэс юм. ... Тагнуулынхан хэргийн тухай мэдээ, баримт сэлтийг бүрэн бүрдүүлж, цагдаагийн мөрдөн байцаах албанд шилжүүлэх тэр үед л гэмт хэргийн нарийн учир начрыг цагдаагийнханд тайлбарлаж өгдөг...” гэх зэргээр өгүүлсэн байна.

“Эртний Хятадын агуу их сэтгэгч,гүн ухаантан, цэргийн жанжин Сүнз “Дайтахуйн ухаан” хэмээх суут бүтээлдээ “... хэрэг явдалд тагнуулаас илүү итгэлт ойр нь үгүй, хөхиүлэн шагнахуйд тагнуулаас илүү ихийг хүртэх нь үгүй, хэрэг явдалд тагнуулаас илүү чанд нууц нь үгүй...Тагнуулыг эс зарах газар ер үгүй...”¹²⁸ гэснийг санахад ер илүүдэхгүй.

Зарим нэг хуульч хувийн үзэл бодлоо тайлбарлахдаа, ЭХХШ тухай хуульд гэмт хэрэгтэй гүйцэтгэх буюу тагнуулын аргаар тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудаас эрх хэмжээнийхээ хүрээнд зохиосон гүйцэтгэх ажлын арга хэмжээний үр дүнг “гэмт хэргийн талаар гаргасан иргэн, хуулийн этгээд, албан тушаалтны гомдол, мэдээлэл”¹²⁹-д хамааруулан шалгах аргаар тусгасан гэх... Гэтэл “... гэмт хэргийг илрүүлэх,таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг эрэн сурвалжлах, нотлох баримт цуглуулах, тэдгээрийн эх сурвалжийг олж тогтоох “зорилгоор хуульд заасан тусгай хүч, арга хэрэгслийг ашиглан гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагаас явуулсан хууль ёсны үйл ажиллагааны үр дүнг гэмт хэргийн талаар гаргасан иргэн, хуулийн этгээд, албан тушаалтны гомдол, мэдээлэлд хамааруулж ойлгож болохгүй нь ойлгомжтой. Ардчилал хөгжсөн цөөнгүй улс орны холбогдох хууль тогтоомжид гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор явуулж буй гүйцэтгэх ажил буюу тагнуулын үйл ажиллагааны явцад холбогдох үндэслэл, нөхцөл, журмын дагуу олж, цуглуулсан гэмт хэргийн талаарх мэдээ, баримт сэлтийг тогтоосон журмын дагуу мөрдөн шалгах зэрэг байгууллагад албан ёсоор шилжүүлдэг, тэдгээр мэдээ, баримт сэлт нь холбогдох шаардлага,шалгуурыг хангасан гэж үзсэн тохиолдолд зохих журмын дагуу нотлох баримтад тооцдог нийтлэг журамтай болоод удаж байна.

¹²⁷ Лео Мартин. Элсүүлэгч. УБ.2020

¹²⁸ Сүнз. Сүнзийн дайтахуйн ухаан.УБ.2005.Урианхан овогт Мэнэрэлийн Чимэдцээгийн орчуулга. тал 62

¹²⁹ ЭХХШ тухай хууль. 30.2.1.1

Терроризм, хүний наймаа, хар тамхи, мансууруулах бодис, зэвсгийн хууль бус худалдаа, мөнгө угаах гэх зэрэг нарийн зохион байгуулалттай,улс үндэстэн дамнаж, орчин үеийн янз бүрийн техник хэрэгслийг ашиглан үйлдэгдэж байгаа гэмт хэргийн аюул, заналхийлэл улам өсөн нэмэгдэж, дэлхийн хүн зонь сэтгэлийг зовоосон асуудлын нэг болоод буй. Тэдгээртэй тэмцэх, түүний дотор илрүүлэх, баримтжуулахад нэн төвөгтэй учраас гүйцэтгэх ажлын буюу тагнуулын аргаар тэмцэх үйл ажиллагаа, түүний үр дүнгийн нотолгооны ач холбогдол улам өсөн нэмэгдэж байна. Тиймээс ч гадаад улс орнуудын төр засгаас тэр талаар янз бүрийн судалгаа хийж, холбогдох арга хэмжээ авсаар байна. Жишээлбэл, АНУ-ын Конгрессоос яамандаа өгсөн үүргийг хэрэгжүүлэхийн тулд АНУ-ын Дотоод аюулгүй байдлын яам(ДАБЯ) АНУ-ын "РАНД" судалгааны байгууллагад хандан тус улсад терроризмтой тэмцэх бие даасан тусгай алба байгуулах шаардлагатай эсэх тухай асуудлыг судлуулах ажлын хүрээнд Холбооны мөрдөх товчоо (ХМТ), ДАБЯ зэрэг дотоод тагнуулын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, харилцан ажиллагаатай холбоотой томоохон судалгаа хийлгэсэн байна. "РАНД"-ын судлаачид судалгааныхаа үр дүнд, тагнуулын ажил зонхилсон бодлогыг хууль сахиулах үйл ажиллагаатай оновчтой хослуулан хэрэгжүүлэх, ялангуяа гэмт халдлага, аюул заналыг дотоод тагнуулын мэдээлэл олж цуглуулах, шинжлэх арга замаар буюу тагнуулын аргаар илрүүлэх, урьдчилан сэргийлэх нь чухал гэдэг дүгнэлтэд хүрсэн байна¹³⁰. Түүнийг монгол хэл дээр ч¹³¹ уншиж болно.

Уламжлалаа хатуу чанд баримталдаг Их Британий, Аюулгүй байдлын алба(МИ-5)-ны тэргүүн, тус албаны үйл ажиллагааг хүйтэн дайны дараах шинэ нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөх ажлыг зоримог шийдвэртэй хэрэгжүүлснээрээ нэрд гарсан Стелла Ремингтон, дэлхий дэх шинэ дэг журам нь мансууруулах бодисын хууль бус эргэлт,мөнгө угаах зэрэг олон улс дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг өсөн нэмэгдэх нөхцлийг бүрдүүллээ. Бид террористуудын эсрэг тэдний хэрэглэж буй арга, хэрэгслийг ашиглаж ирсэн. Дээр дурдсан, улс дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй амжилттай тэмцэхийн тулд түүнийг үйлдэгчдийн хэрэглэж байгаа арга,зэвсэг,хэрэгслийг мөн ашиглан тэмцэх хэрэгтэй. Манай алба зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг ч нэмж авч хэрэгжүүлэхэд бэлэн байна хэмээн мэдэгдэж байсан билээ. Британий ДЯЯ, цагдаагийн өндөр албан тушаалтнуудын эсэргүүцлийг үл харгалзан тус улсын парламент 1995 онд Ремингтоны саналын дагуу МИ-5-ын эрх мэдлийг нэлээд өргөтгөсөн ажээ. МИ-5 нь улс орныхоо УАБ-ыг тагнуул, терроризм, ажил хорлон саатуулах аюул, заналхийллээс хамгаалах, түүний дотор гадаад улс гүрнүүдийн туршуулуудын үйлдэл болон улс төр,аж үйлдвэрийн хийгээд хүчирхийллийн арга, хэрэгсэл ашиглан парламентын ардчиллыг устгах, хорлон сүйтгэхэд чиглэсэн үйл ажиллагаанаас хамгаалах; Холбооны хаант улсын эдийн засгийн чинээлэг байдлыг Британий арлуудын гаднах этгээдүүдийн үйлдэл, санаархлаас учрах аюул, заналхийллээс хамгаалахаас гадна ...цагдаагийн болон хууль сахиулах бусад байгууллагаас ноцтой гэмт хэргийг таслан **сэргийлэх**, илрүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиг үүрэгтэй¹³² болоод буй.

ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийг хамгаалах газар хуулиар хүлээсэн үүрэг, зорилтоо хэрэгжүүлэхдээ тагнуулын бүхийл хүч, арга, хэрэгслийг ашиглах ба түүний явцад олсон гэмт хэргийн талаарх мэдээ, баримт сэлтээ тогтоосон журмын дагуу чиг үүргийг нь харгалзан Холбооны прокурорын байгууллагад, эсвэл холбооны татвар, гааль, цагдаагийн байгууллагад шилжүүлэн өгдөг байна.¹³³

Зохион байгуулалттай, нууц далд аргаар үйлдэгддэг гэмт хэргийг илрүүлэхэд тагнуулын буюу гүйцэтгэх ажлын аргаар тэмцэхийн ач холбогдлыг харуулсан ганц хоёр баримт дурдья. АНУ-ын зүүн эргийн усан боомтын ачаа ачиж,буулгагчдын ҮЭ-ийн байгууллагад зохион байгуулалттай гэмт бүлэглэл ажиллаж байж болох тухай мэдээ олсон ХМТ 1976 онд нууц ажилтнуудаа дээрх боомтын ҮЭБ-ын удирдагчдын дунд нэвтрүүлэх операци зохион байгуулан явуулж, тэдний итгэлийг олсноор тэдгээрийн цаана бүхэл бүтэн мафи ажиллаж байсныг илрүүлсэн байна. Хоёр дахь жишээ. ХМТ нууц ажилтан болон туршуулуудынхаа тусламжтайгаар "Стинг" хэмээх нууц нэртэй цуврал операцийг амжилттай

Commented [u1]: Рүүлэх

¹³⁰ Reorganizing U.S. Domestic Intelligence: Assessing the Options By Gregory F. Treverton, Steven W. Popper, Steven C. Bankes, Gerald P. Frost

¹³¹ Грегори Ф. Тревертон. АНУ-ын дотоод тагнуулын ажлыг дахин зохион байгуулах нь. УБ. 2014.Ц.Мөнхийн орчуулга.

¹³² <https://www.legislation.gov.uk/ukpga/1989/5/section/1>

¹³³ Bundesgesetz zum Schutz der Verfassung von 1990. ?????

зохион байгуулж явуулсны үр дүнд зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдэд ноцтой цохилт өгч, АНУ-ын гэмт ертөнцийн янз бүрийн төвшний хоорондын уялдаа холбоог задлан бусниулж, орлогын зарим эх үүсвэрийг нь устгасан ажээ. Тэрхүү операцийн үр дүнд ХМТ цөөнгүй бизнесмен болон ҮЭБ-ын дээд төвшний зүтгэлтнүүд оролцсон олон тооны гэмт хэргийг илрүүлсний дотор санхүүгийн залилан мэхлэх гэмт хэрэг, түүгээр ч барахгүй АНУ-ын засгийн газрын зарим төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гэмт хэрэг байсан байна.

ХМТ "Стинг" операцийг хэрэгжүүлэх явцад олсон зарим мэдээ, баримт сэлтийг ашиглан илүү өргөн цар хүрээг хамарсан "Абскам" хэмээх нэртэй, эрүүгийн тагнуулын нүсэр том операцийг зохион байгуулсан. Тэр нь 1970-аад оноос АНУ-д авлига, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр зохиосон олон нууц операциас хамгийн үр дүнтэй нь болсон бөгөөд түүнд Конгрессын авлигад идэгдсэн зарим гишүүн ч өртсөн түүхтэй. Вашингтон, Филадельфи, Майами зэрэг хотыг хамруулан хоёр жилийн турш хэрэгжүүлсэн "Абскам" операцид ХМТ-ны 100 орчим ажилтан оролцож, 800 000 доллар зарцуулжээ.

"Абскам"-ын голлон тоглогч болох ХМТ-ны нууц ажилтан Нью-Жерси мужийн казино, түүнчлэн титан болон бусад ашигт малтмалын ордтой холбоотой бизнест хөрөнгө оруулахыг хүсч буй арабын саятан шейхийн дүрд тоглосон аж. "Шейх", түүний туслахууд (ХМТ-ны ажилтнууд) нь хөрөнгө оруулж, бизнесээ эхлүүлэхийн тулд Конгрессын авлигад идэгдсэн зарим нэг гишүүний дэмжлэгийг авах шаардлага гарсан байна. Гэтэл тэдний дэмжлэг авахын тулд хахууль өгөхөөс өөр зам байгаагүй аж. "Шейх" конгрессын тэдгээр гишүүн, тэдний төлөөлөлтэй хийх уулзалт, хэлэлцээрүүдээ тусгай техник хэрэгслээр тоноглогдсон өөрийн харшид явуулсан бөгөөд тэдгээрийн дүрс бичлэгийг нууц телесувгаар АНУ-ын хууль зүйн сайдын туслахад дамжуулж байжээ. Операцийн явцад нууц дүрс бичлэг хийж олж авсан болон бусад олон мэдээ, баримт сэлт нь конгрессын тэдгээр гишүүдийг яллах үндсэн нотлох баримтуудад тооцогдсон аж.¹³⁴ Энэ мэт жишээ олныг дурдаж болно.

Гүйцэтгэх ажлын хөдөлгөөр гэгддэг гүйцэтгэх ажлын буюу тагнуулын аргуудыг тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд хэрэглэх үндэслэл, нөхцөл, журмыг холбогдох хуулиудаар нарийвчлан тогтоох шаардлагатай бөгөөд тэгснээр л гүйцэтгэх ажлын аргаар олсон мэдээ, баримт сэлт буюу гүйцэтгэх ажлын арга хэмжээний үр дүнг нотлох баримтын хэмжээнд үнэлэх нөхцөл, боломж бүрдэхийн сацуу гүйцэтгэх ажлын явцад хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах хууль бус явдалтай тэмцэхэд тодорхой алхам хийж болохыг зарим судлаач тэмдэглэж ирсэн¹³⁵ байна. Холбогдох хууль тогтоомжийг тийнхүү шинэтгэн боловсронгуй болгоогүй, түүний дотор гэмт хэргийн талаарх гүйцэтгэх ажлын мэдээ, баримт сэлтийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах асуудлыг ЭХХШ тухай хуульд тусгаагүй нь оновчтой биш шийдэл болж, олон сөрөг үр дагаврыг дагуулж эхэлсэн ба тэдгээр нь цаашдаа ч улам нэмэгдэх нь ойлгомжтой. Энэхүү байдлаас болж, Эрүүгийн цагдаагийн алба гэх зэрэг зарим гүйцэтгэх байгууллага аргаа барахдаа, мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтад тооцогийг нь харгалзан гүйцэтгэх ажилтнуудаа мөрдөгч, эрүүгийн мөрдөгч гэдэг албан тушаалтай болгож байх жишээтэй. Тэд мөрдөгчийнхөө үүргийг гүйцэтгэж, ихэнх цаг, хүч хөдөлмөрөө гэмт хэргийн талаарх хуулийн этгээд, иргэдийн гомдол, мэдээлэлтэй зууралдан өнгөрөөхөд хүрч байна. Гэтэл Гүйцэтгэх ажлын тухай хуульд зааснаар тус алба нь дараах үндэслэлээр гүйцэтгэх ажил явуулах эрх, үүрэгтэй хэвээрээ байгаа шүү дээ:

- хуулиар харьяалуулсан гэмт хэргийг далд аргаар үйлдсэн буюу үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай үндэслэл бүхий мэдээллийг өөр арга хэрэгслээр шалгах боломжгүй;
- барьцаанд байгаа хүнийг суллах, сураггүй алга болсон хүнийг эрж олох талаар байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлт, хүнийг барьцаанд авсан, хүн сураггүй алга болсон тухай байгууллага, иргэдийн мэдээлэл;
- эрүүгийн хэргийн нотолгоог бүрэн гүйцэд шалгах зорилгоор шүүх, прокурор, мөрдөгчөөс ирүүлсэн даалгавар;
- алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх соёлын дурсгалт болон бусад үнэт зүйлийг эрж олох талаар байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлт;

¹³⁴ Мятавын Цогтоо. Тагнуулын нэвтэрхий толь. УБ.2014. 327-328-р тал

¹³⁵ М.Цогтоо. Тагнуулын үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчмыг хэрэгжүүлэх асуудалд. "Монголын төр, эрх зүй" сэтгүүл. 2009 № 2(58), М.Цогтоо. Тагнуулын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. "Тусгаар тогтнол" сэтгүүл. 2010. №2, М.Цогтоо. Тагнуулын үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчмыг хэрэгжүүлэх асуудал. "Тусгаар тогтнол" сэтгүүл. 2019. №3

- эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг Монгол Улстай байгуулсан гадаад улс, олон улсын байгууллагаас ирүүлсэн хүсэлт¹³⁶.

Иймэрхүү байдал зөвхөн эрүүгийн цагдаагийн албанд ч биш, гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр гүйцэтгэх ажил явуулдаг нэг бус гүйцэтгэх байгууллагад байгаа нь тодорхой. Тэр байдлаа ажилтнуудынхаа албан тушаалыг Гүйцэтгэх ажлын тухай хуулиар тогтоосон "гүйцэтгэх ажилтан"¹³⁷ гэдэг нэрээр биш, харин "мөрдөгч", "төлөөлөгч" гэх зэрэг болон бусад нэр томъёо хэрэглэж, хуулиар тогтоосон чиг үүрэг, эрхийг нь гажуудуулахад ашиглах ноцтой сөрөг үзэгдэл гарч байж болохыг үгүйсгэх аргагүй. Тэр бүхний улмаас далд үйлдэлтэй, ноцтой хор хохирол учруулдаг, хуульд зааснаар гүйцэтгэх ажлын буюу тагнуулын аргаас өөр арга, хэрэгслээр илрүүлэх боломжгүй¹³⁸ гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, өмнө нь үйлдэгдээд олон жилийн нүүр үзсэн, хүнийг алсан, янз бүрийн хүндрүүлэх шалтгаантайгаар алсан гэх зэрэг дуулиантай, хүнд гэмт хэргүүдийг нөхөн илрүүлэх үйл ажиллагаа орхигдоход хүрч байхыг мөн л үгүйсгэх аргагүй л дээ.

Манай улсын төрийн өндөр дээд болон бусад зарим албан тушаалтан, шүүх, прокурорын ба бусад хууль, хяналтын байгууллагын цөөнгүй ажилтан оролцсон зарим томоохон гэмт хэрэг ихэнхдээ хамаг хор хохирол учирсны дараа иргэд болон дотоод, гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагын мэдээлэл, хэргийн этгээдийн хань хамсаатны мэдүүлгийг шалгах явцад л илэрч байгаа нь нууц биш юм. Илрээгүй, тиймэрхүү болон түүнээс ч илүү их хор аюул дагуулсан цөөнгүй гэмт хэрэг байж болох магадлал өндөр... Тэр бүхний нэг шалтгаан нь гүйцэтгэх ажлыг ихэвчлэн хинхэнэ утгаар нь хуульд заасан зорилго, үндэслэлийн дагуу явуулах нь илэрхий багасч, өргөдөл, гомдлын дагуу ялих шалихгүй хэргээр хөөцөлдөн ор нэр болгоход хүрч байгаагаар холбоотой гэж үзэх үндэслэлтэй. Гүйцэтгэх ажилтнууд ч гүйцэтгэх ажлаас нь маш амар хялбар тиймэрхүү гэмт хэргийг мөрдөх шинэ ажилдаа дасч буй нь сайн хэрэг огт биш л дээ.

Монгол оронд маань бас мансууруулах бодисын хууль бус худалдаа, хүний наймаа, мөнгө угаах зэрэг зохион байгуулалттай, үндэстэн дамнасан гэмт хэрэг газар авч байгаа нь шууд ба шууд бусаар нотолсон мэдээ, баримт сэлтүүдээс тодорхой байна. Үндсэндээ ардчилал, зах зээлийн нийгэмд шилжих үеэс эхэлж ихээхэн газар авсан, эртний урлагийн гайхамшигт бүтээлүүд, археологи, палентологийн олдвор гэх зэрэг хосгүй үнэт болон үнэт, монголынхоо түүх, соёлын дурсгалт зүйлийг улсын хилээр нууцаар нэвтрүүлж, борлуулж байгаа зохион байгуулалттай гэмт хэрэг, түүнчлэн авлига хамгийн их нүүрлэсэн гэдэг нь олон жилийн туршийн судалгаагаар тодорхой байсаар буй газрын албаны газрын наймаатай холбоотой гэмт хэргүүд бараг л огт илрэхгүй байсаар л... Манай иргэдийн дунд явуулсан социологийн судалгаагаар Монгол оронд маань авлига хамгийн том асуудал болоод буй. Тиймээс, цаашдаа бид улс төрчидтэйгээ холбоотой бүр ч их аюултай гэмт хэргийн тухай сонсч болохыг үгүйсгэх аргагүй. Чухам энэ бүхний улмаас манай улс хар, саарал жагсаалтад орсоор ирсэн бөгөөд түүний хариуцлагыг дээрх гэмт хэргүүдтэй гүйцэтгэх ажлын аргаар тэмцэх чиг үүрэгтэй байгууллагууд ч ямар нэг хэмжээгээр хуваалцах ёстой гэдэгтээ дүгнэлт хийж байгаа нь мэдээж. Тийнхүү ихэвчлэн нууц далд аргаар үйлдэгддэг гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгтэй, гүйцэтгэх ажил эрхлэх байгууллагуудыг үндсэн чиг үүргээс нь хөндийрүүлэхэд шууд ба тойруу замаар хүргэсний бас нэг ноцтой сөрөг үр дагавар нь энэ байх үндэслэлтэй.

Тухайн нөхцөл байдал иймэрхүү байдлаар үргэлжилсээр байвал дээр дурдсан болон бусад гэмт хэргүүд улам газар аван хяналтаас бүрэн гарч, Монгол орон маань мафижсан, олон төрлийн гэмт хэргийн үүр болж хувирахыг үгүйсгэх аргагүй юм. Өмгөөлөгч, шүүхч нартай холбоотой гэмт үйлдлүүдийн тухай шуугиан ч түүний бас нэг ноцтой дохио байж болох юм.

Зарчмын ач холбогдолтой дээрх ноцтой асуудлаас гадна ЭХХШ тухай хуулийн гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагаатай холбоотой зарим хэсгийг анхааралтай уншваас хоорондоо болон Гүйцэтгэх ажлын тухай хууль зэрэг хуультай зөрчилдсөн, давхцсан гэж хэлж болох заалт нэг биш байна. Жишээлбэл, ЭХХШ тухай хуулийн 12.4.1-д мөрдөгч нь, байгаа газар нь мэдэгдэхгүй байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний хариуцагч, гэрч; оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч; хулгайлагдсан, барьцаалагдсан хохирогч; хэн болох нь тодорхойгүй цогцыг тогтоох; эмнэлгээс оргосон сэтгэцийн өвчтэй хүн; эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий эд зүйл, баримт бичиг, тээврийн хэрэгслийг тус тус эрэн сурвалжлах ажиллагааг өөрийн санаачилгаар, эсхүл шүүхийн шийдвэр, прокурорын даалгавраар явуулна гэж заажээ. Гүйцэтгэх ажлын тухай хуульд, цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажил эрхэлдэг нэгжүүд "...сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүн,

¹³⁶ Гүйцэтгэх ажлын тухай хууль. 11.2

¹³⁷ Гүйцэтгэх ажлын тухай хууль. 13 дугаар зүйл

¹³⁸ Мөн тэнд. 11.2, 11.3

оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон прокурор, шүүхээс даалгасан бусад хүнийг эрэн сурвалжлах, алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх соёлын дурсгалт болон бусад үнэт зүйлийг эрж олох...”,¹³⁹ тагнуулын байгууллага өөрт нь хуулиар харьяалуулсан эрүүгийн хэргийн тухай мэдээлэл, эрүү үүсгэсэн хэргийг шалгахдаа холбогдох үндэслэлээр дээрх хүн, зүйлсийг эрэн сурвалжлах ажил явуулахаар заасан¹⁴⁰ нь мөрдөгч болон гүйцэтгэх байгууллага,ажилтны зарим үүргийг зарим талаар давхардуулахад хүргэсэн байна.

Гэтэл ямар ч чиглэлийн, түүний дотор дээрх заалт дахь эрэн сурвалжлах үйл ажиллагаа нь зөвхөн нууц болон ил мөрдөн шалгах ажиллагаа биш, харин гүйцэтгэх ажил гэж нэрлэж буй ойлголтийн жинхэнэ утгаараа дүйхүүц олон талын нууц арга хэмжээг багтаасан өргөн ойлголт юм. Социалист гэж нэрлэгдэж байсан улсуудаас ОХУ тусгай албадынхаа үйл ажиллагааг зохицуулсан анхны хуулиа “Шуурхай эрэн сурвалжлах үйл ажиллагааны тухай хууль (орсоор-Закон об оперативно-розыскной деятельности)” хэмээн нэрлэсэн ба манай улс тэр хуулиас үлгэр загвар авч, түүнийхтэй ижил харилцааг зохицуулсан хуулиа яагаад ч юм, “Гүйцэтгэх ажлын тухай хууль” гэж нэрлэсэн байна. “Гүйцэтгэх ажил” гэж нэрлээд буй үйл ажиллагаа нь мөн чанартаа үндэсний аюулгүй байдлыг хангах, далд үйлдэлтэй гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас ихэвчлэн нууц хүч, арга, хэрэгслийг ашиглан шаардлагатай мэдээ, мэдээлэл, баримт сэлт, нотолгоо олох, цуглуулах,шалгахад чиглэсэн нууц эрэл, хайгуулын буюу тагнуулын ажил шүү дээ. Чухам тийм ч учраас ОХУ зэрэг цөөнгүй улс бид “Гүйцэтгэх ажил” гэж бид оновчгүй нэрлэчихээд буй үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан хуулиа “Шуурхай эрэн сурвалжлах ажиллагааны (тодруулгыг М.Ц) тухай хууль” хэмээн нэрлэсэн байна. Үүнийг бас “Гүйцэтгэх ажил” хэмээн оновчгүй нэрлэсэн боловч, мөн чанартаа тагнуулын үйл ажиллагааг илэрхийлсэн “Үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор **төрийн эрх бүхий байгууллагаас ердийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан явуулж байгаа мэдээ, мэдээлэл, баримт бичиг, нотолгоо эрж олох, цуглуулах, шалгах үйл ажиллагааг** (тодруулгыг М.Ц) гүйцэтгэх ажил гэнэ” хэмээх тодорхойлолтоос төвөггүй ажиглаж болно.

Тодотгож тэмдэглэхэд, зөвхөн хүн,эд зүйл, хөрөнгийг эрэн сурвалжлах үйл ажиллагааны явцад л гэхэд, нууц болон ил мөрдөн шалгах ажиллагаануудаас гадна сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч болон эрэн сурвалжлагдагч бусад хүн, түүнчлэн эд зүйл,тэдгээртэй гэмт хэргийн болон анхаарал татах өөр төрлийн янз бүрийн харилцаа,холбоо, ашиг сонирхолтой байж болох хүмүүсийн дунд туслагч, нууц ажилтан сонгон олж,ажиллуулах; дээрх хүмүүст анхаарал, сонирхлыг нь татах хуурамч, хагас хуурамч мэдээ хүргэж, хариу үйлдэл, хөдөлгөөнийг нь нууцаар хянаж,мэдээ олох;үндэслэл бүхий сэжигтэй холбогдох этгээдийг түр саатуулан шалгах болон гэмт хэргийг илрүүлэхэд шаардлагатай мэдээ, баримт сэлт олоход ашиглах гэх зэрэг гүйцэтгэх ажлын буюу тагнуулын олон аргыг хэрэглэхэд хүрнэ гэдгийг гүйцэтгэх ажилтнууд сайн мэднэ. Өөрөөр, маш товчхон хэлбэл, эрэн сурвалжлах ажиллагаа нь хуульд заасан гэмт хэрэг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх байгууллагаас эрх хэмжээнийхээ хүрээнд явуулах цогц нууц болон ил арга хэмжээ юм. Харин мөрдөгч нь хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд гүйцэтгэх ажил зохиохоос бусад арга замаар холбогдох этгээд, эд зүйлийг эрж олох ажилд оролцоно. Үүнийг мөрдөгчид маань “биечилсэн эрэн сурвалжлага” гэж нэрлэж хэвшсэн болно. Энэ хэсгийнхээ дүгнэлт болгон хэлэхэд, эрэн сурвалжлах үйл ажиллагааг мөрдөгч биш, харин гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлын аргаар тэмцэх чиг үүрэг бүхий гүйцэтгэх байгууллага,ажилтан холбогдох хуульд заасан үндэслэл болон тухайн гүйцэтгэх байгууллагаас тогтоосон журмын дагуу, оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч; хулгайлагдсан, барьцаалагдсан хохирогч; хэн болох нь тодорхойгүй цогцсыг тогтоох зэрэг зорилгоор ихэвчлэн гүйцэтгэх ажлын “эрэн сурвалжлах хэрэг” үүсгэн шалгах арга замаар хэрэгжүүлэх учиртай. Гүйцэтгэх ажлын тухай хууль дахь “..оргосон этгээд баривчлагдсан,...сураггүй алга болсон,нас барсанд тооцогдсон хүн, эсхүл алдагдсан эд зүйл олдсон...” гэх зэрэг тохиолдолд “...гүйцэтгэх ажлын хэрэг шалгах ажиллагааг дуусгавар болгож, хэргийг хаана...”гэсэн заалт нь дээрх дүгнэлт зөв болохын нэг нотолгоо гэж хэлж болно.

Энэ асуудалтай холбоотойгоор тэмдэглэхэд, **Гүйцэтгэх ажлын тухай хууль(6.2.)-д** “Эрэн сурвалжлах ажил гэж тагнуулын байгууллага цагдаа, хорих ял эдлүүлэх байгууллагад ЭБШ хууль болон бусад хууль тогтоомжоор харьяалуулсан эрүүгийн хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр хийх нууц ажиллагааг хэлнэ” хэмээсэн хачирхалтай тодорхойлолт байх юм. Цагдаа, хорих ял эдлүүлэх байгууллагад хууль тогтоомжоор

¹³⁹ Гүйцэтгэх ажлын тухай хууль. 9.1.3

¹⁴⁰ Гүйцэтгэх ажлын тухай хууль. 11.3.

харьяалуулсан эрүүгийн хэргийг илрүүлэх, түүний дотор үйлдсэн этгээдийг нь олж тогтоох чиглэлээр тагнуулын байгууллага нууц ажиллагаа явуулах үүрэг, эрхтэй гэж үү?

Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журамд¹⁴¹ “Үзлэгийг нууцаар хийх” хэмээн нэрлэсэн гүйцэтгэх ажлын нэг арга болох нууц үзлэгийг “...эрх бүхий нэгжээр гүйцэтгүүлэх шаардлагагүй гэж үзвэл эрх бүхий мөрдөгч явуулна” гэсэн нь биелэгдэх боломжгүй юм. Учир нь, нууц үзлэгийг гүйцэтгэх байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудын олгосон зөвшөөрөл, баталсан төлөвлөгөөний дагуу холбогдох бэлтгэлийг сайтар хангасны үндсэн дээр аль нэг удирдах гүйцэтгэх ажилтны шууд удирдлагын дор холбогдох гүйцэтгэх ажилтан, тусгай техникийн алба, нууц ажиглалтын албаны ажилтнууд зэрэг цөөнгүй ажилтнаас бүрдсэн бүхэл бүтэн баг л хэрэгжүүлэх боломжтой, ихээхэн нарийн төвөгтэй цогц ажиллагаа байдаг. Ялангуяа, айлын орон сууц, албаны өрөө тасалгаа зэрэг газарт хийх тийм ажиллагаа нь тухайн байр, барилга байгууламжийн орчин нөхцөл, харуул хамгаалалт, оршин суугчид, тухайн сууц, өрөө тасалгаанд амьдарч, ажиллагсад, тэдгээрийн ажлын цагийн дэглэм, байнга, ирж, очдог, хүмүүсийг судлах, сууц, өрөө тасалгааны цоож, хамгаалалт, бэхлэгээ, тэдгээрийг онгойлгож, нэвтрэх арга зам, ажиллагаа явуулахад нөлөөлж болох саад бэрхшээл, тэдгээрийг даван туулах хувилбарууд болон үзлэг хийхэд оролцогчид, ашиглах техник хэрэгсэл хийгээд бусад зүйлийг шаардлага гарсан тохиолдолд нэн даруй шилжүүлэн түр байршуулах өрөө тасалгааг сонгон олж бэлтгэх, үзлэг хийсний элдэв ул мөрийг арилгах гэх мэт олон талын бэлтгэл, тооцоо судалгаа, арга ажиллагаа шаардагдана шүү дээ. Зарим гэмт хэрэг гарсан газар болон томоохон ачаа тээшинд ил үзлэг хийх нь нэлээд төвөгтэй, олон талын, нарийн нягт, чамбай ажиллагаа шаарддагийг туршлагатай мөрдөгч нар андахгүй. Тэгвэл тийм ажиллагааг нууцаар хийнэ гээд төсөөл дээ.

Монгол Улсын Үндсэн хуульд, “Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, ...мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно”¹⁴² хэмээн заасанчлан, нууцаар мөрдөн шалгах ажиллагаануудыг хэрэглэх үндэслэл, зорилго болон явуулах хугацааны дээд хязгаарыг ЭХХШ тухай хуульд нэг бүрчлэн тодорхой заасан байх шаардлагатай. Гэтэл тухайн хуульд Үзлэг хийх (23.1.1, 23.1.1.9), Мөрдөн шалгах туршилт хийх (23.5.1, 23.5.5), **Хяналт тогтоох** /орон байранд болон бусад газар, тээврийн хэрэгсэлд нууцаар нэвтрэх/ (26.3), Нууц ажиглалт явуулах(26.4), **Хяналттай хүргэлт** (26.5), **Хяналтын худалдан авалт**(26.6) гэх зэрэг мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулах үндэслэлийг тогтоогоогүй байна. Энэхүү байдлаас болж, мөрдөн шалгах нууц ажиллагааг мөрдөгч хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж байгаа эсэхэд(26.9.2.1) прокурор хяналт тавих(26.9) үүргээ хэрэгжүүлэхэд ч хүндрэлтэй, ер нь боломжгүй болоход хүрч таарч байна. ЭХХШ тухай хуулийн “... мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулах журам, зааврыг Тагнуулын ерөнхий газрын дарга Улсын ерөнхий прокурортой хамтран батална” гэсэн заалт нь ч Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй болж таарч байна.

Гүйцэтгэх ажлын тухай хуульд ч нэрнээс нь эхлээд онговчгүй, эргэж харж өөрчлөх шаардлагатай зүйл, заалт цөөнгүй бий. Тэдгээрээс зөвхөн гэмт хэрэг илрүүлэхтэй холбоотой зарим нэгийг нь тухай цухас дурдъя. Гүйцэтгэх ажлын тухай болон Тагнуулын байгууллагын тухай хуульд тагнуулын буюу гүйцэтгэх ажлын аргын тухай системтэй тодорхой заагаагүй байна. Гүйцэтгэх ажлын тухай хуульд гүйцэтгэх буюу тагнуулын ажилд тавих прокурорын хяналтын тухай асуудлын хүрээнд л харилцаа холбооны сүлжээнд хяналт тавих; шуудан харилцааг хянах; орон байр, барилга байгууламж, газар, тээврийн хэрэгсэл, ачаа, тээш, эд зүйлд нууц үзлэг хийх; нууц ажиглалт явуулах; хяналтын худалдан авалт зэрэг аргыг нэрлээд¹⁴³, “Гүйцэтгэх ажил явуулахдаа холбоо, мэдээллийн систем гэрэл зураг, кино, дүрс, дууны болон бусад бичлэг хийх техник хэрэгсэл ашиглана”¹⁴⁴ гэж заажээ. Тагнуулын байгууллагын хуульд ТЕГ “хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд нууцаар ажиглах, үзлэг хийх, шуудан харилцаа хянах, харилцаа холбооны болон мэдээллийн бусад сүлжээнд нэвтрэх, гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл, полиграф болон бусад арга хэрэгсэл ашиглах”¹⁴⁵-аар заасан байна. Тагнуулын үйл ажиллагаа буюу гүйцэтгэх ажилтай холбоотой харилцааг зохицуулсан дээрх хоёр гол хуулийн алинд нь ч тагнуулын буюу гүйцэтгэх ажилд хамгийн өргөн хэрэглэгддэг тагнуулч, туршуулаар нэвтрэх, тагнуулын (гүйцэтгэх ажлын)-ын туршилт гэх зэрэг нэлээд аргыг тусгаагүй байгаа билээ.

¹⁴¹ Улсын ерөнхий прокурор, ТЕГ-ын даргын 2018.12.26-ны өдрийн хамтарсан А/416/А177 тушаалын Нэгдүгээр хавсралт.4.2

¹⁴² Монгол улсын Үндсэн хууль.Арван зурдаугаар зүйлийн 13

¹⁴³ Гүйцэтгэх ажлын тухай Монгол Улсын хууль. 23.3

¹⁴⁴ Мөн тэнд 9.4

¹⁴⁵ Тагнуулын байгууллагын тухай Монгол Улсын хууль 12.1.1

Тагнуулын буюу гүйцэтгэх ажлын аргууд нь хэн нэгний хүссэнээр дуртай цагтаа хэрэглэж байдаг дур зоргын зүйл биш, харин гүйцэтгэх ажлын тодорхой зорилтыг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд тухайн нөхцөл байдалд нийцсэн аргыг оновчтой сонгон хэрэглэх ёстой гэдэг нь тагнуулын ажлын зуу зуун жилийн практикаар нотлогдсон зүйл юм. Мэдээж хэрэг, тухайн тодорхой нөхцөл байдлаас хамааран хуулийн хүрээнд янз бүрийн үр ухаан, арга чарга хэрэглэж болохыг үгүйсгэж болохгүй л дээ. Чухам тийм учраас тагнуулын буюу гүйцэтгэх ажилтан ямар тодорхой зорилтыг шийдвэрлэхийн тулд ямар аргыг хэрэглэх зайлшгүй шаардлагатай, түүнийг үр дүнтэй ашиглах ямар нөхцөл, боломж буй зэргийг буюу тухайн аргыг хэрэглэх үндэслэл, нөхцөлийг тодорхой тусгасан танилцуулгыг холбогдох журмын дагуу бичиж удирдлагадаа танилцуулах учиртай. Харамсалтай нь манай холбогдох хууль тогтоомжид тэр бүхнийг хагас дутуу тусгасан болон дээрх аргуудыг хэрэглэх үндэслэл, нөхцөлийг сайн ухаарч ойлгоогүй, бас зарим нэг гүйцэтгэх ажилтан өөртөө амар хялбарыг нь боддог зэрэг шалтгааны улмаас ихэвчлэн нууц ажиглалт, харилцаа холбооны сүлжээнд хяналт тавих зэрэг аргыг хэрэглэдэг, тэгснээрээ тухайн арга хэмжээ үр дүнгүй болох, хүний эрх, эрх чөлөөг хангах зарчмыг зөрчих тохиолдол гарах нь бий. Өөрөө явж хөөцөлдөөд хийчихэж болох зарим ажлыг гүйцэтгэх байгууллагад даалгавар болгон өгдөг сөрөг хандлага зарим нэг мөрдөгчдөд ч байдгийг мөрдөгчид ч, тэдний даалгаварыг хэрэгжүүлдэг гүйцэтгэх байгууллагынхан ч андахгүй мэдэж байгаа.

Дүгнэлт

1. Гэмт хэргийг илрүүлэх үйл ажиллагааг зохицуулж буй гол хууль болох ЭХХШ тухай хуулийн зарим нэр томъёо, заалт ойлгомж муутай, оновчтой биш, хоорондоо зөрчилтэйн гадна Гүйцэтгэх ажлын тухай хууль зэрэг хуулийн гол агуулга, зарчмын ач холбогдол бүхий зарим заалттай илэрхий зөрчилдсөн байна. Түүний шалтгаан нь нэг талаас ЭХХШ тухай хуулийн төсөл боловсруулагчид мөрдөн шалгах нууц ажиллагаа захиалан гүйцэтгүүлэх, зохих журмын дагуу явуулсан уг ажиллагааны үр дүнг нотлох баримтад тооцох эрхийг мөрдөгч нарт олгох гэх зэрэг чухал ач холбогдол бүхий шинэлэг зохицуулалтад гол анхаарлаа хандуулж, харин өөрсдийн төдийлөн гүнзгий мэдэхгүй, гүйцэтгэх ажил буюу тагнуулын үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан гол хоёр хуулийг оролдохоос зайлсхийсэнтэй холбоотой байж болох юм. Нөгөө талаас, гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагуудыг төлөөлж, төслийн талаар саналаа илэрхийлж байсан ажилтнууд нууц далд үйлдэлтэй гэмт хэргийг илрүүлэх, хэргийн бодит байдлыг тогтооход гүйцэтгэх ажлын эзлэх байр суурь, утга учир, ач холбогдлыг төсөл боловсруулагчдад гүнзгий ойлгуулж чадаагүйн гадна, хамгийн гол нь гүйцэтгэх ажлын аргуудын тогтолцоо, тэдгээр аргыг хэрэглэх шаардлага, үндэслэл, нөхцөлийг Гүйцэтгэх ажлын тухай хуулиар нарийвчлан тогтоох шаардлагатай байгаа бөгөөд гагцхүү түүний үндсэн дээр тэр дагуу буюу холбогдох үндэслэл, нөхцөл, журмын дагуу (түүний дотор прокурорын зөвшөөрлөөр) олж, шалгаж, бэхжүүлсэн гүйцэтгэх ажлын мэдээ, баримт сэлтийг тогтоосон журмын дагуу мөрдөн шалгах зэрэг байгууллагад албан ёсоор шилжүүлдэг, тэдгээр мэдээ, баримт сэлт нь холбогдох шаардлага, шалгуурыг хангасан гэж үзсэн тохиолдолд зохих журмын дагуу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах тухай заалтыг холбогдох хуулиудад тусгах учиртайг ойлгуулж чадаагүйтэй холбоотой байсан бол уу гэж бодогдож байна.

2. Нийгэмд ашигтай аливаа үйл ажиллагааны субъектын ашигладаг хүч, арга, хэрэгсэл нь тэрээр үйл ажиллагаагаа чиглүүлэх объект, тэрхүү объектын үйл ажиллагаа, ашиглах хүч, арга, хэрэгслийн онцлогийг харгалзсан, түүнд дүйцсэн байдаг нь холбогдох онол хийгээд хүн төрөлхтөний түүхийн олон зуун жилийн практикаар нэгэнт нотлогдсон зүйл юм. Манай улсад энэхүү байдлыг хүлээн зөвшөөрч, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Тагнуулын байгууллагын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Монгол Улсын Хилийн тухай хууль болон бусад цөөнгүй хууль тогтоомжид холбогдох хэмжээгээр тусгасаар ирсэн байна.

3. Гэмт хэрэгтэй тэмцэх, түүний дотор гэмт хэргийг илрүүлэхээр зохиох гүйцэтгэх ажил буюу тагнуулын үйл ажиллагаа нь "... гэмт хэргийг шуурхай бүрэн илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоох..." зэрэг ЭХХШ ажиллагааны нийтлэг зорилтын хүрээнд холбогдох хуулийн дагуу төрийн эрх бүхий байгууллагаас явуулж буй төрийн үйл ажиллагааны бие даасан, өвөрмөц төрөл мөн. Гэтэл гэмт хэрэгтэй тагнуулын буюу гүйцэтгэх ажлын аргаар тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагууд тэрхүү чиг үүргээ хэрэгжүүлснээр гаргадаг үндсэн бүтээгдэхүүн болох гүйцэтгэх ажлын арга хэмжээнийхээ үр дүнг "... гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг эрэн сурвалжлах, нотлох баримт цуглуулах, тэдгээрийн эх сурвалжийг олж тогтоох" зорилгоор ашиглах тухай холбогдох хуулийн заалтыг ЭХХШ тухай хуульд тусгаагүй, өмнө нь мөрдөж байсан хуульд байсан тухайн асуудлаарх заалтыг хассан нь

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн гол агуулга, зарчмын чухал ач холбогдолтой хэд хэдэн заалттай илэрхий зөрчилтэй болгосоны гадна нууц далд аргаар үйлдэгддэг тодорхой төрлийн гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлын аргаар тэмцдэг зүй тогтолт үйл явцыг үгүйсгэхэд хүргэсэн байна.

4.Гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлын буюу тагнуулын аргаар тэмцэх чиг үүрэгтэй байгууллагуудын гүйцэтгэх ажлын мэдээ, баримт сэлтийг эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах боломжгүй болгосноор зарим гүйцэтгэх байгууллага нь гүйцэтгэх ажлаа жинхэнэ утгаар нь хуульд заасан зорилго, үндэслэлийн дагуу явуулахын оронд ажилтнуудаа Гүйцэтгэх ажлын тухай хуулиар тогтоосон "гүйцэтгэх ажилтан"¹⁴⁶ биш, харин "мөрдөгч","төлөөлөгч" болгон хуулиар тогтоосон чиг үүрэг, эрхийг нь гажуудуулахад хүргэх ноцтой сөрөг үзэгдэл гарч эхэлснээр үндсэндээ хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхлэх байгууллага болон хувирч, тэгснээрээ далд үйлдэлтэй,ноцтой хор хохирол учруулдаг, хуульд зааснаар гүйцэтгэх ажлын буюу тагнуулын аргаас өөр арга, хэрэгслээр илрүүлэх боломжгүй гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх,өмнө нь үйлдэгдээд олон жил болсон хүнд гэмт хэргүүдийг нөхөн илрүүлэх үйл ажиллагаа орхигдоход хүрэх нь ойлгомжтой.

Санал

1.Гүйцэтгэх ажлын тухай хуулийг нэрнээс нь эхлэн нухацтай эргэн харж, шинэчлэн найруулах, түүнд тагнуулын буюу гүйцэтгэх ажлын аргуудыг бүрэн тусгаж, тэдгээр аргуудын тогтолцоо, арга тус бүрийг хэрэглэх үндэслэл, нөхцөл, журмыг хуульчлан тогтоох.

2.Гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч нэг субъект болох нь Монгол Улсын болон олон улсын холбогдох хууль тогтоомж хийгээд гэмт хэрэгтэй тэмцэж буй үндэсний ба олон улсын практикаас тодорхой байгааг харгалзан ЭХХШ тухай хуульд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлын аргаар тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага, ажилтны эрх зүй байдлыг нарийвчлан тогтоох нь зүйтэй.

3.Хуульд заасан үндэслэл, нөхцөл,журмын дагуу гүйцэтгэх ажлын арга хэрэглэж, олж, бэхжүүлсэн гүйцэтгэх ажлын мэдээ, баримт сэлтийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглаж болох тухай зүйл, заалтыг ЭХХШ тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хуулийн шинэчлэн найруулах төсөлд тус тус тусгах.

4.ЭХХШ тухай хуульд мөрдөн шалгах нууц ажиллагануудыг явуулах үндэслэл, нөхцөл, журмыг оновчтой бөгөөд тэдгээрийг хэрэглэх хугацааны дээд хязгаарыг нэг бүрчлэн тодорхой тусгах.

5.ЭХХШ тухай хууль дахь "гэмт хэрэг илрүүлэх", "гэмт хэргийг бүрэн илрүүлэх" гэдэг нэр томьёог тайлбарлаагүй, тэдгээрийг хэрэглэсэн зүйл, заалтууд ойлгомж муутай байгааг эргэн харж, оновчтой болгон өөрчлөн найруулах.Шаардлагатай гэж үзвэл, тухайн хуульд "гэмт хэрэг илрүүлэх", "гэмт хэргийг бүрэн илрүүлэх" гэдэг нэр томьёог тайлбарлах.

6.Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журам дахь нууцаар хийх үзлэгийг "... эрх бүхий нэгжээр гүйцэтгүүлэх шаардлагагүй гэж үзвэл эрх бүхий мөрдөгч явуулна" гэдэг заалтыг хүчингүй болгох.

¹⁴⁶ Гүйцэтгэх ажлын тухай хууль.13 дугаар зүйл

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН ХЭСГИЙН БАЙЦААГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ЗАРИМ АРГА ЗАМ

Б.Баянмөнх
ДХИС-ийн ЦС-ийн ЦЭЗТ-ийн дэд профессор,
доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга. Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг нийслэлийн засаг захиргааны анхан шатны нэгж болох баг, хорооны хэмжээнд гардан зохион байгуулж, иргэдтэй хамгийн ойр байж, тэдний итгэл, дэмжлэгт тулгуурлан үйл ажиллагаа явуулдаг албан тушаалтан бол цагдаагийн хэсгийн байцаагч юм. Энэхүү өгүүлэлд цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох замаар үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээг тодорхойлж, ажлын ачааллыг бууруулах боломжийн талаар товч дурдсан болно.

Түлхүүр үг. хэсгийн байцаагчийн ажлын заавар, албан тушаалын тодорхойлолт, ажлын ачаалал

Үндсэн хэсэг. Тухайн нутаг дэвсгэр дэх гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, иргэд гэмт хэрэгт хохирох явдал, иргэдийн аюулгүй байдлын түвшин зэрэг нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хүртээмжийг тодорхойлох хүчин зүйл болдог. Нөгөө талаараа иргэд, олон нийтийн зүгээс цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын үр чадвар, үр дүнгээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь үнэлж дүгнэх нь цөөнгүй байна.

Хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны хамрах хүрээг нарийвчлан тодорхойлох, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, удирдлага, зохион байгуулалтын оновчтой хэлбэрийг нэвтрүүлэх замаар ажлын ачааллыг бууруулахад чиглэсэн үр дүнтэй ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй бол хэсгийн байцаагчийн ажилдаа хандах хандлага буурах, улмаар хэсгийн байцаагчаар ажиллах хүсэл сонирхолтой алба хаагчдын тоо цөөрөх сөрөг үр дагавар үүсч болзошгүй байгаа

Цагдаагийн хэсгийн байцаагч өдөр тутмын ажилдаа мөрдөж ажилладаг гол баримт бичиг бол "Хэсгийн байцаагчийн ажлын заавар" юм. Цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын зааврыг шинэчлэх замаар эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, ажлын ачааллыг бууруулах боломжтой юм.

"Хэсгийн байцаагчийн ажлын заавар"-ыг шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлага:

Нэг. "Хэсгийн байцаагчийн ажлын заавар"¹⁴⁷ нь Цагдаагийн байгууллагын тухай 1993 оны хууль үйлчилж байсан цаг үед батлагдсан бөгөөд энэ хугацаанд Цагдаагийн албаны тухай хууль хоёр удаа шинэчлэгдэн батлагдсан.

1. Зааврын 6.2-д Цагдаагийн байгууллагын тухай 1993 оны хуулийн 24-р зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 172-р дугаар зүйл зэрэг хүчингүй болсон хуулийн заалтыг мөрдлөг болгож ажиллахаар заасан, мөн "захиргааны зөрчил", "нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч", "туслах ажилтан" гэсэн хуучин нэр томьёо хэрэглэсэн.
2. Зааврын 6.4-д "Нууц, далд аргаар үйлдэгдсэн эзэнгүй гэмт хэргийг нөхөн илрүүлэх ажлыг бие дааж болон бусад албадтай хамтарч гүйцэтгэнэ" гэсэн боловч албан тушаалын тодорхойлолтод энэ үүрэг байхгүй.
3. Зааврын 6.5-д хэсгийн байцаагч эрүүгийн хэрэг бүртгэх ажиллагаа явуулахаар тусгасан боловч өнөөдөр эрүүгийн хэрэг бус харин зөрчлийн хэрэг бүртгэл явуулж байгаа.
4. Зааврын 6.11-д хэсгийн байцаагч нь эргүүлийн нэгдсэн байршилд саналаа өгч байгаа боловч нутаг дэвсгэртээ ажиллаж байгаа эргүүл, харуулыг удирдан, үүрэг гүйцэтгэлтэнд хяналт тавина гэсэн нь хэсгийн байцаагчийн үүрэг биш.

¹⁴⁷ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ., 2008. 425-430 дахь тал. Хэсгийн байцаагчийн ажлын заавар.

5. Зааврын 6.12, 6.13, 14-д заасан замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын биелэлтэд хяналтыг хэсгийн байцаагч тавихгүй, үүнийг Замын цагдаагийн алба хаагчид хариуцан гүйцэтгэж байгаа.
6. Зааврын 6.15-д хариуцсан нутаг дэвсгэртээ оршин сууж байгаа гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүсийн талаарх хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавихаар заажээ. Энэхүү заалт нь Цагдаагийн байгууллагын тухай 1993 оны хуулийн 20.2-д заасан заалтыг баримталж зааварт орсон ба 2017 оны хуульд байхгүй, хасагдсан заалт юм.
7. Зааврын 6.16-д заасан "Каратэ, самбо зэрэг зэвсэггүйгээр тулалдах арга /мэх/-ийн хувилбарыг зохион байгуулалттайгаар заах сургалтын үйл ажиллагаанд хяналт тавина" гэсэн заалт мөн цагдаагийн байгууллагын үүргээс хасагдсан.
8. Зааврын 6.17-д заасан "Аж ахуйн нэгж, байгууллагад ашиглаж байгаа өнгөт хувилгагч болон тамга тэмдгийг бүртгэж хяналт тавина" гэсэн заалт мөн хасагдсан.
9. Зааврын 6.19-д заасан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд байгаа галт болон сургалтын зориулалтын галт зэвсэг, техникийг бүртгэлд авч байгаа боловч хяналт тавихгүй, тэсэрч дэлбэрэх, хүчтэй үйлчлэх химийн хорт болон цацраг идэвхт бодисыг бүртгэх, хяналт тавих цагдаагийн байгууллагын үүрэг хасагдсан.
10. Зааврын 6.28-д дурдсан "Нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч" нь "олон нийтийн цагдаагийн ажилтан" гэсэн нэршилтэйгээр ажиллаж байгаа, түүнчлэн цагдаагийн туслах ажилтан гэж байхгүй болсон учир энэ заалтыг шинэчлэх шаардлагатай юм.

Хоёр. "Хэсгийн байцаагчийн ажлын заавар" болон "Албан тушаалын тодорхойлолт" нь хоорондоо уялдаагүй байна. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа "Цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын заавар"-т заасан үүргийг дагаж мөрдөх үү, эсвэл хэсгийн байцаагчийн "Албан тушаалын тодорхойлолт"-нд заасан үүргийг дагаж мөрдөх үү гэсэн асуулт гарч байна.

Гурав. "Хэсгийн байцаагчийн ажлын заавар" болон "Албан тушаалын тодорхойлолт"-д хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүргийг нарийвчлан зааглаж өгөлгүй, хэт өргөн хүрээг хамруулсан байдаг нь ажлын ачааллыг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болсон байдаг.

Хэсгийн байцаагчийн ажлын зааварт гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр зургаа, нийгмийн хэв журам хамгаалах чиглэлээр 14, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр найм, нийт 28 үүргийг гүйцэтгэх зохицуулалттай байгаа нь хэсгийн байцаагчийн ажлын ачаалал их байх, үндсэн үүрэг болох гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил явуулах боломж нөхцөлийг бууруулахад гол нөлөө үзүүлсэн.

Дөрөв. Хэсгийн байцаагчийн шалгах зөрчлийн тухай өргөдөл, гомдол, мэдээллийн хамрах хүрээг тогтоож өгөөгүйгээс хариуцсан хорооны нутаг дэвсгэр дээр үйлдэгдсэн цагдаагийн байгууллагын харьяалах бүхий л зөрчлийг шалгаснаар ажлын ачаалал нэмэгдэж, энэ ажилд ихэнх цагаа зарцуулах болсон.

Тав. Хэсгийн байцаагчаас захиргааны хяналтын чиглэлээр ямар ямар хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавихыг нарийвчлан заах шаардлагатай байгаа.

Зургаа. Хэсгийн байцаагч нарын ажлын орчин нөхцөл харилцан адилгүй байгаа, шаардлагатай техник хэрэгсэл, эд зүйлийн жагсаалт байхгүй, эдэлгээний норматив тогтоож өгөөгүйгээс ажлаа хэвийн явуулахад хүндрэл учрах болсон.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулахын тулд:

- Хэсгийн байцаагчийн ажлын зааврыг шинэчлэх.
- Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх.
- Эрх зүйн зарим баримт бичгийг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Нэг. Хэсгийн байцаагчийн ажлын зааврыг боловсронгуй болгох.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагаандаа баримталдаг гол баримт бичиг бол "Хэсгийн байцаагчийн ажлын заавар" юм.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын заавар нь 11 зүйл, 106 заалттай бол зааврын шинэ төсөл 10 зүйл, 129 заалтаас бүрдэж байна. Зааврын шинэ төсөл нь "Хэсгийн байцаагчийн ажлын заавар"-аас дараах давуу талтай гэж үзэж байна. Үүнд:

- цагдаагийн хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүрэг, ажлын чиглэл, хамрах хүрээг нарийвчлан тодорхойлж өгсөн;
- хэсгийн байцаагчийн шалгах зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн зүйл, заалтаар нь зааж өгсөн;
- хэсгийн байцаагч засаг захиргааны баг, хороо хариуцах бус тодорхой нутаг дэвсгэр хариуцахаар тусгасан;

- хэсгийн байцаагчийн хариуцах нутаг дэвсгэрийн хил хязгаарыг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дарга тогтоож болох зохицуулалтыг оруулж өгсөн;
- хэсгийн байцаагчийн ажиллах цагийн хуваарь болон иргэдийг хүлээн авч уулзах өдөр, цагийг тусад нь зааж өгсөн;
- төсөлд хэсгийн байцаагчид байвал зохих баримт бичгийн иж бүрдлийг оруулж өгсөн;
- хэсгийн байцаагчийн ажлын байрны ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай техник хэрэгсэл, эд зүйлээр хангах асуудлыг хариуцах албан тушаалтныг зааж өгсөн;
- хэсгийн ахлах болон туслах байцаагч гэсэн албан тушаалтны талаар анхлан оруулж өгсөн;
- хэсгийн туслах байцаагчаар ажиллах албан тушаалтанд тавигдах шаардлагыг зааж өгсөн;
- хэсгийн байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах албан тушаалтны хүлээх үүргийг тусад нь оруулж өгсөн.

Хэсгийн байцаагчийн ажлын зааврын шинэ төслөөр дараах зохицуулалтуудыг заавраас хассан. Тухайлбал:

- Цагдаагийн албаны тухай хуульд байхгүй, цагдаагийн байгууллага хариуцахаа больсон зарим үүргийг хассан;
- зааварт байгаа одоогийн хууль тогтоомжид байхгүй нэр томъёонуудыг хассан буюу шинэчилсэн;
- хэсгийн байцаагчийн шуурхай байдлыг хангах заалтуудыг шинэ төслөөс хассан;

Хэсгийн байцаагчийн ажлын зааврыг шинэчлэн боловсруулснаар дараах хүндрэл бэрхшээл арилна гэж үзэж байна. Үүнд:

- Хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүрэг, түүний хамрах хүрээ тодорхой болж, урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээнд төвлөрч ажиллах нөхцөл боломж нэмэгдэнэ.
- Хуучин заавар болон Цагдаагийн албаны тухай хууль, албан тушаалын тодорхойлолтын зарим заалтуудын зөрүүтэй байдлыг арилгасан.
- Хэсгийн байцаагч засаг захиргааны анхан шатны баг, хороо хариуцаж байгаа зохион байгуулалтын хэлбэрийг өөрчилж, тодорхой нутаг дэвсгэр хариуцан ажиллах шинэ хэлбэрийг нэвтрүүлснээр ажлын ачаалал жигдэрч, үр дүн дээшилнэ.
- Хэсгийн байцаагчийн ажиллах орчин нөхцөл, түүнтэй холбоотой харилцааг зохицуулах заалтыг оруулснаар ажлын бүтээмж нэмэгдэх боломж бүрдэнэ.
- Хэсгийн байцаагчид байвал зохих баримт бичгийн бүрдлийг тусгайлан зааж өгснөөр ажлын үр дүнг үнэн зөв дүгнэх, шаардлагатай мэдээллийн эх сурвалжийг бүрдүүлэх нэг боломж бий болно.

Зааврын төслийн эхний хэсэгт хэсгийн байцаагчийн ажлын заавраар зохицуулж буй харилцааны ерөнхий агуулга болон нэр томъёоны тодорхойлолтыг орууллаа. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2003 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 229 дүгээр тушаалаар баталсан “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ын 1.1-д “Цагдаагийн байгууллагын тухай хуулиар даалгасан гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх үүргийг хэрэгжүүлэхээр тодорхой нутаг дэвсгэрийн нэгжийг хариуцуулан Цагдаагийн төв байгууллагаас томилсон цагдаагийн алба хаагчийг хэсгийн байцаагч гэнэ”¹⁴⁸ гэж тодорхойлсон байдаг.

Харин энэхүү тодорхойлолтыг жаахан өөрчилж “Тодорхой нутаг дэвсгэр хариуцан ажиллаж, ажлын зааварт заасан үүргийг хэрэгжүүлж байгаа цагдаагийн алба хаагчийг хэсгийн байцаагч гэнэ” гэсэн тодорхойлолтыг зааварт оруулах шаардлагатай байна. Одоогийн зааварт байгаа тодорхойлолт нь хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүргийг цагдаагийн байгууллагын чиг үүргийг тоочих аргаар тодорхойлохыг оролдсон боловч дутуу оруулсан. Тухайлбал, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, захиргааны хяналт тавих үүргийг орхигдуулсан.

2019 оны байдлаар нийслэлийн нэг хэсгийн байцаагч дунджаар 2549 өрх, 9504 хүн ам хариуцаж байгаа ч хэсгийн байцаагч нарын хариуцаж байгаа хорооны өрх, хүн амын тоо их ялгаатай байна. Үүнийг өөрчилж, нэг хэсгийн байцаагч нэг баг, хороо хариуцах бус, харин хариуцах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг харгалзан тодорхой нутаг дэвсгэр хариуцан ажиллах нь ажлын бүтээмжид эерэг нөлөөлж, ажлын ачаалал буурна гэж үзэж байна. Хэсгийн байцаагчийн хариуцах газар нутгийг орон тоо, төсөвтөө багтаан нутаг

¹⁴⁸ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ., 2008. 425 дахь тал. Хэсгийн байцаагчийн ажлын заавар

дэвсгэрийн цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр тогтоож байхаар зааврын төсөлд оруула нь үр дүнтэй гэж үзэж зааварт оруулах нь зөв гэж үзэж байна.

Цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт сүүлийн 10-аад жил их шинэчлэгдсэнтэй холбоотойгоор мөрдөж ажиллах гол хууль тогтоомжуудыг зааврын төсөлд тоочиж оруулах шаардлага гарч байна. Бидний хийсэн судалгаагаар хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд голлон ашиглагдаж байгаа гол зургаан хуулийг зааврын төсөлд оруулж өгөх нь үйл ажиллагааны хамрах хүрээтэй холбоотой юм.

Хэсгийн байцаагчаар ажиллах алба хаагчид тавигдах нийтлэг болон тусгай шалгуур шаардлагыг шинээр оруулах нь зөв гэж үзсэн. Учир нь 2020 оны 9, 11 дүгээр сард хийсэн судалгаагаар нийслэлийн 38 хэсгийн байцаагч нарын 47.4 хувь, аймгийн төвийн 28 хэсгийн байцаагч нарын 25 хувь нь Дотоод зэргийн их сургуулиас өөр төрийн болон хувийн бусад их дээд сургууль төгссөн алба хаагчид байна. Тиймээс хэсгийн байцаагчид тавих тусгай шалгуурт цагдаагийн мэргэжлийн сургууль төгссөн байх шалгуурыг оруулсан нь ажлын үр дүнд эерэгээр нөлөөлнө гэж үзсэнтэй холбоотой.

Шинээр томилогдсон алба хаагч ажил хүлээн авахтай холбоотой харилцаа болон хэсгийн байцаагчийн хувийн бүрдэл баримт бичгийн жагсаалтыг шинээр оруулж өгснөөр хэсгийн байцаагчийн чадамжийг тодорхойлох, ажлыг дүгнэхэд ач холбогдолтой гэж үзсэн. Тиймээс хэсгийн байцаагчийн хувийн баримт бичгийн бүрдэлд 7, албаны баримт бичгийн бүрдэл 9 бүртгэл, судалгаатай байх нь үр дүнтэй гэж үзэж байна.

Хэсгийн байцаагчид цагдаагийн төв байгууллага, түүний харьяа алба, газар, хэлтэс, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, түүний харьяа тасаг, хэсэг гэсэн олон шатны удирдлагаас үүрэг, даалгавар өгдгийг өөрчилж, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, түүний харьяа нийтийн хэв журам хамгаалах нэгжийн удирдлагаас үүрэг чиглэл, даалгавар өгч байхаар зааварт оруулах нь ажлын ачааллыг бууруулахад эерэгээр нөлөөлнө. Түүнчлэн хэсгийн байцаагчийн ажлын зааварт “хэсгийн байцаагчийн туслах” гэсэн албан тушаалыг шинээр оруулах нь зүйтэй. “Хэсгийн байцаагчийн туслах” гэсэн албан тушаал нь одоогийн хэсгийн цагдаа гэсэн албан тушаалтай дүйцэж байгаа бөгөөд уг алба хаагч нь ахлагч цолтой, цаашлаад хэсгийн байцаагчаар ажиллах хүсэл сонирхолтой байх ёстой.

Нийслэлийн хорооны цагдаа нарын эрх хэмжээг туслах байцаагч нэрийн дор нэмэгдүүлэх, цаашлаад хэсгийн байцаагчийн нөөц бэлтгэхэд ач холбогдолтой гэж үзсэн.

Хэсгийн байцаагчийн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд ажиллах орчин нөхцөл, шаардлагатай техник хэрэгсэл, эд зүйлээр хангагдсан байдал чухал нөлөө үзүүлэх бөгөөд нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дарга үүнийг дангаараа бус харин тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны Засаг дарга дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах шинэ зохицуулалтыг оруулах нь зүйтэй гэж үзлээ.

Баг, хорооны Засаг дарга, иргэн, хуулийн этгээдтэй хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил, арга хэмжээг сард нэгээс доошгүй удаа зохион байгуулан хэрэгжүүлж байх нь үр дүнтэй учраас зааварт оруулах шаардлагатай. Үр дүн муутай урьдчилан сэргийлэх олон ажил, арга хэмжээ зохион байгуулдаг гэж фокус ярилцлагад оролцогчид илэрхийлсэн бөгөөд тэдний саналыг харгалзан сард нэг ажил чанартай явуулах, үүнийгээ жилээр нь урьдчилан төлөвлөж явуулбал үр дүнтэй болно гэж үзсэн.

Хэсгийн байцаагч Зөрчлийн тухай хуулийн дор дурдсан зүйлд заасан зөрчлийн талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаж шийдвэрлэх нь ажлын ачааллыг бууруулахад чухал ач холбогдолтой учраас зааварт дараах зөрчлийг шалгах аар оруулах хэрэгтэй. Тухайлбал:

- 5.1 дүгээр зүйл.Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах;
- 5.2 дугаар зүйл.Танхайрах;
- 5.3 дугаар зүйл.Хүний биед халдах;
- 5.5 дугаар зүйл.Нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах;
- 5.9 дүгээр зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчих;
- 5.16 дугаар зүйл.Энгийн харуул, манааны журам зөрчих;
- 6.5 дугаар зүйл.Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих;
- 6.18 дугаар зүйл.Садар самуун явалтай тэмцэх тухай хууль зөрчих.¹⁴⁹

¹⁴⁹ Төрийн мэдээлэл. 2017. № 24. Зөрчлийн тухай хууль

Хэсгийн байцаагчийн ажлын цагийн хуваарийг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дарга баталж, түүний хэрэгжилтэд хэв журам хариуцсан нэгжийн дарга хяналт тавьж ажиллах зохицуулалтыг оруулах, түүнчлэн хэсгийн байцаагч нь эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас даалгасан хүн, эд зүйлийг эрэн сурвалжлах ажлыг зөвхөн өөрийн хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд явуулж, мэдээлэл солилцох хүрээ хязгаарыг тогтоож өгөх заалт оруулах хэрэгтэй байна.

Хэсгийн байцаагч нь хариуцсан нутаг дэвсгэрийн онцлог, байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл, хүн амын суурьшил, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судалж, үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор объектын болон субъектийн гэсэн 2 төрлийн бүртгэл судалгаатай байхаар оруулж өгмөөр байна. Тиймээс хэсгийн байцаагч объектын 22, субъектийн 19 бүртгэл судалгаатай байх зохицуулалтыг оруулж өгмөөр байна. Гэхдээ хэсгийн байцаагчийн хариуцсан нутаг дэвсгэрийн онцлог, хүн амын нягтаршил, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлаас хамаарч харилцан адилгүй байж болохоор заах нь үр дүнтэй гэж үзэж байна.

Хэсгийн байцаагч объект болон субъектийн бүртгэл, судалгаанаас гадна дараах бүртгэлийг хөтөлж байх зохицуулалтыг оруулж өгөх шаардлага байна. Тухайлбал:

- шалган шийдвэрлэсэн зөрчлийн бүртгэл;
- хүлээн авч шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын бүртгэл;
- эд зүйл түр хураасан бүртгэл;
- согтуурах, мансуурах эмгэг өвчтэй хүнийг албадан эмчилгээнд хамруулсан бүртгэл;
- захиргааны журмаар албадан саатуулсан хүний бүртгэл;
- түр саатуулсан хүний бүртгэл.

Дээрх бүртгэлтэй байх нь хэсгийн байцаагчийн ажлын үр дүнг үнэн зөв тооцож гаргах, үнэлэхэд ач холбогдолтой.

Хэсгийн байцаагчийг нэгдүгээр зэрэглэлийн хамгаалалт болон нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох ажиллагаанд татан оролцуулахаас бусад тохиолдолд нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын даргын шийдвэргүйгээр олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд оролцуулахгүй байх зохицуулалтыг зааварт оруулж өгмөөр байна. Судалгаагаар нэг хэсгийн байцаагч нь нэг жилд дунджаар 10-14 удаа олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд оролцож, үндсэн ажлаа хийх боломж багасдаг.

Баг, хорооны Засаг даргын дэмжлэгтэйгээр нийтийн болон урамшуулалт эргүүл гаргах ажлыг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах зохицуулалтыг оруулж өгөх нь хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд дэмжлэг болох юм. Энэ нь хэсгийн байцаагчаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нийтийн болон урамшуулалт эргүүл ажиллуулахад хариуцсан нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулахад хүндрэл учирдаг байдлыг арилгах зорилготой. Түүнчлэн урьдчилан сэргийлэх субъектийн судалгаанд орсон иргэдтэй нэг бүрчилсэн арга хэмжээг сард нэг удаа зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах зохицуулалт шаардлагатай байна. Өнөөдөр хэсгийн байцаагч нар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон ажил, арга хэмжээ зохион байгуулж, явуулж байгаа ч түүний үр дүнг тооцдоггүй байдлыг өөрчлөх үүднээс энэхүү заалт чухал ач холбогдолтой.

Хэсгийн байцаагч нь ажлын зааварт заасан ажил үүрэг гүйцэтгэх ба үүрэгт үл хамаарах өөр ажил гүйцэтгүүлэхийг хориглохгүй бол бусад алба, нэгжийн дарга, нутгийн захиргааны байгууллагаас үндсэн ажил үүрэгтэй нь хамаарахгүй үүрэг даалгавар өгөх явдал буурахгүй байна.

Хэсгийн байцаагчийн жилийн ажлын төлөвлөгөөг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дарга, сарын ажлын төлөвлөгөөг нийтийн хэв журам хамгаалах нэгжийн дарга тус тус баталж, өдөр тутмын тэмдэглэл хөтөлж байвал төлөвлөгөөний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах боломж бүрдэнэ гэж үзэж байна. Хэсгийн байцаагч өдөр тутмын тэмдэглэл хөтлөх нь хийсэн ажлаа үнэн бодитой танилцуулж үнэлүүлэх, ажлын ачааллаа тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Хэсгийн байцаагч ажлын тайлангаа баг, хорооны иргэд, олон нийтэд жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор танилцуулж, гаргасан санал хүсэлтийг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж ажиллаж байх шаардлага тулгарч байна. Энэ нь тайлан тавих тодорхой хугацаатай байх, нөгөө талаараа ажлын төлөвлөгөөгөө боловсруулахад шаардлагатай мэдээ, мэдээлэл цуглуулах, улмаар цаашид хийх ажлын чиглэлээ тодорхойлоход хэрэгтэй.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан "Алба хаагчийн ажлыг үнэлэх" журам /код 111/-ын 111.4.18.2 "алба хаагчийн ажлыг сар тутам үнэлэх үзүүлэлтийг алба, нэгжийн саналыг

үндэслэн энэ журмын хавсралт болгон баталж, мөрдүүлнэ"¹⁵⁰ заалтыг үндэслэн ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны даргын 2019 оны 5-р сарын 0-ны А/14 дүгээр тушаалаар батлагдсан "Хэсгийн байцаагчийн ажлын дүн мэдээ гаргах аргачлал"-аар хэсгийн байцаагчийн ажлыг дүгнэн, хамгийн өндөр оноо авсан алба хаагчийг байр эзлүүлэх замаар ажлын үр дүнг тооцож байна. Харин ЦЕГ-ын даргын 2003 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Хэсгийн байцаагчийн ажлын заавар"-ын 11 дүгээр зүйл "Хэсгийн байцаагч ажлын дүнг тооцох үнэлэмж"-ийг баримтлахгүй байна.

Хэсгийн байцаагчийн ажлын үр дүнг сар, хагас, бүтэн жилээр тооцон дүгнэж, үнэлэхдээ харгалзах эрх зүйн актуудыг тоочин оруулж өгөх, түүнчлэн тайлан гаргах хугацааг зааж өгөх, ажлыг үнэлэх, баталгаажуулах үе шатуудыг тусгайлан оруулах нь ач холбогдолтой гэж үзэж байна. Хэсгийн байцаагч нь нийтийн хэв журам хамгаалах нэгжийн даргын өгсөн үнэлгээг зөвшөөрөхгүй байх тохиолдол гардаг. Тэгвэл нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын даргад бичгээр хүсэлтээ гаргаж дахин тайлбар, холбогдох нотломжийг гаргаж өгөх замаар ажлаа үнэн зөв үнэлүүлэх, эрх ашгаа хамгаалах боломжийг бий болгох шаардлагатай байна.

Хэсгийн байцаагч өдөр бүр шат шатны эрх бүхий дарга, албан тушаалтнуудаас үүрэг авах бус харин ажлын 7 хоногийн эхний өдөр эрх бүхий дарга нараас нэг удаа үүрэг авах нь хугацаа хэмнэх боломж байгаа талаар судалгаанд оролцогчдоос гаргасан саналыг үндэслэн долоо хоног бүрийн даваа гарагийн өглөө ажилд гарахын өмнө нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дарга болон нийтийн хэв журам хамгаалах нэгжийн даргаас үүрэг чиглэл, зааварчилгаа авч байх зохицуулалт оруулмаар байна.

Хэсгийн байцаагч байнга илүү цагаар ажилладаг гэсэн судалгааны дүн болон оролцогчдын гаргасан саналыг харгалзан илүү цагаар ажилласан цагийг өдөрт шилжүүлэн тооцож, ээлжийн амралтын өдөр дээр нэмж амраана гэсэн зохицуулалтыг оруулах нь ажлын бүтээмжид эерэгээр нөлөөлөх юм. Тэгвэл бодитойгоор нөхөж амрах боломж бүрдэнэ.

"Алба хаагчийн ажлыг үнэлэх журам" /код 111/ Монгол улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх /код 701/, Судалгаа, хяналтын тоо бүртгэл хөтлөх журам /код 703/, "Албан тушаалын тодорхойлолт" зэрэг эрх зүйн актуудын хоорондын уялдаа холбоог хангаагүйгээс хэсгийн байцаагчийн ажил бодитой үнэн зөв дүгнэгдэхгүй байх нөхцөл үүсч байна. Тухайлбал, Хэсгийн байцаагчийн ажлын заавраар хэсгийн байцаагч 15 төрлийн судалгаа хийхээр заасан бол Судалгаа, хяналтын тоо бүртгэл хөтлөх /код 703/ журмаар 41 бүртгэлийг хөтөлж мэдээллийн санд оруулахаар, зөрчил, гэмт хэргийн шинжтэй өргөдөл гомдол шалгасан тохиолдолд Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх /код 701/ журмаар 21 төрлийн маягтыг бөглөж санд оруулахаар байна. Тиймээс нэг хэсгийн байцаагч нийт 77 төрлийн бүртгэл, судалгаа хөтлөхөөр харагдаж байна. Үүнийг заавраар зохицуулах нь зүйтэй юм.

Зааварт шинээр оруулах нэг зүйл бол хэсгийн байцаагч нараас явуулах үйл ажиллагааны чиглэлийг дараах бүлэг асуудлын хүрээнд оруулж өгөх явдал юм. Тухайлбал,

- урьдчилан сэргийлэх эргүүлийн чиглэлээр 2;
- иргэдийг хүлээн авч, хандалтыг шийдвэрлэх чиглэлээр 7;
- хамтын ажиллагааны чиглэлээр 8;
- хариуцсан нутаг дэвсгэрийн нөхцөл байдлыг судалж, үнэлэлт өгөх чиглэлээр 8, нийт 4 чиглэлийн 25 тодорхой ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх зохицуулалтыг оруулах шаардлагатай юм. Дээрх зохицуулалтууд нь хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны хамрах хүрээг тодорхой болгох юм.

Зааварт хэсгийн байцаагчийн явуулах нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамаарах этгээдүүдийг шинээр тусгайлан зааж, зохион байгуулах ажлын хүрээг тодорхойлох нь зөв гэж үзэж байна. Хэсгийн байцаагч дараах этгээдүүдэд нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- захиргааны хяналт тогтоогдсон;
- гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн зөрчил гаргадаг;
- эмнэлгийн байгууллагын хяналтад байдаг согтуурах, мансуурах донтой;
- бага насны хүүхэд уруу татагч;
- архидан согтуурч, орчиндоо түгшүүр төрүүлдэг;
- тодорхой оршин суух хаяггүй, тэнүүчлэн амьдардаг хүмүүс.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн нийгмийн баталгаа нь Цагдаагийн албаны тухай хууль болон Төрийн албаны тухай хуулиар зохицуулагддаг. Харин хэсгийн байцаагчийн

¹⁵⁰ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ., 2018. 86-89 дэх тал. "Алба хаагчийн ажлыг үнэлэх журам /Код-111/

ажиллах орчин нөхцөл, шаардлагатай техник хэрэгслийн хангамжийн талаар зааварт оруулах нь зөв юм.

Мөн шинээр оруулах нэг зохицуулалт бол “Цагдаагийн хэсгийн мэдээллийн самбар” бөгөөд энэхүү мэдээллийн самбараар цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын цагийн хуваарь, иргэдийг хүлээн авах өдөр, цаг, хэсгийн байранд ажиллах албан тушаалтнуудын цол, овог нэр, холбогдох утасны дугаар болон хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авах нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын шуурхай удирдлагын албаны утас зэрэг мэдээллийг иргэдэд хүргэх боломж бүрдэх юм.

Зааварт хэсгийн байцаагчийн үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дарга, нийтийн хэв журам хамгаалах нэгжийн дарга нарын хүлээх үүргийг оруулж өгөх нь ажил үүргийн давхардлыг арилгах, нөгөө талаараа хэсгийн байцаагч үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд удирдлагын оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой болно.

Хэсгийн байцаагч нь хариуцсан нутаг дэвсгэрийн баг, хорооны Засаг даргатай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр олон ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Гэхдээ хамтран ажиллах хүрээ хязгаарыг тогтоож өгөхгүй бол Засаг даргаас явуулах бүхий л үйл ажиллагаанд татагдан орох нөхцөл үүсдэг тул хамтын ажиллагааны 8 хэлбэрийг зааварт оруулах нь зүйтэй юм.

Зааврыг шинэчилснээр хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны хамрах хүрээ тодорхой болж, гол үүрэг болох урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах цаг нэмэгдэнэ.

Хоёр. Албан тушаалын тодорхойлолтыг сайжруулах чиглэлээр.

Хэсгийн байцаагчийн ажлын зааврын дээрхи нэмэлт өөрчлөлтэй уялдуулан албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах шаардлага тулгарч байна.

Албан тушаалын тодорхойлолтын зорилгыг “Хариуцсан нутаг дэвсгэртээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, нийтээр дагаж мөрдөх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих” гэж тодорхойлох нь зөв гэж үзлээ.

ЦЕГ-ын дэд даргын 2019 онд баталсан “Албан тушаалын тодорхойлолт”-ын зорилтыг үйл ажиллагааны хамрах хүрээ, хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүрэг, ажлын онцлогтой уялдуулан дараах байдлаар өөрчилбөл үр дүнтэй гэж үзлээ. Тухайлбал:

Албан тушаалын зорилт:

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, үр дүнг нь тайлагнах.
2. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргийг хэрэгжүүлж ажиллах.
3. Цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм, журмыг мөрдөж ажиллах.

Зорилт бүрийн хүрээнд хийх ажлын чиглэлийг тоочиж оруулах нь үр дүнтэй гэж үзэж байна. Үүнд: нэгдүгээр зорилтын хүрээнд ес, хоёрдугаар зорилтын хүрээнд тав, гуравдугаар зорилтын хүрээнд гурав байх зохицуулалтыг оруулах шаардлагатай байна. Түүнчлэн хэсгийн байцаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг ТТ-10 болгож оруулсан нь өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг, ажлын ачаалал өндөр, нөгөө талаараа хэсгийн байцаагчийн үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилгыг агуулсан болно.

Гурав. Эрх зүйн зарим баримт бичгийг боловсронгуй чиглэлээр:

Нийслэлийн цагдаагийн хэсгийн байцаагч нийслэлийн засаг захиргааны анхан шатны нэгж-хороо хариуцаж ирсэн зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх нь түүний ажлын ачаалал жигдрэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна. Тиймээс Цагдаагийн албаны тухай хуульд зарим агуулга бүхий зохицуулалтыг оруулж өгөх нь зүйтэй гэж үзлээ. Тухайлбал, цагдаагийн хэсгийн байцаагчийн хариуцах нутаг дэвсгэрийн хэмжээ, хил хязгаарыг эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, хүн амын нягтрал, газар зүйн байршил, зам харилцааны нөхцөл, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлогийг харгалзан нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дарга тогтоож болох зохицуулалтыг санал болгож байна.

Тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн хэсэг дээр багаар ажиллах зохион байгуулалтын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх, түүний эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор хуульд тусгайлсан зохицуулалтыг оруулах саналыг дэвшүүлж байна.

Нийслэлд гарч байгаа гэмт хэрэг, зөрчлийн нэлээд нь архидан согтуурахтай холбоотойгоор гардаг бөгөөд Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийг ихэвчлэн цагдаагийн хэсгийн байцаагчид хэрэгжүүлдэг. Гэвч уг хуулийн заалтыг дахин давтан зөрчиж байгаа хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлага сул байдгаас зөрчлийн тоо буурахгүй байгаа нь тулгамдаж буй асуудал болсон. Тэгвэл хэсгийн байцаагчаас уг хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хууль тогтоомж зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх эрх

хэмжээ хязгаарлагдмал байдаг явдлыг өөрчлөх үүднээс согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газар ажиллах журмыг удаа дараа зөрчвөл нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч тусгай зөвшөөрлийг цуцалж болох заалтыг Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6.6-д оруулах саналыг дэвшүүлж байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зарим нэмэлт оруулснаар цагдаагийн хэсгийн байцаагч, төлөөлөгч гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж буй ажил, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх боломж дээшилнэ гэж үзсэн болно.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд харуул хамгаалалтын байгууллагуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, хэсгийн байцаагчтай хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 13.1.5, 13.1.6 дахь хэсэгт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, онц байдал, өндөржүүлсэн бэлэн байдал тогтоосон үед хамгаалалтын албадын хүч хэрэгслийг ашиглах, татан оролцуулах заалт нэмэх санал болгож байна.

Дүгнэлт

Хэсгийн байцаагч үйл ажиллагаандаа өдөр тутам мөрдөж байдаг гол баримт бичиг бол "Цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын заавар" болон "Албан тушаалын тодорхойлолт" юм. Эдгээр баримт бичгийг шинэчилбэл хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт сайжирч, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын бүтээмж нэмэгдэнэ. Түүнчлэн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх үүднээс зарим хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах нь ажлын ачааллыг бууруулж, үр дүн дээшилнэ гэж үзэж байна.

Санал

Хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн "Хэсгийн байцаагчийн ажлын заавар"-ыг хууль тогтоомжийн шинэчлэлтэй холбогдуулан шинэчлэн боловсруулах
2. Хэсгийн байцаагчийн ажлын шинэ заавартай уялдуулан "Албан тушаалын тодорхойлолт"-ыг шинэчлэн боловсруулах
3. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйл /Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх/-ийн 28.1.21. "цагдаагийн хэсгийн байцаагч, төлөөлөгч гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж буй ажил, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэж өгөх саналыг сум, дүүргийн ИТХ, Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх" гэж нэмэлт оруулах, 29 дүгээр зүйл /Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын нийтлэг бүрэн эрх/-ийн 29.1.6 хууль ёс, дэг журам, аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах талаар: в/ "тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагыг хууль тогтоомжийн хүрээнд удирдаж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажилд шаардлагатай зардлыг шийдвэрлэх" гэж нэмэлт оруулах;
4. Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 13.1.5. "гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах" гэж нэмэлт оруулах, 13.1.6 дахь хэсэгт "онц байдал, өндөржүүлсэн бэлэн байдал тогтоосон үед хамгаалалтын албыг төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр дэг журмыг сахиулах ажилд татан оролцуулах" гэж нэмэлт оруулах.
5. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6.6-д "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газар ажиллах журмыг удаа дараа зөрчвөл нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч тусгай зөвшөөрлийг цуцална" гэж нэмэлт оруулах.

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ АЛБАДАН ЗОГСООХ ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Ш.Чулуун

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Дотоодын цэргийн
албаны тэнхимийн дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Цагдаагийн албанд ашиглах тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгслийг алба хаагчаас хэрэглэх эрх болон үндэслэлийг нь Цагдаагийн албаны тухай хууль¹⁵¹, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-126/А-102 тоот тушаал¹⁵², Хууль зүйн сайдын баталсан А/190 тоот тушаал¹⁵³-д дараах байдлаар тус тус хуульчлан тусгасан байна.

Тээврийн хэрэгслийг зогсоох зорилгоор ашиглах зориулалттай төхөөрөмжийг тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл гэнэ.



Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгслийг дараах тохиолдолд хэрэглэнэ.¹⁵⁴

Үүнд:

- Өөрийнх нь, эсхүл бусдын амь нас, эрүүл мэндэд учирч болох бодит аюулыг таслан зогсоох шаардлага тулгарсан;
- Баривчлагдсан хүн, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан өөрөө жолоодон зугтсан, эсхүл түүнийг тээвэрлэн зугтсан;
- Тээврийн хэрэгслийг зогсоох талаар эрх бүхий албан тушаалтны тавьсан шаардлагыг үл биелүүлж зугтсан;
- Онц ноцтой гэмт хэрэг үйлдсэн хүн хэргийн газраас тээврийн хэрэгсэл ашиглан зугтсан, эсхүл тээврийн хэрэгслийг дээрэмдсэн, жолоочийг барьцаалан авч яваа тухай цагдаагийн байгууллагаас зарлан мэдээлсэн.

Хууль зүйн сайдын баталсан 2015 оны А/190 тоот тушаалд Цагдаагийн алба хаагчаас тээврийн хэрэгслийн жолоочид хандан шүгэл, дохиур модоор өгсөн ойлгогдохуйц дохиогоор /биеийн байрлал, гарын хөдөлгөөн/, эсхүл тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар, өнгийг хэлж, чанга яригчаар тавьсан зогсох шаардлагыг биелүүлээгүй, зугтаасан үйлдэл нь тухайн тээврийн хэрэгслийг албадан зогсоох үндэслэл болно¹⁵⁵ гэж тодотгон оруулж өгсөн байна.

Өөрийнх нь, эсхүл бусдын амь нас, эрүүл мэндэд учирч болох бодит аюулыг таслан зогсоох шаардлага тулгарсан, баривчлагдсан хүн, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан өөрөө жолоодон зугтсан, эсхүл түүнийг тээвэрлэн зугтсан, тээврийн хэрэгслийг зогсоох талаар эрх бүхий албан тушаалтны тавьсан шаардлагыг үл биелүүлж зугтсан, онц ноцтой гэмт хэрэг үйлдсэн хүн хэргийн газраас тээврийн хэрэгсэл ашиглан зугтсан, эсхүл тээврийн хэрэгслийг дээрэмдсэн, жолоочийг барьцаалан авч яваа тухай цагдаагийн байгууллагаас зарлан мэдээлсэн тохиолдолд тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэх боломжгүй бол галт зэвсэг хэрэглэх, эсхүл ачаа тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгсэл

¹⁵¹ Цагдаагийн албаны тухай хуулийн 5-р бүлгийн 55-р зүйл

¹⁵² Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалын 1-р хавсралт "Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар"

¹⁵³ Хууль зүйн сайдын 2015 оны А/190 тоот тушаалын 1-р хавсралт "Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам"

¹⁵⁴ Цагдаагийн албаны тухай хуулийн 55-р зүйлийн 55.1 дэх заалт

¹⁵⁵ Хууль зүйн сайдын 2015 оны А/190 тоот тушаалын 1-р хавсралт "Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам"-ын 7.1 дэх хэсэг

болон бусад хэрэгслээр хаалт тавьж тээврийн хэрэгслийг албадан зогсоож болно гэж заажээ.¹⁵⁶

Энэ тохиолдолд хүнд даацын тээврийн хэрэгслийг ашиглаж, хаалт тавихдаа шатахууны саванд шууд цохилт ирэхгүй байхаар байрлуулж, жолооч, зорчигчийг гаргасан байна. Өөрөөр хэлбэл цагдаагийн алба хаагч нь тухайн тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангаж тухайн ажиллагаанд ашиглахыг анхааруулсан байна.

Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэрийг цагдаагийн байгууллагын дарга, эсхүл шуурхай удирдлагын албаны зохицуулагч гаргана гэж шийдвэр гаргах албан тушаалтныг тодорхой зааж өгсөн.¹⁵⁷

Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэх тохиолдолд дор дурдсан нөхцөл байдлыг харгалзан үзнэ. Үүнд:

- Тээврийн хэрэгслийг нэн даруй албадан зогсоох үндэслэл бий болсон буюу гэмт этгээдийн жолоодож, эсхүл зорчин яваа тээврийн хэрэгсэлд байгаа хүн, тухайн ажиллагаанд оролцож буй алба хаагч, бусад этгээдэд аюул учруулж болох
- Тухайн нөхцөлд тусгай хэрэгсэл хэрэглэх, хаалт тавих ажиллагааны аль нь тохиромжтойг сонгох

Тусгай хэрэгслийг зөвхөн тухайн албадан зогсоох шаардлагатай байгаа тээврийн хэрэгсэлд нөлөөлөхөөр хэрэглэнэ. Тээврийн хэрэгслийг албадан зогсоохын өмнө хурдыг сааруулах зорилгоор саад хэрэглэж болно. Өөрөөр хэлбэл тухайн тээврийн хэрэгслийн болон тухайн орчны аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авсан байвал зохино.

Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгслийг хэрэглэсэн тохиолдолд хэрэглэх шийдвэр гаргасан, түүнийг гүйцэтгэсэн алба хаагч тус тус илтгэх хуудас бичиж даруй байгууллагын хариуцсан газар, хэлтсийн даргад, дарга нь харъяалах прокурорын байгууллагад мэдэгдэнэ. Дараах тохиолдолд тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгслийг хэрэглэхийг хориглоно. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөн ихтэй газар
- Тусгай хэрэгсэл ашигласнаар олон нийтэд эрсдэл, аюул учруулж болох үед

Мөн тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгслийг хэрэглэхдээ дараах зам, газрыг сонгосхоод анхаарсан байна. Үүнд:

- Замын нарийссан хэсэг
- Албадан зогсоох шаардлагатай тээврийн хэрэгслийн жолоочид харагдахааргүй газрыг сонгох гэх мэт
- Алба хаагчийн аюулгүй байдалд эрсдэл учрахаар бол
- Үзэгдэх орчин хязгаарлагдмал нөхцөлд, замын уулзвар, эргэлт, гүүр, төмөр замын гармын орчимд
- Явган зорчигчийн хөдөлгөөн ихтэй газар

Тээврийн хэрэгсэл ашиглан оргон зайлсан онц аюултай гэмт хэрэгтэн, мөн өөрийгөө хянах чадваргүй согтуу буюу мансуурсан этгээд тээврийн хэрэгсэл ашиглаж байгаа нь тогтоогдсон тохиолдолд тээврийн хэрэгслийг албадан зогсоох арга хэмжээ авна.

Үүрэг гүйцэтгэх явцад хангалттай үндэслэл бүхий сэжиг илэрсэн тохиолдолд зогсоох арга хэмжээ авах бөгөөд тавьсан шаардлагыг үл хэрэгсэн зугтсан тохиолдолд дараагийн хяналтын хэсэг рүүгээ мэдээлэхийн зэрэгцээ бусад замын цагдаагийн бусад хяналтын цэгт уг машины марк, улсын дугаарыг яаралтай мэдэгдэх шаардлагатай. Уг мэдээллийг авсан замын цагдаагийн ажилтан зугтсан тээврийн хэрэгслийг угтан ойр орчиндоо аль болох аюулгүй аргаар зогсоох арга хэмжээ авна.

Замын цагдаагийн ажилтан нь зориулалтын хаалтын хэрэгсэл ашиглах, дугуй хагалагч /зараа/-г зам дээгүүр хөндлөн татах, хүнд даацын тээврийн хэрэгслээр замын зорчих хэсэг дээр хөндлөн байрлуулах зэрэг арга хэмжээнүүдийг авна.

Шалтгаан нь тодорхойгүй тохиолдолд бусдын тээврийн хэрэгслийг хөөж, хууль бус зөвшөөрөгдөөгүй аргаар зогсоох нь эрсдлийг үүсгэх нөхцөл бий болно. Тиймээс аль болох татгалзах хэрэгтэй.

Түүнчлэн цагдаагийн алба хаагч тээврийн хэрэгсэл дайчлан ашиглах явцдаа нөхцөл байдлыг буруу үнэлэн шийдвэр гаргаж уг тээврийн хэрэгслийг гэмтээвэл цагдаагийн алба хаагч өөрөө буруутан болно.

¹⁵⁶Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалын 1-р хавсралт "Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар"-ын 5.2 дахь хэсэг

¹⁵⁷Чулуун.Ш., "Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл", УБ хот., 2019 он., 83 дахь тал

Тийм учраас цагдаагийн алба хаагчаас тээврийн хэрэгслийг албадан зогсоох ажиллагааг хийж гүйцэтгэхдээ Хууль зүйн сайдын баталсан 2015 оны А/190 тоот тушаал¹⁵⁸-аар заасан арга барил, аргачлалыг авч хэрэгжүүлэн ажилласан байвал зохистой юм. **Үүнийг тодруулбал:**

Тээврийн хэрэгслийг албадан зогсоох зорилгоор ашиглах багаж, эд зүйл, зэвсэг хэрэгслийг тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл гэнэ.

Тээврийн хэрэгслийг албадан зогсооход тусгай хэрэгслийг дараах тохиолдолд хэрэглэнэ.

1.Цагдаагийн алба хаагчаас жолоочид тээврийн хэрэгслээ зогсоох талаар өгсөн ойлгогдохуйц дохио, шаардлагыг биелүүлээгүй, сэжигтэй байдлаар зугтсан;

2.Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч болон ялтан өөрөө жолоодон зугтсан, эсвэл тийм этгээдийг тээвэрлэн зугтсан, мөн онц ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээд хэргийн газраас зугтахдаа тээврийн хэрэгслийг ашигласан, эсхүл дээрэмдэх, барьцаалах хэлбэрээр авч яваа тухай цагдаагийн байгууллагаас зарлан мэдээлсэн;

3.Хулгайд алдагдсан тухай зарлагдсан тээврийн хэрэгслийг жолоодож яваа болон хулгайд алдагдсан эд зүйлийг тээвэрлэн зугтсан;

4.Хүний амь нас, эрүүл мэндэд бодит аюул учруулж болзошгүй яваа жолоочийн үйл ажиллагааг таслан зогсоох.

Тээврийн хэрэгслийг албадан зогсооход дараах үйл ажиллагаа хамаарна.

1.Тээврийн хэрэгслээр хөөж, хөөгдөж яваа тээврийн хэрэгслийг гүйцэж зэрэгцэн очиж зогсох дохио өгч, замын хашлага /хөвөө рүү/ шахан урдуур хөндлөн зогсож хаах;

2.Автомашины дугуй хагалах зориулалттай багаж /зараа/ зугатаж яваа тээврийн хэрэгслийн замд тавьж дугуйг хагалан зогсоох;

3.Ачааны автомашин, трактор, чиргүүл болон бусад саад хийж болох зүйлийг ашиглан зам дээр хаалт хийж зогсоох.

Цагдаагийн алба хаагч нь тээврийн хэрэгслийг албадан зогсоохдоо доорх үйл ажиллагааг баримтална. Үүнд:

1.Жолоочид тээврийн хэрэгслээ зогсоох талаар өгсөн ойлгогдохуйц дохио, шаардлагыг биелүүлээгүй зугтсан тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар, өнгийг тухайн тээврийн хэрэгсэл явсан чиглэлд ажиллаж байгаа суурин хяналтын байр, цагдаагийн алба хаагчид холбооны болон бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан мэдээлж зогсоож, саатуулах арга хэмжээг авахуулах;

2.Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг мөрдөн хөөх зайлшгүй үедтээврийн хэрэгслээр хөөж зогсоох шаардлагатай бол аль чиглэлд яваа ямар марк, дугаартай, ямар өнгийг тээврийн хэрэгслийн араас хөөх тухайг жолоочид хэлж, хурдыг тохируулах, болзошгүй аюул, ослоос сэргийлэхийг анхааруулж, аюулгүй байдлыг хангуулах;

3.Боломжтой бүх тохиолдолд тээврийн хэрэгслийг хөөж яваа тухайгаа харъяа цагдаагийн байгууллагын ерөнхий зохицуулагчид мэдэгдэж, түүний зааврын дагуу ажиллах;

4.Зугтсан тээврийн хэрэгслийг бусад тээврийн хэрэгслээр хөөж зогсоохдоо хөөгдөж яваа тээврийн хэрэгслийг гүйцэж зэрэгцээ эгнээнд орох үедээ жолоочид нь тээврийн хэрэгслээ зогсоохыг дохиогоор болон чанга яригчаар мэдэгдэхүйц өгч, хөөж яваа тээврийн хэрэгслээр замын хашлага /хөвөө/ рүү шахах үйлдлийг хийж урьд нь орж хааж зогсооно.Энэ тохиолдолд хөөгдөж яваа тээврийн хэрэгслийг хурдаа сааруулж, зогсох боломжийг ойлгохуйц зайнд өгч зогсоох;

Тээврийн хэрэгслийг хөөж яваа тухай мэдээллийг хүлээн авсан ерөнхий зохицуулагч тухайн тээврийн хэрэгслийг албадан зогсоох ажлыг удирдан зохион байгуулж, холбогдох байгууллага /прокурор, дээд шатны албан тушаалтан гэх мэт/ албан тушаалтанд мэдэгдэх ажлыг зохион байгуулна.

Тээврийн хэрэгсэл ашиглан зугтаж яваа этгээд галт зэвсгээр зэвсэглэсэн, түүнийгээ хэрэглэх магадлалтай, эсвэл жолоочийг юм уу өөр бусад гэмгүй хүмүүсийг барьцаалан амь насанд нь илтээр аюул заналхийлж яваа тохиолдолд харъяа цагдаагийн байгууллагын ерөнхий зохицуулагчид мэдэгдэж, түүний шийдвэрээр ажиллана.

Тээврийн хэрэгслийг тусгай багаж, техник хэрэгсэл ашиглан албадан зогсоох тохиолдолд дараах үйл ажиллагааг явуулна.¹⁵⁹ Үүнд:

1.Тээврийн хэрэгслийн дугуйг хагалах багаж "зараа"-г ашиглахдаа зугатаж яваа тээврийн хэрэгслийн өмнө зам дээр хөндлөн буюу дагуу хэлбэрээр сунгаж байрлуулах;

¹⁵⁸Хууль зүйн сайдын 2015 оны А/190 тоот тушаалын 1-р хавсралт "Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам"-ын 7-р хэсэг

¹⁵⁹Хууль зүйн сайдын 2015 оны А/190 тоот тушаалын 1-р хавсралт "Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам"-ын 7.8 дахь заалт

2.Ачааны автомашин трактор, чиргүүл болон бусад саад хийх /алсаас харагдахуйц овор хэмжээтэй/ зүйлээр хаалт хашлага хийж тээврийн хэрэгслийг албадан зогсоохдоо албадан зогсоох гэж байгаа тээврийн хэрэгслийн замыг угтуулан ачааны автомашин, тракторын толгой /бүхээгний/-н хэсгийг замын гадна тал руу харуулж их бие, тэвшээр нь хоёр талаас уулзуулах хэлбэрээр зам дээр хөндлөн хаалт хийх.

Хаалтад тавигдсан тээврийн хэрэгслийн бүхээгт жолооч, зорчигч байлгахыг хориглоно.Тээврийн хэрэгслийг албадан зогсоох ажиллагааг дуу, дүрс бичлэгийг хэрэгсэл ашиглан баримтжуулна.

Зугтаж яваа тээврийн хэрэгслийн өмнө дугуй хагалах багаж "зараа" болон тээврийн хэрэгслээр хаалт хийсэн тохиолдолд ойролцоо нь цагдаагийн алба хаагчийг байрлуулж, зугатаж яваа этгээдэд урьдчилан сануулж, зогсох дохио өгч анхааруулбал зохино.

Албадан зогсоох тусгай хэрэгсэл, хаалт хэрэглэн албадан зогсоох ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах бөгөөд бололцоотой бүх тохиолдолд тухайн тээврийн хэрэгслийг жолоодож яваа этгээдэд урьдчилан сануулсны дараа, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахаас сэргийлэх, аль болох хүнгүй, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнгүй замд хэрэглэх нь зүйтэй.

Тээврийн хэрэгслийг албадан зогсоох багаж /зараа/ болон тээврийн хэрэгсэл, эд зүйлээр хаалт, хашлага хэрэглэсэн тухай бүрт тэмдэглэл үйлдэж 24 цагийн дотор прокурорт танилцуулна.

Тээврийн хэрэгслийг хөөхөд ашигласан тээврийн хэрэгслийн жолоочид Цагдаагийн байгууллага хариуцаж барагдуулна. Харин зугтсан тээврийн хэрэгслийг хөөх, албадан зогсоох үед иргэн, байгууллагад учирсан хохирлыг гэм буруутай этгээд хариуцна.

Манай улсын цагдаагийн байгууллагын хэмжээнд өнөөдрийн байдлаар тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгсэл болох "Дэлгэдэг зараа"-г албаны үйл ажиллагаанд ашиглаж байна.

Харин хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулахгүйгээр тээврийн хэрэгслийг албадан зогсоох зориулалттай олон төрлийн тусгай хэрэгслийг гадаадын цэрэг, цагдаагийн байгууллага өөрийн үйл ажиллагаандаа өргөнөөр хэрэглэж байна. Тухайлбал: АНУ-ын цэрэг, цагдаа, шерифийн албанд дор дурдсан тусгай хэрэгслийг хэрэглэж байна. Үүнд:

Өргөс¹⁶⁰

- Хөнгөн жинтэй, зөөвөрлөхөд авсаархан, аль ч талаар нь шидсэн дээшээ харч унадаг.
- Автомашины дугуйнд шигдэж хагарах, цаашилбал дугуйг ураг нөлөө үзүүлнэ.
- Цуваа байдлаар хооронд холбож хэрэглэж болох ба ингэснээр үр нөлөөг нь дээшлүүлнэ.
- Автомашиныг зогсоох, тодорхой газар оронд зорчигчдыг болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хорих зорилгоор ихэвчлэн хэрэглэдэг.
- Ротын түвшинд 400 ш, салааны түвшинд 50 ш байна.

Хадаас

Босоо хадаас бүхий автомашин шигдэн хийг хөдөлгөөн

Энэ нь дугуй буудаж хяналтаа алдахаас сэргийлсэн сайн талтай. дугуйнд шигдсэн

тохиолдолд



зогсоох хэрэгсэл нь дугуйнд гарган, автомашиныг цаашид үйлдэх чадваргүй болгодог.



4-6 ширхэг хадаас машины 15-20 секундэд хий бүрэн гарна.


¹⁶⁰Аминд үл хүрэх зэвсэг-2010" сургалт /Зэвсэгт хүчний 150, 084, 032-р анги болон Цагдаа, дотоодын цэргийн төлөөлөл болон оролцсон нийт 162 цагдаа, цэргийн алба хаагчдад "Таван толгой"сургалтын төвд зохион байгуулсан АНУ-ын сургагч багш нарын сургалт/

Дэлгэн байрлуулах, зөөвөрлөхөд хялбар, тодорхой газар оронд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хянах, хаалт хийхэд тохиромжтой.

Ротын түвшинд 12 ш, салааны түвшинд 3ш байдаг байна.

Тээврийн хэрэгсэл зогсоох хэрэгсэл

- Хэт богино долгион гаргах замаар автомашины цахилгааныг таслан зогсоох зориулалт бүхий төхөөрөмж
- Бие бүрэлдэхүүн, барилга байгууламжийн хамгаалалт, энгийн иргэдийг болзошгүй аюулаас хамгаалахад тохиромжтой.



автомашины таслах замаар зогсоох үзүүлнэ.

- Хөдөлгөөнт, хурдан хугацаанд боломжтой.

Vehicle Interrupt System - Portable Unit



Тээврийн хэрэгслийг зогсоох цахилгаан хэрэгсэл (VIS)

- Цахилгаан гүйдлээр цахилгааныг үйлчилгээ

байрлалыг солих

Тээврийн хэрэгсэл зогсоох хэрэгсэл (дэлгэдэг тор)¹⁶¹



жин -18кг

- Хот дотор болон задгай дээр ашиглах
- "Иракийн эрх чөлөө" ашиглаж байсан байна.

- 60 км/ц хүртэл хурдтай 2500 кг жин бүхий тээврийн хэрэгслийг 200 м зайд зогсооно.

- Түргэн дэлгэн байрлуулах боломжтой, эвхэгддэг, авч явахад авсаархан, тусгай зориулалтын хадаас бүхий торон бүтэцтэй тээврийн хэрэгсэл зогсоох хэрэгсэл юм.



- Хэмжээ – 3мх6м, өөрийн хувийн

газар, ШНЦ боломжтой. ажиллагаанд

¹⁶¹Аминд үл хүрэх зэвсэг-2010" сургалт /Зэвсэгт хүчний 150, 084, 032-р анги болон Цагдаа, дотоодын цэргийн төлөөлөл болон оролцсон нийт 162 цагдаа, цэргийн алба хаагчдад "Таван толгой" сургалтын төвд зохион байгуулсан АНУ-ын сургагч багш нарын сургалт/



Тээврийн хэрэгсэл зогсоох зөөврийн хаалт (PVAB)¹⁶²

- Шалган нэвтрүүлэх цэг болон замын хаалтанд ашиглана.
- Замын хөдөлгөөнд саад болохгүй.
- 1.5 секундэд ашиглахад бэлэн болно.
- 70км/ц-ийн хурдтай явж буй 3750 кг жинтэй тээврийн хэрэгслийг зорчигчид болон машинд гэмтэл учруулахгүйгээр зогсооно.

Дүгнэлт

Цагдаагийн алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэж, бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг чанд баримтлан түүнд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулах нь учирч болох аливаа сөрөг үйлдэл, үр дагавраас урьдчилан сэргийлэх, эрхээ хэтрүүлэхгүй байх үр дүнтэй арга хэмжээ болох юм.

Мөн төв орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс, тасаг, сумын хэсгийн төлөөлөгч нарт тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгслийг нэгдсэн хангалтаар тавьж олгох, тусгай хэрэгслийг ашиглах онолын болон үр чадварын сургалтыг тухай бүр зохион байгуулж хэвшүүлэх шаардлагатай байна. Ингэснээр нэг талаас өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах, нөгөө талаас хүний эрхийг дээдлэх үндсэн нөхцлийг бий болгоно.

Цаашид хөгжингүй болон хөгжилтэй орнуудын цэрэг, цагдаагийн албанд ашиглаж буй тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгслийн талаар дэлгэрэнгүй судалгаа хийх, мэргэжлийн алба хаагчдыг энэ чиглэлийн сургалтанд хамруулах, албанд нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Ном зүй

Нэг. Хууль тогтоомж:

- Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017.02.09
- ХЗДХС,УЕП-ын хамтарсан 2017.09.06-ны өдрийн А-224/А-102 тоот тушаалын 1 дүгээр хавсралт "Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар"
- Хууль зүйн сайдын 2015 оны А/190 тоот тушаалын 1-р хавсралт "Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам"

Хоёр. Сурах бичиг, гарын авлага

- Ш.Чулуун. "Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл", УБ хот., 2019 он

Гурав. Бусад

- Аминд үл хүрэх зэвсэг-2010" сургалт /Зэвсэгт хүчний 150, 084, 032-р анги болон Цагдаа, дотоодын цэргийн төлөөлөл болон оролцсон нийт 162 цагдаа, цэргийн алба хаагчдад "Таван толгой" сургалтын төвд зохион байгуулсан АНУ-ын сургагч багш нарын сургалт/

¹⁶²Аминд үл хүрэх зэвсэг-2010" АНУ-ын сургагч багш нарын сургалт

МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ, ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ ШАЛГУУР, ТЭДГЭЭРИЙН ОНЦЛОГ

Л.Нямдаваа
ДХИС-ийн докторант, цагдаагийн хурандаа

Товч агуулга. Ёс зүй нь хувь хүний ёс суртахууны сайн талын шинж чанаруудын нийлбэр цогцыг, нөгөө талаас хүмүүсийн хоорондын харилцааны хэм хэмжээний нийлбэр цогцыг судалдаг шинжлэх ухаан юм.

Хүмүүс өдөр тутмынхаа ажил амьдралд эрх зүйн төдийгүй, ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгодог. Ёс зүй гэдэг нь тухайн мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тавигдах ёс суртахууны өвөрмөц хэм хэмжээнээс гадна хүнлэг, энэрэнгүй байж ажил мэргэжлээ өндөр ур чадвартайгаар хийж гүйцэтгэхийг давхар шаарддаг билээ. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагчийн үйл ажиллагаа нь ямагт хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндийг хөндөж байдаг тул түүний хийсэн үйлдэл бүхэн зөвхөн хуулийн хүрээнд хийгдэх шаардлага нийгмийн болон эрх зүйн зүгээс тавигддаг.

Энэхүү өгүүлэлд мэргэжлийн ёс зүй, хандлагыг тодорхойлох шалгуур, эрдэмтэн, судлаачдын шалгуурт тавьсан хүчин зүйлүүдийн талаар товч дурдсан болно.

Түлхүүр үг. Мэргэжлийн ёс зүй, хандлага, ёс суртахуун, шалгуур, шаардлага

Үндсэн хэсэг. Доктор Ц.Гомбосүрэн “Ёс зүй” сурах бичигтээ “Ёс зүй нь гүн ухааны нэгэн салбар бөгөөд ёс зүйн талаарх сайн эсвэл муу, зөв эсвэл буруу, сайн үйл эсвэл муу үйл, хууль дүрэм эсвэл гэмт хэрэг гэх мэт зүйлүүдийг судална. Ёс зүй хэмээх ойлголт нь эртний Грекийн “Ethos” буюу хамтран амьдрах, оршин амьдрах газар утгатайгаар илэрхийлэгддэг байсан. Хожим нь хөгжлийн явцад “ёс заншил, зан төлөв, зан араншин, сэтгэлгээний хэв маяг” гэсэн агуулгатай болж, тэдгээрийн шинж чанарыг илэрхийлэх болжээ¹⁶³.

Ёс зүй нь зарим тохиолдолд эрх зүйгээс ч ихээхэн хүчтэй байдаг нь хүмүүс түүнийг ямар нэгэн албадалгүйгээр өөрсдөө тогтоож, урт удаан хугацааны туршид зан үйлээрээ журамлан зохицуулж ирсэнд оршдог. Нийгмийн уур амьсгал бүрэлдэн тогтоход ёс зүй нь хоёр талт нөлөө үзүүлсээр ирсэн.

Мэргэжил гэдэг нь Профессия (лат. professio; от profiteor — «өөрийн үйл хэргийг тунхаглаж байна¹⁶⁴» гэсэн латин үгнээс гаралтай ба олон улсад “Profession” гэж нэрлэгддэг. Мэргэжил нь тусгай сургалт эсвэл тусгай боловсролын явцад олж авсан онолын мэдлэг, практик ур чадварыг эзэмшсэн байхыг хэлдэг.

Эзэмшсэн мэргэжилдээ эзэн нь байж ёс суртахуунтай мэргэжлийн үйл ажиллагааны ёс суртахууны зарчим, хэм хэмжээг дагаж албаны нэр төрийг хамгаалах алдаа дутагдлыг арилгах, тийм алдаанаас урьдчилан сэргийлэхэд мэргэжлийн ёс зүйн боловсрол хэрэгтэй билээ.

Мэргэжлийн ёс зүй бол мэргэжлийн үйл ажиллагааны ёс суртахууны зарчим, хэм хэмжээний тогтолцоог судалдаг ёс зүйн нэг салбар билээ. Мэргэжлийн ёс зүй нь мэргэжилтэн бүр өөрсдийнхөө үйлдлийг ёс суртахууны шаардлагад нийцүүлж байх, тэрчлэн мэргэжлийн ёс суртахууны зөрчлийг илрүүлж, ёс суртахууны хувьд муу үйлдэлд хориг саад тавих зэрэг ёс суртахууны зарчим, хэм хэмжээг танин мэдэх, хэрэгжүүлэхэд ач холбогдолтой.

Мэргэжлийн ёс зүй нь мэргэжлийн нэр төрийг хамгаалах, мэргэжлийн ёс суртахууны алдаа дутагдлыг арилгах, тийм алдаанаас урьдчилан сэргийлэх, мэргэжлийн ёс суртахууны хариуцлагыг дээшлүүлэх, мэргэжлийн нэг хүндийг өргөх нэг үндсэн арга юм.

Мэргэжлийн ёс зүй бол тодорхой ажил мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд зан үйлийг зохицуулах арга хэрэгсэл юм. Аливаа мэргэжлийн онцлогийг илэрхийлсэн ёс суртахууны зарчим, хэм хэмжээний нийлбэр цогц юм.

Мэргэжлийн ёс зүй бол мэргэжлийн үйл ажиллагааны ёс суртахууны үндэслэлийг судлах ёс зүйн судалгааны чиглэл, аливаа мэргэжилтнийг бэлтгэх үйл ажиллагааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь мэргэжлийн ёс зүйд суралцах үйл ажиллагаа байдаг.

Доктор С.Наранчимэг Мэргэжлийн ёс зүй бүрэлдэх үе шатыг доорх байдлаар авч үзсэн байна¹⁶⁵.

¹⁶³ Бунхийхны Ц.Гомбосүрэн. Ёс зүй.2008., тал6-8

¹⁶⁴ Прохоров А.М. (гл.ред.) Большой энциклопедический словарь. М.1993. с. 912.

¹⁶⁵ С.Нарантуяа. Хүн хэдийн ухаантай ч. УБ., 2010. 8-9 дэх тал.



Мэргэжлийн ёс зүй нь хувь хүний ёс суртахууны төлөвшлийг сайжруулах, мэргэжлийн ёс зүйг дээшлүүлэх, нийгмийн харилцааг боловсронгуй болгох, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүн төрөлхтний түүхийн бүхий л цаг үед улс орнууд, эрдэмтэн мэргэд мэргэжлийн ёс зүйн асуудалд онцгой анхаарсаар ирсэн билээ.

МЭДЛЭГ.

Мэдлэгийн тогтолцоонд мэргэжлийн ёс зүй томоохон байр суурь эзэлдэг. Орчин үед дэлхий дахинд мэргэжлийн ёс зүйн асуудлаар сургалт, судалгааны ажил улам өргөн цар хүрээтэй болж байна. ЮНЕСКО-ийн зүгээс ч мэргэжлийн ёс зүйн боловсрол бол зөвхөн хөдөлмөрийн зах зээлд орох бэлтгэл гэхээсээ илүү амьдралын үнэт зүйл, үнэ цэнийг авчирдаг¹⁶⁶ билээ. Өөрөөр хэлбэл, танин мэдэх үйл ажиллагааны үр дүнд тодорхой мэргэжлээр сурч боловсрол эзэмшсэн түвшин, мэдэц ба боловсрол дадал зуршлаар ур чадвар олж авах тодорхой мэдээллийг сайн мэдэж байхыг хэлнэ.

Мэдлэгийн ёс суртахууны асуудал нь хувь хүний оршихуйн баталгааны асуудал төдийгүй нийгмийн өмнө тулгамдсан асуудлын нэг болж байна. Мэдлэгийг практик хэрэглэхэд эерэг ба сөрөг үр дагавартай. Эерэг үр дагавар нь техник, технологийн дэвшлийг бий болгож, нийгмийн хөгжлийг түргэсгэх гол хүчин зүйл болдог бол сөрөг үр дагавар нь оршихуйг устгах юм. Ёс суртахууны мэдлэг "эвдэн сүйтгэгч", "хүчирхийлэл, дайснагл"-ыг ч бий болгодог талаар дэлхийд түүхэнд гунигт цаг хугацаа ч бий.

Мэдлэгийн менежмент: Энэ нь хэрэгтэй чухал мэдээллүүдийг тодорхойлох, сонгох, боловсруулах, тараан дэлгэрүүлэх, дамжуулахад нь туслах процесс бөгөөд байгууллагын цөм, байгууллага дотор системчлэгдээгүй хэлбэртэй оршин байгаа мэдлэгийг экспертийн болгох нэгээхэн хэсэг юм. Мэдлэгийг ийнхүү системчлээд ирэхээр асуудлыг хурдан бөгөөд оновчтой шийдэх, эрчимтэй суралцах, стратеги төлөвлөх, шийдвэр гаргах зэрэгт тустай. Мэдлэг нь асуудал хэрхэн үүссэн, тэдгээр нь хэрхэн шийдвэрлэгдэж байгааг тодорхойлох явдал мөн бөгөөд мэдлэгийн менежмент нь байгууллагын суралцах үйл явц, цаашдын мэдлэг бүтээх үйл явцыг дэмжиж байдаг үйл ажиллагаа юм¹⁶⁷.

Мэдлэг бүтээх үе шат: Орчин үед дэлхий хөгжлийг тодорхойлох чиг хандлага нь мэдлэгийн менежмент дээр суурилах билээ. Энэ нь туршлага, үнэт зүйлс, мэдээлэл, мэргэжлийн үзэл бодол, хандлага, түүгээр дамжуулан шинэ мэдээллийг олж авах, үнэлж дүгнэх, хуучин мэдлэгтэй хослуулан хэрэглэх үр чадварын цогц юм.

Мэдлэг бүтэх үе шатуудыг судлаач Benjamin Bloom доорх байдлаар авч үзсэн байна.

1. Сургуулийн өмнөх боловсрол / ясли, цэцэрлэг/
2. Сургуулийн шатны боловсрол
3. Мэргэжлийн боловсрол
4. Практик боловсрол¹⁶⁸

Өөрөөр хэлбэл, мэдлэг бүтээх ойлголтод бүтээлч сэтгэлгээ, мэдлэгийг үнэлэх, анхаарах, зориудын зорилготой эрэл хайгуул, оролдлого үйл ажиллагаа, илүү тусгай нарийн мэдлэг, өрсөлдөх чадвартай мэдлэгт суурилсан байдаг байна. Иймд мэдлэгийн суурийг тавих чадварлаг багш нараас эхлээд шинэ мэдлэгийг бүтээгч нар нь нийгэмд ихээхэн үүрэгтэй. Өнөөгийн бидэнд дутагдаж байгаа нэг зүйл нь мэдлэг бүтээх үйл явц билээ.

¹⁶⁶ <https://ru.unesco.org/themes/informacionnaya-etika> (хандалт: 2021.03.30)

¹⁶⁷ Girard, John P.; Girard, JoAnn L. "Defining knowledge management: Toward an applied compendium" (PDF). Online Journal of Applied Knowledge Management. (2015). P. 14.

¹⁶⁸ Bloom, Benjamin S. Taxonomy of Educational Objectives. 1956. <https://www.uky.edu/~rsand1/china2018/texts/Bloom%20et%20al%20-%20Taxonomy%20of%20Educational%20Objectives.pdf>

БОДОЛ ЭРГЭЦҮҮЛЭЛ, СЭТГЭХҮЙ.

Тунгаан бодох чадвар гэдэг нь тодорхой дарааллын дагуу асуудал дэвшүүлж сайтар эргэцүүлэн бодохыг хэлнэ. Мөн дүгнэлт, итгэл үнэмшилд хүрэхийн тулд үндэслэл болон логикийг бүтээлчээр ашиглахыг хэлж болно. Тунгаан бодох чадварт аливаа мэдээлэл болон итгэл үнэмшилд дүн шинжилгээ хийх, сонсож буй зүйлээ үнэн эсэхийг тогтоох чадвар багтана. Түүнчлэн ертөнцийн олон янзын хэв маяг, өнгө төрх дундаас санаа бодлоо ургуулж түүнийгээ сургамж, туршлагатай холбон үзэх боломж олгодог. Үндэслэл сайтай шинэ онол боловсруулах, мөн бодитой, сайтар томъёологдсон нотолгоо гаргаж ирэхэд тунгаан бодох чадвар нь зайлшгүй шаардагдана.

Тунгаан бодох чадвар нь үндэслэл гаргаж, асуулт тавих чадварыг хөгжүүлдэг учраас хүний амьдралын бүхий л хүрээний мэдээлэл түүнд хамаардаг. Чухал шийдвэр гаргахын тулд шалтгааныг олох боломжийг хүнд олгодог учраас тунгаан бодох чадвар нь маш чухал билээ. Хүний амьдралын бүхий л хүрээний асуудалд түүний үзүүлэх нөлөө нь харилцан адилгүй байдаг.

Тунгаан бодох чадвараа хөгжүүлээгүй, бусдын хийх мэдэгдлийн цаана нуугдаж байгаа санаа жинхэнэ үнэнийг олж харах чадваргүй хүн бусдын заль мэхэнд хууртаж, ашиглуулах магадлал өндөр байдаг. Учир дутагдалтай шалтгаан, бодитой биш нотолгоог ялгаж салган ойлгодоггүй хүн найз нөхөд, үе тэнгийнхэн болон бусдын нөлөө, ятгалгад автаж эрүүл бус, аюултай нөхцөл байдалд хялбархан орох эрсдэлтэй байдаг. Тийм хүн нь мэргэжлийн алдаа дутагдал гаргах боломж их байдаг байна.

Тунгаан бодох үйл явцыг дотор нь:

1. *Шалтгаан ба дүгнэлт*: энэ нь нотолгоог бүрдүүлэгч жижиг хэсгүүд юм. Нотолгоонд гарч буй дүгнэлт нь өгүүлэгчийн үнэн, бодит хэмээн дэвшүүлж буй мэдэгдэл, харин шалтгаан нь тэр мэдлэгийн дэмжих зорилгоор өгүүлэгчийн ашиглах санаа юм. Бүх нотолгоонд шалтгаан нь дүгнэлтээ үнэн гэдэгт бусдыг итгүүлэхэд чиглэсэн байдаг. шалтгааны бие биетэйгээ болон дүгнэлттэйгээ хэрхэн холбогдож байгаа арга замыг нотолгооны бүтэц хэмээн ойлгодог.

2. *Дүн шинжилгээ*: энэ нь ятган үнэмшүүлэх зорилготой шалтгаан болон дүгнэлт хоорондоо хэрхэн уялдаж байгааг шалгах үйл явц юм. Мөн дүн шинжилгээг нотолгооны бүтцийг тодорхойлох явц гэж хэлж болно. Холбоо үндэслэлийн хувьд шалтгаан нь тус тусдаа биш, бүгд нийлж дүгнэлтээ дэмждэг бөгөөд тэдгээр шалтгааныг салангид авч үзэж болдоггүй. Энэ үйл явц нь ихэвчлэн хэцүү, бэрхшээлтэй байдаг ч нотолгооны бүтэц янз бүр, нарийн төвөгтэй байхаас шалтгаалахаас гадна гаргасан үндэслэл тодорхой бус байх, эсвэл тэр үндэслэлээ гаргасан хүмүүс нь өөрсдөө ч сайн ойлгохгүй байх зэргээс шалтгаалдаг.

3. *Үнэлгээ*: үнэлгээг дүн шинжилгээний дараа хийдэг ба үүнд дараах үйл ажиллагаа багтана. Үүнд:

1. Шалтгааныг хүлээж авах боломжтой эсэхийг тодорхойлох;
2. Шалтгаан нь дүгнэлтээ хэр сайн "дэмжиж" байгааг тодорхойлох;
3. Гол дүгнэлт үнэн зөв эсэх талаар ерөнхий дүгнэлт гаргах.

4. *Тунгаан бодох бүдүүвч*: нотолгоонд дүн шинжилгээ, үнэлгээ хийх нэг арга нь "Тунгаан бодох бүдүүвч" юм. Энэ нь суралцагчдаар илүү сайн үндэслэл гаргуулахад чиглэсэн асуултын удирдамж юм. Эдгээр нь янз бүрийн санал бодолд дүн шинжилгээ, үнэлгээ хийх, шалтгааныг хүлээж авах боломж болон эх сурвалжийн найдвартай байдлыг шүүн тунгаах гэсэн тус тусдаа зорилготой байдаг.

5. *Нотолгооны бүдүүвч*: нотолгоонд дүн шинжилгээ, үнэлгээ хийхэд ашиглах хоёр дахь арга нь "Нотолгооны бүдүүвч байгуулах" явдал юм. Нотолгооны бүтцийг дүрслэхдээ тунгаан бодох бүдүүвчид бичгэн тэмдэглэгээг ашигладаг бол нотолгооны бүдүүвчид график дүрслэлийг ашигладаг. Нотолгооны бүдүүвчийн өөр нэг ашигтай тал нь нотолгоо дахь янз бүрийн мэдэгдлийн аль нь гол дүгнэлтийг дэмжиж, эсвэл эсэргүүцэж байгаа тодорхой харуулах, мөн аль шалтгаан нь тус болох суурь ойлголт, эсвэл төсөөлөлтэй холбоотой вэ гэдгийг харуулдаг байна.

Шүүмжит сэтгэлгээ /Critical thinking/: Аливаа зүйлийн сайн ба муугийн талаарх ойлголтыг танин мэдэх нь тухайн хувь хүн бие хүн болж буйн шинж. Болсон асуудлыг олон талаас нь нотлох баримтад тулгуурлан, олон ургач үзэл, шинжлэх ухаанчаар авч үзэх чадвар.

ХАНДЛАГА: Хандлага тухайн хүн өөртөө, бусдад нийгэмд өөрөөр хэлбэл амьтай амьгүй бүх зүйлд хандахад хүний дотоод сэтгэлээс шалтгаалан эерэг сөргөөр илэрхийлэгдэж бусдад мэдүүлж буй мэдрэмж гэж үздэг. Өөрөөр хэлбэл, хандлага нь бодол, үйлдлээр дамжин илэрдэг байна.

Хандлага судлаач Carol Dweck өөрийн амьдралын бүхий л хугацааг хандлага болоод гүйцэтгэлийн талаар судлахад зарцуулжээ. Тэрээр судалгаагаараа таны амжилтыг IQ биш хандлага тодорхойлдог гэдгийг баталсан байна. Тэрээр хүмүүсийн хандлага нь:

1. Тогтмол сэтгэлгээ (a fixed mindset)
2. Өсөлтийн сэтгэлгээ(a growth mindset)¹⁶⁹ гэж хоёр хэсэгт хувааж болно хэмээсэн байна.

Тогтмол сэтгэлгээтэй хүн бол та өөрийгөө байгаа хүн гэдэгтээ итгэдэг тул та өөрчлөгдөж чадахгүй. Таны хийж чадахаас илүү юм шиг санагдах зүйл нь найдваргүй, цөхөрсөн мэдрэмж төрүүлэх нь мэдээжийн тул энэ нь таныг сорилтод ороход асуудал үүсгэдэг.

Өсөлтийн сэтгэлгээтэй хүмүүс өөрсдийгөө хүчин чармайлтаар сайжруулж чадна гэж итгэдэг. Тэд IQ-ийн түвшин доогуур байсан ч гэсэн тогтсон сэтгэлгээтэй хүмүүсээс илүү сайн зүйл хийдэг, учир нь тэд бэрхшээлийг тэвчиж, шинэ зүйл сурах боломж гэж үздэг.

Орчин цагт олон төрлийн гадаад хэлтэй болох, гадаад улсад боловсрол эзэмших боломж бүрдэж хүн бүр л үр хүүхдээ харь оронд боловсрол эзэмшүүлэх хүсэл эрмэлзэлтэй болов. Чинхүү боловсрол эзэмшсэн зарим хүмүүс нь ёс зүйн мэдлэг дутмаг, ёс суртахууны ухамсаргүйгээс энэрэнгүй сэтгэл, хүн чанар, шударга ёсоо алдаж эд хөрөнгө, эрх мэдэл, мөнгөний төлөө юу ч хийхээс буцахгүй бологсод олшров.

ЗАН ҮЙЛ: Зан үйл гэдэг нь хүний аж амьдралтай уялдан хэвшиж тогтсон заншил, түүнтэй холбоотой элдэв үйл хөдлөл¹⁷⁰ гэж монгол хэлний их тайлбар тольд тайлбарласан байна.

Хүн төрөлхтөн үүсэж бий болсон цагаасаа байгалийн элдэв үзэгдлийг даван туулж, зохицон амьдрахын тулд аливаа зан үйлийг бий болгож түүндээ итгэсээр иржээ. Эртний хүмүүсийн үйлддэг зан үйл нь анх үг хэллэггүй, хөдөлгөөн төдий зүйл байсан бөгөөд хүний оюун ухаан, үйл хөдлөл хөгжин дэвжихийн хэрээр зан үйлийг дагалдах аман зохиол бий болсон байна. Аливаа зан үйлийн ёслол үйлдсэнээр байгалийн хүчийг тайтгаруулах, хөдөлмөрийг хөнгөвчлөх, өвчин эмгэг эдгээх, элдэв аюулыг зайлуулах, бусдад хор хүргэх зэрэг явдал биеллээ олох боломжтой, тийм чадал шингэсэн байдаг мэтээр ойлгож байв. Гэхдээ ард түмний ухамсар, танин мэдэхүй өсөж, шинжлэх ухааны мэдлэг дэлгэрэх болсноор өдөр тутмын амьдралд нь элдэв мухар сүсэг, шашин шүтлэгийн нөлөө суларч зан үйлийн аман зохиол нь үгийн шидэд итгэх хүмүүсийн гэнэн хандлага, сүсэг бишрэлийн илэрхийлэл байхаа бараг больж, харьцангуй уран сайхны зориулалттай түүх соёлын өв болж үлдэж байна¹⁷¹.

Зан үйлийн нэг судлагдахуун нь зан суртахуун билээ. Гегель хүний ёс суртахуун, зан суртахуун хоёрыг зааглан тайлбарласан байдаг. Тэрээр үзэхдээ хүний тодорхой үйлдлийн субъектив талыг ёс суртахуун, объектив талыг зан суртахуун гэж тайлбар өгсөн түүхтэй улбаатай. Үүнтэй бид санал нэгдэж байна.

Я.А.Коменский "Аливаа хүнд зан төлөвийн байдал нь ёс суртахууны үндэс мөн. Иймээс зан байдал, сэтгэл санааны талаар сайныг дуурайж биеэ авч явах нь чухал" гэж хэлжээ.

ХАРИЛЦАА:

Communication буюу харилцаа нь Латин хэлний Communicare-аас "хуваалцах" гэсэн үгнээс гаралтай¹⁷². *Харилцаа гэдэг* нь нэг хүнээс нөгөө хүнд мэдээлэл, бодол санаа, мэдрэмжийг үгэн болон үгэн бус илэрхийллээр дамжуулж, түүнийг хүлээн авагч нь ямар нэгэн байдлаар хариу үйлдэл үзүүлэх хоёр талт үйл явцыг хэлнэ. Харилцаанд хоёроос доошгүй хүн оролцоно. Хүн өөрийн бодол, санаа, хандлага эсвэл мэдрэмжийг бусадтайгаа хуваалцаж байгаа тохиолдол бүр харилцааны төрөл юм. (Зураг...)

Харилцааны чадвар гэдэг нь бусад хүнийг ойлгох, өөрийгөө бусдад ойлгуулахад хэрэгтэй чадварыг хэлнэ. Үүнд үгэн буюу ярих, сонсох үндсэн чадвараас гадна үгэн бус харилцааны чадвар болох хүний нүүрний хувирал, дууны өнгө, гарын хөдөлгөөн, дохио зангаа, үйл хөдлөл гэх мэт хүний бүхий л мэдрэмж, хандлагыг илэрхийлдэг далд утгатай, хэлсэн үгний утгаас санааг гүнзгийрүүлдэг дохио багтаадаг. Үгэн ба үгэн бус харилцааг нэгэн зэрэг ашиглаж байгаа тохиолдолд үгэн бус харилцаа нь илүү үнэн бодитой байдаг.

Харилцааны чадвар эзэмших гэдэг нь өөрийн санаа, бодол, мэдрэмжээр өөртөө итгэлтэйгээр хэзээ, хэрхэн илэрхийлэхээ мэддэг, хэрэгжүүлж чаддаг болоход суралцахыг хэлнэ. Өнөөгийн нийгэмд харилцаа улам бүр өргөжсөөр байна. Тухайлбал, гар утас, интернэт, электрон шуудан гэх зэрэг цахим харилцаа хүрээгээ тэлсээр байна. Хүмүүс хамдаа байгаа бүх тохиолдолд харилцаа үүсгэдэг учраас харилцааны чадвар нь хүний амьдралын нэгээхэн хэсэг болно. Энэ нь тухайн хүний гэр бүлийнхэн, найз нөхөд, хамт ажиллагсадтайгаа тогтоосон харилцаа холбоонд шууд нөлөөлдөг.

¹⁶⁹ Travis Bradberry, Why Attitude Is More Important Than IQ. Article. Talent smart. 2015. P.2.

¹⁷⁰ Монгол хэлний их тайлбар толь. МУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газар. <https://mongoltoli.mn/>

¹⁷¹ Л.Навчаа. Зан үйл. Монгол утга соёл цуврал: IX боть.

¹⁷² Harper, Douglas. "communication". Online Etymology Dictionary. Retrieved 2021.

Харилцаа нь өдөр тутам тасралтгүй явагддаг учраас түүнийг хүмүүс ихэвчлэн онцгойлон анхаарч үздэггүй бөгөөд харилцааны муу зуршлаа засаж залруулах нь зарим хүнд хэцүү байдаг байна. Ихэнх хүмүүс бусадтай харилцахдаа гаргадаг дутагдлаа олж харж чаддаггүй ба харилцаандаа учирч буй бэрхшээл, хүндрэлийг гэр бүлийнхэн, найз нөхөд, хамт ажилладаг хүмүүстэй холбон, тэднийг буруутгаж үл ойлголцол үүсдэг байна.

Харилцааны чадвараа хөгжүүлж чадвал үл ойлголцол, ганцаардалд орохгүйгээр, сэтгэл хангалуун, аз жаргалтай амьдарна гэж үздэг билээ. Энэ чадварыг л эзэмшиж байж гэр бүл, найз нөхөд, хамаатан садан, ажлын хамт олонтойгоо нийцтэй амьдарна. Хүний сэтгэл санааны байдлаас хамаарч ажлын бүтээмж дээшилдэг.



Харилцааг дотор нь:

1. Лавлаж нягтлах: харилцаанд мэдээллийг дамжуулах (илгээх) болон хүлээн авах үйл явц багтана. Мэдээлэл илгээгчийн хэлж буй санааг хүлээн авч байгаа хүн нь зөв ойлгосон тохиолдолд хүмүүс харилцан ойлголцож чаддаг. Өөрөөр хэлбэл, мэдээллийг хүлээн авагч нь илгээж байгаа хүнээс хэлсэн зүйл нь ямар утгатай болохыг лавлаж нягтлах үйл явц юм.

2. *Үгийн бус харилцаа*: энэ нь тодорхой утга санааг илэрхийлэхийн тулд ашигладаг биеийн хөдөлгөөн, харц, дуу хоолой, дохио, зангаа, үйлдлийг хэлнэ. Үгийн бус харилцааны үед мэдээллийн утга санаа тухайн нөхцөлөөс шалтгаалаад өөр өөр байдаг. үүнийг ихэнх дээ санамсаргүй, өөрийн эрхгүй хийгддэг учраас мэдээлэл дамжуулагчийн жинхэнээсээ бодож байгаа, юм уу мэдэрч байгаа зүйлийн тухай ойлголт өгдөг.

3. Идэвхгүй буюу өөртөө итгэлгүй харилцаа: энэ нь бусадтай харилцаж байгаа хүн өөрийн мэдрэмжийг шууд, тодорхой илэрхийлэхгүй байх харилцааны нэгэн хэлбэр юм. Идэвхгүй харилцагчид нь ихэнх тохиолдолд өөрийн хэрэгцээ, хүсэл зорилгыг хамгаалж чаддаггүй ба тэд өөртөө итгэлгүй, харилцааны чадвар дутмаг байдаг.

4. *Түрэмгийн харилцаа*: энэ нь хүмүүс бусад дарамт шахалт үзүүлэлгүйгээр, бусдыг гутаан доромжлолгүйгээр өөрийн хэрэгцээ, хүсэлээ илэрхийлэх итгэл, чадваргүй байдаг. өөрөөр хэлбэл, түрэмгий харилцагчид нь өөрийн хүсэж байгаа зүйлээ бусад хүнээр хийлгэхийн тулд дарамт шахалт үзүүлэх, айлган сүрдүүлэх, эсвэл хүч хэрэглэх зэрэг аргыг ашиглах хандлагатай байдаг.

5. *Өөртөө итгэлтэй харилцаа*: энэ нь идэвхгүй болон түрэмгүй харилцааны хооронд орших харилцааны эрүүл зөв, хэлбэр юм. Өөртөө итгэлтэй харилцаа нь хүний хүсэл сонирхлыг хүндэтгэн харилцахын зэрэгцээ тухай хүн өөрийн бодол санааг маш тодорхой бөгөөд шууд илэрхийлэх харилцааны хэлбэр юм.

6. *Ятгалаг*: энэ нь хүнээр ямар нэгэн зүйл хийлгэх, эсвэл бодуулах зорилготой хийгдэж байгаа харилцаа юм. Зохио ёсоор, болгоомжтой байдлаар ашигласан тохиолдолд ятгалаг нь хүнд хэрэгтэй, тодорхой үр өгөөжтэй байдаг. итгэлтэй харилцах, эсвэл өөрийгөө хамгаалах оролдлого олонх тохиолдолд эсэргүүцэл, ятгалгатай тулгарна.

7. *Бусдыг ойлгох харилцаа*: энэ нь бусадтай зөвхөн оюун бодлоороо ярилцаж, сонсож харилцах бус харин зүрх сэтгэлээсээ харилцахыг хэлнэ.

Мэргэжлийн ёс зүй: Ёс зүй нь судлах зүйлээ онолын хийгээд практик талаас нь авч үзэж, шийдвэрлэж байдаг. Үүний учир шалтгаан нь ёс суртахууны шинжтэй асуудал хүний амьдралын бүхий л салбарт үүсэн бий болж байдагт оршдог. Ёс зүй нь нийгэм-хүмүүнлэгийн аль ч ухаанаас илүүтэйгээр нийгмийн амьдрал, хүний үйлдэл, үйл ажиллагаа, харилцаатай нягт холбогддог онцлогтой. Мэргэжлийн ёс зүйн талаар судалсан эрдэмтэн, доктор, гүн ухаантнуудаас дурдвал Аристотель¹⁷³, Ж.Бентам¹⁷⁴, Т.Гоббс, З.Китийский¹⁷⁵, Ж.Локк¹⁷⁶, Ж.Руссо¹⁷⁷, Ф.Ницше¹⁷⁸ гэх зэрэг төлөөллүүд байна.

АНУ-ын ёс зүй судлаач J.Svara “Ёс зүй нь үүрэг, зарчим, тодорхой зан чанар, нийгэмд ашиг тустай байх хүрээнд хүний юуг хийх ёстойг заадаг зөв болон бурууг ялгах хэм хэмжээ” гэж тодорхойлжээ. Тэрээр ёс зүйн эх сурвалжийн дөрвөн элементийг багтаасан бөгөөд нэг нь нийтийн албаны мөн чанартай холбоотой, гурав нь философийн агуулгатай. Үүнд:

1. Үүрэг (duty): хүний эрхэлж буй ажил мэргэжил, албан тушаалтай холбогдон гарч ирэх ногдсон үүрэг хариуцлага, зан чанарын цогц;

2. Зан байдал, сайн чанар (virtue): “сайн хүн”-ийг тодорхойлох чанарууд;

3. Зарчим (principles): зан чанарын үндэс суурийг тодорхойлдог үнэн буюу зөв болон биелүүлэх ёстой үйлдлүүд;

4. Нийгэмд ашиг тустай байх (benefits to society): хамгийн олон хүнд хамгийн их сайныг авчрах үйлдэл гэж үзсэн байдаг¹⁷⁹.

Мэргэжлийн ёс зүй нь нийгмийн хөгжлийг тодорхойлогч үндсэн хүчин зүйлд хүний хөгжлийн асуудал гол байр суурийг эзэлдэг. Хүний хөгжилд мэдлэг, боловсрол голлох үүрэгтэй боловч хувь хүний ёс суртахууны ухамсар, төлөвшил чухал тул мэргэжлийн үйл ажиллагаанд ёс зүйн асуудал үргэлж нэн тэргүүнд тооцогдсоор ирсэн. Түүнчлэн мэргэжлийн ёс зүйн салбар бүр нийгмийн институтад зайлшгүй хэрэгжүүлэх өөрийн ёс суртахууны зарчим, хэм хэмжээтэй.

Ихэвчлэн мэргэжлийн ёс зүйг өөрийн сонгосон мэргэжил, хариуцсан ажилдаа үнэнч байх, ажил үүргээ чанартай гүйцэтгэх, хувийн эрх ашгийг огоорох, мэргэжлийнхээ нэр хүндийг хамгаалах, нийгмийн хариуцлагаа ухамсарлах, үүргээ чанд биелүүлэх журмын тогтолцоо гэж үздэг. АНУ-ын эрдэмтэн Dean Geuras, Charles Garofalo нар мэргэжлийн ёс зүй хувийн ёс зүйгээс ялгаатай юу гэсэн асуултад “ёс зүй нь мэргэжлээс ангид оршдог ч мэргэжил нь ёс зүйгүйгээр оршдоггүй” хэмээн хариулсан байдаг¹⁸⁰.

Мэргэжлийн ёс зүй нь төрийн албан хаагчийн, багшийн, сэтгүүлчийн, эмнэлгийн ажилтны, цагдаагийн, цэргийн, инженерийн, бизнесийн, мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн гэх мэт мэргэжлийн онцлогоос хамаарсан олон төрөлтэй байдаг. Мэргэжил бүхэн өөр өөрийн онцлогтой бөгөөд ёс суртахууны нийтлэг зарчим, хэм хэмжээ тухайн мэргэжлийн хүмүүсийн хөдөлмөрийн явцад янз бүрээр хэрэгждэг. Ч.Баярчимэг, Д.Оюунгэрэл нар “Мэргэжлийн ёс суртахууны боловсролын ач холбогдол” илтгэлдээ “Нийгэм хөгжихийн хэрээр мэргэжилтэнд тавигдах ёс суртахууны шаардлага нэмэгдэж байна. Өнөөгийн монголын нийгэмд өндөр мэдлэг, ур чадвар бүхий иргэн шаардлагатай байгаагийн зэрэгцээ, үүрэг хариуцлагаа ухамсарласан, ёс суртахуунтай мэргэжилтэн түүнээс дутуугүй чухал юм¹⁸¹” гэжээ.

Мэргэжлийн ёс суртахууны үндсэн ойлголтод мэргэжлийн үүрэг, мэргэжлийн хариуцлага, мэргэжлийн нэр хүнд, мэргэжлийн үнэ цэнэ багтдаг.

Мэргэжлийн үүрэг: Мэргэжлийн ёс зүйн уг сурвалж, суурь ойлголт болох үүрэг нь зан байдлын дүрэм, үйл ажиллагааны сэдэл чиглүүлэгч болдог. Албан үүргээ ухамсарлах нь ажил хэрэгтээ хариуцлагатай хандах, бие хүн болон нийгмийн харилцаа холбоонд чухал ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, үүрэг нь хувь хүнээс бусдын, нийгмийн болон өөрийнхөө өмнө хүлээх хариуцлагын ухамсрыг багтаасан ойлголт. Мэргэжилтэн албан үүргээ сайн биелүүлж,

¹⁷³ Зубов В. П. Аристотель: Человек. Наука. Судьба наследия. («Научно-биографическая серия»). — М.: Изд-во АН. 1963. — 368 стр

¹⁷⁴ Бентам Иеремия // Бари — Браслет. — М. : Советская энциклопедия, 1970. — (Большая советская энциклопедия : [в 30 т.]

¹⁷⁵ Зенон из Кития / А. А. Столяров // Новая философская энциклопедия : в 4 т. / пред. науч.-ред. совета В. С. Стёпин. — 2-е изд., испр. и доп. — М. : Мысль, 2010. — 2816 с.

¹⁷⁶ Локк / А. Л. Субботин // Новая философская энциклопедия : в 4 т. / пред. науч.-ред. совета В. С. Стёпин. — 2-е изд., испр. и доп. — М. : Мысль, 2010. — 2816 с.

¹⁷⁷ Букер И. Свобода и фантазии Жан-Жака Руссо. // Правда.ру, 28.06.2012.

¹⁷⁸ Dr. Large. "Nietzsche and Moral Nihilism". www.arasite.org. Retrieved 2019.

¹⁷⁹ James Svara "The Ethics primer for Public administrators in government and nonprofit organizations" Jones and Bartlett Learning LLC, 2015, p.12.

¹⁸⁰ Д.Тунгалаг "Ёс зүйн зангилаа асуудлууд", УБ., 2015. 57-61 дахь тал.

¹⁸¹ Ч.Баярчимэг, Д.Оюунгэрэл. Мэргэжлийн ёс суртахууны боловсролын ач холбогдол-Монгол дахь ёс суртахууны боловсролын тулгамдсан асуудал. УБ., 2015. 28 дахь тал.

үр дүнтэй ажиллах нь ёс суртахуунтай байдлын нэгэн илрэл болно. Германы нэрт философич Иммануэл Кант “Үүрэг бол хуулийг хүндэтгэснээр үйлдэх зайлшгүй мөн чанар бөгөөд албадлагаар бус сайн дураараа гүйцэтгэх ёстой” гэж үзсэн.

Мэргэжлийн хариуцлага: Өөрийн болон бусдын өмнө хүлээсэн ёс суртахуун, сахилга, дэг журмын тухай ойлголт. Харин нийгмийн хариуцлага нь иргэд болон байгууллага үйл ажиллагаа, эрх мэдэл, ажлын үр дүнгийнхээ төлөө хамт олон, ард түмэн, улс орны өмнө тодорхой үүрэг хүлээж, хариуцлага үүрэх чадвар юм. Хариуцлагатай байх нь оногдсон үүргээ хангалттай түвшинд биелүүлдэг байх, эрх зүйн хэм хэмжээг мөрдөх, ёс суртахууны үнэт зүйлийг ухамсарлахтай холбоотой ойлголт билээ.

Мэргэжлийн нэр хүнд: Нэр төр, нэр хүнд гэх ойлголтууд нь хоорондоо ялгаатай ч харилцан бие биеэ нөхдөг. Нэр төрөө хамгаалах нь тухайн хүнээс их хариуцлагатай байхыг шаарддаг. Бусдын өмнө хүлээсэн итгэл найдвар, хариуцлагаа ухамсарлаж, үүргээ сайтар биелүүлснээр нэр төр бий болох ба тухайн мэргэжилтний үйл ажиллагаа, үйлдэлд бусад субъектээс ёс суртахууны үнэлэлт, дүгнэлт өгч байгаагийн илэрхийлэл хэмээн тодорхойлж болно. Харин мэргэжлийн нэр хүнд нь тухайн мэргэжлийг төлөөлж буй хүмүүсийн үйл ажиллагаа, ёс суртахууны соёлд нийгмээс өгч байгаа үнэлгээ юм. Мэргэжилтэн иргэний болон албаны эрх үүрэг, нийгмийн үнэлэмжээ ухамсарласны үр дүнд мэргэжлийн нэр хүндээ сахин хамгаалж чаддаг. Эрхэлж буй албан тушаалын хариуцлага, нөлөө өндөр байх тусам оюун ухааны болон зан суртахуун, бусдыг ойлгох, сэтгэл хөдлөлийг удирдах чадварыг эзэмшсэн байх шаардлагатай тулгарч байдаг билээ.

Мэргэжлийн үнэ цэнэ: Тухайн хүн хийж буй ажил мэргэжилдээ үнэнч, хайртай, дуртай, өөрийн болон байгууллагын үнэ цэнийг тодорхойлж, зөвөөр ухамсарласан үйлдэл нь үр дүнд хүрч, үнэн цэнийг бүтээж байдаг. Мэргэжилтэн төдийгүй нийгэм бүхэлдээ ёс суртахууны үүднээс хүлээн зөвшөөрч байгааг илэрхийлдэг ойлголт. Мэргэжлийн үнэ цэнэ нь мэргэжил, мэргэжилтэнд нийгмээс өгөх үнэлгээ, мэргэжилтний өөрийнх нь үнэлэмж юм. Мэргэжилтэн нь тухайн мэргэжлийнхээ үнэ цэнийг дотоод оюун ухаандаа ойлгох нь үүргээ биелүүлэх, хариуцлагаа ухамсарлахтай холбогдоно. Нөгөө талаас мэргэжлийн үнэ цэнийг мэдрэхэд нийгэм, хүрээллийн нөлөө, үйл ажиллагааны үр дагавар, өөрийн идэвх, санаачилга зэрэг гадаад, дотоод олон хүчин зүйлтэй холбогдож байна. Мэргэжлийн давтагдашгүй чанар, үнэт чанарыг ойлгох нь үнэ цэнийг бий болгодог билээ.

Цөөн тооны ёс суртахуунгүй, шударга бус төрийн албан хаагчийн буруутай үйлдэл нь нийт төрийн албан хаагчдын нэр хүндэд сөргөөр нөлөөлж, шударга үйлдлийг харлуулдаг билээ. Тэдний мэргэжлийн ёс зүйгээ алдаж зүй бус харьцсан, ёс суртахуунгүй, харилцааны соёлгүй, ёс бус харьцах, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэх явдал үргэлжилсээр байна.

Мэргэжилтэн бүхэн сургуулиа төгсөөд нийгэм, хамт олны дунд амьдардаг. Тэд хүмүүсийн дунд амьдарч, ажиллаж, бүтээж, буй хөдөлмөр нь өөрийнхөө төдийгүй бусад хүн, нийгмийн сайн сайхан бүхний төлөө байх ёстойг ухаарч, өөрийн мэргэжил, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхийн учир утга, ач тусыг мэргэжлийн ёс зүйн боловсролоос авч байх ёстой байдаг.

Тэгвэл ёс зүйн боловсрол олгохдоо тодорхой бүлэг, мэргэжил гэхээс илүүтэйгээр бүх нийтийн ёс зүйн боловсрол олгох улсын бодлого, хөтөлбөр дутагдалтай байна. Бидний ирээдүй хойч үе болсон хүүхдүүдэд бага балчир наснаас нь ёс суртахууныг суулгах тусгайлсан хөтөлбөр боловсруулах нь ихээхэн үр дүнтэй болох буйзаа. Мэдээж гэр бүлийн эцэг, эхийн, үлгэрлэл, дуурайлал энд маш чухал билээ.

Мэргэжлийн ёс зүйн сургалт:

Мэргэжлийн ёс зүйн сургалт, судалгаа бол олон салбар ухааны уулзвар дээр хийдэг, судлаачаас өргөн хүрээний мэдлэг, мэдээлэл шаарддаг онцлогтой.

Ёс зүй судлаач Д.Тунгалаг “Төгсөж гарсан мэргэжилтэн нийгэмд хэр зэрэг үр бүтээлтэй ажиллах нь түүний ёс суртахууны ухамсар, төлөвлөсөөс багагүй шалтгаалдаг. Чадвартай мэргэжилтэн олон боловч ёс суртахууны доголдлын улмаас ажилдаа алдаа гаргаж, улмаар ажлын үр дүн нь сөргөөр нөлөөлж, тэр нь хамт олон, ард түмэн, нийгмийг ч хохироодог тохиолдол ихээр үзэгдэх боллоо. Үүний тулд мэргэжилтэн бүрд ёс зүйн боловсрол хэрэгтэй. Утга мэдлэгийг суурь нь ёс суртахууны мэдлэг, хүний хөгжлийн суурь нь ёс суртахууны төлөвшил байх учиртай”¹⁸²

Мэргэжлийн ёс суртахуун төлөвшихөд “мэргэжлийн ёс зүй” хичээлийн нөлөө чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд энэ тал дээр гадаадын их, дээд сургуулиуд сүүлийн үед анхаарал тавьж байна. Их дээд сургуульд суралцах нь тухайн мэргэжлийн боловсрол олгож, хүмүүжих

¹⁸² Д.Тунгалаг. Монгол дахь ёс зүйн сургалт, судалгааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал. УБ., 2014. 6 дахь тал.

эхний хариуцлагатай үе шат юм. Энэ шатанд нийгмийн амьдралд тухайн мэргэжлийн эзлэх байр суурь, нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагын талаарх анхны төсөөлөл, ойлголтуудыг бүрэлдүүлэн өгдөг билээ. Тийм учраас их, дээд сургуулийн нэгдүгээр түвшнөөс эхлэн оюутнуудад ёс зүйн мэдлэг,

Мэргэжлийн ёс зүйн сургалт нь мэргэжлийн үйл ажиллагааны өвөрмөц онцлог, шинэ төрлийн мэргэжил бий болж байгаатайгаар холбогдуулж үүсэн бий болжээ. Мэргэжлийн ёс зүйн сургалт нь:

- Шинжлэх ухааны үүднээс онолын түвшинд судлах;
- Олон улсын түвшинд;
- Судалгаа, шинжилгээ, үнэлгээ нь дээр тулгуурлах;
- Асуудалд суурилан судлах;
- Тухайн мэргэжлийн практик дээр гарч буй алдаа дутагдал /кейс/ дээр үндэслэн алдаанаас суралцах. Гэсэн агуулгатай байвал сургалтын үр дүнд нөлөөлж, мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж чадна.

Шилжилтийн нийгэмд тулгамдсан асуудал олон байдаг ч ёс суртахуунаар эрүүл байх, түүний доройтлоос ангихрах талаар дорвитой үйл ажиллагаа маш их дутагдаж байна¹⁸³.

Нийгэм хөгжихийн хэрээр мэргэжилтэнд тавигдах мэргэжлийн ёс суртахууны шаардлага нэмэгдэж байна. Өнөөгийн монголын нийгэмд өндөр мэдлэг, ур чадвар бүхий иргэн шаардлагатай байгаагийн зэрэгцээ, үүрэг хариуцлагаа ухамсарласан, ёс суртахуунтай мэргэжилтэн түүнээс дутуугүй чухал юм. Мэргэжлийн ёс зүйг хөгжүүлэх нь ажил мэргэжлийн нэр хүнд, үнэ цэн, ёс суртахууны үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн хөгжлийг хангахад ихээхэн ач холбогдолтой.

С.Наранчимэг докторын гаргасан энэхүү гурвалжин дээр нэмэх нэг санаа бол "Мэдээлэл" юм. Мэдээлэл гэдэг нь Латин хэлний "informatiō" аливаа зүйлийн талаар тодруулга, танилцуулга, тайлбар, ойлголт" гэсэн утгатай үг ба "informare" хэлбэр, хэлбэр, заах; бодох, төсөөлөх гэсэн утгыг илэрхийлдэг байна¹⁸⁴.

Мэдээлэл нь өгөгдөл болон мэдлэгтэй холбогддог. Өгөгдөл нь параметрт ашиглагдсан үнэлэлтийг илэрхийлдэг бол мэдлэг нь бодит зүйл болон хийсвэр зүйлсийг илэрхийлдэг. Хамгийн чухал нь мэдээлэл бол системд учирч буй шалтгаан болон нөлөөллийн тархалт юм. Мэдээлэл нь бүх зүйлийн шууд болон шууд бус ажиглалтаар эсвэл мэдээллийн контент болж илэрдэг. Ингэж ойлгогдсон нь өөрийн зөвийн дагуу мэдээгээр байгуулагдаж болох ба эндээс хараад үзвэл мэдээлэл нь үргэлж мэдээний контент болж илэрдэг. Мэдээлэл нь дамжуулалт болон тайлбар зэрэг олон төрлийн хэлбэрт шифрлэгддэг (жишээлбэл, мэдээлэл нь тэмдгийн дараалалд шифрлэгдэж эсвэл дохионы дарааллаар дамжуулагддаг)¹⁸⁵.

Эрдэмтэд "Мэдээлэл" гэдэг бол юун ухаан, сэтгэлгээний хоол гэж үзсэн байдаг. Сэтгэлгээ зэрэг эсвэл сөрөг байх эсэх нь тухайн хүмүүсийн эхийнхээ хэвлийд байхаас эхлээд өнөөг хүртэл авсан мэдээллийн чанараас хамаардаг. Өөрөөр хэлбэл эргэн тойронд чинь сөрөг мэдээлэл, сөрөг хандлагатай хүмүүс байх тусам сөрөг мэдээллээр алсуур идэх болно. Бид аав ээжээ, найз нөхөд, эргэн тойрны хүмүүсээсээ 50% сөрөг мэдээлэл авдаг ба дунджаар амьдралаас сонсож, мэдэж авч байгаа мэдээ мэдээллийн 70% нь сөрөг байх нь. Бие махбодыг хоол тэжээлдэг бол оюун ухаан сэтгэлгээг тань мэдээлэл тэжээдэг байх нь.

Өөрт байгаа нөөц боломжоо ашиглаж өөрийгөө зэрэг мэдээллээр хүрээлүүлэх нь аливаа амжилтын ул суурь болно. Орчин цагийн хүмүүс мэдээллээр зэвсэг хийж, олж авсан мэдээллээ маш хурдан боловсруулж үйл хийж тодорхой үр дүнд хүрэх нь чухал билээ.

Өнөөдрийн нийгэмд мэдээллийн жигд бус боломжоос шалтгаалан хүүхдүүдийн сурах боломж тэгш бус эхэлж байна. Хөдөө орон нутагт интернэт, техник, технологи, багшийн ур чадвар, сурах орчин хот суурийн газраас ялгаатай байгаа нь бүхний суурь болсон мэдлэг олж авах боломжид нөлөөлж байна.

Улмаар ёс зүйн шинжлэх ухааны нэг зорилго нь аливаа мэргэжлийг соёл тус бүрийн параметр эсвэл нийгмийн хэм хэмжээний дагуу сайн сайхны замд хөтлөх явдал юм. Ёс суртахууны тэгш байдал гэдэг нь бусадтай болон өөртэйгөө зэрэгцэн оршихуйг хөнгөвчлөх ухамсартай, уялдаа холбоотой амьдрах, үйлдэх арга хэлбэрийг хэлнэ. Мэргэжлийн ёс зүй бол мэргэжил тус бүрийн зорилго, зарчмуудын тусгал юм.

Мэргэжлийн салбар дахь ёс суртахууны тэгш байдал нь хариуцлага, цаг баримталдаг байдал, хүндэтгэл гэх мэт хэд хэдэн үнэт зүйл буюу үүргээ биелүүлэхийг хэлдэг.

¹⁸³ Р.Дарьхүү. Ёс зүйн асуудлууд. УБ., 2016. 286 дахь тал.

¹⁸⁴ Коголовский М. Р. и др. Глоссарий по информационному обществу / Под общ. ред. Ю. Е. Хохлова. — М.: Институт развития информационного общества, 2009. — 160 с.

¹⁸⁵ "Information - Definition of Information by Merriam-Webster". Merriam-webster.com. Retrieved 1 May 2017.

Эдгээр элементүүд нь бүх нийтийн үнэт зүйл боловч мэргэжил тус бүрд тодорхой үүрэг шаардагдаж магадгүй юм.

Хандлага нь боловсролоос илүү: Зах зээлийн нийгмийн давуу талыг тооцоод барахгүй боловч амин хувиа хичээх, бэртэгчин үзэл газар авч байна. Би л болсон бол болоо гэх үзэл. Энэ бүхэнд ёс зүйн шинжлэх ухааныг судлах хэрэгцээ, шаардлага тавигдаж байна. Бие мах бодь, оюун санаа, сэтгэлийн хувьд хүн хөгжиж байж хүн шиг хүн болно.

Сэтгэлийн хувьд хүн болно гэдэг нь өөрийгөө таньж, өөртэйгөө харьцаж, өөрийгөө шүүж, алдаагаа ухамсарлаж, түүнийг засаж, зөв дадал зуршлыг өөртөө бий болгож, төлөвшүүлж, ашиглаж, хэрэглэж чадаж байж сэтгэлийн хүн боллоо гэж үздэг. Өөрийн хүчин чармайлтаар хүссэн бүхэндээ хүрэх замыг хэлж байна.

Орчин үед ёс суртахуун, ёс зүй, түүний хэм хэмжээ, хандлагын нийгмийн харилцаанд гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэж, техник технологийн хөгжлөөс илүүтэйгээр хувь хүний хөгжил, "Emotional Intelligence" (EQ) буюу сэтгэл хөдлөлийн чадвар ухааныг хойч үедээ сурган өвлүүлэхийг хичээх болсон ба зарим улс орнуудын эрх зүйн онолд хууль, эрх зүйн хэтийн төлөв нь нийгмийн харилцааг дан ганц хуулиар зохицуулахаас гадна, ёс зүйн хэм хэмжээгээр хослуулан зохицуулах хандлага руу чиглэгдэх болжээ.

Дэлхийд улс гүрнүүд ёс зүй, амьдралд хандах хандлагын талаар мэдээлэл судалгааны төв, шилдэг их дээд сургуулиуд сургалтын хөтөлбөр боловсруулж, дээрх асуудалд онцгой анхаарч байна. Манай орны хувьд, гадаадад боловсрол эзэмшсэн судлаач, эрдэмтэд ёс суртахуун, ёс зүй, хандлагын чиглэлээр сургалт явуулж, мэдлэгийг түгээх, дэлхийн жишигт хүргэх талаар чармайн ажиллах болжээ.

Дүгнэлт

Бид дээрх өгүүлснийг нэгтгэн дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

- Мэргэжлийн ёс зүй бол мэргэжлийн үйл ажиллагааны ёс суртахууны зарчим, хэм хэмжээний тогтолцоог судалдаг ёс зүйн нэг салбар билээ;
- Мэргэжилтэн бүр өөрсдийнхөө үйлдлийг ёс суртахууны шаардлагад нийцүүлж байх, тэрчлэн мэргэжлийн ёс суртахууны зөрчлийг илрүүлж, ёс суртахууны хувьд муу үйлдэлд хориг саад тавих зэрэг ёс суртахууны зарчим, хэм хэмжээг танин мэдэх шаардлага тавигдаж байна;
- Мэргэжлийн ёс зүйн пирамид нь мэдлэг, бодол эргэцүүлэл, хандлага, зан үйл, харилцаагаар дамжиж илэрдэг. Бид эдгээр суурь ойлголтууд дээр нэмж "мэдээлэл" гэх ойлголтыг нэмж авч үзсэн. Техник, технологийн хурдацтай хөгжлийн энэ үед мэдээллийн ач тус бүхнээс чухал билээ. Үнэн зөв, мэдээллийг авч түүнийгээ боловсруулж, шинжлэх ухаанчаар түүнд хандаж, үйлдэл болгон үр дүнд хүрнэ;
- Бидний өнөөгийн нийгэмд ёс зүйн шинжлэх ухааныг бүх нийтээр сайтар судалж, бага балчир наснаас нь хүүхдүүдийн боловсрол анхаарах асуудлыг төр, нийгмийн хүрээнд авч үзэж, шинжлэх ухаанчаар хандах нь юунаас ч илүү чухал байна;
- Мэргэжил бүр өөрийн гэсэн онцлогтой тул түүнд тохирсон мэргэжлийн ёс суртахууны сургалтын модуль гаргаж, ёс суртахууны боловсролыг нэмэгдүүлснээр хувь хүн, албан тушаалтан, улс орны хөгжилд тодорхой дэвшил гарна хэмээн үзэж байна;
- Хандлага бол боловсролоос илүү. Өөрөө хэлбэл, боловсролтой байлаа гээд амжилтанд хүрч, ёс суртахуунтай байна гэсэн үг биш гэдгийг бид амьдрал дээр харлаа. Харин аливаа зүйлд хандаж буй хүний хандлага нь түүнээс илүү гэдгийг дэлхий нийт хүлээн зөвшөөрөх боллоо.

Ном зүй

Ном, сурах бичиг, гарын авлага:

- Ц.Гомбосүрэн. Ёс зүй. Уб. 2008
- С.Нарантуяа. Хүн хэдийн ухаантай ч. Уб., 2010
- Л.Навчаа. Зан үйл. Монгол утга соёл цуврал: IX боть.
- Д.Тунгалаг. Монгол дахь ёс зүйн сургалт, судалгааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал. Уб., 2014
- Д.Тунгалаг "Ёс зүйн зангилаа асуудлууд", Уб., 2015.
- Ч.Баярчимэг, Д.Оюунгэрэл. Мэргэжлийн ёс суртахууны боловсролын ач холбогдол-Монгол дахь ёс суртахууны боловсролын тулгамдсан асуудал. Уб., 2015
- Р.Дарьхүү. Ёс зүйн асуудлууд. Уб., 2016

Гадаад эх сурвалж:

- Прохоров А.М. (гл.ред.) Большой энциклопедический словарь. М.1993

- Girard, John P.; Girard, JoAnn L. "Defining knowledge management: Toward an applied compendium" (PDF). Online Journal of Applied Knowledge Management. 2015
- Travis Bradberry, Why Attitude Is More Important Than IQ. Article. Talent smart. 2015
- Bloom, Benjamin S. Taxonomy of Educational Objectives. 1956
- Harper, Douglas. "communication". Online Etymology Dictionary. Retrieved 2021.
- Зубов В. П. Аристотель: Человек. Наука. Судьба наследия. («Научно-биографическая серия»). — М.: Изд-во АН. 1963
- Бентам Иеремия // Бари - Браслет. - М. : Советская энциклопедия, 1970.
- Зенон из Кития / А. А. Столяров // Новая философская энциклопедия : в 4 т. / пред. науч.-ред. совета В. С. Стёпин. — 2-е изд., испр. и доп. — М. : Мысль, 2010
- Локк /А. Л. Субботин// Новая философская энциклопедия : в 4 т. / пред. науч.-ред. совета В. С. Стёпин. 2-е изд., испр. и доп. — М. : Мысль, 2010.
- Букер И. Свобода и фантазии Жан-Жака Руссо. // Правда.ру, 28.06.2012.
- Dr. Large. "Nietzsche and Moral Nihilism". www.arasite.org. Retrieved 2019.
- James Svara "The Ethics primer for Public administrators in government and nonprofit organizations" Jones and Bartlett Learning LLC, 2015,
- Когаловский М. Р. и др. Глоссарий по информационному обществу / Под общ. ред. Ю. Е. Хохлова. — М.: Институт развития информационного общества, 2009
- "Information - Definition of Information by Merriam-Webster". Merriam-webster.com. Retrieved 1 May 2017.

Цахим эх сурвалж:

- <https://ru.unesco.org>
- <https://www.uky.edu>

ХУУЛЬ ЗҮЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН ЗАРИМ ХӨТӨЛБӨРТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

*Н.Мөнхзул
Доктор, дэд профессор*

Үндсэн хэсэг

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй...” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын иргэний Үндсэн хуулиар баталгаажсан дээр дурдсан эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх, төрөөс иргэнийхээ өмнө хариуцсан үүргийг биелүүлэх зорилгоор сүүлийн жилүүдэд олон хууль тогтоомж батлагдан гарч, хүчин төгөлдөр үйлчилж байна. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль нь хуульчдын үйл ажиллагааны хариуцлага, ил тод байдлыг нэмэгдүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаанд нэгдсэн шаардлага, стандарт, хариуцлагын тогтолцоог бий болгох, уг арга замаар тэдгээрийн мэдлэг, ур чадвар, ёс зүйг нэмэгдүүлэн хуульчдын нэр хүнд, олон нийтийн итгэл, хүндлэлийг олж авах, хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын зохистой бүтцийг бий болгох зорилгоор батлагдан, хэрэгжиж байна.

Хуулиар хуульчийн үргэлжилсэн сургалтыг зохион байгуулах бүтцийг бий болгож, хуульчдад хуульчийн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, тодорхой багц цаг хангах үүргийг хүлээлгэсэн.

Сургалтын хороо нь хуульчдад зориулсан сургалтын бодлого, үндсэн чиглэл, хэлбэрийг тодорхойлж, хуульчийн үргэлжилсэн сургалтад зориулан боловсруулсан сургалтын хөтөлбөрийг хянаж хэлэлцэх, сургалт явуулах багш нарын талаар санал өгөх, сургалтын явц үр дүнгийн талаар дүгнэлт гаргах, үргэлжилсэн сургалтын багц цагийг тооцох аргачлал, журмыг боловсруулж Зөвлөлөөр батлуулах, хуульчийн үргэлжилсэн сургалтын чанар, хүртээмж, заавал мэдвэл зохих агуулгад суурилсан сургалтын тогтолцоог бүрдүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Энэ чиг үүргийн хүрээнд Азийн сангийн дэмжлэгтэйгээр сургалтын хөтөлбөрийг үнэлэх ажлыг зохион байгуулж цаашид хуульчийн үргэлжилсэн сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд анхаарах асуудлыг тодруулан гаргаж ирэхийг зорьсон.

Судалгааны хүрээнд Монголын Хуульчдын холбооны Сургалтын хорооноос 2017 онд магадлан итгэмжлэгдсэн 1, 2018 онд магадлан итгэмжлэгдсэн 7, 2019 онд магадлан итгэмжлэгдсэн 3, нийт 11 сургалтын хөтөлбөрт шинжилгээ хийлээ. Дүн шинжилгээ хийхдээ “Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журам”-ын¹⁸⁶ зохицуулалтыг шалгуур болголоо.

1. Сургалтын нэгдсэн хөтөлбөрийн агуулгаар авч үзвэл:

1.1. Мэргэжлийн суурь сургалтад (Үндсэн хуулийн эрх зүй, Хүний эрх, Хуульчийн ёс зүйн чиглэлийнх байна) хамаарах “Хүний эрх ба хорих байгууллага”, “Шүтэх, эс шүтэх эрх чөлөө”, “ХДХВ, ДОХ ба хүний эрх” гэсэн хөтөлбөр байна.

¹⁸⁶ Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн хурлын 27 дугаар тогтоолын хавсралт

1.2. Мэргэшүүлэх сургалтад (Үүнд: Эрүү, Иргэн, Захиргаа зэрэг салбар эрх зүй болон Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд шаардлагатай бусад салбар шинжлэх ухааны чиглэлийнх байна) хамаарах дараах хөтөлбөрүүд байна.

1.2.1. Захиргааны эрх зүйн чиглэлээр “Захиргааны үйл ажиллагааны зарчим”

1.2.2. Татварын эрх зүйн чиглэлээр “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн уялдаа”, “Татварын хуулийн хэрэглээ болон татварын маргаан, хяналт шалгалт”

1.2.3. Газрын эрх зүйн чиглэлээр “Газрын харилцаа, үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт”

1.2.4. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн чиглэлээр “Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрлүүд”, “Захиргааны хэргийн шүүхийн хяналтын цар хүрээ”, “Сонгуулийн маргаан ба шүүхийн практик”, “Захиргааны процессын орчин үеийн үзэл хандлага, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” гэсэн хөтөлбөр байна.

2. Сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагын хүрээнд авч үзвэл:

2.1. Журмын 5.2.1.Үргэлжилсэн сургалтын хөтөлбөрийг Сургалтын хороогоор магадлан итгэмжлүүлсэн байна. 5.2.2.Энэ журмын 3.1 дүгээр зүйлийн 3-т заасан этгээдийн зохион байгуулах сургалтын хөтөлбөрийг 2 жил тутамд Сургалтын хороо магадлан итгэмжилнэ. (3.1.3.Хууль зүйн мэргэшлийн чиглэлээр сургалт явуулдаг байгууллагууд сургалтын хөтөлбөрөө Сургалтын хороогоор магадлан итгэмжлүүлж, олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хуульчдад зориулсан сургалтыг гэрээний үндсэн дээр тогтмол зохион байгуулж болно. Зөвшөөрлийг Тамгын газрын саналыг үндэслэн Зөвлөл шийдэрлэнэ.)

Энэхүү шалгуураар авч үзвэл нийт 11 хөтөлбөрийн 1 нь гурав дэх жилдээ, үлдсэн 10 нь журамд заасан хугацаанд хэрэгжиж байна.

2.2. Журмын 5.2.3. Үргэлжилсэн сургалтын зорилго нь хуульчдын мэдлэг, мэргэшлийн түвшин, ур чадварыг эрх зүйн онолын орчин үеийн чиг хандлага, эрх зүйн шинэтгэл, шүүх эрх мэдлийн байгууллагын хөгжлийн шаардлагад нийцүүлэн тогтмол дээшлүүлэх, мэргэжлийн ёс зүйг чанд мөрдөж, шударга, хараат бусаар ажиллах чадварыг төлөвшүүлэхэд чиглэнэ.

д/д	Хөтөлбөрийн нэр	Зорилгод нийцсэн эсэх	Тайлбар
1	Хүний эрх ба хорих байгууллага	Мэдлэг дээшлүүлэх	
2	Шүтэх, эс шүтэх эрх чөлөө	Мэдлэг дээшлүүлэх	
3	ХДХВ, ДОХ ба хүний эрх	Мэдлэг дээшлүүлэх	
4	Захиргааны үйл ажиллагааны зарчим	Ур чадварыг дээшлүүлэх	
5	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн уялдаа	Ур чадварыг дээшлүүлэх	
6	Татварын хуулийн хэрэглээ болон татварын маргаан, хяналт шалгалт	Эрх зүйн шинэтгэлтэй уялдсан	
7	Газрын харилцаа, үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт	Ур чадварыг дээшлүүлэх	
8	Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрлүүд	Ур чадварыг дээшлүүлэх	
9	Захиргааны хэргийн шүүхийн хяналтын цар хүрээ	Ур чадварыг дээшлүүлэх	

10	Сонгуулийн маргаан ба шүүхийн практик	Ур чадварыг дээшлүүлэх	
11	Захиргааны процессын орчин үеийн үзэл хандлага, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал	Эрх зүйн онолын орчин үеийн чиг хандлагатай уялдсан	

3. Сургалтын хөтөлбөрт тусгах мэдээллийг агуулсан эсэх шалгуураар авч үзвэл:

3.1. Сургалтын нэр, төрөл, мэргэжлүүлэх чиглэл:

Нийт хөтөлбөрийн 27 хувь нь хүний эрхийн, 9 хувь нь захиргааны эрх зүйн, 18 хувь нь татварын эрх зүй, 9 хувь нь газрын эрх зүй, 37 хувь нь ЗХШХШЭЗ-н хөтөлбөр байна.

3.2. Хөтөлбөрийн сэдэв, агуулгыг хоорондоо уялдаа:

д/д	Хөтөлбөрийн сэдэв	Хөтөлбөрийн агуулга	Тайлбар
1	Хүний эрх ба хорих байгууллага	Хоригдлын эрх, алба хаагчийн үүрэг, хариуцлагын асуудал	Оновчтой
2	Шүтэх, эс шүтэх эрх чөлөө	Шашны зүгээс ялгаварлах, дарамтлах, хүчирхийлэх үйлдлээс урьдчилан сэргийлэх	Оновчтой
3	ХДХВ, ДОХ ба хүний эрх	ХДХВ, ДОХ-ын тархалт, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, халдвартай хүмүүсийн эрхийн асуудал	Оновчтой
4	Захиргааны үйл ажиллагааны зарчим	Зарчмыг тодорхой жишээн дээр тайлбарлах	Оновчтой
5	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн уялдаа	Тус 2 хуулийн эрх зүйн зохицуулалт, татварын болон санхүүгийн тайлангийн уялдаа	Өргөн хүрээтэй
6	Татварын хуулийн хэрэглээ болон татварын маргаан, хяналт шалгалт	Шинэ хуулийн өөрчлөлт, татварын зардлын тооцоолол, хуулийн практик хэрэглээ	Өргөн хүрээтэй
7	Газрын харилцаа, үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт	Газрын харилцаа, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн хуулийн зохицуулалт	Өргөн хүрээтэй
8	Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрлүүд	Нэхэмжлэлийн төрөл бүрт тавигдах шаардлагыг тодорхой жишээн дээр тайлбарлах	Оновчтой
9	Захиргааны хэргийн шүүхийн хяналтын цар хүрээ	Захиргааны шүүхээс захиргааны байгууллагын үйл ажиллагааны хууль зүйн үндэслэлийг хянах хязгаарыг тодорхой жишээн дээр тайлбарлах	Оновчтой
10	Сонгуулийн маргаан ба шүүхийн практик	Сонгуулийн тогтолцоо, төрөл, сонгогч, нэр дэвшигчид тавигдах шаардлага, нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах, нэрсийн жагсаалтаас хасах үндэслэл, санал хүчингүйд ооцох үр дагавар, шүүхийн харъяалал, сонгуулийн маргаан хянан шийдвэрлэх онцлог	Өргөн хүрээтэй
11	Захиргааны процессын орчин үеийн үзэл хандлага, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал	Захиргааны процессын эрх зүйн орчин үеийн онол, урсгал чиглэл, Захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хоёрдмол шинж, мөрдөн шалгах зарчим	Өргөн хүрээтэй

Хөтөлбөрийн 55 хувь оновчтой, 45 хувь нь өргөн хүрээтэй томъёолсон байгаа ба сайжруулах, сэдвийн томъёоллыг нарийвчлан тодорхойлох шаардлага байна.

Сэдэв хэт өргөн, цагийн багтаамж бага тохиолдолд сургалтын агуулгыг багш өөрөө "дур мэдэн" тодорхойлох орон зайг бий болгодог. Мөн өргөн хүрээний сэдэв, агуулга нь цаашдын сургалтын сэдвүүдтэй давхцах нөхцөлд хүргэх, андуурагдах, нэгдсэн зохион байгуулалт хийхэд төвөгтэй болох зэрэг асуудлыг үүсгэж болзошгүй юм. Иймд хөтөлбөрийг магадлан итгэмжлэхдээ **сургалтын сэдэв, агуулга хоорондын хамаарлыг шалгаж байх** шаардлага байна.

3.3. Сургалтын зорилго, зорилт, товч агуулга, эх сурвалж;

д/д	Хөтөлбөрийн сэдэв	Эх сурвалж	Тайлбар
1	Хүний эрх ба хорих байгууллага	Байхгүй	
2	Шүтэх, эс шүтэх эрх чөлөө	Байхгүй	
3	ХДХВ, ДОХ ба хүний эрх	Байхгүй	
4	Захиргааны үйл ажиллагааны зарчим	Байгаа	Ашигласан материал гээд 4 эх сурвалж дурдсан (1 цахим сайт)
5	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн уялдаа	Байгаа	Ашигласан материал гээд 4 хууль, 2 стандарт, 1 тушаал, 1 эмхэтгэл
6	Татварын хуулийн хэрэглээ болон татварын маргаан, хяналт шалгалт	Байгаа	Ашигласан материал гээд 4 эх сурвалж дурдсан (нэмэлт 4 хууль)
7	Газрын харилцаа, үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт	Байгаа	Ашигласан материал гээд 5 эх сурвалж дурдсан. 2 нь гадаад хэлээр (нэмэлт 5 хууль)
8	Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрлүүд	Байгаа	Ашигласан материал гээд 4 эх сурвалж дурдсан (1 цахим сайт)
9	Захиргааны хэргийн шүүхийн хяналтын цар хүрээ	Байгаа	Ашигласан материал гээд 4 эх сурвалж дурдсан (1 цахим сайт)
10	Сонгуулийн маргаан ба шүүхийн практик	Байгаа	Ашигласан материал гээд 2 эх сурвалж дурдсан (2 хууль, 1 цахим сайт)
11	Захиргааны процессын орчин үеийн үзэл хандлага, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал	Байгаа	Ашигласан материал гээд 12 эх сурвалж дурдсан (нэмэлт 2 хууль)

Эдгээр 11 хөтөлбөрөөс 8 нь буюу 72,7 хувь нь ашигласан эх сурвалжаа дурдаж, академик эх сурвалжийг ашигласан. Харин 3 нь огт эх сурвалж дурдаагүй нь "Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журам"-ын шаардлагыг хангаагүй байна. ЗЭЗ, ЗПЭЗ-н 3 хөтөлбөрийн ашигласан материалын жагсаалт яг ижил байгаа нь 1 багш боловсруулсантай холбоотой байна. Гадаад эх сурвалж ашигласан байдлыг үзвэл "Газрын харилцаа, үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт" гэсэн хөтөлбөрт л 2 гадаад эх сурвалжийг ашигласан байна.

Цаашид сургалтын хөтөлбөрт тухайн асуудлыг шийдвэрлэж болохуйц **олон улсын туршлага зэргийг агуулсан гадаад, дотоод эх сурвалжийг** ашигладаг байх шаардлага байна. Тухайн хөтөлбөрийн агуулгыг дэлгэрүүлэн судлах эх сурвалжийн төрөлд ач холбогдол өгөх шаардлага байна.

3.4. Сургалт явуулах арга зүй;

д/д	Хөтөлбөрийн сэдэв	Арга зүй	Хичээлд төлөвлөлтөд тодорхой оруулсан эсэх
1	Хүний эрх ба хорих байгууллага	Цагийн багтаамж	Байхгүй
2	Шүтэх, эс шүтэх эрх чөлөө	гэсэн хэсэгт	Байхгүй
3	ХДХВ, ДОХ ба хүний эрх	лекц,	Байхгүй
4	Захиргааны үйл ажиллагааны зарчим	хэлэлцүүлэг, тохиолдолд дүн	Цаг хуваарилалтыг төлөвлөхдөө "лекц, хэлэлцүүлэг, оролцогчид бодлого бодох" гэж оруулсан

5	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн уялдаа	шинжилгээ хийх гэж заасан.	Цаг хуваарилалтыг төлөвлөхдөө "лекц, дадлага" гэж оруулсан
6	Татварын хуулийн хэрэглээ болон татварын маргаан, хяналт шалгалт		Цаг хуваарилалтыг төлөвлөхдөө "лекц, хэлэлцүүлэг" гэж оруулсан
7	Газрын харилцаа, үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт		Цаг хуваарилалтыг төлөвлөхдөө "лекц, хэлэлцүүлэг, оролцогчид багт хуваагдан дасгал ажиллана" гэж оруулсан
8	Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрлүүд		Цаг хуваарилалтыг төлөвлөхдөө "лекц, хэлэлцүүлэг, оролцогчид багт хуваагдан дасгал ажиллана" гэж оруулсан
9	Захиргааны хэргийн шүүхийн хяналтын цар хүрээ		Цаг хуваарилалтыг төлөвлөхдөө "лекц, хэлэлцүүлэг, оролцогчид багт хуваагдан дасгал ажиллана" гэж оруулсан
10	Сонгуулийн маргаан ба шүүхийн практик		Цаг хуваарилалтыг төлөвлөхдөө "лекц, хэлэлцүүлэг, оролцогчид багт хуваагдан дасгал ажиллана" гэж оруулсан
11	Захиргааны процессын орчин үеийн үзэл хандлага, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал	Лекц, хэлэлцүүлэг, бүлгээр ажиллах, бичил багаар ажиллах, хүн бүр багш	Цаг хуваарилалтыг төлөвлөхдөө "Асуудал дэвшүүлэн задлан шинжилж зөвлөлдөх, асуулт, хариулт, кейс дээр ажиллах" гэж оруулсан.

Хуульчийн үргэлжилсэн сургалтын магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрүүдээс лекцийг хэлэлцүүлэгтэй хослуулсан 6, лекцийг дасгал болон тохиолдолтой хослуулсан 7, цаг сэдвийн хуваарилалт байхгүй 3, "Багц цаг" гэсэн хэсэгт яг ижил дурдсан 10 сургалтын хөтөлбөр байгаа юм.

Цаашид сургалтын арга зүйг оновчтой, зөв тодорхойлох, **интерактив аргууд** буюу суралцагчдын **оролцоонд түшиглэсэн аргуудыг** сургалтад нэвтрүүлэх шаардлагатай байна.

3.5. Цагийн багтаамж, олгогдох багц цаг;

д/д	Хөтөлбөрийн сэдэв	Цагийн багтаамж	Кредит
1	Хүний эрх ба хорих байгууллага	4 цаг	0,5
2	Шүтэх, эс шүтэх эрх чөлөө	4 цаг	0,5
3	ХДХВ, ДОХ ба хүний эрх	4 цаг	0,5
4	Захиргааны үйл ажиллагааны зарчим	4 цаг	0,5
5	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн уялдаа	6 цаг (30 минутаар 6 удаа, 60 миунтаар 3 удаа төлөвлөсөн)	0,5 гэж бичсэн
6	Татварын хуулийн хэрэглээ болон татварын маргаан, хяналт шалгалт	4 цаг	0,5
7	Газрын харилцаа, үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт	4 цаг	0,5
8	Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрлүүд	4 цаг	0,5

9	Захиргааны хэргийн шүүхийн хяналтын цар хүрээ	4 цаг	0,5
10	Сонгуулийн маргаан ба шүүхийн практик	4 цаг	0,5
11	Захиргааны процессын орчин үеийн үзэл хандлага, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал	8 цаг	1,0

Эдгээр 11 сургалтын хөтөлбөрөөс 82 хувь нь 4 цаг, 9 хувь нь 8 цагийн багтаамжтай, бүгд 1 цагийг 45 минутаар төлөвлөсөн байна. Харин "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн уялдаа" хөтөлбөрийн цагийг 60 минутаар төлөвлөж 6 цаг байхаар тооцсон байна. Энэ нь хичээл төлөвлөлт, кредит тооцоход хүндрэл учруулахуйц, журам зөрчсөн байна.

Кредит цагийн хувьд 82 хувь нь 0.5 кредит, 9 хувь нь 1 кредит, үлдсэн 9 хувь нь 0,5 гэж хөтөлбөрт бичсэн боловч цагтай нь харьцуулахад 1,5 кредит байхаар байна.

Ихэнх хөтөлбөр цагийн багтаамж болон кредит багатай байгаа тул хөтөлбөрийг магадлан итгэмжлэх явцад цаг ашиглалтын талаар нарийвчилсан төлөвлөгөө гаргуулах, хичээлийн хэрэглэгдэхүүнийг урьдчилан бэлтгэсэн байхыг шаардах нь цаг ашиглалтыг сайжруулахаар байна.

3.7. Сургалтын хэрэглэгдэхүүн;

д/д	Хөтөлбөрийн сэдэв	Хэрэглэгдэхүүн заасан эсэх
1	Хүний эрх ба хорих байгууллага	Заагаагүй
2	Шүтэх, эс шүтэх эрх чөлөө	Заагаагүй
3	ХДХВ, ДОХ ба хүний эрх	Заагаагүй
4	Захиргааны үйл ажиллагааны зарчим	Кейс
5	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн уялдаа	Кейс
6	Татварын хуулийн хэрэглээ болон татварын маргаан, хяналт шалгалт	Үзүүлэн, кейс
7	Газрын харилцаа, үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт	Үзүүлэн, кейс

8	Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрлүүд	Кейс
9	Захиргааны хэргийн шүүхийн хяналтын цар хүрээ	Кейс
10	Сонгуулийн маргаан ба шүүхийн практик	Кейс
11	Захиргааны процессын орчин үеийн үзэл хандлага, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал	Үзүүлэн, кейс

Судалгаанд хамруулсан сургалтын хөтөлбөрүүдийн хувьд дийлэнх нь сургалтын хэрэглэгдэхүүнийг дурдаагүй, дурдсан ч ямар хэрэглэгдэхүүн байх нь тодорхойгүй, хяналтын асуулт зэргийг л хэрэглэхээр заасан тул цаашид сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, сайжруулах ажлын хүрээнд **хэрэглэгдэхүүнийг шинэчлэх, сургалтын хөтөлбөрт заавал тусгадаг болох** шаардлагатайг харуулж байна.

3.8. Сургалтын үнэлгээ

д/д	Хөтөлбөрийн сэдэв	Хэрхэн үнэлэхийг тусгасан эсэх
1	Хүний эрх ба хорих байгууллага	Үнэлгээний шалгуур, 8 тест
2	Шүтэх, эс шүтэх эрх чөлөө	Үнэлгээний шалгуур, 10 тест
3	ХДХВ, ДОХ ба хүний эрх	Үнэлгээний шалгуур, 5 тест
4	Захиргааны үйл ажиллагааны зарчим	Үнэлгээний шалгуур, үнэлэх арга, хэлбэр, 9 тест
5	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн уялдаа	Үнэлгээний шалгуур
6	Татварын хуулийн хэрэглээ болон татварын маргаан, хяналт шалгалт	Оролцоо, ирц, даалгавар (өөр зүйл байхгүй)
7	Газрын харилцаа, үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт	Үнэлгээний шалгуур, үнэлэх арга, хэлбэр
8	Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрлүүд	Үнэлгээний шалгуур, үнэлэх арга, хэлбэр
9	Захиргааны хэргийн шүүхийн хяналтын цар хүрээ	Үнэлгээний шалгуур, үнэлэх арга, хэлбэр, 9 тест
10	Сонгуулийн маргаан ба шүүхийн практик	Үнэлгээний шалгуур, үнэлэх арга, хэлбэр, 9 тест
11	Захиргааны процессын орчин үеийн үзэл хандлага, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал	Үнэлгээний шалгуур, үнэлэх арга, хэлбэр

Эдгээр 11 хөтөлбөрийн үнэлгээний шалгуур бүгд ижил “тодорхой асуултад онолын үндэслэлтэй хариулж чадаж байгаа эсэх, хариулт болон үзэл бодлын үндэслэл, нотолгоо гаргаж байгаа байдал, мэдлэг шалгах сорилд хариулсан байдал, сургалтад бүрэн хамрагдсан эсэх” гэсэн байгаа ба үнэлгээний хэлбэр нь явцын үнэлгээ, эцсийн үнэлгээ, ирцийн үнэлгээний нийлбэр байхаар заасан байна. Явцын үнэлгээг хяналтын асуултаар, эцсийн үнэлгээг тестээр

авахаар заасан ба 11 хөтөлбөр хяналтын асуулттай, 6 хөтөлбөр 5-10 тесттэй, бусад 5 хөтөлбөр үнэлгээ хийх тест байхгүй байна.

Цаашид үнэлгээ хийх аргачлалыг боловсронгуй болгох шаардлага байна. Өөрөөр хэлбэл сургалтын үр дүнгээ тодорхойлох замаар хөтөлбөрийг сайжруулдаг тул тест бөглөх, хяналтын асуултад хариулах гэхээс илүү, санал асуулга, үнэлгээний хуудсыг (цаасан болон цахим хэлбэрээр) бөглүүлэн сургалтыг сайжруулах механизмыг бий болгох шаардлага байна.

Судалгаа хийсэн 11 хөтөлбөрийн 45 хувь нь сэдвийн агуулгын хувьд өргөн байгаа нь хуульчдыг мэргэшсэн түвшинд бэлтгэх шалгуурт нийцэхгүй байгаа ба өргөн хүрээний сэдэв, агуулга нь цаашдын сургалтын сэдвүүдтэй давхцах нөхцөлд хүргэх, андуурагдах, багш сэдвийн агуулгыг хааш нь эргүүлж болох зэрэг асуудлыг үүсгэж болзошгүй тул хөтөлбөрийг магадлан итгэмжлэхдээ сургалтын сэдэв, агуулга хоорондын хамаарлыг шалгаж байх шаардлага байна.

Мөн эрх зүйн хэрэгжилттэй холбоотой практикийн тулгамдсан асуудлуудад дүн шинжилгээ хийсэн, тухайн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар олон талаас нь дүгнэж анализ хийсэн байх зэрэг шаардлагыг хангасан хөтөлбөрийг нарийвчлан боловсруулах хэрэгцээ байна. Үүнийг дагаад нэг сургалтын үргэлжлэх хугацаа 0,5 кредит буюу дунджаар 4 цагаас хэтрэхгүй, нэг хуульч олон хөтөлбөрт хамрагдах боломж нэмэгдэнэ.

Эсвэл хуульчдад зориулсан тодорхой түвшин бий болгож, сургалтын хөтөлбөрт ямар түвшний сургалтад зориулсныг бичсэнээр сургалтын хөтөлбөрийн үнэ цэнэ нэмэгдэх боломжтой.

Сургалтын хөтөлбөр нь хичээлийн цагийн багтаамж, агуулга, үнэлгээ, хяналтын асуулт, эх сурвалж, хичээлийн хэрэглэгдэхүүн гэх мэт мэдээллийг бүрэн гүйцэд агуулах ёстой.

Эх сурвалжийн тухайд сургалтын хөтөлбөрт тухайн асуудлыг шийдвэрлэж болохуйц олон улсын туршлага зэргийг агуулсан гадаад, дотоод эх сурвалжийг ашигладаг байх шаардлага байна. Тухайн хөтөлбөрийн агуулгыг дэлгэрүүлэн судлах эх сурвалжийн төрөлд ач холбогдол өгөх шаардлага байна.

Сургалтын арга зүйг оновчтой, зөв тодорхойлох, **интерактив аргууд** буюу суралцагчдын **оролцоонд түшиглэсэн аргуудыг** сургалтад нэвтрүүлэх шаардлагатай байна.

Ихэнх хөтөлбөр цагийн багтаамж болон кредит багатай байгаа тул хөтөлбөрийг магадлан итгэмжлэх явцад цаг ашиглалтын талаар нарийвчилсан төлөвлөгөө гаргуулах, хичээлийн хэрэглэгдэхүүнийг урьдчилан бэлтгэсэн байхыг шаардах нь цаг ашиглалтыг сайжруулахаар байна.

Судалгаанд хамруулсан сургалтын хөтөлбөрүүдийн хувьд дийлэнх нь сургалтын хэрэглэгдэхүүнийг дурдаагүй, дурдсан ч ямар хэрэглэгдэхүүн байх нь тодорхойгүй, хяналтын асуулт зэргийг л хэрэглэхээр заасан тул цаашид сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, сайжруулах ажлын хүрээнд **хэрэглэгдэхүүнийг шинэчлэх, сургалтын хөтөлбөрт заавал тусгадаг болох**, сургалтад хамрагдаж буй хуульчдыг гарын авлагаар хангадаг байх шаардлагатайг харуулж байна.

Мөн үнэлгээ хийх аргачлалыг боловсронгуй болгох шаардлага байна. Өөрөөр хэлбэл сургалтын үр дүнгээ тодорхойлох замаар хөтөлбөрийг сайжруулдаг тул тест бөглөх, хяналтын асуултад хариулах гэхээс илүү, санал асуулга, үнэлгээний хуудсыг (цаасан болон цахим хэлбэрээр) бөглүүлэн, түүнд үндэслэн сургалтыг сайжруулах механизмыг бий болгох шаардлага байна.